



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-13
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-115
<hr/>	
<i>1.Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2022.12.30-ны өдөр ирүүлсэн/</i>	14-30
<i>2.Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	30-35
<i>3.Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	35-40
<i>3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	40-64
<i>5.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцэх /Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023.03.29-ний өдөр ирүүлсэн/</i>	64-105
<i>6.Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан /Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023.03.29-ний өдөр ирүүлсэн/</i>	105-115

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 27-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 64.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 13 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Б.Баттөмөр, Б.Баярсайхан, Б.Бейсен, Д.Ганбат, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ч.Ундрам, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн;

Хоцорсон: С.Амарсайхан-3 цаг 37 минут, С.Батболд-4 цаг 09 минут, Х.Болорчулуун-16 минут, Л.Мөнхбаатар-34 минут, Ц.Туваан-54 минут, С.Чинзориг-36 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлсэн боловч үгээ татсан болохыг мэдэгдэв.

Нэг.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Н.Жамъянхүү, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын хуульч, судлаач Р.Лхагвабаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Анужин, Ж.Чинбүрэн, Г.Мөнхцэцэг, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлэгээс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн Б.Пүрэвдорж ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 1 өдрийн завсарлага өгөв./11:12/

Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Х.Итгэлт, мөн газрын Усан замын тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төмөр замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, А.Адьяасүрэн, Э.Бат-Амгалан, Б.Баттөмөр, Б.Жавхлан, М.Оюунчимэг, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “бусад байгууламж” гэсний өмнө “салбар зам,” гэж нэмэн, мөн заалтын болон 4.1.2 дахь заалтын “технологийн” гэснийг хасаж, 4.1.9 дэх заалтын “зам талбай, хүлээн авах, олгох, хадгалах үйлчилгээ үзүүлэх” гэснийг “, хадгалах зам талбай” гэж, 4.1.24 дэх заалтын “аюулгүй байдлыг хангах хатуу бүртгэл, дугаар, хяналттай ашиглах” гэснийг “аюулгүй байдлыг хангахад ашиглах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 22
Бүгд: 46
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт буюу “нийтийн зориулалттай төмөр зам”, 4.1.8 дахь заалт буюу “тусгай зориулалтын төмөр зам” гэсэн нэр томъёог доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд тусгагдсан эдгээр нэр томъёог тохиолдол бүрд нийцүүлэн өөрчлөх:

“4.1.7.“нийтийн төмөр зам” гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий төмөр замын суурь бүтцийг;

4.1.8.“үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан төмөр замын суурь бүтцийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтыг хасаж, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “эмчлөгч” гэсний дараа “, эзэмшигч нь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “30 дугаар зүйлийн 30.1-д заасан хилийн бүсэд” гэснийг “26.1-д заасан хилийн зурваст” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 7.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.5, 14.1.6 дахь заалт, 14.4 дэх хэсэг болон 14.3 дахь хэсгийн “, 5.12, 5.13” гэснийг тус тус хасаж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “14.1.2-14.1.6-д” гэснийг “14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т” гэж, 14.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадвартай эсэх, төмөр замын объект, үйл ажиллагаанд тавигдах” гэснийг “энэ хуулийн 14.3-т заасан” гэж тус тус өөрчлөн, 14.1.1 дэх заалтын “суурь бүтэц барих” гэсний дараа “, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 7.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.5, 14.1.6 дахь заалт, 14.4 дэх хэсэг болон 14.3 дахь хэсгийн “, 5.12, 5.13” гэснийг тус тус хасаж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “14.1.2-14.1.6-д” гэснийг “14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т” гэж, 14.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадвартай эсэх, төмөр замын объект, үйл ажиллагаанд тавигдах” гэснийг “энэ хуулийн 14.3-т заасан” гэж тус тус өөрчлөн, 14.1.1 дэх заалтын “суурь бүтэц барих” гэсний дараа “, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 21
Бүгд: 46
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “ашиглах зөвшөөрлийг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын “төмөр замын тээвэр зуучлалын” гэснийг хасаж, 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-г заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.” гэсэн саналаар санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Б.Пүрэвдорж Төмөр замын тээврийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн дээрх зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан үг хэлж, ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 1 өдрийн завсарлага өгөв./11:40/

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусаагүй болно.

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	21
Бүгд:	42

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг” гэснийг “14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь заалт болгон шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 26¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26¹.2.Хуулийн үйлчлэх хугацааг тухайн хуульд зохицуулсан тохиолдолд тус хугацаа дуусмагц хууль хүчингүй болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 29.2 дахь хэсгийн “хариуцлагын төрөл, хэмжээ” гэснийг “хариуцлага” гэж өөрчилж, мөн заалтын 29.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 33.7 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4. Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол энэ хуулийн 40.1.2, 40.1.3-т заасан баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж, хамтад нь байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46¹.1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46¹ дүгээр зүйл. Хууль тогтоомжийн орчуулга хийх

46¹.1. Шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн орчуулгыг англи хэлээр хийнэ.

46¹.2. Хууль тогтоомжийн орчуулгын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

46¹.3. Хууль тогтоомжийн орчуулгын санг бүрдүүлэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

46¹.4. Энэ хуулийн 38.4-т заасан хууль тогтоомжийн орчуулгыг тухайн хууль тогтоомж батлагдснаас хойш 90 хоногийн дотор эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “гарах” гэсний дараа “болон хуулийн албан бус орчуулгын” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг, мөн зүйлийн 3 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу” гэснийг, мөн хэсгийн “энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 12.2.10 дахь заалтын “6.3-т” гэснийг “6.3, 6.4-т” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15.11 дэх хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд” гэснийг, мөн заалтын 15.12 хэсгийн “үзэл баримтлалын төслийг” гэснийг, мөн зүйлийн 7 дахь заалтын 30.8 дахь хэсгийн “боловч өөр бичилттэй тухайн” гэснийг, 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 51.1 дэх хэсгийн “байдлаар” гэснийг тус тус хасаж, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 22.3 дахь хэсгийн “22.2-т” гэснийг “14.4-т” гэж, мөн хэсгийн “хууль” гэснийг “төсөл” гэж, 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын 49.5 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж, мөн зүйлийн 12 дахь заалтын 52.1 дэх хэсгийн “хууль тогтоомжид зохих” гэснийг “түүнд” гэж, мөн хэсгийн “хууль тогтоомжийг системчлэн” гэснийг “системчлэн” гэж, 5 дугаар зүйлийн “мөн хэсгийн” гэснийг “мөн зүйлийн 21.11 дэх хэсгийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр нарын гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1. Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “дараах харилцааг зохицуулж буй хуулиудын” гэснийг “хуулийн” гэж, мөн зүйлийн “Хууль зүй, дотоод хэргийн яаманд” гэснийг “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хуулийн хэлтсийн дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 18 минутаас хуралдааныг даргалав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Энхбаяр, Х.Нямбаатар, Ц.Идэрбат, Д.Батлут, Ж.Чинбүрэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Сангийн яамны Хуулийн хэлтсийн дарга З.Энхболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 10 минут үргэлжилж, 13 цаг 23 минутад өндөрлөв.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Тав.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцэх /Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023.03.29-ний өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн Комиссын гишүүн С.Дондов, Х.Мөнхзул, Г.Нарантуяа, Д.Сүнжид, Б.Энхболд, Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, С.Одонтуяа, Д.Тогтохсүрэн, Б.Жаргалмаа, С.Бямбацогт, Г.Тэмүүлэн, Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь, А.Адъяасүрэн, Н.Ганибал, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов, Х.Мөнхзул, Г.Нарантуяа, Д.Сүнжид, Б.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 16 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан /Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2023.03.29-ний өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг, мөн хэлтсийн ахлах референт Д.Түвшинтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Б.Буянзаяа нар байлцав.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, тайланг хэлэлцсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр нар танилцуулав.

Тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адъяа нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 17 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./17:26/

Бусад.Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Э.Бат-Амгалан, Г.Ганболд нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн урилгаар “Амгалан цогцолбор” Ерөнхий боловсролын сургуулийн 9^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн Музейн ажилтан, албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн урилгаар “Шинэ Монгол” Ерөнхий боловсролын сургуулийн 7 дугаар ангийн багш сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Туваан, Н.Энхболд нарын урилгаар Төв аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн багш, магистрантурууд, Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн урилгаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих 405 дугаар ангийн ажилтан, албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 34 минут үргэлжилж, 73 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 72.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их
Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2023 оны хаврын
ээлжит чуулганы 4 дүгээр сарын 27-ны
өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг
мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар
хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 6 асуудал
хэлэлцэнэ.

1. Аялал жуулчлалын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн
анхны хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын
зөрүүтэй 96 саналтай юм байна.

Хоёрт, Төмөр замын тээврийн
тухай хуулийн шинэчилсэн найруулгын
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг
явуулна. Зарчмын зөрүүтэй 36 саналтай
юм байна.

Гуравдугаарт, Хууль
тогтоомжийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн
анхны хэлэлцүүлгийг явуулна. 16 Зарчмын
зөрүүтэй саналтай.

Дөрөвдүгээрт, Төрийн болон орон
нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,
үйлчилгээ худалдан авах тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн төслүүдийн анхны
хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй
30 саналтай.

Тавдугаарт, Монгол Улсын Монгол
Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын
талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцэнэ. 6
дахь ХЭҮК-ын эрүү шүүлтээс урьдчилан
сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний
Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл
ажиллагааны тайланг хэлэлцэнэ ээ.

Энэ Хууль зүйн байнгын хорол
оруулж ирсэн юм байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж
дараалал, асуудлыг хойшлуулах, дараалал
өөрчлөх, асуудал нэмэх горимын саналыг
Улсын Их Хурлын гишүүн Адъяа,
Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлсэн
боловч үгээ татсан болохыг мэдэгдье.
Энэ чинь протоколд тусгагдах ёстой
байх.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Аялал жуулчлалын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн
анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг
явуулсан талаарх Эдийн засгийн байнгын
хорооны санал, дүгнэлтийг Улсын Их
Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг
танилцуулна аа.

Индэрт урьж байна аа.

Г.Занданшатар: Улсын Их
Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Х.Ганхуяг: Монгол Улсын Засгийн
газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны
өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн
Аялал жуулчлалын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн
хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын
2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн
шийдвэрлэж төслүүдийг анхны

хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ганхуягаар ахлуулж, гишүүдэд Адышаа, Булгантуяа, Доржханд, Оюунчимэг нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал тус бүрээр хэлэлцээж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжлээ.

Үүнд:

Төслийн зарим нэр томъёог Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас баталсан нэр, томъёог тодорхойлж, тайлбартай нийцүүлэн өөрчлөх. Жуулчны үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал болгон өөрчлөн найруулж тус жуулчлал нүүдэлчдийн соёл ахуй зан заншлыг танилцуулан сурталчлах. Зочны гэрээр болон ердийн хөсгөөр үйлчлэх аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хамааруулж нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын эрхлэгч эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулах стандартыг үйл

ажиллагаандаа мөрдөх тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, дэмжих байгаль түүх, соёлын, өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор улсын газар зохион байгуулалт ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн орон зайн зохистой төлөвлөлт бүхий аялал жуулчлалын бүстэй байх. Тус бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа газар ашиглалттай холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх, түүнд нийцсэн менежментийн төлөвлөгөөтэй байх.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь түр оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч, тайлбарлагч нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчдийн нэгдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдын сургалт, зөвлөгөө, мэдээлэл мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллага, ажилтныг баримтлах мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулж батлах үндсэн чиг үүрэг бүхий ашигийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд байх.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эргэлт, байгаль орчны даацыг үндэслэн отоглох цэгээ байршуулан байршлыг тогтоох.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх санд төвлөрүүлэх орлогын эх үүсвэр тодорхойгүй тул тусгай сан байгуулах шаардлагагүй гэж үзэн төслөөс уг сантай холбоотой зохицуулалтыг хасах. Үүнтэй холбогдуулан дээрх хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийг хууль санаачилсанд буцаах, Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлүүлэх оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дөчдүгээр зүйлийг баримтлан Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлж боловсруулах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ганибал Энхтүвшин нар зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан аялал жуулчлалыг хөгжүүлэх сан, жуулчны хөтөч, тайлбарлагч, отоглох цэг, бүс нутгийн болон хил орчмын аялал жуулчлалын талаар, аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн татах талаар асуулт асууж хариулт авсан болно. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналуудыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Баярлалаа. Байнгын хорооны гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулж

асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Жигжидсүрэнгийн Чинбүрэн Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн нараар тасаллаа.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Ерээд он 2000 оны дунд хүртэл ер нь бол агнуурын асуудал бол нэг капитализмын зарчмаар буюу хэн илүү мөнгө төлсөн нь явдаг ийм одоо байсан. Тэгээд үүнийг нь хуулиар зохицуулж бас яг тухайн орон нутагт агнуурын бүс нутгийг гаргаад тэр бүс нутагтаа тодорхой менежментийн үйл ажиллагаа явуулж нөхөрлөл орон нутгийн одоо хүмүүсийг оролцуулсан ийм одоо нөхөрлөл бас хоршоодыг болон бусад одоо бүтцийн байгууллагыг байгуулж ингэж явсан. Тэгээд үүний үр дүнд бол агнангаа ан амьтнаа одоо хамгаалах ийм одоо боломжийг бий болгосон. Өөрөөр хэлбэл орон нутгийн иргэд янз янзын бухимдалгүй болсон. Гаднын хүн ирээд нэг тийм хамгийн сайн одоо аргал тэхийг нь буудаад явчихдаг биш тэр хүмүүс өөрсдөө бас үр ашиг хүртэнгээ дээрээс нь тэр нөхөрлөлдөө оролцсон тэр ан амьтнаа хамгаалах, өвс тэжээл хүргэх, тэгээд л одоо идэш ууштай л байвал тэр ан амьтан чинь л эвэр нь ургаад л илүү сайн одоо ан болж хувирдаг л байхгүй юу даа.

Тэгэхээр энэ бүх зүйлийг хийгээд явж байсан энэ тогтолцоог бас яг энэ анхны хэл анхны одоо хувилбараар бол энэ хуулийн төслийн анхны хувилбараар шууд дуудлага худалдаанд оруулаад л хэн их төлбөр төлдөг нь ангаа агнадаг ийм одоо нөхцөл рүү оруулж ирсэн. Тэгэхээр энэ бол одоо болохгүй. Яагаад гэвэл буудаад буудаад л явчихна тэгээд ерөөсөө тэр анг хайрладаг хамгаалдаг тэр хүнгүй болчихоор чинь сайныг шилж, сонгож буудаад л ингээд л явчихаар нөгөө ан амьтан чинь ховордож байгаа нөхцөлд нөгөө одоо менежмент энэ тэр байхгүй болоод ангаа өсгөдөг хамгаалдаг энэ зүйл

маань одоо байхгүй болчих ийм хувилбар луу орж байсан.

Тийм учраас би энэ хуулийн төслийн ажлын хэсгийн ахалж байсан Ганхуягт бас энэ талаар бас нэлээн сайн хэлж ер нь бол энэ агнангаа хамгаалах энэ зарчим бол одоо энэ агнуурын энэ одоо бизнест бол сайнаар нөлөөлөх илүү сайн антай болох ийм одоо боломжийг л бий болгоно гэж үзсэн юм л даа. Тэгэхээр яг энэ асуудлаар яаж яаж энэ хууль дээр орсон бэ?

Дээрээс нь Зөвшөөрлийн хуулийн тэр зохицуулалттайгаа яаж зохицуулж өөрчилсөн бэ гэдэг энэ асуудлаар асуулт асууя.

Г.Занданшатар: Байнгын хороо уул нь хариулах ёстой шүү дээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд БОАЖ-ын сайд, ажлын хэсэг хариулна. Хариулахын өмнө түр байж байгаарай.

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийн урилгаар нийслэлийн БЗД-ийн ерөнхий боловсролын Амгалан цогцолбор сургуулийн 9-ийн ангийн сурагч багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Тэгээд эрхэм хүндэт сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилт сайн сайхныг хүсэн ерөөе өө.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулна.

Ажлын хэсгийг танилцуулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ БОАЖ-ын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ТНБД Сүхбаатарын Цогтгэрэл, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Нармандахын Жамъянхүү, Монголын эрх зүй судалгаа хөгжлийн төвийн төв ТББ-

ын хуульч, судлаач Ринченпүрэвийн Лхагвабаяр.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулна. 81.

Б.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. БОАЖ-ын сайд Бат-Эрдэнэ.

Аялал жуулчлалын тухай хуулийг Засгийн газраас өргөн барихдаа ан агнууртай холбоотой заалтыг бол өргөн барьсан. Хэлэлцүүлгийн явцад бол Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор бол төслийг хууль санаачлагчид буцаах ийм шийдвэр гарсан. Таны асуусан асуулт бол 2022 оны 6 сарын 17-ны өдөр батлагдсан. 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжих зөвшөөрлийн тухай хуулиар бол дуудлага худалдаа сонгон шалгаруулалтыг 5, 6 дугаар зүйл дээр бол хуульчилж өгсөн байгаа.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.18, 1.23 гээд энэ ан агнууртай холбоотой ялангуяа тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах барих үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтныг агнах барих гэдэг заалт бол Зөвшөөрлийн тухай хуульд 2022 оны 6 сарын 17-ны өдөр орсноор 2023 оны 1 сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Хуучин бол яах вэ яг өргөн баригдаад юу? Зөвшөөрлийн тухай хууль батлагдахдаа бол тухайн сум, дүүргийн Засаг дарга зөвшөөрөл олгохоор байсныг бол 2023 оны 1 сарын 6-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр бол аймаг, нийслэлийн Засаг дарга олгохоор хуульчилж өгсөн байгаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Хассуурийн Ганхуяг гишүүн гүйцээж хариулъя.

Х.Ганхуяг: Зөвшөөрлийн тухай хууль 2022 оны 6 сард батлагдсан байгаа. Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсэг

Пүрэвдорж гишүүн маань бас хамт орж ажилласан байгаа. Маш одоо либералчилсан ийм хууль байгаа. Энэ хуулиар бол бид нар 23 төрлийн төрийн нийтийн өмчтэй холбоотой зөвшөөрлийг дуудлага худалдаа сонгон шалгаруулалтаар явуулахаар хуульчилж оруулж өгсөн байгаа.

Тэгээд 2022 оны 11 сарын 6-ны өдөр Засгийн газраас яг тэр зөвшөөрлөөсөө яг энийг нэг нь дуудлага худалдаагаар явуулъя энийг нь сонгон шалгаруулалтаар явуулъя гэдгээр бол өргөн барихдаа бол ялгаж оруулж ирсэн. Тэгээд ан амьтантай холбоотой асуудлуудыг болохоор дуудлага худалдаагаар орохоор орж ирсэн байгаа. Гэхдээ дуудлага худалдаагаар оруулна гэдэг маань Засгийн газар нь тухайн жилдээ даац нөөц хэмжээгээ тодорхойлоод аль бүс нутгаас хэдийг юуг гэдгээ тогтоогоод тэгээд тэр тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга нь одоо тэдэн насны ийм янгирьг агнаж гэдэг юм уу иймэрхүү байдлаар тогтоогоод явахаар хуульд бол туссан байгаа шүү. Баярлалаа.

Г.Занданиатар: *Пүрэв-Очирын Анужин гишүүн. Пүрэвдорж гишүүн тодруулж асууя. 1 минут.*

Б.Пүрэвдорж: *Тэгээд наадах Зөвшөөрлийн хууль дээрх тэр нөгөө дуудлага худалдаагаар одоо энэ ан амьтны асуудлыг шийдвэрлэнэ гэдэг чинь үлдчихээр тэгээд анхан шат хууль санаачлагчид нь буцаачихсан байна шүү дээ. Ан агнуурын тухай хуулийг. Тэгээд энийгээ яаж оруулах гэж байгаа юм, яаж шийдэх гэж байгаа юм. Би бол дахиад нэг өөр асуудлаар л шийдэх ийм хувилбар л та нар сонгохгүй бол наадах чинь тэгээд бүүр нөгөө нэг энэ ан агнуурын энэ олон нөхөрлөл энэ олон жил явсан сайн зүйлийг бүгдийг нь нураах ийм нөхцөл байдал руу оруулж байна шүү дээ. Наадах чинь дуудлага худалдаагаар мөнгө цохисон хүн л энд тэнд очоод буудаад байна. Нөгөө*

хүмүүст нь ямар ч үр дүн байхгүй нөгөө наадах ан агнуурын систем чинь бүгдээрээ нуран унаж байна шүү дээ.

Энийгээ яаж зохицуулах юм бэ? Та нар тодорхой биш хариулт өгөөд байна шүү дээ.

Г.Занданиатар: *Байхгүй юмыг мэдрэмжээрээ бүтээгээд хуульд суулгана гэж байхгүй л дээ. Байхгүй хууль дээр байхгүй л бол байхгүй шүү дээ. Бат-Эрдэнэ сайд хариулъя. 81. Хассуурийн Ганхуяг гишүүн.*

Х.Ганхуяг: *Энэ дуудлага худалдаатай холбоотой асуудал бол дуудлага худалдаагаар явах уу, сонгон шалгаруулалтаар явах уу гэдэг асуудлыг бол Засгийн газрын түвшинд тухайн яам нь төрийн захиргааны төв байгууллага шийдээд оруулчихсан гэсэн үг 2022 оны 11 сард оруулж ирсэн. Тэрэн дээр ажлын хэсэгт нь та өөр гишүүнээр байсан. Пүрэвдорж гишүүн ээ. Тэгээд энд чинь хоёулаа хамт ажлын хэсэг дээр сууж байгаад батлаад явуулсан шүү дээ. Дуудлага худалдаа муу юу, сайн уу ямар зарчмаар сонгох вэ гэдэг бол энэ бол төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий асуудал гэж харж байгаа.*

Яагаад сонгон шалгаруулалт болохгүй байна яагаад дуудлага худалдаагаар явсан бэ гэдэг энэ дээр бол яам хариулах ёстой байх. Гэхдээ энэ бол нөгөө шударга өрсөлдөөний зарчимд бол нийцнэ гэж харж байгаа. Энэ дуудлага худалдааны орлогын энэ чинь 40 хувь билүү, 80 хувь нь тухайн орон нутагт үлдэж байгаа.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн музейн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд сайн сайхныг хүсье ээ.

Одоо Пүрэв-Очирын Анужин гишүүн асуулт асууна.

П.Анужин: Аялал жуулчлалын хуулийн шинэчилсэн найруулга гээд 33 зүйлтэй хууль байна. Тэгээд өнөөдөр бараг ерэн хэдэн зарчмын зөрүүтэй санал хураана гэж байгаа юм. Тэгээд 33 зүйлтэй хууль дээр ерэн хэдэн зарчмын зөрүүтэй санал оруулж ирэхээр энэ хууль чинь үлдэж байгаа юм уу? Тэгэхээр энийгээ ажлын хэсэг нь татаж юм уу өөрсдөө энэ цэгцэлж оруулж ирэхгүй юм уу? Яг ямар учиртай зарчмын зөрүүтэй санал юм бэ? Энэ 70 орчим нь Үндсэн хуультайгаа холбоотой юм байна 20 дагалдах хуультайгаа холбоотой. Гэхдээ ийм зүйл байх юм уу? ийм хууль гэж одоо байж болдог юм уу?

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Зарчмын зөрүүтэй олон санал гарсан. Тэгэхдээ энэ бол нөгөө яаралтай горимоор Засгийн газраас өргөн барихдаа бас зарим нэг зүйлээ орхигдуулсан дутуу дулимаг хийсэн юмнууд бол гарсан юм шиг байгаа юм тэгээд тийм учраас ажлын хэсэг дээр бол тухайн үеийн төрийн захиргааны төв байгууллагаас бол мэдээллүүдээ сайн аваад нэмж 2, 3 судалгаа хийлгэсэн. Тэгээд тийм ч учраас энэ дээр бол зарчмын зөрүүтэй саналууд бол орж ирсэн байгаа. Хууль санаачлагчид нь буцааж бол болно. Буцаахад бол асуудал байхгүй. Энэ Байнгын хороон дээр хүртэл энэ асуудал яригдсан. Гэхдээ асуудал нь юу вэ гэхээр энэ нөгөө нэн яаралтай горимоор орж ирсэн буюу Засгийн газар аялал жуулчлалын жил гээд зарлачихсан байж байгаа. Хууль нь батлагдаагүй байгаа. Тэгээд энэ аялал жуулчлалын энэ сезон нь эхэлчихсэн байж байна. Одоо 4 сараас эхлээд явж байна. Буцаах шиг амархан юм байхгүй ээ. Тийм та бүхний эрх бүхий асуудал. Баярлалаа.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ сайд хариулъя. Энэ 43 зүйлтэй хууль дээр 96, Үндсэн хууль дээр нь 70 санал өөрчлөгдөх гэж байна. Хуулийг одоо яаж боловсруулж оруулж ирсэн юм бэ хуулийн чанар 81. Буцаагаад дахиж сайжруулж орж ирэх юм уу гэж асуугаад байна шүү дээ?

Б.Бат-Эрдэнэ: Анужин гишүүний асуултад хариулъя.

Анх 2022 оны 4 дүгээр сард энэ хуулийг хэлэлцэх шинэчилсэн найруулгын асуудал дээр бол хэлэлцүүлгүүдийг албан ёсоор эхлүүлсэн. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо байгуулагдсанаар дэд ажлын хэсгүүд гарсан. Дэд ажлын хэсгүүд дээр бол аялал жуулчлалыг хөгжүүлэх яг энэ хууль хуулийн ажлын хэсгийг бол тусад нь байгуулсан. Тэнд бол тодорхой хэмжээний өөрчлөлтүүд орсон. Үүний дараагаар болбол өргөн баригдсан, өргөн баригдсаны дараагаар болбол Булгантуяа гишүүн анх энэ ажлын хэсгийг ахалж дэд ажлын хэсгийг байгуулж хэлэлцэгдсэн байгаа. Үүний дараагаар бол Булгантуяа гишүүн сайд болсонтой холбогдуулж ажлын хэсгийн ахлагчийг одоо мөн сольж Хассуурийн Ганхуяг гишүүн ахалж ажилласан.

Энэ явцад бол аялал жуулчлалын компаниуд бол тодорхой хэмжээнд өөрсдөө энэ хууль дээр орж ажиллах ийм саналыг тавьснаар энэ дээр бол бас тодорхой хэмжээний ажлын хэсэг дээр гарсан болон одоо хэлэлцүүлгийн шатанд явсан өөрчлөлтүүдийг бол олонхын саналаар тусгаж өгсөн байгаа. Ер нь бол энэ аялал жуулчлалын компаниуд энэ дээр маш сайн оролцож өөрсдийн одоо бас гар бодол оюун сэтгэл оролцсон ийм хууль болж байгаа гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн тодруулж асууя.

П.Анужин: Сайдаа энэ хуульд хэн ямар гар бие оролцсоныг бол би энд яриагүй. Ямар зүтгэл гаргасныг ч яриагүй. Эцсийн дүндээ энэ хууль чинь ямар чанартай хууль болж вэ гэдгийг л ярьж байгаа юм. Тэгэхээр энэ боловсон хүчин ажилласан энэ хууль санаачилсан хүмүүс бол энэ хуулиа татаж авах хэрэгтэй. Улсын Их Хурал бол энэ дутуу дулимаг хаячихсан юмыг нөхдөг хуулийг нь нөхөөс хийдэг аль эсвэл хуулийг нь бөөс түүдэг газар биш.

Тэгэхээр ийм хуулийг бол бид нар өнөөдөр 33 зүйл заалт дээр ерэн хэдэн юм яриад сууж байх ийм болбол бас цаг хугацаа Улсын Их Хуралд байдаг юм уу, байхгүй юм уу гэдгийг бол бодох ёстой гэж ингэж бодож байна. Хичээл зүтгэлийн асуудал биш шүү дээ. Энэ бол хариуцлагын энэ мэргэжлийн асуудал байхгүй юу. Хууль бичих мэргэжлийн асуудал.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Буцаах тухай яриа бол байхгүй байх. Яагаад гэхээр энэ хуулийн үзэл баримтлалын хүрээнд энэ өөрчлөлтүүдийг тусгасан байгаа. Саналуудыг бол авалгүй яах вэ. Зарчмын зөрүүтэй саналууд ажлын хэсэг дээр ч гарч байгаа. Дэд ажлын хэсэг дээр ч гарч ирж байгаа. Тэгээд тэрийг бүгдийг нь Эдийн засгийн байнгын хороон дээр бид нар хэлэлцээд санал тус бүр дээр нь саналаа хураагаад явсан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулъя. Байнгын хорооны дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Энэ Байнгын хороон дээр ингээд дэмжигдээд явсан. Сая ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн сайн тайлбарлалаа. Яаралтай горимоор орж ирсэн юм гээд. Тэгээд бас Их Хурал

дээрээ байгуулагдсан ажлын хэсэг дээр бас тодорхой Байнгын хорооноос бас санал гаргаж, ялангуяа энэ хууль ялангуяа энэ аялал жуулчлалын бизнес бол нутгийн иргэдэд түшиглэж явах ёстой. Нутгийн иргэдийн оролцоо хангалттай хангагдсан байх ёстой гэдэг энэ шаардлагыг тавьж гаднын судлаачид судалгаа хийдэг байгууллагуудын бас санал, дүгнэлтийг оруулж саналыг оруулж энэ ажлын хэсгийг бол нэлээн сайн ажиллуулсан юм. Засгийн газар дээр бол нөгөө яаралтай горимоор орж ирсэн учраас бол бас энэ дээр илүү дутуу юм байсан. Тэгээд энэ ажлын хэсгийг бол одоо удаан хугацаанд бас сайн ажиллуулсан.

Г.Занданшатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе ээ.

Аялал жуулчлалын тухай хуулийг бол одоо дэмжиж байгаа. Хэдүүлээ хэлэлцээд зарчмын зөрүүтэй саналууд дээр нь санал хураагаад олон хүн ажилласан. Ер нь бас манай парламентын бас нэг чухал үүрэг бол бид энэ өргөн барьсан хуулийн төслийг сайжруулах алдаа оноог нь засах амьдралд хэрэгжих боломжтой болох энэ чухал үүргээ биелүүлж ажиллаж байгаа л гэж харж байгаа.

Тэгэхээр энийгээ хэдүүлээ бас санал хураагаад явчихсан нь зөв байх аа. Би нэг ийм асуулт асуух гээд байгаа юм. Ер нь бол энэ аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн үйлчилгээний дараах үйлчилгээнээс хамаарна гэсэн 5.3 дахь заалт дотор бид эрүүл мэндийн аялал жуулчлал гэдэг үг, өгүүлбэр ороогүй байгаад байгаа юм аа.

Тэгэхлээр Монгол Улсын бас одоо газар нутагтай холбоотой рашаан сувилал, уламжлалт эмчилгээ, тэр битгий хэл зарим одоо Европын анагаах

ухааны чиглэлээр Монгол Улсад бусад оронд хийж чадахгүй байгаа зүйлийг хийж чадаж байгаа ийм зүйлүүд байгаа.

Тийм учраас энэ дээр эрүүл мэндийн аялал жуулчлалыг яагаад оруулсангүй вэ. Энд нэг хариулаарай. Зүгээр нэг мэдээлэл хэлэхэд бол жишээлбэл Солонгосын эрүүл мэндийн аялал жуулчлалын нийгэмлэгийн мэдээлснээр 2008 онд Өмнөд Солонгост ирсэн эмнэлгийн жуулчлалын тоо 1 сая байсан бол 2018 он, 2020 он гэхэд энэ 12 сая болж нэмэгдсэн. Зөвхөн 2010 онд гэхэд 10.2 тэрбум америк доллар болсон байдаг.

2019 онд 20 тэрбум доллар болсон байдаг. Тэгээд Ковид цар тахал гарсантай холбоотой энэ орлого нь 10 тэрбум болж буусан байдаг.

Тэгэхлээр эрүүл мэндийн аяллаар нэг хүн дунджаар ойролцоогоор 6.8 мянган доллар олох боломжтой. Тэгэхлээр энэ чиглэлээр бас бид энийгээ оруулж өгвөл хууль гэдэг маань ирээдүйд чиглэсэн байдаг зүйл учраас бид энийг илүү оруулах, энэ чиглэлд бол анхаарах нь чухал юм аа.

Жишээлбэл одоо Солонгост эрүүл мэндийн аялал жуулчлалаар хамгийн их очдог улсууд гэхэд АНУ, БНХАУ, Вьетнам. Дөрөвт нь Монгол Улс бичигдэж байна. Тайланд бол эрүүл мэндийн аялал жуулчлалын ДНБ-ийхээ 21.6 хувийг бүрдүүлдэг гэж байгаа юм. БНСУ 8 хувийг эзэлдэг гэж байгаа юм.

Тийм учраас энэ дээр одоо эрүүл мэндийн аялал жуулчлал гэдгийг одоо яагаад оруулсангүй вэ? Энэ талаар ер нь яригдсан уу? Хариулт авъя аа.

Г.Занданшатар: Эхлээд зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяагийн урилгаар Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургуулийн 5 дугаар ангийн багш, сурагчид

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн сурицааж сайн хүмүүс болцгоогоорой.

Хассуурийн Ганхуяг, Байнгын хороон дарга хариулна.

Х.Ганхуяг: Эрүүл мэндийн аялал жуулчлал нь бол тусгай сонирхлын аялал гэдэг шиг одоо аялал жуулчлалын нэг төрөл юм байгаа юм аа. Тэгээд дагалдах бүтээгдэхүүн үйлчилгээ нь одоо аялал жуулчлалыг дэмжих үйлчилгээнүүдийн нэг бөгөөд яг энэ аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээнд бол дараах аяллууд хамаарна, үйлчилгээнд хамаарна гэдэг орчихсон байгаа. Яах вэ тэрэн дээр бол бүр бусад үйлчилгээ гэдэг дээр орчихсон байгаа юм. Тэгээд бусад гэдгээрээ биш одоо бид нар ингээд бүгдийг нь тоочоод яваад байх бас нэг жоохон зохисгүй харагдаад байхгүй юу. Тэрнээс биш одоо яг энэ бид нарын энэ Аялал жуулчлалын энэ хууль батлагдсанаар бол тэр чинь нэлээн олон 3 жилийн хугацаанд яг аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдээ дэмжээд явах ийм боломжууд нэмэгдээд явах. Энэ чинь зөвхөн одоо нэг төрөл гэхээсээ гадна эвентүүд бас явагдана. Одоо өвлийн ямар эвент байх юм? Спортын эвент байж болж байна.

Сая бид нар сагсан бөмбөгийн Азийн аварга шалгаруулахын өмнөх юуг бас нэг иймэрхүү байдлаар бид нар спортын эвентүүд ч хийгээд явах боломжтой. Мөн шинэ үйлчилгээнүүдийг ч нэвтрүүлэх боломжтой. Ингээд энэ хууль нь өөрөө энийг дэмжээд явчих боломжуудыг нь бүрдүүлээд явах юм байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн 1 минут.

Ж.Чинбүрэн: Ганхуяг гишүүн ээ энэ бусад гэдгийн доор орчихоор л нөгөө бид анхаарах асуудал биш болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас бас энэ Монголын уламжлалт анагаах ухаан бусад одоо газар байдаггүй энэ хануур, төөнүүр мөн одоо ургамлын, рашаан сувиллын гээд зөндөө зүйл байгаа юм аа. Энийг бол бүр зайлиггүй бүр эрүүл мэндийн аялал жуулчлал гэж оруулах нь чухал аа. Ингэж байж нөгөө чухал зүйл болгож энэ бүлэглэж оруулах нь энэ салбарын хөгжилд бас өөрөө чухал төлөө үзүүлэх юм гэж бодож байна.

Г.Занданшатар: Баяртай хүүхдүүд ээ, амжилтын үндэс бол эрдэм мэдлэг, дадал сургууль, хүмүүжил, боловсрол 3 гэж байгаа шүү дээ, дадал тогтоох.

Одоо Хассуурийн Ганхуяг хариулъя.

Х.Ганхуяг: Чинбүрэн гишүүний саналыг хүлээж авъя аа. Би тэр бусад гэдгийнхээ өмнө гүйцээн боловсруулахаар чиглэл аваад оруулъя аа. Гэхдээ бол энэ нөгөө Засгийн газрын түвшиндээ хангалттай хийх боломжтой юм л даа. Одоо нөгөө Солонгос руу эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бол Засгийн газар нь одоо тухайлбал визний горим дээрээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх гэж байвал гээд хөнгөлөлттэй ингээд нөхцөлүүдээ өгөөд өгөөд явчихдаг байхгүй юу. Яг л тэрэнтэй адилхан. Уг нь бол энэ зүгээр нэг хууль нь өөрөө байж байхад бол Засгийн газар өөрийнхөө түвшинд хийгээд хангалттай явчих боломжтой юм. Гэхдээ яах вэ таны саналыг хүлээж авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн.

Г.Мөнхцэцэг: Аялал жуулчлалын тухай хууль шинэчилсэн найруулгаар орж ирж байна. Тэгээд энэ хууль маань одоо бас зарим хэлж байгаа гишүүдтэй би бас

санал өгөөд байгаа юм. 33 зүйлтэй хэрнээсээ 90 гаруй ийм зарчмын зөрүүтэй саналтай үндсэн одоо хуулийн маань агуулга тэр зарчим нь бол бас нэлээн хэд хэд бичсэн болов уу гэж ингэж харагдаж байгаа. Тэгээд энэ Эдийн засгийн байнгын хороогоор орсон энэ хууль. Тэгээд ер нь бол одоо аялал жуулчлалыг голдуу энэ хуулийн гол агуулга нь бол одоо эдийн засгаар яаж аялал жуулчлалаар яаж эдийн засгаа тордох вэ? Эдийн засгийн аялал жуулчлалыг одоо бас яаж хөгжүүлэх вэ л гэсэн ийм одоо үндсэн агуулга юман дээр бас нэлээн олон зарчмын зөрүүтэй санал гарсан юм уу гэж харагдаж байгаа.

Энд уул нь бол одоо зарчмын хувьд бол бас байгаль орчин ХАА-н Байнгын хороогоор бас дахин хэлэлцэгдэх ингэж явах болов уу гэж бас харсан. Тэгээд хуулийн маань ер нь үндсэн одоо гол юмнууд нь бол одоо бас соёлын аялал жуулчлал, соёлын чиглэл рүү нэлээн одоо ингээд түлхүү явуулахаар нэлээн олон саналууд энэ дотор туссан байгаад байгаа юм аа.

Тэгэхээр зарим зүйл дээр Чинбүрэн гишүүний бас хэлж байгаатай бас санал нэг байна. Энэ одоо дэлхий нийт чинь тэр чигээрээ соёлын аялал жуулчлал гэдгээрээ л одоо эдийн засгаа хөгжүүлж байна шүү дээ. Ер нь соёлын аялал жуулчлалыг л хөгжүүлж байна.

Тэгэхээр бид нар одоо энэ хууль ингээд нэгэнт ороод ирж байгаа дээр энэ соёлын хуультайгаа яаж зөрчигдөж байгаа юм? Дээр нь бас соёлын өвийг хамгаалах талын энэ хуулиудтай яаж зөрчилдөж байгаа юм. Бас тусгай хамгаалалттай газар нутгуудын тухай хуультай яаж одоо бас зөрчилдөж байгаа юм гээд энэ одоо зүйлүүд дээр бас нэлээн анхаарч ажиллах ёстой байсан юм болов уу гэж бас ингэж харагдаж байгаа. Тэгээд 5.3 дээр гэхэд л аялал жуулчлалын дараах бүтээгдэхүүн үйлчилгээнд хамрагдана гээд зөвхөн одоо урлаг үзвэр

үйлчилгээ, соёлын бусад үйлчилгээ гээд ингээд нэг тийм жишжигхэн хүрээнд заагаад өгчихсөн байх жишээний. Тэгээд ер нь бол одоо бас энэ бүс нутгийн соёлын аялал жуулчлал гэдэг хөгжлийг одоо бид нар бас анхаарах ёстой байгаад байгаа юм. Ялангуяа энэ говийн бүсийн аялал жуулчлал дээр бол тусгайлан анхаарах ёстой гэж би бас ингэж хардаг.

Одоо говийн бүсэд бол ерөөсөө аялалд соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх ийм бололцоо нөхцөлүүд нь маш их хумигдаж байгаа. Ер нь яагаад гэвэл одоо уул уурхайтай холбоотойгоор энэ үздэг хардаг зүйлүүд маань одоо үндсэндээ уул уурхайн хөлд бас автаад ер нь одоо булш бунхан ухдаг, тоногддог, дээрэмддэг ялангуяа одоо энэ эртний сүм хийдүүдийн туурь тэр чигтээ устаж үгүй болж байгаа гээд ингээд олон зүйлийн зөрчлүүд бас их үүсэж байгаа.

Ийм учраас бид нар одоо зөвхөн одоо аялал жуулчлалыг хөгжүүлж байна гээд нэг хэсэг гадаадын аялал жуулчдыг авчраад одоо Тэрэлж үзүүлээд ингээд явдаг тэр одоо хэрэгцээ чинь бол одоо орхигдсон. Тийм учраас шинэ түвшинд гаргахын тулд бид нар тусгайлан бүс нутгийг хөгжүүлэх ийм аялал жуулчлалыг бол одоо сонгож хийх ёстой гэж ингэж бодож байгаа. Тэгэхээр энэ одоо хуулиудтай энэ одоо хууль чинь хэр зөрчигдөж байгаа вэ би бол зөрчигдөж байна гэж бас харж байгаа, зохицолдлогоо нь юу байгаа юм? Соёлын аялал жуулчлалтай, Соёлын өвийг хамгаалах тухай хуультай.

Бас дээрээс нь тусгай хамгаалалттай газар нутгуудын тухай хуультай ер нь дүйцэж байгаа зүйл нь юу байгаа вэ? Энэ дээр одоо манай ажлын хэсгийнхэн яаж ажилласан юм. Тухайлбал манай Байгаль орчны яам одоо бас яаж ажилласан юм бэ гэдэг дээр ерөнхий одоо бас асуулт тавья.

Тэгээд энэ дээр хариулт өгчих үү?

Г.Занданшатар: Байнгын хороон дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Мөнхцэцэг гишүүний эхний асуултад нь хариулчихъя.

Энэ бас бусад Байнгын хороогоор явах ёстой байсан юм биш үү? Эдийн засгийн байнгын хороогоор орсон нь зөвхөн эдийн засгийнх нь ач холбогдлыг түлхүү өгөөд байгаа юм уу гэсэн агуулгаар асууж байгаа юм байна гэж ойлголоо. Хуулийн үзэл баримтлал бол дунд бол байгаа эдийн засгийн үр өгөөжийг одоо нэмэгдүүлнэ ээ гээд байна аялал жуулчлалын салбарын. Тэгээд бид нар өнөөдрийн ямар нэгэн хууль хийхдээ бас практик амьдрал бодит амьдралаа сайн харах хэрэгтэй. Мэдээж энэ аялал жуулчлал гэдэг юмыг ингээд бүх юмтай хамруулбал хамрахгүй хүрэхгүй салбар гэж байхгүй.

Тийм учраас бол өнөөдөртөө бид нар яг энэ бодит аялал жуулчлал гэдэг юм хөгжүүлэхэд бид нарт өнөөдөр ямар ашиглаж болох нөөц бололцоо байгаа юм бэ гэдгээ харж энэ үзэл баримтлал гарсан гэж ойлгож байгаа. Энэ нь бол одоо байгаль, түүх, соёлын өвдөө тулгуурлана гээд. Тэгэхээр бид нарт байгаа баян юм бол түүх, баян юм бол соёлын өвүүд байгаа. Тэгээд эд нарыгаа бид нар яаж харин эдийн засагжуулах вэ гэдэг дээр энэ хууль бол анхаараад эндээ бид нар, энэ гол соёлын өв тэр уламжлалт мал аж ахуйгаа эрхэлж байгаа энэ малчин нүүдлийн соёл аж ахуйгаа авч байгаа малчин энэ ард түмнийхээ бас энэ аялал жуулчлалын салбарын энэ бизнест оролцох боломжийг нь гол нь нээж өгөх гэсэн ийм одоо агуулгатай ийм хууль болсон.

Цаашидаа бол мэдээж энэ хууль маань одоо бусад салбарууд жишээлбэл түрүүний Чинбүрэн гишүүний яриад байгаа шиг эрүүл мэндийн салбар, ингээд

бусад салбаруудын ажлууд одоо хамраад өргөжөөд бид нарт тийм нөөц бололцоо нь бий болоод үнэхээр тэрний тэр аялал жуулчлалыг татах одоо эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх том хүчин зүйл болоод ирэх юм бол мэдээж энэ нь гол ач холбогдол өгөөд явна.

Тийм учраас бол энэ бол одоо яг өнөөдөр бодит бидэнд тулчихсан байгаа. Энэ жил хүртэл одоо энэ байгаль аялал жуулчлалын жил гээд Засгийн газраас зарлачихсан байгаа.

Тийм учраас бол бидэнд одоо бас богино хугацаанд үр өгөөжөө өгөх ийм бодитой нөөц бололцоонуудаа дайчилж ажиллах ийм одоо үзэл баримтлалтай бас байгаа юм шүү. Тэгэхээр бол цаашид ингээд өргөн тэлээд байвал бас олон асуудлыг хамруулж орж ярьж болно. Таны тэр одоо ярьж байгаа соёлынхоо өвүүдийг бид нар одоо яаж одоо аялал жуулчлалын сайн бүтээгдэхүүн болгох вэ гэж байгаа дээр бол үнэхээр анхаарч ажиллах ёстой. Тэгээд би бол хувь гишүүнийхээ хувьд одоо Завхан аймагтаа гэхэд энэ аялал жуулчлалын бүтээгдэхүүн хийх гээд одоо энэ хувийн хэвилийнхний энэ олон улсын байгууллага, судлаачдын нөөц бололцоог татаж одоо аялал жуулчлалын бүтээгдэхүүн хийх гээд ажиллаж байгаа.

Энэ дээр туршилага судлахаар бол би бас хувиасаа бас сайхан тантай туршилагаа хуваалцаж болохоор байгаа шүү. Баярлалаа.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Энэ хуулийн төсөл бол Хууль зүйн яаман дээр боловсруулагдсан юм шүү Мөнхцэцэг гишүүн ээ. Тэгээд ажлын хэсэг байгуулагдаад яг салбарын төрийн захиргааны төв байгууллага орж ажилласан байх. Тийм учраас яах вэ цаашидаа бол ер нь энэ хууль боловсруулалт эд нар дээрээ бол яг

Засгийн газрын түвшинд бол яг энэ чанарт үг хэллэг нийцүүлэх бусад хуулиудтай нийцүүлэх асуудал дээр бол нэлээн анхааралтай бас ажиллах ёстой гэж харж байгаа.

Гагцхүү энэ хууль нь өөрөө нэн яаралтай горимоор орж ирсэн болохоор одоо бид нар ингээд хэлэлцээд явж байна аа. Гэхдээ ажлын хэсэг бол сайн ажилласан. Бид нар бол нэлээн ч олон судалгаанууд нэмж хийлээ. Хувийн хэвилийн төлөөлөлтэйгөө ч уулзлаа. Бусад төрийн бус байгууллагуудтайгаа ч уулзлаа. Тэгэхдээ энэ хуулийн гол концепт бол бид нар энэ хувийн хэвилийнхнийхээ зориулсан энэ хувийн хэвилийнхэн шийдвэрээ гаргаж явуулах хувийн хэвшил нь Засгийн газартайгаа хамтарч ажилладаг байх энэ арга хэрэгсэл үүд хаалгаа нээгээд өгчихсөн байгаа. Тэгээд таны ярьж байгаа санаа зовниж байгаа манай Чинбүрэн гишүүний ярьж байгаа тэр төрөлжсөн аялал жуулчлалыг бол яваандаа бол ингээд хөгжүүлээд яваад байх боломж нь үүд хаалгаа нээгээд өгчихсөн байхгүй юу.

Соёлын өвийг хамгаалах эд нар бол угаасаа нөгөө Соёлын өвийн хуулиараа явна шүү дээ. Тэгээд Соёлын хуулиараа бас явна. Энэ хууль хоорондын ямар нэгэн зөрчил бол байхгүй ээ. Бусад хуулиудтай бүгдийг нь нийцүүлээд явсан байгаа гэдгийг бас цохон тэмдэглэмээр байна аа. Баярлалаа.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ сайд хариулъя. 81 гүйцээж хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр бол Соёлын өвийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуультай бид нар их нийцүүлсэн. Ялангуяа аялал жуулчлалын тухай хууль дээр орсон энэ заалтууд маань түүх соёлын өвд тулгуурласан

тогтвортой аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх дэмжихтэй холбогдсон болон аялал жуулчлалын үйл ажиллагаанд төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино гээд энэ хуулийн зорилтыг бид нар томъёолсон. Томъёолол дотроо соёлын өвийн асуудал оруулсан.

5.3.3, 5.2.3 дээр бол аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох хөгжүүлэх үйлчилгээг бол аялал жуулчлалын үйлдвэрлэл буюу үүн дотроо бид нар ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн татварын тодорхой хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоо бүхий заалтууд орсон.

6.9 дээр аялал жуулчлалын байгууллага нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй соёлын биет өв буюу түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх.

Г.Занданшатар: Бат-Амгалан гишүүн байж байгаарай. Энэ 3 гишүүн 3-уулаа байж байгаа дээр төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлье. Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье.

4 дүгээр сарын 25-нд Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа, бас мөн өнөөдөр 4 дүгээр сарын 25-нд Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд, 4 дүгээр сарын 27-нд Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан нар одоо эхээс мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн одоо Одонтуяа Дангаасүрэнгийн Салдан, Баяндалайн Чимэддолгор нарын отгон хүүхэд болж, Гочоогийн Ганболд, Дамбадаржаагийн Гочоо, Агчбазарын Должин нарын 3 дахь хүүхэд болж, Бат-Амгалан, Балдоржийн Энхтайван, Базаржавын Хандсүрэн нарын ууган хүү болж эхээс мэндэлсэн. Тэгээд Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа, Гочоогийн Ганболд, Энхтайваны Бат-Амгалан нартаа төрсөн өдрийн мэндчилгээ

дэвшүүлж Монгол төрийн түшээ, ард түмний элч болсон та бүхэнд болон гэр бүлийнхэнд нь Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе өө.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Засгийн газраас энэ жилийг одоо аялал жуулчлалын жил болгосон учраас энэ дээр онцгой анхаарч байгаа, аялал жуулчлалын тоог нэмэх гэж мэрийж байгаа ийм цаг үе. Ерөнхийдөө бол одоо манайх шиг ХАА-н орны хувьд бол аялал жуулчлал маш чухал аа. Мах сүүн бүтээгдэхүүнээ гадагшаа гаргахад бол эрүүл мэндийн хорио цээр маш хүндрэлтэй байдаг.

Тийм учраас бид нар гадагшаа гаргахад байгаа хүндрэлээ хөнгөвчилье гэх юм бол гаднын жуулчныг энд авчраад хооллож ундлах асуудал хамгийн чухал. Сая жуулчин 3 сая жуулчин ирэхэд бол манай махыг бол сайхан идчихээд сайхан экспорт хийчхээд л явна шүү дээ. Тэгэхээр Монгол дотроо экспорт хийх боломж бол аялал жуулчлал учраас энийг бид нар нэлээн анхаарах ёстой. Харин би энэ Засгийн газраар орсон хуулийн маань агуулга одоо юу болчхов оо гэдэг дээр бас санаа зовоод байна л даа. Ерэн хэдэн санал хураалт болчихоор чинь одоо нөгөө шинэчилсэн найруулга маань одоо юу болчхов? Агуулга нь одоо тэгээд алдагдсан уу? Алдагдаагүй. Ер нь тэгэхдээ Их Хурлын хэлээд байгаа зөв шүү мэдээж гишүүд одоо хууль санаачлагчид үнэн. Тэгэхдээ ингээд хуулийн төслийг бүүр яг боловсруулаад нэг бүрчлэн нягтлаад ингээд сууна гэдэг бол бас амаргүй судалгаа шинжилгээ шаарддаг ийм ажил шүү дээ. Судалгаатай байж байж хийх ёстой болохоос биш зүгээр л одоо тархиндаа орж ирснээр хууль хийгээд суугаад байж болохгүй. Цаг хугацаа шаардагдана. Тэгээд энэ талаасаа одоо хэр болсныг нь би сайн

мэдэхгүй байна. Ер нь аялал жуулчлал бол Засгийн газар хийх ажил уу хийх ажил мөн. Гэхдээ эрх зүйн зохицуулалт шаардлагатай байхгүй юу.

Тийм учраас л оруулж ирээд байгаа юм шүү дээ. Байгаль орчин, аялал жуулчлал 2 эсрэг тэсрэг учраас тэнд зохицуулалт хэрэгтэй.

Тэр Чинбүрэнгийн яриад байгаа эрүүл мэнд гээд тэгэхэд бас л одоо боломжийн бизнес мөн. Одоо жишээлбэл Оросууд яаж байна вэ? Шүдээ манайд харьцангуй хямд байгаа учраас маш их шүдний эмнэлгээр ирж үйлчилгээ үзүүлж байна шүү дээ. Үгүй ээ тэрийг эрх зүйн талаас нь зохицуулж өгөх ёстой Ганхуяг гишүүн ээ. Даатгалын тогтолцоо байх уу, татварын тогтолцоо байх уу тэр эмнэлгүүдийг нь яаж дэмжих вэ гэсэн юмнуудыг хийж өгөх ёстой байхгүй юу?

Тэрнээс биш энэ Засгийн газрын хийх ажил гээд хаях юм бол энд хууль орж ирээд хэрэг байхгүй. Бүгдийг нь хийж болно. Угаасаа л засаг хийнэ шүү дээ. Тэгэхдээ эрх зүйн зохицуулалт шаардлагатай учраас тэр аялал жуулчлалд оролцож байгаа этгээдүүдийг дэмжих дэмжлэг нь эрх зүйн талаасаа зохицуулалт шаардлагатай байгаа учраас л энэ хууль чинь орж ирээд байгаа шүү дээ. Тэр талаас нь бас анхаарах хэрэгтэй. Гэхдээ л арай дэндүү л өөрчлөлт болсон байна. Энэ чинь одоо гучин хэдэн заалттай орж ирчхээд, ерэн хэдэн санал хураагдана гэдэг бол бас л одоо ямар хууль болчхов оо гэдэг дээр бас эргэлзээ төрмөөр болж эхэлж байна шүү дээ.

Тэгээд энэ дээр анхааръя. Тэр одоо яаралтай горимоор орсон гэдэг бол шалтаг биш. Чанартай л байх ёстой. Яагаад гэвэл хууль чинь хувь заяа байхгүй юу. Тухайн бизнесийн байгууллагын тэрэнд оролцож байгаа этгээдүүдийн одоо хувь хүний бизнес үйл ажиллагаанд шууд нөлөөлж байгаа эд учраас хууль бол

чамбай, маш сайн, одоо сөрөг үр дагаваргүй гарах ёстой.

Тэр талаасаа бол ажлын хэсэг нэлээн бодож анхаарч ажилласан байна. Сайн байна. Гэхдээ одоо Их Хурлын ажлын хэсгийн тэр цаг зав гэдэг бол одоо бас хайран. Тэгээд бид нар энэ хуулийн төсөл дээр нэлээн анхааралтай хандахгүй бол болохгүй нь ээ.

Тэр аялал жуулчлалын санг нь яагаад энэ хэлэлцүүлгийн явцад болиулчихсан юм уу? Би бол ингэж бодоод байна шүү дээ. Аялал жуулчлал, байгаль орчин 2 сөрөг нөлөөтэй. Тэр агуулгаараа ч гэсэн сан байх хэрэгтэй. Тэр ан амьтны асуудал. Одоо ингээд нүүрснээсээ орлогоо бүрдүүлж байгаа байгалийн баялгаасаа орлогоо бүрдүүлж байгаа үед заавал ховор ан амьтнаа алаад устгаад ингээд байх шаардлагатай юу үгүй юу? Гэхдээ хэрвээ тэрийг одоо ингэж.

Г.Занданшатар: Ганхуяг гишүүн асуултад хариулна.

Х.Ганхуяг: Даваасүрэн гишүүний саналыг бол дэмжиж байна. Ер нь бол нэн яаралтай горимоор орж ирлээ гээд бид нар нэн яаралтай хэлэлцээд байгаа юм бол бас биш ээ. Энэ өнгөрсөн жил орж ирсэн шүү дээ. Он гараад 1 сард орж ирсэн байна. Өнгөрсөн жил 12 сард орж ирлээ. Тэгээд энэнээс хойш бол бид нар бас нэлээн олон тооны хэлэлцүүлгүүд хийсэн. Бас 2, 3 байгууллагууд нэмэлт судалгаанууд хийлгэсэн байгаа. Тэгж байж бас энэ зарчмын зөрүүтэй саналууд дээр ажилласан байгаа. Яах вэ гол асуудал нь юу гэхээр энэ хууль өөрөө тэр салбарын төрийн захиргааны төв байгууллага нь өргөн бариагүй. Хууль зүйн яамнаас өргөн бариад нэн яаралтай горимоороо ороод ирсэн болохоор яалт ч үгүй одоо тэр салбарын төрийн захиргааны төв байгууллагын ажлын дэд хэсэгт нь оруулаад, саналуудыг нь аваад бусад хуулиудтай нийцэж байгаа эсэхийг нь хараад явахаас өөр арга байсангүй ээ.

Тэгээд олон зарчмын зөрүүтэй санал гарсан. Тэгээд яах вэ энэ дээр бол бид нар санал болгон дээрээ нэлээн сайн нухацтай ярилцсан. Хэрвээ та ямар нэгэн зарчмын зөрүүтэй санал дээр санал байвал бас саналаа илэрхийлэхэд бид нар бас хүлээн авч сонсоод явахад бол бэлэн байна аа.

Сантай холбоотой асуудал яагаад хасагдсан бэ гэхээр үндсэндээ нөгөө байхгүй байгаа орлогуудаар сан байгуулна гээд ороод ирчихсэн байсан. Тэгэхээр нөгөө Казиногийн хуулийг батлагдахыг хүлээх хэрэгтэй байгаа юм. Тэр чинь казиногийн орлогын тэдэн хувь, морин тойруулгын орлогын тэдэн хувь гээд ороод ирчихсэн байхгүй юу. Тэгээд Казиногийн хууль нь ч батлагдаагүй Морин тойруулгын хууль нь ч батлагдаагүй. Тэгээд ажлын хэсэг нь хэзээ оруулж ирэх юм хэзээ батлуулах юм бид нар мэдэхгүй байгаа учраас байхгүй байгаа хуулийн юман дээр үндэслээд бид нар сан байгуулах боломжгүй ээ. Эх үүсвэр нь тодорхойгүй байна гээд. Угаасаа Засгийн газрын тусгай зориулалттай сан бол эх үүсвэр нь тодорхой байх ёстой байдаг. Үндсэндээ эх үүсвэргүй сан байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас сангийн асуудлыг бол хойшлуулсан буюу энэ юунаас хассан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Эхлээд Даваасүрэн гишүүн тодруулна.

Ц.Даваасүрэн: Тэр сангийн хувьд тэр орлогуудыг нь хасчхаж болох байхгүй юу. Харин аялал жуулчлалаас оролцож байгаа орлогын жишээлбэл 1 хувийг байгаль орчинд гэдэг ч юм уу, аль эсвэл тэр одоо агнаж байгаа ангийн орлогын тэдэн хувийг гэдэг ч юм уу бас болно шүү дээ. Яагаад гэвэл би хэрвээ тэр анг агнаж байгаа бол тэр анги одоо өсгөж үржүүлэхэд нь тэр байгаль орчны

асуудалд нь тодорхой хувийг нь зарцуулах ёстой л гэж бодож байна. Тэгээд сан бол зайлиггүй байх ёстой.

Харин орлого дээр нь бол та хэд ярьж байгаад одоо дараагийн хэлэлцүүлгийн явцад жишээлбэл, аялал жуулчлалаас орсон орлогын тэдэн хувь гэж болно. Тэр ан агнуурын орлогын хувь гэж болно. Өшөө бодоод бол орлого олдоно шүү дээ. Тэгээд тэр ялангуяа байгаль орчин, ариун цэврийн, тэр бохирын байгууламжийн асуудал энэ тэрийг нь шийдэж байхгүй бол нэгдсэн зохицуулалтаар зохицуулж өгөхгүй бол тэрийг шийдэхгүй байгаа.

Байгаль орчныг жуулчин яваад өнгөрдөг баахан хогтой л үлдэж байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг Байнгын хорооны дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Даваасүрэн гишүүн тэр сантай холбоотой асуулт асууж байгаа. Бид нар бас Байнгын хороон дээр ярилцсан юм. Тэгээд ер нь энэ сан гэдэг юм бас одоо яагаад нэг хэтэрхий олдоод байна. Бас одоо энэ хэчнээн олон сан байна гээд л манай зарим гишүүд чинь шүүмжлээд байгаа шүү дээ. Тэгээд энэ сан гэдэг дээр чинь хамгийн л одоо булхайтай болохгүй юмнууд чинь яваад байгаа шүү дээ. Энэ ард түмэн харж л байгаа. Тэгээд бид нар чинь төсөвтэй. Тэгээд энэ төсвөө ингээд одоо Даваасүрэн сайд та Сангийн яамны хүн одоо тэгээд л төсөв санхүү бол одоо бүүр маш сайн мэдэж л ойлгодог л гишүүн. Тэгэхээр зэрэг бид нар ингээд төсвөө ийм олон сан болгоод ингээд энэ төсвийнхөө орлогыг ингээд тал тал тийш нь ингэж хувааж тавиад тэгээд бид нар энэ төсвийг ярилцах гэж байгаа гэдэг бол суух ч хэрэггүй л болно л доо. Тэгэх дээр бид нар бас Эдийн засгийн байнгын хорооноос нэг бодлого барья.

Эдийн засгийн байнгын хорооны гишүүд ч олонх нь дэмжиж байна лээ.

Г.Занданшатар: Даваасүрэн гишүүн 1 минут тодруулъя.

Ц.Даваасүрэн: Сан бүүр байхгүй байна гэж бас болохгүй шүү дээ тэр чинь, байж л таарна. Тэгээд хэлж байгаа шалтаг чинь бол үндэслэл биш л дээ. Үгүй ээ тэрийг зөв л байлгах асуудал. Тэр хууль хүчний байгууллагууд нь тэр удирдлагууд нь зөв авч явах л тухай асуудал шүү дээ. Тэгээд л тэр ЖДҮ-ийн сан чинь дамжуураа биз дээ.

Нэг ёсондоо ЖДҮ-ийн бизнесийг дэмжих ёстой юу дэмжих ёстой шүү дээ. Би бол энэ байгаль орчинд бол энэ сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг нь бол энэ аялал жуулчлалын орлогоор нь буцааж шийдэх ёстой л гэж бодож байна шүү дээ. Энэ жуулчны дараа чинь дандаа хог нови үлдэж байгаа. Тэгээд ялангуяа тэр ариун цэврийн асуудал. Одоо манай Хөвсгөл далай дээр хамгийн хүндрэлтэй асуудал бол бохирын асуудал байгаа шүү дээ. Тэгэхээр энэ мөнгөөр нь буцааж хийхгүй бол өөр одоо ямар орлогоор хийх вэ дээ? Төсвөөс тэр мөнгийг гаргаад хийгээд байна гэж байхгүй. Хувийн компаниуд нь хийж байгаа юм байхгүй. Тэгэхээр энэ байгаль орчны асуудлыг нь шийдэх гэж л уг нь.

Г.Занданшатар: Санал хураалтын өмнө нэг мэдээлэл байна.

Улсын Их Хурлын гишүүдэд онцгойлон анхааруулж хэлэх нэг зүйл байна. Улсын Их Хурлын гишүүд хуралдаанд хэрхэн оролцож байгаа ирц, хууль эцэслэн батлахад гишүүдийн өгсөн саналыг дэмжсэн, дэмжээгүй, хуралдаанд оролцсон эсэх, ирц идэвхийн байдлаар нэрээр нь гаргаж мэдээлж байх. Энэ төрлийн мэдээллийг нээлттэй авч байх шаардлагыг энэ ТББ, иргэдээс олон давтамжтай Улсын Их Хурлын дарга

дээр болон Тамгын газрын нэр дээр ирүүлж байгаа.

Энийг бол одоо бид судалж үзэхэд хууль зүйн хувьд энэ хаалттай мэдээлэл учраас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй олон нийтэд мэдээлж байгаа мэдээлэлд хамаарч байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 17 дугаар хэсэгт Монгол Улсын иргэн нь төр түмний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх хүлээн авах эрхтэй гэж заасан.

Тийм учраас энэ мэдээллийг шаардах авах эрхтэй байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан.

Ийм учраас гишүүдийн хууль батлахад өгсөн саналын мэдээлэл нь нууцад хамаарахгүй ээ. Харин Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль түүнийг дагалдуулж гаргасан журмын зарим заалтуудад бол хуралдааны тэмдэглэлийг албажуулах нийтлэх, архивд шилжүүлэх хугацаа гээд зарим нэг хүндрэлтэй асуудлууд байдаг юм байна. Тэгээд энийгээ одоо Улсын Их Хурлын Тамгын газарт цэгцэлж олон нийтэд ил тод болгохыг үүрэг даалгавар болж байна. Дэгийн тухай хуульд шаардлагатай бол одоо хуульд өөрчлөлт оруулж болно. Жишээлбэл Дэгийн тухай хуульд санал хураалтын дүнг нэрээр биш, тоо хувиар, хуралдааны товч тэмдэглэлд тусгана гэж заасан байгаа юм. Тэгээд хуралдааны тэмдэглэл нээлттэй байдаг. Архивд шилжих гэж тэрийг чинь шивж

оруулна, хянана, редакторлана, засна, тэгээд нэг сарын дараа архивд шилждэг. Архив нээлттэй байдаг. Тэгээд ийм хугацааны ийм зөрүү гараад байдаг учраас бас төрийн бус байгууллагуудаас тэр дор нь авч байх ийм шаардлага гараад байдаг. Энэ бүхэн чинь төрийн протоколын нарийн үйл явц байх учраас бүгд нягтлан шалгагдаж байх. Ёстой ийм процедурын асуудлууд байна. Хуралдааны тэмдэглэл дуу дүрсний бичлэгтэй гишүүд Тамгын газрын ажилтнууд бол шууд бусад байгууллагын ажилтан, албан тушаалтан, Тамгын газрын ЕНБД-ын зөвшөөрснөөр архивтай танилцаж болно гэж заасан байдаг юм байна. Заавал зөвшөөрөл авч архивтай танилцдаг ийм журам байна.

Тэгэхээр энэ журмыг өөрчлөх хэрэгтэй. Мөн хуралдааны тэмдэглэл хөтлөх журмаар тэмдэглэл нь хууль одоо эцэслэн баталсан даруйд биш зохих хяналтын шатыг дамжсаны дараа нөгөө ёсчилсны дараа нэлээд хугацааны дараа албаждаг юм байна. Тиймээс шаардлагатай бол энэ мэт журамласан заалтуудад өөрчлөлт оруулаад ингээд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиа хэрэгжүүлж эдгээр мэдээллийг ил тод байлгах шаардлагатай гэж үзэж байна.

Өнөөдрөөс эхлээд гишүүдийн ирцийн мэдээ хууль эцэслэн батлахад өгсөн саналын мэдээллийг ил тод болгож одоо иргэний мэдэх эрхийг хангахыг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газарт үүрэг болгож байна аа.

Гишүүд үүнийгээ одоо бас онцгой анхаарч ажиллавал зохино оо. Иргэд, олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллагуудын зүгээс хууль болгоноор өгсөн санал дэмжсэн, дэмжээгүй, эцэслэн батлахад өгсөн саналыг одоо шаардаж байгаа. Мааш олон иргэдийн хүсэлт бичиг ирсэн. Иргэдийн өргөдөл гомдлууд ирсэн.

Ингээд одоо ирцийн мэдээ, хууль эцэслэн батлахад өгсөн саналууд одоо ард түмэн сонгогчид нээлт илт тод мэдээлдэг энэ журам зарчимд шилжиж байгааг анхааруулж байна. Бас төрийн бус байгууллагууд бас энэ үүрэг чиглэл энэ мэдээллийг өгөхийг Тамгын газарт үүрэг болгож байна.

Ингээд санал хураалтдаа оръё.

Зун боллоо, аялал жуулчлалын сезон эхэллээ.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн горимын санал.

Б.Пүрэвдорж: Аялал жуулчлалын хуулийн өөрчлөлт одоо 33 зүйлтэй орж ирсэн боловч, 88 зарчмын зөрүүтэй санал гарсан байна. Тэгэхээр энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл яам, Тамгын газарт очсон дарга нар дандаа одоо хүнээ өөрчилдөг, мэргэжлийн хүмүүсийг байхгүй болгодог. Тийм учраас одоо ийм зөрчилтэй өөрөөр хэлбэл одоо хууль хоорондын зөрчилтэй дээрээс нь одоо асуудлыг зохицуулж чадаагүй ийм одоо муу хуулийг оруулж ирж байна аа.

Тийм учраас энэ АН энэ 33 зүйлтэй хууль дээр 88 өөрчлөлт одоо зарчмын зөрүүтэй санал гаргана гэдэг бол үнэхээр одоо Улсын Их Хурлын энэ Тамгын газрын ажилтнууд маш сайн ажилласан байна, ажлын хэсэг сайн ажилласан байна. Хууль хоорондын зөрчлийг нь арилгасан байх мэдээж.

Тэгэхдээ бид манай Ардчилсан нам бас энэ асуудлыг нягтлан гаргах зорилгоор 7 хоногийн завсарлага авч байна аа.

Г.Занданшатар: Та бүлэг төлөөлөх эрхтэй байгаа юу?

Эхлээд зочид танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд,

Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Эрдэнэ сумын ЕБС-ийн 12 дугаар ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Эрхэм хүндэт багш сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилт хүсэж сурах чиглэлийг эрхэм болговоос хандах зүг чинь өөрөө тогтоно шүү гэдгийг эрхэмлэн захиж хэлмээр байна аа. Тэгээд амжилтын үндэс бол мэдлэг, дадал, хичээл зүтгэл 3 болой. Үүнийг анхаараарай гэж хүсье. Эрдэнэ суманд чинь би бас одоо таньдаг хүүхдүүд ч байж магадгүй юм байна.

Завсарлага өгөх болчихлоо. Ирэх 7 хоногийн ажлын хуваарь энэ тэрийг харгалзаад аялал жуулчлалын сезон эхлэх гээд байна л даа. Ирэх 7 хоногт Үндсэн хууль энэ тэр хэлэлцээд эхэлбэл ингээд 1 хоногийн л завсарлага өгье. Энэ хугацаатай шахуу асуудал учраас. Тэгэхдээ байна шүү дээ хууль зүйн техникийн хувьд ажлын хэсэг ч тэр БОАЖЯ ч анхаармаар юм их байна лээ. Жишээлбэл аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж байгаа юм. Энэ дээр зочид буудал, жуулчны бааз, амралтын газар, хоол үйлдвэрлэл, жуулчны бусад төрлийн жуулчны байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг гээд тоочиж заах гээд байгаа байхгүй юу. Дээрээ аж аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ тодорхойлчихсон бол аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгчийг эрхлэх хуулийн этгээдийг аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж хэлнэ ээ гээд л тодорхойлчихвол болно.

4.1.4-т заасан энэ бүтээгдэхүүн үйлчилгээ эрхэлдэг байгууллага бол тийм байна гээд заачихна. Тэгэхээр чинь ингээд үзмэр үйлчилгээгээ дэмжиж байгаа юм. Тэгээд соёлын үйлчилгээ байж болно. Тэр нь биш болох юм уу? Урлагийн үйлчилгээ байж болно тэр нь бол болох юм уу? Заавал бүх хоолны газрууд ресторанууд

тэгвэл аялал жуулчлалын байгууллага болж хувирах юм уу энэ тэр гээд. Тэгэхээр энэ аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж байгаа чинь л аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага болгох жишээтэй. Гэх мэтчилэн ингээд хууль зүйн техникийн хувьд хялбаршуулах гээд хүндрүүлчихсэн. Тэгээд тэр сан энэ тэр дээр нь бичиж байгаа юмнууд нь бас өргөн барьсан төсөл дээрээ ч гэсэн Байнгын хорооны ажлын хэсгийн санал дээрээ ч гэсэн ингээд уншаад үзэхээр аялалын агент нөгөө 3 юмаа тодорхойлох тэгээд цаашаа юмнууд явж байна гээд аягүй тийм тоочихоор чинь бусад юм нь хасагдчихдаг байхгүй юу. Ерөнхий байж хуулийг чинь тодорхой заалтуудаар журмаар зохицуулах юмнууд байна. Ингээд ер нь бас Пүрэвдорж гишүүний хэлж байгаа зөв шүү. Энэ 43 зүйлтэй санал дээр 96 санал хураагдаж байна гэдэг чинь одоо энэ чинь бараг зүйл заалт болгон дээр 2 санал шахуу хураагдчихаж байгаа байхгүй юу. 70 санал байна лээ л дээ. Яах вэ бусад 26 дагасан хуулиуд дээр. Тэгээд энэ бол бас л хуулийн чинь чанарыг харуулж байна. Хуулиа чанартай оруулж ир, завсарлага өглөө 1 хоногийн хугацаатай маргааш хүртэл завсарлага.

Тэр хооронд энэ Байнгын хороо ахиж үзээд энэ юмнуудаа нэг цэгцлээдэх.

11.13 цаг

Дараагийн асуудалдаа орёе оо.

Энэ сайд нь байхгүй авто замчдын хуралдаан болж байгаа учраас энийг энэ Төмөр замын тээврийн тухай хууль дээр байгаа нөгөө нэг хувь нийлүүлэгч талын 1 маргаантай асуудлыг олон улсын гэрээгээр зохицуулна гээд зохицуулчихсан гэж ойлгосон. Тийм ээ Бат-Эрдэнэ асуудалгүй биз. Сүүлд нь ингээд төмөр замын тээвэр хаагдчихвал эрсдэл гарахгүй биз. Баталгааг нь та гаргана шүү.

Ингээд Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаар явуулж, Байнгын хорооны санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудын хамт Улсын Их Хурлын 2023 оны 4 дүгээр сарын 6, 7-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан билээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооны хуралдаанаар дахин хэлэлцүүлэх горимын санал гаргасныг нэгдсэн хуралдаанаар оролцсон гишүүдийн олонх дэмжиж хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулахаар Эдийн засгийн байнгын хороонд буцаасан.

Байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах үед хуулийн төслийн зарим нэр томъёоны

тодорхойлолтыг тодорхой болгож болгох төмөр замын суурь бүтцийн төр хувийн хэвшлийн түншиллээр барих тохиолдолд түншилэлийн гэрээнд суурь бүтцийн төрийн өмчлөлд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг зайлиггүй тусгаж өгөх. Энэ хугацаанд суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч нь тээвэрлэгчийн үйл ажиллагааг давхар эрхлэх эрхэлж болох зохицуулалтын төсөлд нэмж зохицуулалтыг төсөлд нэмж тусгах зарчмын зөрүүтэй саналыг нь томъёолоод ажлын хэсгээс бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Дээрх Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны төсөл, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналуудыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Дагвын ЖавхланЗам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Усан замын тээврийн хэлтсийн дарга, Сүхээгийн МяндасмааЗам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Хүчитбаатарын ИтгэлтЗам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам далайн тээврийн Бодлогын хэрэгжилтийг

зохицуулах газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, Далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Лхамрагчаагийн Булганхүү. Манай улс ч бас өөдрөг улс шүү. Далайд гарцгүй ч гэсэн ингээд 3 дарга нь 3-уулаа далайн тээврийн асуудал хариуцдаг байх юм. Төмөр замаа хөгжүүлдэг.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулна аа. Байнгын хорооны санал, дүгнэлт Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Зарчмын зөрүүтэй 36 санал байгаа.

Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “бусад байгууламж” гэсний өмнө “салбар зам,” гэж нэмэн, мөн заалтын болон 4.1.2 дахь заалтын “технологийн” гэснийг хасаж, 4.1.9 дэх заалтын “зам талбай, хүлээн авах, олгох, хадгалах үйлчилгээ үзүүлэх” гэснийг “, хадгалах зам талбай” гэж, 4.1.24 дэх заалтын “аюулгүй байдлыг хангах хатуу бүртгэл, дугаар, хяналттай ашиглах” гэснийг “аюулгүй байдлыг хангахад ашиглах” гэж тус тус өөрчлөх

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Амгалангийн Адьяасүрэн, Энхтайваны Бат-Амгалан, Баагаагийн Баттөмөр,

Болдын Жавхлан, Мөнхөөгийн Оюунчимэг, Содномын Чинзориг. Цаашид ажлын хэсэг гэнэ ээ.

Г.Занданшатар: Санал хураалт явуулахад бэлэн үү? Эрхэм гишүүн Хассуурийн Ганхуяг суудалдаа сууж саналаа өгье.

Цэдэндамбын Цэрэнпунцаг Байнгын хороон дарга, Хассуурийн Ганхуяг санал хураах гээд байна. Санал хураалт.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт буюу “нийтийн зориулалттай төмөр зам”, 4.1.8 дахь заалт буюу “тусгай зориулалтын төмөр зам” гэсэн нэр томъёог доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд тусгагдсан эдгээр нэр томъёог тохиолдол бүрд нийцүүлэн өөрчлөх:

“4.1.7. “нийтийн төмөр зам” гэж нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий төмөр замын суурь бүтцийг;

4.1.8. “үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зориулагдсан төмөр замын суурь бүтцийг;” санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Зам, тээврийн хөгжлийн яам тэр далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах гэдэг үгээ аваарай за юу. Энэ төмөр замаа яая гэж байж одоо далайн тээврийг зохицуулах гээд. Ямар олон.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтыг хасаж, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “өмчлөгч” гэсний дараа

“, эзэмшигч нь” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “30 дугаар зүйлийн 30.1-т заасан хилийн бүсэд” гэснийг “26.1-д заасан хилийн зурваст” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлнэ. Дэмжсэн дэмжээгүй үг хэлж болно.

Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Сая тэр түрүүн хураагдаж байгаа юун дээр ажлын хэсэг анхаарахгүй бол одоо ингээд сүүлдээ хувийн компанийн төмөр зам гэсэн ийм юм орж ирвэл энэ чинь болохгүй шүү. Нийтийн байгууллага сая компанийн төмөр зам гээд нэг юм да баталчихлаа шүү дээ. Тэгж болохгүй шүү дээ. Сая би тэгж ойлгосон шүү. Үйлдвэрлэлийн зориулалттай компанийн гэж тэгж тэгж байж болохгүй шүү. Үйлдвэрлэлийн гэвэл хаашаа байдаг юм тэ. Үйлдвэрлэлийн зориулалт.

Г.Занданишатар: Энийг одоо маш олон удаа л анхааруулж анхааруулж л өнгөрсөн хэлэлцүүлгийг хойшлуулсан шүү дээ.

Тэгээд анхны хэлэлцүүлэгт нь буцаасан юм.

Үгүй ээ би компанийг гээгүй үйлдвэрийн зориулалттай төмөр зам гэсэн. Компанийн гэдэг нь ингээж

унишигдаж байгаа юм. Үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам гэж ААНБ-ын үйл ажиллагаанд зориулагдсан төмөр замын суурь бүтцийг. Энэ төсөл дээрээ тусгай зориулалтын төмөр зам гэж байсан юм. Тусгай зориулалтын төмөр зам гэж төмөр замын суурь бүтэц бүхий ААНБ-ын үйл ажиллагаанд зориулагдсан гэрээний үндсэн дээр нийтэд тээврийн үйлчилгээ үзүүлэх төмөр замыг гэж байсан юм. Суурь бүтцийг улс өмчлөх үү, компани өмчлөх үү гэдэг чинь суурь асуудал шүү дээ.

Салбар зам гэж тусдаа байгаа л даа.

Санал хураалт.

55.8 хувиар дэмжигдлээ.

Бас хуучнаараа үлдэхээр бас болохгүй болчихоод байгаа юм. Төслөөрөө бас болохгүй болчихоод байгаа юм.

5. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 7.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.5, 14.1.6 дахь заалт, 14.4 дэх хэсэг болон 14.3 дахь хэсгийн “, 5.12, 5.13” гэснийг тус тус хасаж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “14.1.2-14.1.6-д” гэснийг “14.1.1, 14.1.2, 14.1.3, 14.1.4-т” гэж, 14.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадвартай эсэх, төмөр замын объект, үйл ажиллагаанд тавигдах” гэснийг “энэ хуулийн 14.3-т заасан” гэж тус тус өөрчлөн, 14.1.1 дэх заалтын “суурь бүтэц барих” гэсний дараа “, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Тэгэхдээ энэ Казахстан ийм замаар яваад баларсан шүү дээ. Казахстаны загварыг л авч байгаа юм байна л даа. Энэ заалт уначихлаа. Унаж

болохгүй заалт гэж юу байх вэ. Та 2 нь ирцэд орсон юм уу? Хишигээгийн Нямбаатар гишүүн үг хэлнэ.

Х.Нямбаатар: Саяын хураасан саналыг хүчингүй болгох санал хураалт явуулж өгөөч. Сая би ирцэд орчхоод байхад 2 талд хоёуланд нь гарахгүй байна. Тэгээд би дахиад сая уншууллаа.

Тийм учраас дахин санал хурааж өгөөч.

Г.Занданшатар: Нямбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Наадах чинь Засгийн газрын бүрэн эрхэд орчхож байгаа юм. 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд хүчингүй болгох санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя.

Тав дахь санал хураалтыг карт чинь болох гэж байна 59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “ашиглах зөвшөөрлийг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ яаж байгаа юм. Энэ түгээмэл тархацтай ашигт малтмал энэ хайрга дайрга олборлох зөвшөөрөл чинь орон нутгийн Засаг дарга олгодог юм шүү дээ. Зөв шүү дээ. Энийг чинь хасчихлаа шүү дээ. Онцгой нөхцөл байдал л юм байна л даа. Төмөр замын аюулгүй байдал алдагдсаны улмаас гээд.

Тэгэхээр аюулгүй байдал алдагдлаа гээд л хор уршигийг арилгана гээд л өөрсдөө олборлоно гэсэн үг болчих юм уу. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр хянаж үзэх хэрэгтэй. Аюулгүй байдал алдагдсан

гэдгийг хэн тогтоох юм. Үгүй ээ тэгээд тэр дураараа аюулгүй байдал алдагдлаа гээд л мод, ус, түгээмэл тархацтай ашигт малтмалыг дур зоргоороо ашиглах эрх олгоно шүү дээ энэ чинь. Үгүй ээ бороо ус гэж энд чинь алга байна л даа.

Одоо тусгай зориулалтын төмөр зам гэдгээ үйлдвэрлэлийн зориулалттай төмөр зам болгочихсон. Бусад газрууд нь тэр чинь найруулгын засвараар авах юм чинь.

6 дахь санал дэмжигдсэн.

7. Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.27 дахь заалтын “төмөр замын тээвэр зуучлалын” гэснийг хасаж, 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.2.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2, 11.1.3-т заасан дүрэм, 11.1.4, 11.1.5, 11.1.7, 11.1.8, 11.1.9, 11.1.12, 11.1.14, 11.1.17, 11.1.25, 11.1.27-д заасан журам, 11.1.20-д заасан аргачлал, 11.1.21-д заасан нормыг төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, энэ хуулийн 11.1.6, 11.1.10, 11.1.11, 11.1.13, 11.1.16, 11.1.18, 11.1.19-д заасан журмыг төрийн захиргааны байгууллага тус тус батална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ төмөр замын тээврийн дүрэм журам тохирлын үнэлгээ энэ заалт дээр нийтдээ 27 журам одоо батлах тухай асуудал байгаа салбарын сайд. Тэгэхээр энэ ер нь бол ялангуяа одоо энэ төмөр замаар ачаа тээвэрлэх төв 11.1.2 байгаа 11.1.3 төмөр замаар зорчигч тээш ачаа тээш тээвэрлэх дүрэм. Энэ дүрмийг салбарын сайд баталснаас болоод аливаа одоо нөгөө нэг иргэн, ААН-үүд хохирсон тохиолдолд энийг шүүх дээр очоод маргаан үүсгээд явахаар шүүх энийг ерөөсөө авч хэлэлцдэггүй.

Яагаад гэвэл иргэний хэргийн, иргэний хэрэг шийдвэрлэх тухай хуулийн 3.5 дээр ямар заалт байдаг вэ гэх дээр Засгийн газрын баталсан дотоод журам, одоо эрх зүйн актыг шүүх хэрэглэж болно.

Гэтэл нөгөө энэ салбарын сайдын баталсан дүрэм журмыг шүүх хэрэглэдэггүй байхгүй юу даа.

Тийм учраас шүүх ер нь иргэний талд, ААН-ийн талд ерөөсөө шийдвэр гаргадаггүй. Ингэж хохирч үлдэх тохиолдлууд байгаад байгаа юм. Тийм учраас энэ 11.1.2-ын төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм, төмөр замаар зорчигч тээш ачаа тээш тээвэрлэх дүрмийг Засгийн газраар батлуулах ийм журмын заалтад оруулах зайлиггүй шаардлагатай байна.

Яагаад гэвэл энэ салбарын сайдын эрх зүйн акт, гаргасан эрх зүйн актыг шүүх ерөөсөө хэрэглэдэггүй байхгүй юу даа. Тэгээд бусад нөгөө нэг 27 журмын чинь 25 нь бол яг энэ төмөр замын дотоод асуудалтай холбоотой журам учраас энийг салбарын сайд батлаад яваад байж болно. Хамгийн гол нь одоо иргэн, ААН-үүд хохирсон тохиолдолд салбарын сайдын гаргасан дүрэм, журмыг одоо шүүх авч хэлэлцдэггүй учраас энийг зайлиггүй Засгийн газраар батлуулах шаардлага байна аа. Тэгж байж энэ нөгөө нэг шүүх дээр хэрэг маргаан үүслээ гэхэд үгүй адлах юм биш шүү. Энэ Иргэний хуулийн 3.5-ыг та нар анхааралтай сайн уншиж үзээрэй. Энэ дээр чинь Засгийн газрын гаргасан эрх зүйн актыг шүүх авч хэрэглэнэ ээ гэсэн ийм тодорхой заалттай байгаа. Энэнээс болоод одоо иргэн ААН-үүд хохирдог тохиолдол байгаа юм. Энэ дээр нэгэнт одоо ингээд асуудал ороод ирчихсэн учраас энийг бас 2 дахь хэлэлцүүлэг явахад нь бас тодорхой анхаарч үзэх чиглэлийг Их Хурлын даргаас одоо Байнгын хороонд өгүүлмээр байна.

Хоёрдугаарт нь энэ хуультай холбоотой нэлээн нэлээн асуудлууд бас яг энэ Ардчилсан намын бас тодорхой бодлого шийдвэрт нийцээгүй мөн бодол энэ талаар одоо энэ хууль дээр саналууд аваагүй хэт нэг өнцгөөс бэлтгэсэн ийм одоо тал байна. Тийм учраас 5 хоногийн завсарлага авъя аа.

Г.Занданшатар: Тайлбар гэж байхгүй л дээ. Энэ ер нь эрх зүйн актын хувьд бол Пүрэвдорж гишүүний хэлж байгаа зөв л дөө. Хууль зүй, дотоод хэргийн яам баталж Засгийн газраар хэлэлцэж байж энэ эрх зүйн актад тооцогдож энэ төмөр замын аюулгүй байдалтай холбоотойгоор ер нь бол.

Тэгээд тэр тусгай тээвэрлэлтийн журам, тусгай ачаа тээвэрлэх төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх журам ачиж буулгах харилцааны журам энэ тэр чинь тусдаа харилцаа шүү дээ. Ингээд Ардчилсан намын бүлэг завсарлага авах эрхтэй завсарлага авъя. Хугацаагүй.

Энэ хуулийн юмнууд энэ Төмөр замын тээврийн хуулийг бас. Завсарлага өгсөн. Ямар ч байсан маргааш хүртэл 1 өдрийн завсарлага өглөө маргааш хүртэл.

Ахиад ярьж байгаад тав хоног ч болгож магадгүй. Наадах чинь бас их маргаантай юмнууд их байна аа.

Төмөр замын хойд талын тээвэр чинь бүрэн гацчихсан байгаа. Тэгээд бүр зогсох аюул л эрсдэл байгаа шүү.

11.41 цаг

Ингээд дараагийн асуудалд орно оо.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын

хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарим заалт болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих боломжгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих боломжгүй талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналаа тус тус тайлбарласан болно оо.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж, Г.Тэмүүлэн, Б.Энхбаяр нараас гаргасан зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг оруулъя.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт явуулна аа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй 16 санал байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Тэмүүлэн гишүүн өөрөө алга байна. Санал хураалт явуулна.

Санал хураалт. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал. Бямбасүрэнгийн Энх-Амгалан.

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны дарга. Энэ миний төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр энэ саналыг хүчингүй болгох санал хурааж өгөөч.

Г.Занданшатар: Хүчингүй болгох санал гаргаж байгаа юм байна.

Санал хураалт Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулья. Энх-Амгалан гишүүний аргасан хүчингүй болгох горимын саналыг 59.5 хувийн саналаар дэмжиж, санал дэмжигдлээ.

Энэ санал дэмжигдсэн учраас саяын саналаар дахин санал хураалт явуулья. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн. Санал хураалт 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг” гэснийг “14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэг” гэж өөрчилж, мөн зүйлийн 3 дахь заалт болгон шилжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 26¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26¹.2.Хуулийн үйлчлэх хугацааг тухайн хуульд зохицуулсан тохиолдолд тус хугацаа дуусмагц хууль хүчингүй

болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 29.2 дахь хэсгийн “хариуцлагын төрөл, хэмжээ” гэснийг “хариуцлага” гэж өөрчилж, мөн заалтын 29.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт.

Энэ чинь нөгөө юу яахгүй бол хууль дагалдуулж анхдагч болон шинэ хууль дагалдуулж өргөн бариад байсныг л больж байгаа юм л даа тэ? Тийм хүзүү дагуулаад гуя болоод байсан байхгүй юу.

Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 33.7 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол энэ хуулийн 40.1.2, 40.1.3-т заасан баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж, хамтад нь байршуулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт.

Энэ нөгөө Ил тод байдлын гэрээний заалтыг хэрэгжүүлж байгаа юм.

7. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46¹.1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46¹ дүгээр зүйл.Хууль тогтоомжийн орчуулга хийх

46¹.1.Шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн орчуулгыг англи хэлээр хийнэ.

46¹.2.Хууль тогтоомжийн орчуулгын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

46¹.3.Хууль тогтоомжийн орчуулгын санг бүрдүүлэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

46¹.4.Энэ хуулийн 38.4-т заасан хууль тогтоомжийн орчуулгыг тухайн хууль тогтоомж батлагдсанаас хойш 90 хоногийн дотор эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Энэ шаардлагатай тохиолдол гэхээр чинь тэгээд ямар тохиолдлыг шаардлагатай гэж үзэх вэ? Тэгвэл шаардлагатай тохиолдол гэж хэлэхгүй яг тэрийгээ заачихвал уул нь эцсийн найруулга дээр тэрийгээ анхаараарай гэж чиглэл өгч байна.

Яагаад гэхээр тийм яг тэр нөгөө нэг хөрөнгө оруулалт бизнесийн орчинтой хууль тогтоомжийн орчуулгыг хөрөнгө оруулалт, гадаад дотоодын хөрөнгө оруулалт гэсэн агуулгаар бичихгүй бол шаардлагатай тохиолдол гэх юм бол бүх хууль орчуулагдахгүй, шаардлагагүй л гэж үзэж байна тийм үү?

Санал хураалт. Эцсийн хэлэлцүүлэг дээр тэрийгээ тэгээд анхаарчхаарай. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төслийн 2 дугаар зүйлийн “11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “гарах” гэсний дараа “болон хуулийн албан бус орчуулгын” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт. Энэ чинь үнэхээр одоо Засгийн газрын хууль санаачилж гишүүд хууль санаачилсан байсан.

Энхбаяр дарга аа. Таслан зогсоохоос гадна Энхбаяр дарга Нямбаатар сайд хоёр нэг ийм юмыг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарчхаарай. Энэ Үндсэн хуульд нөгөө хууль санаачлах хүрээ хязгаарыг тогтооно гээд. Их Хурлын тухай хууль дээр татвар өмчтэй гэж байгаа юм. Өмчтэй холбоотой асуудлыг өмч хувьчлал шиг асуудлыг бол зөвхөн Засгийн газар санаачилна гэж байгаа юм.

Тэгээд одоо зарим тохиолдолд гишүүд ч юм уу өөр субьектээс өмч хувьчлалын шинж чанартай өмчийг шилжүүлэх асуудал санаачилж орж ирээд байгаа байхгүй юу. Тэрийг энд хориглочихвол бас сайн байна. Тэгээд агуулгын хяналтыг сэргээчихвэл сайн байна нэг газар заалт оруулаад. Агуулгын хяналтыг. Хуучин агуулгын хяналт байсныг хасчихсан юм шүү дээ тэ. Тэрнээс чинь болоод нэг бөөн маргаан дэгдэх юм. Их Хурал хүлээж авна, хүлээж авахгүй гээд л.

Санал хураалт дэмжигдсэн.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт.

Шинэчилсэн найруулга. Өмч бол өмчийн харилцаан дээр бол анхдагч хууль энэ тэр гэж байхгүй учраас. Өмч дээр бол өөр байх юм байна лээ. Тийм өмч хувьчлал гэхээр бол авхуулчхаад байгаа юм. Өмч хувьчлалыг бол Улсын Их Хурлын гишүүд чинь бас өөр субъект санаачлах нь зохимжгүй юм. Засгийн газраас санаачилна. Өмч хувьчлал шиг харилцааг.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг, мөн зүйлийн 3 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу” гэснийг, мөн хэсгийн “энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу нийгмийн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр Энхбаяр.

Санал хураалт 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Адьяасүрэн, Бямбацогт гишүүд анхаараарай. Санал унаад байна шүү.

11.Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 12.2.10 дахь заалтын “6.3-т” гэснийг “6.3, 6.4-т” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12. Төслийн 6 дугаар зүйлийн “9 дүгээр зүйлийн” гэсний өмнө “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг,” гэж нэмэх. Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт 58.5 хувийн саналаар санал дэмжигдэнэ.

Эцэст нь одоо найруулгын санал. Найруулгын саналын өмнө Хууль зүйн байнгын хорооны даргад бас өгөх чиглэл санал байна. Нямбаатар сайдтай бас хэдүүлээ уулзаад завсарлахаар. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй холбоотой асуудлыг хууль зүйн нэр томьёо, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн харьяаллыг Улсын Их Хуралд байх Улсын Их Хурлын Хууль зүй, дотоод хэргийн яамны дунд энэ хууль боловсруулах ажил одоо гишүүдийн энэ хууль боловсруулахтай холбоотой харилцаа энэ тэр дээр бас хамтарч оролцдог хэлбэрээр зохион байгуулалтын ямар нэг бололцоо байгааг.

Энийг эцсийн хэлэлцүүлэгт анхаарна уу.

Ингээд найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15.11 дэх хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд” гэснийг, мөн заалтын 15.12 хэсгийн “үзэл баримтлалын төслийг” гэснийг, мөн зүйлийн 7 дахь заалтын 30.8 дахь хэсгийн “боловч өөр бичилттэй тухайн” гэснийг, 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 51.1 дэх хэсгийн “байдлаар” гэснийг тус тус хасаж, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 22.3 дахь хэсгийн “22.2-т” гэснийг “14.4-т” гэж, мөн хэсгийн “хууль” гэснийг “төсөл” гэж, 3 дугаар зүйлийн 10 дахь заалтын 49.5 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж, мөн зүйлийн 12 дахь заалтын 52.1

дэх хэсгийн “хууль тогтоомжид зохих” гэснийг “түүнд” гэж, мөн хэсгийн “хууль тогтоомжийг системчлэн” гэснийг “системчлэн” гэж, 5 дугаар зүйлийн “мөн хэсгийн” гэснийг “мөн зүйлийн 21.11 дэх хэсгийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт одоо явуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Баттөмөрийн Энхбаяр.

Санал хураалт 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн.

Санал хураалт. 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль.

Найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “дараах харилцааг зохицуулж буй

хуулиудын” гэснийг “хуулийн” гэж, мөн зүйлийн “Хууль зүй, дотоод хэргийн яаманд” гэснийг “хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна за.

12.02 цаг

Дараагийн асуудалд оръё.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчлэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 30, 2023 оны 1 дүгээр сарын тавны өдрийн нэгдсэн

хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 1 дүгээр тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очироор ахлуулж бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж нар ажиллалаа.

Төсвийн байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Үүнд:

Монгол Улсыг гадаад улсад сурталчлах Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотойгоор зөвхөн гадаад улсад бараа үйлчилгээ худалдан авах тохиолдолд энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй байх, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн бүх байгууллагын зарласан тендер шалгаруулалтад тухайн орон нутгийн хуулийн этгээд ААН-д давуу эрх олгох, захиалагч, гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр олгох нөхцөлийг тодорхой болгох, худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх

худалдан авах ажиллагааны нэгжийн эрх үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ТББ-д шилжүүлж болох зарим чиг үүргийг нарийвчлан зохицуулах, үнэлгээний хорооны зохион байгуулалт, бүрэлдэхүүний талаарх зохицуулалтыг тодорхой болгох, Хуулийн дагаж мөрдөх хугацааг 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөх нь зүйтэй гэсэн саналууд гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн, Ш.Раднаасэд нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд хуулийн төсөлд тусгасан бага үнийг сонгох арга буюу хэмнэлттэй байх зарчим нь эм, эмийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаанд нийцэхгүй байна гэж зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно оо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн

байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Дамбын Батлут гишүүнээр тасаллаа.

Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

Г.Занданшатар: *Ажлын хэсгээс, Байнгын хорооноос 2 асуулт асууя. Энэ эмийн чанар үнэтэй холбоотой асуудал сүүлийн үед энэ иргэдийн дунд маш их бухимдал төрүүлээд байгаа асуудлын нэг байгаа юм аа.*

Тэгэхээр энэ эмийн үнэ чанартай холбоотой асуудлаар юу гарч байна вэ гэхээр одоо энэ Тендерийн тухай хуулиар чинь хамгийн бага үнийн одоо саналаар тендер сонгон шалгаруулахаар тэрэнд нь таарсан чанар одоо муутай эм орж ирэх ийм одоо асуудлууд маш түгээмэл болчихоод байгаа юм.

Энийг одоо яаж одоо зохицуулах вэ? Боловсронгуй болгох арга юу юу байна уу? Одоо манайд хатуу зохицуулалттай орнууд гэж. Өөрөөр хэлбэл энэ нөгөө өндөр хөгжилтэй Европын орнуудаас авч байгаа чанарын өндөр шаардлага хангасан тэгээд бас тодорхой хэмжээний үнэ өртөг нь бас арай илүү өртөгтэй байдаг. Энэ орнуудаас авдаг эмийн ханган нийлүүлэлтийн хэмжээ нь нэлээн сүүлийн жилүүдэд нэлээн буугаад байгаа юм байна лээ? Одоо энэ хатуу зохицуулалттай орнуудаас авч байгаа эмийн ханган нийлүүлэлтээр авч байгаа эмийн хэмжээ нийт одоо Монголын зах зээл дээр борлогдож байгаа эмийн нэг 60 хувь руу орчихсон байна лээ. Үлдэж байгаа 40 орчим хувь нь бол энэ Зүүн Өмнөд Азийн орнуудаас одоо бас тэр чанар, үнийн одоо санал нь бага гэдэг ийм

шалгуураар орж ирээд манай зах зээлд нэлээн бас өндөр эзлэх хувьд дүнтэй болчихоод байна аа.

Тэгэхээр энийг бас одоо боловсронгуй болгох зохицуулах ийм боломж юу байна аа? Энэ дээр та ажлын хэсэг, Байнгын хороо бас яаж яаж одоо ажилласан юм бэ?

Хоёр дахь асуудал нь. Манайд ханган нийлүүлэлт импортлох зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагуудаас гадна энэ ДЭМБ болоод НҮБ-ын системийн байгууллагууд өөрсдөө зах зээл дээрээс чанартай хямд өртөгтэй эм оруулж ирдэг ийм системүүд худалдан авах одоо системүүд ашиглаад байгаа юм.

Хүүхдийн сан байна, ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газар байна, Хүн амын сан байна. Тэгэхээр энэ байгууллагуудын энэ эм худалдан авдаг энэ эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авдаг энэ системийг нь бид бас энэ Худалдан авах ажиллагааны тухай хуульд оруулаад эдгээр байгууллагуудын энэ худалдан авдаг системийг ашиглаж эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч болно оо гэдэг ийм зохицуулалт оруулаад өгчихмөөр байна.

Ингэх юм бол энэ хувийн хэвшилүүдийг гэхээсээ илүүтэй бид нар энэ өндөр чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл оруулж ирж байгаа энэ НҮБ-ын системийн байгууллагууд ДЭМБ-ын энэ системийг бид нар шууд өөрсдөө аваад ашиглачих юм бол энэ Монголын зах зээл дээр борлогдож байгаа эмийн одоо чанарт асар одоо том эргэлт оруулах ийм боломж байгаа юм. Одоо манайд бол ийм туршилага байна.

Дархлаажуулалтынхаа тухай хуульд энэ одоо НҮБ-ын системийн байгууллагуудын эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авч байгаа энэ худалдан авах системийг ашиглаж бараа бүтээгдэхүүн худалдаж авна гээд

Дархлаажуулалтынхаа тухай хуульд оруулчихсан учраас энэ вакциныг бид нар ямар ч одоо хугацаанд заавал энэ ханган нийлүүлэлтийн байгууллагуудыг харахгүйгээр энэ НҮБ-ын худалдан авдаг системийг ашиглаад шууд одоо худалдан авалт хийгээд богино хугацаанд чанартай вакцин оруулж ирэх ийм боломжууд нээгдчихсэн юм. Одоо бусад одоо эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой асуудлуудыг энэ НҮБ-ын систем ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрын ашиглаж байгаа энэ системийг манайх одоо шууд бас ашиглах эрхийг нь энэ Худалдан авалтын тухай хуульд оруулаад нээгээд өгчихмөөр байна. Тэгэх юм бол энэ эмийн чанартай холбоотой асуудлаар маш одоо том өөрчлөлт гарах ийм боломж байгаа юм аа.

Г.Занданшатар: Байнгын хороон дарга хариулах уу? Ганзоригийн Тэмүүлэн байнгын хороон дарга хариулъя.

Г.Тэмүүлэн: Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ Тендерийн тухай хуультай холбогдуулаад Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад бол бас хэд хэдэн зарчмын саналууд гарсан. Тэр дундаа энэ эмийн чанартай холбоотой, чанартай эм нийлүүлэхтэй холбоотой өнөөгийн энэ Тендерийн хуулийн зохицуулалтаас сүүлээд бол энэ хязгаарлагдмал байгаа асуудлуудыг анхаарч үзэх тодорхой зарчмын зөрүүтэй саналуудыг тодорхой гишүүдийн зүгээс гаргасан. Тэр дундаа Раднаасэд гишүүн бол одоо энэ санал хураалт дээр орж ирнэ.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан. Байнгын хороон дээр хэдий дэмжигдээгүй ч гэсэн энэ саналыг бол бид нар бас харгалзаж үзээд эцсийн хэлэлцүүлэг дээр одоо тодорхой гишүүдийн саналыг аваад тусгаад найруулаад өөрчлөх боломжтой гэж бол харж байгаа. Саяын тэр нарийвчилсан эм нийлүүлэх эрхтэй холбоотой гээд НҮБ болоод ДЭМБ-тай

холбоотой энэ системийн асуудлыг бол мэдээж энэ манай одоо ажлын хэсгийнхэн Худалдан авах ажиллагааны газрынхан бас хариулах байх.

Ажлын хэсгийн дарга Сандаг-Очир гишүүн бас та энэ дээр тодорхой нэмэлт мэдээллийг өгөөд яваач ээ л гэж хэлэх гэж байгаа юм.

Сандаг-Очир гишүүн.

Зочид танилцуулъя. Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн стратеги тактик хөтөлбөрийн багш магистрантууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт багш магистрантууд та бүхэнд сурлагын хөдөлмөрийн бүх талын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултад хариулъя.

Ц.Санадаг-Очир: Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Энэ эмийн чанарын асуудал яах аргагүй анхаарал татсан асуудал. Тэгээд Тендерийн хуулийн зарчимд бол хэмнэлттэй үр ашигтай байх гэсэн зарчим байгаа. Тэгээд энэ зарчмаа барихаар яг энэ эмийн асуудал дээр бол хамгийн хямд үнэтэй эмийг худалдан авах асуудал яригдахаар цаанаа эмчилгээний үр дүн чанарын асуудал дээр бас сөрөг асуудал үүсээд байдаг. Манай энэ Тендерийн хуулийн харилцаа бол Монгол Улсад Эрүүл мэндийн яам ажлын хэсэг гараад Эрүүл мэндийн сайдын баталсан ажлын хэсэг баталсан тушаалаар тэр эмийн зөвлөл нь эмийн агентлаг нь Монгол Улсад хэрэглэгдэж болох тэр одоо эмнэл зүйн бүх шаардлагыг хангасан одоо эмийг бүртгээд авчхаж байгаа юм.

Тэгээд манай хуулиар бол яг энэ бүртгээж авсан энэ хуулийн хүрээнд л одоо худалдаалж болно гэсэн энэ эмүүдээс хамгийн хямд үнэтэй эмийг л худалдан авах харилцааг нь зохицуулж байгаа хууль.

Үнэхээр одоо энэ эмийн чанарын асуудал нь цаанаа одоо өнөөдөр шаардлага хангахгүй байна гэж үзэж байгаа бол эмийн энэ бүртгээж авч байгаа энэ ажлын хэсэг сайдын тушаалаар батлагдаж байгаа энэ ажлын хэсэг цаашидаа энэ эмүүдээ, чанарын шаардлагын, одоо тэр тавигдаж байгаа шалгуур шаардлагаа өндөрсгөх асуудлаа л ярих юм.

Хэрвээ Монгол Улсад бүртгээж одоо хэрэглэж болохгүй ээ, муу чанартай эм байна гээд бүртгээж авахгүй бол энэ хуулиар зохицуулагдахгүй шүү дээ. Монгол Улсад хэрэглэж болно гээд бүртгээд авчхаж байгаа учраас бүртгээд авчихсан эмийн хүрээнд манай энэ хуулийн харилцаа зохицуулагдаж байгаа юм.

Тийм учраас энэ Эрүүл мэндийн яам бодлогын хүрээнд эмээ бүртгээж авах асуудал дээрээ стандарт шаардлагаа өндөрсгөх асуудал давхар яригдаж байгаа юм шүү. Хэрвээ одоо стандарт шаардлага нь өндөр болоод тэр одоо нэг эм гэхэд л 10 гаруй нэр төрлийн юм байгаа шүү дээ. Одоо жишээ нь одоо дотроо үзүүлэлтүүд нь янз бүр байгаа, улс орноороо ч өөр байна, үнэ нь ч өөр байна.

Тийм учраас Монгол Улсад өнөөдрийн байдлаар энэ хэрэглэгдэж байгаа мянга гаруй бүртгэлтэй эмүүдээс худалдан авалтын энэ хууль бол хамгийн хямд үнээр худалдаж авна гэсэн энэ л хуулиар л хариуцлагыг зохицуулж байгаа. Яг Эрүүл мэндийн яам өөрөө эмийн зөвлөл нь одоо эмийн агентлаг байгуулагдсан ноднин 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй. Энэ одоо агентлаг өөрөө цаашидаа эмийнхээ шаардлага шалгуурыг өндөрсгөөд ирсэн тохиолдолд чанарын

асуудал нь дагаад сайжирна гэж бид хувьд үзэж байгаа.

Энэ дээр одоо манай бас ажлын хэсгийнхэн нэмж хариулна биз. Системийн байгууллагуудын эмийн бас асуудал дээр нь энэ асуудал дээр яг Эрүүл мэндийн яам одоо ажлын хэсэгт саналаа гаргаад ингээд одоо ярилцаад явахад бол таны гаргасан санал дээр үнэхээр одоо энэ тогтолцоог хийж чадвал эмийн чанарт өөрчлөлт гарахаар байна гэж үзэж байгаа бол энэ хуульдаа бас нэмэлт, өөрчлөлт оруулаад явахад одоо болохгүй юм байхгүй ээ.

Тодорхой саналуудаа бас яг ийм одоо харилцааг оруулж өгмөөр байна гэсэн ийм одоо санал одоогоор бол ирээгүй. Бид нар бол яамдуудаас санал авсан ЭМЯ-наас хуулийн ажлын хэсэгт бас төлөөлөл оруулсан. Тэгээд одоо бас оруулж ирсэн гаргасан саналуудыг бол аль болохоор бид нар дийлэнх олонхыг нь хуулийн төсөлдөө тусгаад явж байгаа гэдгээ бас хэлье.

Ажлын хэсгийнхэн бас нэмж тайлбарлах байх.

Г.Занданшатар: Ажлын хэсгээ танилцуулах уу? Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулна аа.

Ажлын хэсгийн гишүүн Зоригтбаатарын Энхболд байна уу? Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ганболдын Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Доржпаламын Гантулга.

Одоо Содномыг Чинзориг гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: Яах вэ бид эмийн тухайн хуулийг оруулах гээд ажиллаж байна. Тэгээд тэр хуулийг боловсруулах дээр бид нар энэ нөгөө Худалдан авах ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг давхар яриад бас яваад байгаа юм. Нэгэнт одоо энэ Худалдан авах ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа асуудал яригдаж байгаа учраас миний яриад байгаа тэр 2 асуудлыг хэлэлцүүлгийн шатад анхаар гээд чиглэл өгчихвөл сайн байна. Нэг дэх асуудал нь тэр эмийн чанартай холбоотой асуудал. Зөвхөн одоо эм эмийн худалдан авалт дээр бол чанарыг гол одоо шалгуур болгох гэж байгаатай холбоотой нэг зохицуулалт орох хэрэгтэй байна.

Хоёрдугаарт тэр НҮБ-ын системийн байгууллагуудын худалдан авах системийг ашиглаж болно гэдгийг бас оруулж өгмөөр байгаа юм. Тэгэх юм бол бид нар нөгөө тендер гэхгүйгээр тэдний худалдан авах системийг ашиглавал шууд одоо ийм тариагаа худалдан авах асуудал байгаа юм.

Тийм учраас тэр НҮБ-ын системийн байгууллагуудын худалдан авах ажиллагааны системийг ашиглаж болно. Ийм нөхцөлд тендер гэхгүй шууд одоо худалдан авах эрхийг нь одоо нээж өгсөн асуудал оруулах зайлиггүй шаардлагатай байна. Тэгээд энэ чиглэлээр чиглэл өгчихвөл одоо их сайн байна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. 82 дугаар микрофон өгье.

Ц.Батзул: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 36.1.2 дээр хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгсэл, яаралтай дархлаажуулалтад шаардлагатай вакциныг үйлдвэрлэгчээс эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол гэрээ шууд байгуулж болно гээд заачихсан

зохицуулалт байгаа. Тэгэхээр гишүүний асуусан одоо харилцаа бол одоо хуульд бүрэн тусчихсан явж байгаа. Эмийн чанартай болон энэ хямд үнийн асуудлаар нэмж хариулахад бол Монгол Улсад бол жилдээ нэг 650 орчим тэрбум төгрөгийн эм импортлогдож борлуулагдаж байгаа юм. Үүнээс бол 224 тэрбум төгрөг орчим буюу 35 хувийг нь төр худалдаж авч байгаа. Тэгэхээр 65 хувийг нь бол иргэдээс шууд нөгөө хувийн хэвшлийнхэн худалдаж авч байгаа. Тэгээд Монгол Улсад одоо олон улсын нэршилээр бол 1321 нэр төрлийн эм тэгээд 481 төрлийн төрлийн.

Л.Мөнхбаатар: Гүйцээж хариулах уу? Гүйцээгээд хариулчихъя.

Ц.Батзул: Эм дээр бол тавигдаж байгаа шалгуур стандартыг нь хангасан эмүүд дотроосоо бага үнэ санал болгож байгааг нь авч байгаа. Тэгэхээс шууд бага үнийг нь шууд санал болгосныг нь авдаг ийм зохицуулалт бол байхгүй ээ. Нөгөө талаараа Монгол Улсад нийтдээ 44 эм үйлдвэрлэгч байна. 444 эм ханган нийлүүлэгч Монгол улсын үйлдвэрлэсэн 173 нэр төрлийн 851 төрлийн эм худалдаанд байгаа юм. Тэгээд энэ үйлдвэрлэж байгаа эм болон хилээр орж ирж байгаа эм дээр тавигддаг биш ээ. Хаанаас орж ирж байгааг нь харах юм бол өнгөрсөн 2022 онд бол нийт 58 улсаас 143 сая долларын эмийг бол импортолсон. Тэгээд энэ орж ирж байгаа эм дээрээ тавигдах болон үйлдвэрлэж байгаа эм дээр тавигдах стандарт шаардлагуудаа өсгөх юм бол тэр дотроос нь бол санал болгосон шаардлага хангасан эмүүд дотроосоо бага үнэтэйг нь л авах юм.

Тэгэхээс биш энэ нөгөө үйлдвэрлэж байгаа эм болон орж ирж байгаа эмүүд дотроо стандартыг нь өсгөхгүй бол чанар муутай эм дотроосоо өндөр үнэтэйг нь авдаг ийм л тогтолцоо руу явах гээд байгаа юм л гэж хэлээд байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Чинзориг гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: Яах вэ бид нар тэр бүртгэлтэй холбоотой асуудлыг бол жаахан цэгцэлж болно. Гэхдээ тэрийг чинь бас бүртгэж болохгүй бас асуудлууд байдаг юм. Тэгэхээр тэр бүртгэлтэй бүртгэгдсэн дотроосоо чанар үнэ багатайг нь ав гэдэг ийм одоо асуудал байж болохгүй байгаа юм аа. Тийм учраас дарга энийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдэхдээ бас энэ чинь эмийн чанартай холбогдуулан худалдан авахтай холбоотой асуудлыг эргэж нэг хар гэсэн чиглэл өгөөд, 2 дахь асуудал нь тэр зөвхөн вакцин гэж оруулчихаад байгаа юм аа. Тэр НҮБ-ын системийн худалдан авах системийг ашиглахдаа зөвхөн вакцин дээр ашиглаж болно гээд байгаа юм. Тэнд чинь бүх төрлийн эм тариаг НҮБ-ын системийн байгууллагууд чинь шууд өөрсдөө энэ олон улсын чанартай үйлдвэрээс нөгөө шууд худалдан авалт хийгээд байгаа юм. Тэгээд тэр эрхийг нь л нээгээд өгчих хэрэгтэй. Зөвхөн вакцин биш. Тийм учраас бол энэ чанартай холбоотой асуудал тэр НҮБ-ын системийн байгууллагуудын худалдан авах системийг зөвхөн вакцин гэхгүйгээр бүх одоо эм тариан дээр одоо энийг шууд худалдан авалт хийж болно гэдгийг нь нээгээд өгчихвөл энэ маш том эргэлт болох юм.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулсны дараа чиглэл өгье. 84 дүгээр микрофон өгье. Ажлын хэсэг хариулъя. Нэр албан тушаалаа хэлээд гишүүний асуултад хариулаарай.

3.Энхболд: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Энхболд.

Хуулийн төслийн 36.1.2 дээр хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгсэл, яаралтай дархлаажуулалтад шаардагдах вакцин

гээд эм болон эмнэлгийн хэрэгслийг ингээд оруулчихсан байгаа. Хуулийн төсөл дээрээ.

Одоо шууд нэмэлт мэдээлэл хэлэхэд 2011 он байна уу, 2013 онд тендерийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр эмийг бас чанартай эм худалдаж авах шаардлагатай байна гэж үзээд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүн дээр бол чанар болон онооны үнэлгээний хосолмол аргаар үнэлдэг ийм зохицуулалтуудыг оруулсан байгаа. Энэ зохицуулалт одоо мөрдөгдөөд явж байгаа. Үүнтэй холбогдох журам заавар дээр нь мөн.

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүний саяын ярьсан асуудлаар гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Эцсийн хэлэлцүүлэг дээр одоо оруулж ирэхдээ энэ асуудлыг анхаарч оруулж ирнэ шүү. Байнгын хороо ажлын, хэсэгт чиглэл өгч байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Анужингийн урилгаар ШШГЕГ-ын хорих 405 дугаар ангийн албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүгдэд ажлын амжилт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Одоо Хууль зүйн байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр асуултаа асууя.

Б.Энхбаяр: Эхлээд би нэг ерөнхий асуулт асууя. Өнгөрсөн онд энэ Тендерийн хуулийн өөрчлөлт орж ирж байхад би удаа дараа ярьж байсан. Энэ одоо 60 их наядын дүн бүхий нөгөө томоохон төсөл хөтөлбөрүүдийг тендергүйгээр шууд хэлцэл байгуулах байдлаар иийдье ээ гээд орж ирж байсан. Тэгээд буцааж байсан л даа. Өөрчилж байсан. Тэгэхээр энэ асуудал одоо энэ шинэчилсэн найруулга дээр ямар байдлаар яригдаж байгаа вэ ямар нэг заалт байна уу? Одоо жишээлбэл 5 дугаар цахилгаан станцыг барья гэхэд одоо тендергүй хийх ч юм уу

томоохон төсөл хөтөлбөрүүдийг яриад байгаа шүү. Энэ дээр ямар заалт байна вэ гэсэн эхний асуулт байгаа юм.

Хоёр дахь асуулт нь төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн одоо төсвийн байгууллагын зарласан тендерт орон нутгийн хуулийн этгээд ААН-д бол давуу эрх олгоно гэдэг ийм зарчим Байнгын хороон дээр яригдсан юм байна.

Тэгэхээр энийгээ яаж хийж байгаа вэ төсөл дээр? Орон нутгийн компани л байвал өндөр үнэтэй ч байсан ялна гэж хийж байна уу? Юугаар нь одоо давуу байдал олгох тухай хийж байгаа вэ? Тэгэхээр одоо мэдээж ойлгож байна л даа. Хотоос очсон нөгөө барилгын компаниуд эзэн ч олддоггүй юу нь ч олддоггүй. Тэнд нэг дутуу юм бариад л зовлон болоод байдгийг бол би ойлгож байгаа юм. Тэгэхээр одоо энэ заалт болохоор нөгөөдөх хөл чинь бүх аймгуудад 21 аймагт одоо охин компаниудаа байгуулаад л явахаар чинь орон нутгийн компани л болчихно шүү дээ.

Бид нар бол бэлчээр өвөлжөөн дээр бол тэгж л харагдаад байдаг юм байна лээ шүү дээ. Бэлчээр дээр нөгөө тухайн орон нутгийнхаа иргэдэд бэлчээр эзэмшил ашиглалттай холбоотой бас асуудал ярингуут чинь нөгөө энэ алдарт уяач нар чинь хөдөө хүүхэд, хүү, хүргэн бэрүүдээ бүгдийг нь харьяаллыг нь шилжүүлээд л хамт эсвэл хүнтэй суулгаад л тухайн аймаг, сумын иргэн болгочихдог юм байна лээ шүү дээ. Тэгэхээр одоо энэ тендерийн хууль явахаар нөгөө том компаниуд чинь одоо бүгд 21 аймагт бүгдэд нь охин компаниа байгуулаад л явчих байх болов уу яадаг бол? Тэгээд л давуу байдал явж байна гээд л барилгын компаниуд авах болов уу? Энийг ер нь яаж бодсон юм бол оо гэсэн ийм 2 дахь асуулт байгаа юм.

Гуравдугаарт Монгол Улсыг гадаад улсад сурталчлах Засгийн газрын үйл ажиллагаан дээр бол тендерийн

үйлчлэл хамаарахгүй ээ гэж байна. Энийг бол би ойлгож байна. Том том одоо үзэсгэлэн гадаад улсад сурталчлах ийм арга хэмжээн дээр бол энэ мэдээж боломжгүй.

Энэнтэй хамт нөгөө нэг юу яадаг юм одоо энэ янз бүрийн үл хөдлөх хөрөнгө объектууд бас манай дипломат төлөөлөгчийн газар консулын газар худалдаж авдаг байх. Энд бол хамаардаггүй юм байгаа биз дээ тэ? Тендерийн хууль бол хамаарахгүй шууд авдаг байлгүй дээ. Энэнтэй хамт зүгээр арилжааны компаниуд ийм бизнес одоо юман дээр энэ хамаарахгүй биз дээ гэсэн ийм санаа байгаа юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Засгийн газрын одоо бодлогыг бүтээгдэхүүнээ сурталчлах гэж байна гээд манай нэг компани Засгийн газрын нэрээр тэнд үл хөдлөх хөрөнгө аваад дэлгүүр нээгээд бараагаа зараад ингээд одоо юу явах зүгээр би бол зүгээр сайн уншаагүй учраас зүгээр асууж байгаа шүү. Ийм одоо уут муут бол байхгүй биз дээ гэж. Одоо хуулийн хүн болохоор чинь дандаа л одоо хартай сэртэй юм асуудаг юм шүү. Уучлаарай.

Л.Мөнхбаатар: Энхбаяр гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье.

Ц.Батзул: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах ажиллагааны газар Батзул.

Нэгдүгээр асуултын хүрээнд бол хуулийн төсөлд өнгөрсөн хавар 2022 оны хавар шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд нийт эдийн засгийг тэлэх томоохон төслүүдийг нь бол хэлэлцээ хийж гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулдаг нэмэлт, өөрчлөлтийг хуульдаа оруулахаар санаачилсан болж Их Хурлын гишүүдийн болон Их Хурлаас шаардлагагүй гэж үзсэн учраас хуулийн нэмэлт, өөрчлөлт бол дэмжигдээгүй явсан байгаа. Энэ агуулгынхаа хүрээнд мөн шинэчилсэн

найруулгын төсөлдөө бол яг ийм зохицуулалтуудыг бол оруулаагүй. Таны хэлсэн одоо томоохон станц байна уу, жижиг станц байна уу хамаа байхгүй бүгд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар явахаар хуулийн төсөлд бол тусгасан байгаа.

Бүгд ил тод зарлаад явна. Одоо мөн түүнчлэн гэрээ шууд байгуулах аргыг маань бол бүүр илүү ил тод нээлттэй болгоод хэрэглэх нөхцөлүүдийг нь хумьсан. Тэгээд мөн хуулийн үйлчлэх хүрээг нь бол өргөтгөсөн байгаа. Төвлөрлийг сааруулах хүрээнд тэр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа. ААН-үүд дээр бид нар нэг шаардлага тавьж байгаа нь сүүлийн 2-оос доошгүй жилийн хугацаанд тухайн орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулаад тэгэхдээ зүгээр үйл ажиллагаа явуулж байгаа биш ажлын байр бий болгосон шаардлага тавьж байгаа юм. Ингэсэн тохиолдолд бусад компаниудаас нэмэлт 5 хувийн давуу эрхтэй оролцохоор ярьж байгаа. Тэгэхээс биш тухайн орон нутгийнхаа үйл ажиллагаа явуулдаг гэдэг агуулгаараа шууд гэрээ байгуулаад ялдаг ийм зохицуулалт бол байхгүй ээ.

Дараачийн зохицуулалт болохоор энэ Монгол Улсаас гадаад улсад сурталчлахтай холбоотой зөвхөн гадаад улсаас худалдаж авах гэж байгаа бараан дээр энэ бол хамаарахгүй. Монгол Улсаасаа худалдаж авч явж байгаа бараан дээр бол тендерийн шалгаруулалт бол нээлттэй тендер шалгаруулалтын журмаар явна. Дипломат консулын газар дээр бол тухайн консул болон дипломат элчин сайдын одоо өөрийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээнд бол энэ үйлчлэхгүй гэдэг заалтыг нь 3.3.5 дээр оруулсан байгаа.

Таны хэлсэн хувийн хэвшил нь болохоор энэ хуулийн заасан захиалагчид хамаарахгүй учраас энэ хууль үйлчлэхгүй. Тэгэхээр энэ заалтын дагуу хувийн

компаниуд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс нь үйл ажиллагаа явуулна гэдэг зохицуулалт бол байхгүй ээ.

Хариулж дууслаа.

Л.Мөнхбаатар: Тодруулж асууя. Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Тэгэхээр хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1.3-т Улсын Их Хурлын баталсан хөгжлийн төслийн жагсаалтад багтсан улсын эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр болохуйц тэргүүлэх чиглэлийн хөгжлийн төслийн ажил үйлчилгээг гүйцэтгэх этгээдийн чадавх туршилагыг харгалзан гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах шаардлагатай гэж үзвэл шууд байгуулна гэж байгаа юм. Тэгээд энэ заалт чинь ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Энэ байхгүй юм уу хасагдсан юм уу яг биз. Би энэ төслөөс уншаад байна шүү. Үгүй ээ үгүй өмнө нь нөгөө хаслаа гээд өмнөх төсөл дээр бас залилчихсан байхгүй юу. Хаслаа гэж хэлэнгүүтээ төсвийн хуулийн өөр хууль дагалдуулсан юман дээр дахиж оруулж ирээд 2 дахиа баригдсан байхгүй юу. 2 удаа хуулийн хулгай хийх гэж байхад нь барьсан байхгүй юу. Би тийм учраас одоо бүүр хартай сэртэй болчихоод байна шүү дээ энэ чинь одоо хэцүү болчихоод байна шүү дээ яг уу гэсэн яг л гэж байна.

Одоо Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар асуултаа асууя.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Их Хурлын дэд даргыг энэ дээр бас анхны хэлэлцүүлэг дууссаны дараа нэг чиглэл өгөөсэй гэж бодож байгаа. Энэ юу вэ гэхээр 2022 оны 12 дугаар сард Шүүх шинжилгээний байгууллагын тухай хуулийг Улсын Их Хурал баталсан. Тэгэхээр шүүх шинжилгээний байгууллага бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжлэх

ухааны нарийн мэдлэг шаардсан зүйл дээр дүгнэлт гаргадаг, хэргийн үнэн зөвийг олдог, үйлдэгдсэн гэмт хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд мөрийн баримтуудыг харьцуулан шинжилж, дээжид дүгнэлт гаргадаг. Ийм одоо шинжилгээний байгууллага. Тэгээд энэ байгууллага жилдээ нэг 400 гаран сая төгрөгийн химийн урвалж бодис авдаг юм.

Тэгээд одоогийн энэ та бүгдийн батлуулах гэж байгаа төслөөр бол энэ байгууллага гарцаа байхгүй нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар энэ химийн урвалж бодис авахаар болчхоод байгаа юм.

Тэгэхээр бид нар өнгөрсөн жилүүдэд энэ химийн урвалж бодис үндсэндээ тасалчихсан одоо хүн амины хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хэргийн газрын үзлэг дээрээс ул мөр бэхжүүлэх ДНК-ийн шинжилгээг харьцуулсан шинжилгээ хийх, хүний цусанд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис байгаа эсэхийг ингээд тогтоох ийм нарийн мэргэжлийн шинжилгээ хийхэд шаардлагатай химийн урвалж бодисуудыг маш бага хэмжээгээр авдаг.

Өөрөөр хэлбэл би нийлбэр дүнгээр нь хэлж байгаа юм 450 гэдэг нь. Энэ маш олон төрлийн бодисууд хуваагдаж байгаа. Тэгээд ерөөсөө харьцуулсан аргаар шууд нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар тендер зарлаад ААН-үүд энд оролцохоо больчхоод байгаа юм. Зарим төрлийн энэ төрөлтэй төсөөтэй төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд жилд шаардлагатай гэж үзвэл өөрийнхөө оруулж ирж байгаа бодист нь хавсарга байдлаар авчраад одоо манайд тухайн зах зээлийнх нь үнээр нийлүүлдэг ийм жишгээр явж ирсэн юм аа.

Тэгэхээр энийг одоо яаж хэдүүлээ шийдэх вэ? Эс үгүй бол одоо яг энэ харьцуулсан аргаар шууд тендерийн

аргаар явбал энэ ерөөсөө ААН оролцохгүй. Тэгээд бид нар хэрэг төвгөө илрүүлж чадахгүй. Цаана нь хүний эрх, амь нас, эрүүл мэнд, бусад зүйл энэ ингээд сэргээгдэхгүй ингээд хохирох ийм тал үүсэж байна аа. Энэ дээр ажлын хэсэг нэг хариулаач.

Тэгээд одоо үнэхээр энэ дээр эргэж харъя гэвэл хуралдаан даргалагч нэг чиглэл өгмөөр байна.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайдын асуултад хариулъя.

Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгье. Асуултад хариулсны дараа чиглэл өгнө өө.

Нямбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Ц.Батзул: Төрийн худалдан авах ажиллагааны газар, Батзул. Өмнө Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр бас энэ асуудлыг яриад Сангийн яам болон Шүүх шинжилгээний хүрээлэнтэй уулзаад ер нь бол энэ заавал гэрээ шууд байгуулах аргаар биш бид нар ерөнхий гэрээ байгуулаад явах боломжтой юм байна гээд санхүү болон хөрөнгө оруулалт хариуцсан албаны хүмүүстэй нь уулзаж ярилцсан.

Тэгээд Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бол энэ одоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.12 дугаар заалт бол байгаагүй. Тэгээд худалдааны явцад энэ нэмж орж ирсэн. Энийг нь харгалзаж үзээд бас хуулийн төслийн шинэчилсэн найруулга дээр бол 36.1.1-ээр оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар нь бараа, ажил үйлчилгээ үйлдвэрлэгч, оюуны өмчийн эрх эзэмшигч эс үгүй бол түүний лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан албан ёсны I этгээд гүйцэтгэх боломжтой бол

нэг эх үүсвэртэй худалдан авах ёстой буюу шууд гэрээ байгуулах замаар нь худалдан авах эрх нь байгаа.

Нөгөө талдаа энэ урвалжийг оруулж ирдэг. Энэ хэрэгслийг нь оруулж ирдэг компаниуд нь болохоор нөгөө зах зээл нь бага учраас тухайлан оруулж ирдэггүй.

Тэгэхээр бид нар хуулийн төсөл дээрээ бол энэ гэрээг нь 3 хүртэл жилийн хугацаагаар нь байгуулах боломжтой гээд бас заасан байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? 36.1.2 хөндөгдчихсөн байгаа тийм ээ.

Нямбаатар гишүүн асуултаа тодруулж асууя.

Х.Нямбаатар: Үгүй ээ хэдүүлээ энэ нөгөө нэг амьдрал баян учраас энд чи зөвхөн энэ чуулганы танхимыг биднийг нэг аргацаагаад өнгөрөх тухай асуудал ярьж болохгүй л дээ. Чи ерөнхий гэрээ байгуулахын тулд эхлээд эхлэх харилцаа үүсгэх ёстой биз дээ. Харилцаа үүсгэхийн тулд заавал наадах чинь нээлттэй тендер шалгаруулалт хийгдэнэ шүү дээ. Тэгээд тэрнээс хойш 3 жил байна уу, үгүй юу гэдэг асуудал яригдана шүү дээ.

Хоёрдугаарт чи жижигхэн 1 килограмм хүрэхгүй урвалж бодис авахад Монгол Улсад ердөө жилдээ 1 килограмм хэрэглэдэг урвалж бодис дээр ямар юмных нь албан ёсны дистрибьютерийн эрх, хэн өгөх юм?

Хоёрдугаарт чи зохиогчийн эрх гээд ХБНГУ-ын химийн том үйлдвэр манайд зохиогчийн эрхээр танайтай шууд гэрээ хийх гэсэн юм. Танайх ийм ийм бичиг баримт бүрдүүлээд өгөөч гэхээр нэг килограмм бодис нийлүүлэхийн төлөө манайд ийм үйлдэл хийх үү? Чи зүгээр энгийн үгээр бод доо. Чи амьдрал баян цаана чинь энэ шүүх шинжилгээний байгууллагууд өчнөөн өдөр тутамдаа

хэргийн газрын үзлэг дээр явдаг, харьцуулсан шинжилгээнүүд хийдэг.

Л.Мөнхбаатар: Ер нь юу яая чиглэл өгчихье, ойлголоо.

Шүүх шинжилгээний тухай хууль шинэчлэгдэн батлагдаж одоо хэрэгжиж байгаа. Энэ хуулийг одоо батлахтай холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүд Хууль зүйн байнгын хорооныхон Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн дээр очиж ажилласан. Энэ энэ ажиллах үед бол мөн одоо гол яригдсан зүйл бол энэ урвалжийг одоо худалдан авах ажиллагаатай холбоотой нэлээн гомдол саналууд байгаа. Иргэд бас нэлээн гомдолтой байдаг.

Яагаад гэвэл энэ урвалж бодис одоо хүрэлцээгүй буюу энэ тендер зарлаад тэнд нь компаниуд ордоггүйгээс болоод урвалж бодис тасраад тэгээд шинжилгээний одоо дүнгүүд хүлээгдэж байгаа ийм одоо тохиолдлууд их байгаа юм байна лээ. Ер нь бол ингээд нийтдээ 1 жилд нэг 400 орчим сая төгрөгийн урвалж бодис авдаг. Гэхдээ энэ нь бол олон төрлийнх шүү дээ. Хар тамхи, мансууруулах бодис, одоо ДНК гээд ингээд олон төрлийнх байдаг. Ийм учраас эдгээрт нь бол нь тендер зохион байгуулаад явуулахад бол их хүндрэлтэй байгаа нь бол харагдсан.

Тийм учраас энэ асуудлыг бол нь тухайлан одоо энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгынхаа төсөл дээр одоо та бүхэн гүйцээн боловсруулж тусгаж оруулж ирэх нь зүйтэй.

Томьёоллыг бол ажлын хэсэг боловсруулах нь зөв. Шинэчилсэн найруулга учраас уг асуудлаар бол одоо хөндөгдсөн заалтууд болоод шинээр оруулах боломж чинь хууль зүйн техникийн хувьд бол байгаа.

Ийм учраас тэр 34.12, 36.1.1 дээрээ юм уу аль эсвэл шинээр томьёолоод одоо ийм хууль зүйн хувьд ийм гарц гаргах нь зүйтэй. Энэ чиглэлийг ажлын хэсэг болон Байнгын хороонд өгч байна аа.

Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Энэ худалдан авалттай холбоотой асуудлаар гишүүд бол бас салбар салбарт тулгамддаг асуудлуудынхаа талаар ярьж байна. Миний хувьд бол бас яг энэ зохих хуулиар зохицуулагдаж байгаа энэ худалдан авалтын үйл ажиллагаа анхан шат дээр ямар хүндрэлүүд гардаг юм гэдэг талаар энэ шинэ хуулийн одоо найруулга дээр ямар зүйл заалт орсон юм бэ гэдэг талаар бас нэг 4 асуулт байгаа.

Нэгдүгээрт энэ шууд гэрээг Засгийн газрын тогтоолоор баталдаг гэж ингэж ярьж байгаа. Ер нь бол би түрүүнд хэлэлцэх эсэхийг шийдэж байх үед энэ шууд гэрээгээр орон нутагт хийгдэх ажлын босгыг өндөрсгөх нэмэгдүүлэх энэ тал дээр ямар ажил байгаа вэ гэдэг тал дээр би асуусан. Ялангуяа одоо орон нутгийн хөгжлийн сан гэж энэ 330 сумд очиж байгаа. Энэ төсвийн хөрөнгө бол ихэнх нь одоо орон нутагт хийх боломжтой ажлуудад хуваарилагддаг. Хуулийн зохицуулалтаар 20 сая гэдэг нэг ийм босго тавьчихсанаас болоод тусгай зөвшөөрөлтэй ААН хийх хэрэг гардаг. Тэр 20, 30 сая төгрөгийн 25 сая, 30 сая төгрөгийн ажлыг хийж байгаа. Тусгай зөвшөөрөлтэй компани гэж А4-ийн цааснаас өөр юм байхгүй. Хүн хүч байхгүй. Хөрөнгө мөнгө байхгүй, техник байхгүй тийм л хүмүүс нутгийн хүмүүсийг нэг удирдаад хийлгэж байгаа.

Тэгэхээр миний хувьд бол орон нутгийн хүмүүс өөрсдөө одоо заавал тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр хийх

ажлууд байна. Одоо надад олон хүмүүс санал хэлж байна. Хэнтий аймгийн Батиширээт сумын Алтанхуяг гэдэг хүн сургуулиудын ширээ сандлыг би хийчихмээр байна гэсэн ийм зүйл ярь. Өвөл би тойргоор явж байхад Батноров сум дээр 25 сая төгрөгөөр нэг тусгай зөвшөөрөлтэй компани ирээд малын ванн хийсэн. Мал угаах ванн. Өнөөдөр тэр нь гоожоод байж байгаа. Бид нар өөрсдөө хийчихвэл тэр байтугай гоё юм хийчихмээр байна гээд. Ингээд худалдан авалтын энийг босгохоос болоод нэг ийм асуудлууд гараад байгаа юм, нэгдүгээрт. Энэ дээр ямар зохицуулалт байгаа вэ?

Хоёрдугаарт, хариуцлагын асуудал. Аймаг, сумын Засаг дарга нар таныг хар жагсаалтад оруулна шүү л гэж яриад байгаа болохоос биш жагсаалтад ордоггүй юм байна лээ шүү. Энийг орох орохгүйг хэн нэгэн хүний үзэмжээр шийдээд байна уу. Хуулиар яг тийм тодорхой зохицуулалтууд байна уу? Хэрвээ байхгүй бол энэ хууль дээр ямар юм орж ирж байгаа вэ? Ардаа хамгаалалттай байдаг юм уу, яадаг юм. Хар жагсаалтад орно гэдгээс огт айхгүй явдаг шүү дээ тэд нар чинь. Чанаргүй юм хийдэг, хаяад явчихдаг, хүмүүсийн цалин мөнгийг өгдөггүй энэ бол хар жагсаалт гэдэг хариуцлагын тогтолцоо байхгүйгээс болж байна.

Хэнтий аймгийн чуулгыг бариад бантагнуулсан компани 10 жилийн дараа дахиад цэцэрлэг барина гээд л ирж байгаа шүү дээ. Хар жагсаалт ямар зохицуулалт байгаа юм бэ? Надад бүүр нэг тодорхой хариулж өгөөч гэж хэлэх гээд байгаа юм.

Дараагийн нэг асуудал нь бол энэ цахим дэлгүүртэй холбоотой асуудлуудыг худалдан авалтын газраас бас гаргаж ирсэн. Надтай чуулганы завсарлагаанаар ЕБС-ийнхантай уулзахад тухайн захирлуудын зүгээс тэр дотор нь хэдхэн юм байгаа юм. Шаардлага хангахгүй тэрийг нь авах гэхээр. Тэгэхээр үнэтэй. Тэрнээс авахгүй л бол өөр юмаар тендер

зарлаж болохгүй гэсэн нэг ийм зүйл байна аа. Гэтэл сургуулийн хэрэгцээ шал өөр юмнууд байгаад байдаг.

Тэгэхээр энэ ер нь ямар учиртай юм ямар байгаа юм бэ? Одоо энэ дээр тэр гажуудал юм байгаа бол хэрвээ зассан уу?

Хамгийн дараагийн асуулт нь нэг гол юм бол энэ орон нутагт энэ хүнсний ногоо мах, ялангуяа энэ боловсролын байгууллагуудаас худалдаж авдаг энэ процессыг нэг жоохон хөнгөхөн болгоод өгчих юм бол орон нутгийн малчин орон нутгийн ногоочид эд нар тийшээ нийлүүлэх бололцоо байгаад байгаа юм аа. Тэгээд энэ дээр ингээд нэг маш том худалдан авалттайгаа дүйцүүлээд энийгээ ингээд айхтар нарийн хуулийн зохицуулалтууд хийчихсэн.

Тэгэхээр махыг заавал ААН-ээс авахын тулд тэр малчны мах бол хэчнээн юм дамжиж очиж байгаа байхгүй юу. Тэгэхээр эрүүл мэндийн шаардлага хангасан ийм зүйлийг одоо шууд авах бололцоо байна уу? Ногоо бас мөн ялгаагүй. Чадахгүй болоод тэгээд орон нутагт төсвийн худалдан авалтууд Барс захаас ногоо хийгддэг юм шүү дээ. Хавар тийшээгээ уул нь энийг жоохон зохицуулаад өгчих юм бол орон нутгаасаа ногоогоо худалдаад аваад байвал хэн хэндээ хаана хаанаа энэ хүнсний хувьсгалтай нэлээн.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын I дүгээр сургуулийн 12-ын E ангийн багш сурагчид, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүгдэд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Асуултад хариулъя 82 дугаар микрофон Батзул дарга хариулъя.

Ц.Батзул: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Өмнө хэлэлцэх эсэх асуудлыг Их Хурал дээр хэлэлцэж явахад Идэрбат гишүүн бас энэ өмнөх нэг асуултаа асууж байсан. Тэгээд бид нар одоо бол Засгийн газрын тогтоолоор бол шууд худалдан авалтын босгыг нь бол тогтоодог зохицуулалт бол хэвийн хэмжээгээр л аваад явж байгаа. Энэ дээр бас тооцоо хийгээд үзэхэд бол орон нутагт зарлагдаж байгаа нийт 7000 тендер шалгаруулалт энэ босго өссөнөөрөө алга болох юм байна лээ.

Тэгэхээр үндсэндээ сумд бол ямар ч тендер шалгаруулалтгүй бүгд шууд худалдан авалтаар явдаг. Бас ийм эрсдэл байгаа юм байна лээ. Тэгээд Засгийн газар бол тухайн үеийнхээ худалдан авалтын чадвар одоо нөгөө мөнгөний үнэ цэнээсээ хамаараад инфляц хэрэглээний үнийн индекс дээр үндэслэж байгаад босго үнийг уялдуулан тухай бүрд нь уян хатнаар нь шийдээд явах боломж нь бол байгаа. Хариуцлагын хүрээнд бол бид хар жагсаалтад бол шинэ зохицуулалт оруулж ирж байгаа нь одоо ААН-үүд хажуудаа 2, 3 компанитай явдаг. Тэгээд нэг нь хариуцлагад орохоор нөгөөдөхөд нь ямар ч тийм нөлөөлөл үзүүлдэггүй учраас энэ нь бол тэр ААН-үүдэд ерөөсөө өвдөлт өгөхгүй байгаа.

Тэгэхээр энийг нь бид нар хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулаад эцсийн өмчлөгчтэй нь хамт оруулдаг. Эцсийн өмчлөгч нь түүний хамааралтай компаниуд нь хамтдаа орно гэсэн үг. Тэгэхээр аливаа этгээд бүх өөрийнхөө хуулийн этгээдээрээ ёс зүйтэй, оролцъё, хариуцлагатай оролцъё гэдэг ийм зохицуулалт орж байгаа. Одоо хууль тогтоомжийн дагуу бол хар жагсаалтад оруулах журмыг нь Засгийн газар баталж байгаа. Журамд заасны дагуу бол гэрээ байгуулсан захиалагчийн хүсэлтэд үндэслэн улсын байцаагч ажиллаад хар жагсаалтад оруулах хүсэлтийг гаргаж байгаа. Одоо бол 46 компани хар

жагсаалтад байгаа. Одоо энэ ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа.

3 дугаар асуултын хүрээнд бол ЕБС-ийн хүрээнд цахим дэлгүүрт байхгүй бол өөр эх үүсвэрээс авах боломж нь бол нээлттэй байгаа. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дээр биш ээ 14 дүгээр зүйл дээр нь бол цахим дэлгүүрт байгаа барааг л цахим дэлгүүрээс авна. Хэрвээ авах гэж байгаа бараа нь байхгүй бол өөр эх үүсвэрээс авах нь эрх нь бол бүх захиалагч нарт бол нээлттэй байгаа. Энэ дээр бол бас ойлголтын буруу зөв байгаа зүйл байх шиг байна. Хүнсний ногооны хувьд бол Боловсролын яам болон Боловсролын ерөнхий газар дээр үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтын асуудал дээр бас ажлын хэсэг ажиллаад шууд худалдан авах боломжтой. Эсвэл цахим дэлгүүрээс авах уу, тухайн орон нутгаас нь авах уу гэдэг дээр нь бас шийдэл гаргаад ажиллаж байгаа. Одоо хуулиар бол нийт худалдан авах босго нь 20 сая төгрөгөөс доош байх юм бол шууд худалдаж авч байгаа. Хуульд болон одоо мөрдөж байгаа болон хуулийн төсөл дээр иргэнээс худалдаж авахыг нь хориглосон ямар нэгэн зохицуулалт бол байхгүй ээ. Бас хариулт дууслаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Тодруулж асууя Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Орон нутагт анхан шатан дээр тэр худалдан авалт байхгүй болно гэдэг бүүр 100 хувь ч байхгүй болчихгүй байх. Гэхдээ дийлэнх нь байхгүй болно гэдэг нь бас үнэн. Гэхдээ одоо яг сумын Засаг даргын Тамгын газар дээр энэ худалдан авалтыг зохион байгуулах хүн олдохоо байсан шүү АЗ гэдэг сертификатыг авахын тулд шалгалтад ороод зориуд унадаг болчихсон шүү дээ. Маши хэл үгтэй, маш их хардлага сэрдлэгтэй, зунжин амраадаггүй, нөгөө орон тоо дутуу нөхдүүдийг чинь гол тамладаг юм энэ байхгүй юу. Тэгэхээр худалдан авалтыг бид нар үгүй ээ тэнд

байхгүй болбол байхгүй болно л биз дээ. Тэр орон нутгийнхаа хэнээрээ хийлгэх вэ гэдгээ тэд нар нь шийдээд бусад нь ашиг сонирхол явдаг бол хуулиараа л тэгээд л хариуцлагаа тооцогдоод л явна биз дээ. Энд одоо юуг нь тэгж одоо нэг их тэнд гайхаад байх юм байхгүй байх гэж би бодож байгаа юм. Хариуцлагын тогтолцоо та нар одоо явж байна гэж. Одоо явахгүй байгаа. Би аймгийн Засаг дарга байхдаа 3, 4 нөхрийг явуулаад нэгийг нь ч тооцоогүй шүү дээ.

Тэгэхээр одоо байгаагаасаа чангалаад өгөөч ээ л гэж байгаа юм болохоос биш одоо явж байгааг чинь мундаг гэж ердөө хэлэхгүй байгаа шүү дээ.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний тодруулгад нэмж хариулья. 82 дугаар микрофон Батзул дарга хариулья.

Ц.Батзул: Хуулийн төсөл дээр бас энэ захиалагч байгуулчхаад гэрээнийхээ үүргийн хэрэгжилтэд нь хяналт тавих эрхийг нь бол хуулийн төслийн 48 дугаар зүйл дээр тодорхой заасан. Хэрвээ гүйцэтгэгч өөрөө одоо хар жагсаалтад орох нөхцөл байдалд эсвэл гэрээний үүргээ гэрээнд заасан гэрээ болон хуульд заасны дагуу биелүүлээгүй бол энэ талаар заавал хүсэлт гаргаад энэнийх нь дагуу заавал хянан шалгалт хийхээр хуулийн төсөлд бол тусгасан байгаа. Тэгэхээр одоогийн тогтолцоог бол илүү нотлох баримтад үндэслээд шийдвэр гаргах, одоо гаргахгүй байх, эс үйлдэхүй үйл гаргахгүй байхаар зохицуулсан байгаа. Тэгээд босго үнийн хувьд нь болохоор орон нутагт явж байгаа асуудал. Ер нь АЗ дээр ч гэсэн бид нар бол хугацаагүй болгоод эхэлсэн. Өнгөрсөн оноос эхлээд. Тэгэхээр 3 жил тутам шинэчилж авдаг байсан зохицуулалтыг бол эргэж харсан байгаа. Тэгээд орон нутгийн тэр худалдан авалтын босгыг өсгөснөөрөө энэ хуулийнхаа үндсэн зарчмаас нь ухарчхаж байгаа юм аа.

Л.Мөнхбаатар: Тодруулж асуух уу? Идэрбат гишүүн тодруулаад асууя. Нэг минут.

Ц.Идэрбат: Тэр нээлттэй байх ил тод байх эд нар гэсэн зарчмаас бол энийг босгыг өндөрлөснөөсөө ухрахгүй ээ. Энэ ил тод нээлттэй байх чинь бол тэр суманд аймагт бол нээлттэй хэвээрээ л явна шүү дээ. Хэнд өгчхөв гэдэг нь ч нээлттэй болно. Тэгэхээр энэ нөгөө зарчмаас бол би ухрахгүй зохицуулалт болно харин орон нутагт олон залуучууд ажилтай болно, олон залуучууд нэгдэж нягтарч юм хийнэ ээ л гэж. Тэр талаас нь бас би 1 жоохон гэгээлэг талаас нь хараач ээ гэж би та бүхнээс хэлэлцэх эсэхээс нь авхуулаад л хүсээд байгаа юм.

Хоёрт одоо миний энэ гарт нэг юу байна? Энэ барилга барьсан компани гүйцэтгэлээ авахын тулд 13 хүний гарын үсгийг цуглуулж авч байна. 13 нэр төрлийн энэ дотор одоо тэгээд хэрэгтэй ч юм уу, хэрэггүй ч юм уу дарга, мэргэжилтэн, газрын дарга тэгээд гарын үсэг болгон чинь хүнд суртал гарын үсэг болгон чинь цаг хугацаа магадгүй гарын үсэг болгон цаанаа мөнгө цаас өгөө авааны юм байгаа юм биш биз дээ?

Энэ дээр ер нь яг ямар зохицуулалт явдаг юм бэ?

Бизнес эрхлэгчдийн толгойтой үсийг нь босгодог гол бэрхшээл бас энэ юм байна лээ шүү дээ. Хийсэн юмныхаа юмыг авах.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Хэддүгээр микрофон бэ? 84 дүгээр микрофон өгье. Албан тушаал нэрээ хэлээд асуултад хариулаарай.

3.Энхболд: Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Энхболд байна аа. Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тэр орон нутагт тэр шууд худалдаж авах босгыг бол хуулийн төсөл дээр Засгийн газрын шийдвэрлэхээр байгаа. Тийм

учраас хэрэглээний үнийн индекс энэ тэрийг харгалзаж үзээд засгаар бол уян хатан тогтоох бололцоо байгаа. Санхүүжилтийн асуудал барилгын ажлын гүйцэтгэл дээр гарын үсэг зурах асуудал нь бол холбогдох Барилгын тухай хууль болон барилгын норм дүрмийн дагуу тухайн ажил дээр хяналт тавьж байгаа бүх улсууд бол гарын үсэг зурж байгаа байх аа. Сангийн яамнаас гүйцэтгэл гарч байгаа тохиолдолд бол ирүүлсэн материал бүрэн бүтэн бол 3 хоногийн дотор санхүүжилтийг шийдвэрлэж байгаа. Өмнө нь бол гүйцэтгэлийг ирүүлэхдээ захиалагчаас гүйцэтгэл ирүүлээд буцаагаад санхүүжилтийг захиалагчид хийгээд захиалагч.

Л.Мөнхбаатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-эрдэнэ: Ажлын хэсгийнхний ярьж байгаа зүйлүүдийг сонсож байхад Засгийн газраас шийднэ, Засгийн газар дээр шийдүүлнэ, батална эд нар гэсэн юм л яриад байх юм. Алийн болгон энэ бүх юмнуудаа дээшээ татаж байх юм бэ? Сая одоо энэ Идэрбат гишүүн хэлээд байна шүү дээ. Орон нутагт хийж байгаа зүйлүүдийг орон нутагт нь хийлгүүлдэг орон нутгийн тэр залуучууд хүмүүсийг иргэдийг ажилтай болгох энэ талаас нь ерөөсөө манай энэ төрийн албаныхан ерөөсөө харж өгөхгүй юм аа, ажлын хэсэг. Ерөөсөө дээшлүүлээд чангаруулаад л ар талынхаа л юмыг яваад байх юм. Тэгээд тэгсэн мөртөө бид нарын Засгийн газрын зорилго маань юу байгаа билээ?

Чинээлэг дундаж давхаргыг бий болгоно гэсэн том зорилт тавьчхаад байгаа шүү дээ бид нар чинь хүмүүс ээ. Тэгсэн мөртөө асуудлыг нь дээш нь татаж авчраад тэр орон нутаг дээр ажиллах боломж бололцоо мөнгө төгрөгтэй болох бололцоо ААН нь хөл дээрээ босох бололцоог нь ерөөсөө дандаа хаасан юмнууд оруулж ирээд байх юм. Энэ үнээрээ уралддагийг хэзээ болих вэ?

Түрүүний хэлэлцэх эсэх асуудал дээр үнэтэй холбоотой асуудал дээр маш олон гишүүд ярьсан санагдаад байгаа юм.

Тэгээд өнөөдөр энэ ажлын хэсэг бас хариулж өгөөч. Энэ 27-той холбоотой заалтууд, энэ дүгнэх тендер үнэлэхтэй холбоотой асуудлууд ерөөсөө энэ юуны саналын томъёолууд дотор орж ирээгүй явсан байх юм? Тэгээд энд бол ерөөсөө энэ бол эрэмбэлнэ. Тэгээд хамгийн одоо эрэмбээрээ бага тендерийг хамгийн сайн тендер гэж үнэллээ гээд ерөөсөө үнээ барьчихаад байна шүү дээ. Үнээсээ болоод бид нар хамгийн бага үнээ авдаг, хамгийн чанаргүй зүйл хийдэг хамгийн одоо олон юуны тендер төрийн тендер нь хүчингүй болдог төрийн тендер нь дандаа муу, бохир, чанаргүй хийгддэг гэсэн ийм зүйл рүү орчихоод байгаа шүү дээ худалдан авалт.

Тэр тусмаа энэ зураг төслийн үнээс доош нь хийдэг асуудлыг хэзээ болих ёстой юм бэ? Ер нь бол мэргэжлийн байгууллага зураг төсөл гаргаж байгаа. Тэрийг нь хөндлөнгийн хяналт хийж байгаа, тэгчхээд одоо энэ байгууламж энэ сургууль бол нэг тэдэн тэрбум төгрөгт босно гэсэн зүйл байхад гаргаж ирчхээд байхад л бид нар хамгийн хямдаар хийнэ ээ гээд л доош нь орж ирээд л тендер аваад явчихдаг шүү. Тэгсэн мөртөөрөө явцын дунд нөгөөдхөө тендерээ элдэв янзын юм арга саам хэлсээр байгаад тендерээ буцаагаад дээш нь татаад үнийг нь нэмэгдүүлээд ороод ирэх гээд байдаг. Тэгэхээр энэ үнэтэй холбоотой асуудал дээр яагаад энэ дээр яригдаагүй юм бэ? Ер нь энэнээс үнийг одоо хамгийн бага үнэтэй ингээд хийлгээд байх чинь одоо зөв юм уу гэсэн асуулт дээр нэг хариулж өгөөч ээ.

Хоёрдугаарт тэр орон нутагт ААН-үүд дээр нь дунд нь одоо хийлгэдэг ийм асуудлууд байж болохгүй юм уу? Ямар нэгэн зохицуулалт хийж болохгүй юм уу? Булган аймгийн ихэнх тендерүүдийг хажуу талын

Эрдэнэтийнхэн хурч ирээд л авч байдаг эсвэл Улаанбаатар хотоос очоод л хийж байдаг. Буцаад эзэн нь олддоггүй алга болчихдог. Хүлээлгээж өгсөн болоод л алга байхгүй. Тэгээд тэнд чинь өчнөөн олон компаниуд байж л байгаа шүү дээ. Тэдний түвшинд яг энэ үзгийг бол ийм л чанартайг авна, зураг төсөл дээр ийм л юмыг хийсэн байгааг энийг л хийж чадах ёстой гэсэн нэг ийм зүйлүүдийг нь хяналт, хөндлөнгийн хяналт эд нар гээд том томоор нь одоо ямар юу байдаг юм? Тусгай зориулалтын байгууллагууд зөндөө л байж байгаа. Тэрүүгээр нь хянаад ингээд чанарыг нь хүлээж аваад ингээд явчхаж болдоггүй юм байх даа. Хоршоо нөхөрлөлүүд байж байна. Тэгэхээр ийм талынхаа гарцуудыг гаргах ийм боломж болох байхгүй юу. Энэ хууль дээр одоо орж ирсэн эсвэл ажлын хэсэг дээр өөрсдөө шинэчлээд орж ирсэн ийм зүйлүүд байна уу, үгүй юу? Энийг нэг хэлж өгөөч.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Батзул дарга хариулах уу та. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоныг өгөөрэй. Батзул дарга хариулъя.

Ц.Батзул: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя аа.

Хуулийн 8 дугаар зүйл дээр дотоодын үйлдвэрлэлийг дэмжих дотоодын давуу эрх тооцох зохицуулалтуудыг нь бол оруулж өгсөн. Үүн дээрээ бол эхний зохицуулалт бол одоо ажлын хувьд 10 тэрбум байгаа босго үнийг 30 тэрбум болгож өсгөсөн. Одоо цаашидаа бол барилга байгууламжийн тендер шалгаруулалтын төсөвт өртөг нь 30 тэрбумаас доошоо бол гадаадын компанид оролцохгүй. Мөн энэ нь болохоор барааны хувьд тэрбум болгосон. Нөгөө талдаа түрүүн би хэлсэн 8.7.1 дээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН тендер шалгаруулалт орох юм бол давуу эрх олгодог байхаар бүүр тусгайлан зааж өгсөн байгаа.

Ажлын хэсгийн гишүүд дээр бас Батжаргал гишүүнээс санал гаргаад энэ асуудлыг нь оруулж ирсэн байгаа.

Мөн түүнчлэн энэ үнээ өрсөлдүүлэх асуудал дээр бид нар тендер шалгаруулалтыг зарлахтай харьцуулах үнэ болон ашиглалтын хугацааны өртөг гэдэг байдлаар яллагчийг тодруулах зохицуулалтыг нь шинээр нээж өгсөн байгаа. Тэгэхээр зөвхөн цаашидаа нэрлэсэн үнээр нь биш тухайн барилга байгууламж болон үйлчилгээг нь ашиглах хугацаанд нь гарах нийт өртгийг нь тооцож үзээд энийг нь бага байх хувилбарыг нь яллагчаар нь тодруулах ийм зохицуулалтыг нь шинээр орж ирсэн байгаа.

Нөгөө талдаа хуулийн төслийн 21.5 дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын оролцогч нь тендерийн үнийн төсөвт өртгийн 80 хувиас доош үнээр санал болгох юм бол татгалздаг ийм зохицуулалтыг нь оруулж өгсөн байгаа. Төсөвт өртгийн 80-аас дооших хувиар бага үнэ, үндэслэлгүй бага үнэ өгөх юм бол хязгаарлаж байгаа юм. Ийм зохицуулалт оруулж ирсэн байгаа. Тэгээд нөгөө Засгийн газраар бүх юмыг нь бол зохицуулж байгаа юм байхгүй. Зүгээр мөрдөх, харьцуулалтын аргыг мөрдөх шүүд худалдан авалтыг мөрдөх нээлттэй тендер шалгаруулалтыг зарлах ийм босго үнийг л баталж байгаа юм. Тийм шүүд худалдан авалт бол өсөж байгаа хэрэглээний үнийн индекс дээр үндэслэн энийг нь бол тухайн онд нь бол тодруулаад явж байгаа. Хариулж боллоо. Баярлалаа.

Тодруулж асуух уу? Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ орон нутгийн ААН хоршоод энэ хоршоодуудыг одоо дэмжих ийм боломж бололцоог нь одоо хангах тал дээр бас ямар зүйлүүд байна

гэдэг дээр бүүр нэг тодорхой хэлж өгөөч ээ. Ер нь бол орон нутагт бид нар энэ ААН-үүдийг нь дэмждэг байх, иргэдийг нь дэмждэг байх. Хүнстэй холбоотой асуудлууд, хүнсний ногоотой холбоотой асуудлууд иргэд өөрсдөө хийж болж байгаа ААН-үүд хоршоод нь хийж болж байгаа зүйлүүдэд нь зориулсан худалдан авалтыг бол бүүр яг тухайлан тийшээ нь шилжүүлээд тэднийг одоо хөл дээр нь босгох боломж бололцоог нь нээж өгмөөр байгаад байна шүү дээ.

Хоёрдугаарт энэ гаднын компаниудыг гэдэг асуудлыг ер нь болимоор байгаад байгаа шүү. Гаднаас орж ирж байгаа компаниуд Монгол Улсад ихэнх нь би маш сайн мэдэж байна. Ихэнх нь орж ирээд одоо бүтээн байгуулалт хийхээсээ илүү бараг л энэ туришилт хийгээд явчхаж байгаа. Ийм зузаан зузаан худлаа материалтай нэг их том зураг төсөл болсон. Тийм ч ажил хийсэн ийм ч ажил хийсэн гэсэн том компанийн нэр барьж орж ирээд тэгээд хийх нь энд ганц нэгэн одоо төлөөлөгч нь энд одоо ямар ч тоног төхөөрөмжгүй техникүүдийн.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүний тодруулгад хариулъя. 82 дугаар микрофон Батзул дарга хариулъя.

Ц.Батзул: Асуултад хариулъя аа.

Төрийн худалдан авах ажиллагааны газар Батзул. Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг дээр захиалагч 12.7-д заасан тусгайлан шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сургах, нийгэм, амьдралд оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээр гэрээний үүргийг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичиг тусгайлан зааж болно. Хэрэв ингэж заасан бол орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь энийг нь гүйцэтгэх боломжийг нь бол нэмж зааж өгсөн байгаа. Мөн дотоодын давуу эрхийн зөрөө тооцдог арга

аргачлалыг нь бол тодорхой зааж тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-д давуу эрх олгохоор хуулийн төсөлд бол шинээр зааж оруулж ирсэн байгаа.

Гадаадын компаниудын хувьд бол бид нар судалгаа авахад бол өнгөрсөн 3 жилийн хугацаанд 217 компани л Монгол Улсын тендер шалгаруулалтад оролцсон. Үүнээс нь бол 17 компани нь тендер шалгаруулалтад нээлттэй оролцсон. Ийм байгаа.

Л.Мөнхбаатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя нэг минут.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ улс даяар Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан хүнсний хангамжийг сайжруулах хүнсний аюулгүй байдлыг хангах ийм том хөтөлбөр явж байгаа шүү дээ. Хүнсний хувьсгал явж байгаа. Энэ хүнсний хувьсгал чинь өөрөө Монгол Улсын хүнсний дотоодын хангамжтай холбоотой асуудлууд орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих ийм том хөтөлбөр явж байгаа байхгүй юу даа. Тэгэхээр би одоо энэ Их Хурлын даргаас удирдамж өгөөд энэ дээр бас найруулгын чанартай зүйлүүд орох боломж бололцоо болбол оруулж ирээч ээ. Тэнд нь орон нутгийн үйлдвэрлэгчид хоршоодыг дэмжсэн ийм санал Хүнсний хувьсгалтай холбоотой ийм саналыг оруулж ирэх боломж бололцоо байна уу?

Энэ дээр нь бас нэг удирдамж өгөөч ээ гэсэн ийм хүсэлт байгаа шүү. 20 сая байгаа юм байна. Одоо энэ 20 саяыг бол цаашаа 100 сая болгох хэрэгтэй шүү дээ. Одоо энэ чинь 100 сая гэдэг чинь боломжийн аж ахуй ажиллах ийм боломж хоршоод ажиллах боломж бололцоотой дүн болчихоод байна шүү дээ ер нь бол.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя 82 дугаар микрофон. Батзул дарга.

Ц.Батзул: Хуулийн төслийн 8.1 дэх хэсэг дээр дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Мөн Засгийн газар энэ дотоодод үйлдвэрлэж байгаа барааны жагсаалтыг батална.

Ийм жагсаалтад багтсан барааг бол импортлогчоос бол худалдаж авахгүй гээд тодорхой заачихсан.

Тэгэхээр сая 2023 оны Засгийн газраас дээрх тогтоолоо шинэчлэн батлаад нийт 15 бүлгийн 164 нэр төрлийн барааг зөвхөн дотоодын үйлдвэрлэгчээс худалдаж авахаар хуулийн төсөлд бол тусгасан мөрдөөд явж байгаа. Мөн 2022 оны тоогоор бол нийт 671.6 тэрбум төгрөгийн дотоодын бараа авсан. Тэгэхээр цаашдаа энэ дотоодын барааг нь жагсаалтад оруулаад хэрвээ тэр жагсаалтад тогтсон бараа байх юм бол импортын барааг ерөөсөө оруулахгүй худалдаж авахыг нь хориглосон ийм зохицуулалттай байгаа. Тэгээд энэ дотор бол мөн хүнсний бүтээгдэхүүнд орсон байгаа мах, махан бүтээгдэхүүнүүд, төмс хүнсний ногоо болон бусад.

Л.Мөнхбаатар: Хуулийн холбогдох заалт байгаа юм байна.

Гэхдээ Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа одоо томьёоллоор Байнгын хороон дээрх эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ анхааръя аа. Энэ хуулийн төслийг Төсвийн байнгын хороо хэлэлцэж байгаа. Тийм учраас Тэмүүлэн даргад чиглэл өгч байна. Томьёоллыг нь одоо ажлын хэсэг болоод Байнгын хороон дээрээ гүйцээн боловсруулаад оруулж ирье ээ. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Л.Мөнхбаатар: Дамбын Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа худалдан авахтай холбоотой хуулийн төсөл яригдаж байна. Цаг үеийнхээ шаардлагаа хангахгүй байгаагаас нэмэлт, өөрчлөлтүүд орж байгаа. Тийм учраас бид нар дорвитой өөрчлөх хэрэгтэй гэж харж байгаа юм. Тэгэхээр манайхан бас ярьж байна л даа үнийн асуудал ярьж байна. Үнэ дагаж чанар гэдэг үг байдаг. Өнөөдөр бид нар хамгийн хямд үнэ гэж туйлиурсаар байгаад одоо бараа үйлчилгээ тэр барилга байшин барихад нь дандаа муу тийм чанарын стандарт шаардлага хангаагүй тийм байшин барилга худалдан авалтууд хийгдэж байгаа. Эргээд 1 жилийн дараа 2 жилийн дараа магадгүй нөгөө барилга байшингаасаа илүү үнэ одоо мөн засвар үйлчилгээний хөлс нэхээд зогсож байгаа ийм л түүх байгаа шүү дээ. Дүр зураг байгаа.

Тэгэхээр бид нар энэ үнэ гэдэг зүйлийг анхаарах ёстой юм. Хамгийн бага үнэ гэдэг чинь үндсэндээ хамгийн чанаргүй зүйл гэсэн үг шүү нэг талдаа.

Тэгэхээр энэ дээр ямар зохицуулалтуудыг хийж өгөхөөр тусгасан байгаа юм бэ гэдгээ асууя.

Хоёрдугаарт нь үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд худалдан авалт хийх боломжууд байгаа юу?

Тухайлбал би ганцхан салбараар жишээ авъя эрүүл мэндийн салбар нэгж кейс ярья. Өвдөгний үе солих протез 800-аас 1000 доллароор хилээр орж ирсэн байгаа. Эргээд эмнэлэгт нийлүүлэхдээ 7 сая төгрөгөөр нийлүүлэгдэж байгаа. ЭМД-аас санхүүжих дүн нь 6.5 сая. Энэ хооронд 3 сая гаран төгрөг хэн нэгний карманд орж байна. Энийг алга болгох хэрэгтэй шүү дээ. Бид нар шууд худалдан авалтуудыг хийх боломжуудыг гаргаж өгөх хэрэгтэй. Энэ дээр ямар зохицуулалтууд хийх юм бэ? Зарим тодорхой салбарууд дээр.

Гуравдугаарт нь энэ иргэд бичил бизнес эрхлэгчдийг хэрхэн дэмжих юм бэ? Бид нар бол жижиг, дунд үйлдвэрлэл гэж ярьсаар байгаад л одоо тэгээд тэр жижиг, дунд үйлдвэрлэл нь боломжийн хэмжээнд ингээд хөгжсөөд явж л байгаа. Орхигдоод орхигдож байгаа тэр зүйл бол иргэд бичил бизнес эрхэлж байгаа хүмүүс. Өнөөдөр бид нар худалдан авалтад ороход заавал компани байх ёстой гээд заагаад өгчихсөн. Би одоо Бат-Эрдэнэ гишүүний саналыг дэмжинэ л дээ. Иргэд байхгүй, хоршоо нөхөрлөл байхгүй босго нь одоо өнөөдөр 20 сая. Шууд худалдан авалт цаг үеэ мэдэрч, зөв тооцоолж, босго үнээ гаргаж ирэх хэрэгтэй.

Дээрээс нь иргэдээ хоршоо нөхөрлөлүүдийг энэ худалдан авалтад оролцох боломжуудыг нь нээж өгөх хэрэгтэй. Хэт төвлөрүүлээд хэт 1 нэр бариад явах нь өөрөө ристэй юм. Магадгүй иргэд хоршоо нөхөрлөлүүдийг бид нар дэмжиж өгөх юм бол хуулийн зохицуулалтуудыг хийж өгөх юм бол илүү том эдийн засгийн потенциалыг орон нутагт бий болгох боломжоор бүрдсэн шүү. Олон үр дүнгүүд гарна, ажлын байр нэмэгдэнэ, иргэд тодорхой хэмжээний орлоготой болно. Тэгээд үйлдвэрлэлээ нэмэгдүүлээд жижиг, дунд үйлдвэрлэлүүд шат дараалсан шилжилтүүд хийгдэх ийм боломжууд бүрдэнэ ээ гэж одоо харж байна. Тэгэхээр энэ тал дээр ямар өөрчлөлтүүдийг энд хийж өгөх юм бэ? Бас нэг зүйл байгаа. Бид нар чанар стандарт гэж ярьчихаад тэгээд орон нутгийн одоо үйлдвэрлэгч нарыг худалдан авах боломжуудыг байхгүй болгодог шүү. Чанар стандартын шаардлага хангаагүй гэдэг үгээр тэр худалдан авалтыг зохион байгуулж байгаа хүмүүс чинь ам хаагаад гаднын импортын юмнуудыг дэмждэг ийм нөхцөл байдал байгаа.

Нөгөө талдаа дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжих нь зөв. Тэгэхдээ өнөөдөр хэрэгжиж байгаа цахим дэлгүүрт одоо жишээлбэл ширээ сандал

хийе хүүхдийн сургуулийн гэхэд асар үнэтэйгээр байриччихсан байгаа шүү.

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг хараад юу гэж дүгнэж байгаа вэ гэхээр манай төрийн худалдан авалтын бодлогод зах зээлийн судалгаа буюу маркетингийн асуудал байх шаардлага байна гэж харж байгаа юм. Зах зээлээ судалж үнэ ханшийнхаа төлөвлөлт, тухайн нөхцөл байдлыг үнэлж байж бид нар худалдан авалтынхаа бодлогыг гаргаж өгөх ёстой. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр энэ маркетингтай холбоотой зах зээл судалгаатай холбоотой асуудлууд туссан уу? Ийм нэгж байгуулах зайлшгүй шаардлага байна гэж хараад.

Л.Мөнхбаатар: Батлут гишүүний асуултад Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул хариулъя. 82 дугаар микрофон Батзул даргын микрофон өгөөрэй.

Ц.Батзул: Батлут гишүүний асуултад хариулъя аа.

Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг шинэчлэх зорилт орсон. Ингээд цахим хэлбэрт бүрэн шилжих, хүний оролцоог бууруулах чиглэлээр бол хуулийн төсөлд бол томоохон өөрчлөлтүүд бол орж байгаа. Одоо бол ААН-үүд тендер нэрээр I материалыг олон давтан илгээдэг тэгээд тэр мэдээлэл нь бодитой бодьгүйг нь үнэн бодит байдлыг нь шалгадаггүйгээр тендер шалгаруулалт явуулдаг учраас дээрх асуудал бас гарч байгаа.

Тэгэхээр цаашидаа тендер шалгаруулалтыг төр өөрийнхөө одоо тендер шалгаруулалт төр өөртөө байгаа мэдээллийг ААН-ээс асуулгүйгээр өөрийнхөө мэдээллийн сан дээр үндэслэж үнэлгээ хийх боломжийг нь бол олгоно. Мөн энэ үйлдвэрлэгчээс худалдан авах асуудал дээр нь нэг жишээ хэлэхэд

өрсөлдөөнийг нь илүү олон болгочих юм бол бид нар энэ үнэ бол аяндаа буурдаг гэдгийг нь бол сая Эрдэнэс Тавантолгой нүүрс тээврийн тендерээс харсан. Нийтдээ манай Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр нүүрс тээврийн тендер шалгаруулалт явсан. Нийт 217 компаниас санал ирсэн. Тэгээд 108000 төгрөгийн тээвэрлэлтийн хөлсийг нь бид нар 54000-аар тогтоож бүүр 2 дахин буулгаж ирсэн ийм сайн жишээ байгаа.

Тэгэхээр цаашидаа энэ өрсөлдөөнийг улам бодитой болгох оролцох боломжийг нь нээх, тэгээд энэ оролцоход саад тоггор үзүүлдэг зүйлсийг нь бол бид нар хуулийн төслөөрөө маш багасгаж өгсөн. Нөгөө талдаа бас бичил бизнес эрхлэгч буюу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид нь бол дэмжиж байгаа. ЖДҮ-лэгчдийн үйлдвэрлэж байгаа бараанд бол бусад бараанаас илүүтэйгээр 15 хувийн давуу эрх олгож байгаа юм. Хуулийн төслийн 4.1.2 дээр хүн, хуулийн этгээдийг нь тендерт оролцогч аж ахуй эрхлэгчээр тооцож хуулийн төсөлд шинэ томъёо оруулж ирсэн.

Тэгэхээр цаашидаа бол та хувь хүн байна гээд тендерээс татгалздаг. Ийм юм бол байхгүй. Одоо ч гэсэн уг нь бол хувь хүн орсон тохиолдолд та хувь хүн орж болохгүй ээ гэдэг ийм зохицуулалт бол байхгүй явж байгаа.

Нөгөө талдаа би түрүүн Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулсан нөгөө чанар стандартын шаардлага хангасан дотоодод үйлдвэрлэж байгаа барааны жагсаалт батална аа. Энэ жагсаалтад багтсан барааг нь бол тухайн үйлдвэрлэгчдээс нь л авдаг. Ийм хуулийн зохицуулалтыг нь бол хуулийн төсөлд 8 дугаар зүйлд нь бол тусгайлан заасан байгаа. Тэгэхээр цаашидаа бол илүү өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор оролцох боломжийг нь нэмэгдүүлэх замаар үнэ тогтох мөн нөгөө талдаа тэр цахим дэлгүүр дээр байгаа барааны үнийг нь бол салбарын яамдуудаас ирсэн үнэ

дээр нь өмнөх онуудын жишигт тавьсан үнээр нь тооцож байгаа. Тэгээд 2 үе шаттайгаар сонгон шалгаруулалт явагддаг. Эхний тавьсан тааз үнээс 2 дахь шатанд доошоо үнэ хаялцах замаар шинэ үнэ тогтоож тэр үнээрээ бараагаа нийлүүлдэг ийм тогтолцоо байгаа юм.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Тэгэхээр миний түрүүний асуусан 3 асуулт ерөнхийдөө төр өөрөө маркетинг хийхгүй байгаатай холбоотой асуудал байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтаар бид нар тийм зүйл хийж болохгүй юм уу, тийм бүтцийг бий болгож болохгүй юу? Энэ бол илүүтэйгээр зөв шударга, стандарт шаардлага хангасан, зах зээлийн үнэтэй нийцсэн тийм худалдан авалтыг хийх боломжийг бүрдүүлж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч ээ.

Зүгээр өрсөлдөөний зарчим гэж ярьж байна л даа. Зарим нэг салбар дээр тухайлах юм бол эрүүл мэндийн салбар дээр шууд өрсөлдөөний зарчмыг тавиад байх нь хэр оновчтой вэ? Магадгүй тийм топ үйлдвэрүүд байгаа шүү дээ. Тэндээс бид нар яг үйлдвэрийнх нь үнээр шууд худалдан авалтууд хийх боломжуудыг гаргаж өгөх хэрэгтэй юм гэж. Одоогийн хууль дээр нөгөө талдаа одоогийн хууль дээр иргэдийг дэмжсэн бодлого байгаа гэж байхгүй шүү. Наад орон нутгийнхан чинь тийм боломжийг гаргаж өгөхгүй бол орон нутагт тийм боломжийг гаргаж өгөхгүй байгаа. Иргэд аж ахуйн нэгж гэхээс илүү иргэд нөхөрлөлүүдийг маш сайн дэмжих хэрэгтэй. Бичил бизнесийг дэмжих бодлогыг энэ хууль.

Л.Мөнхбаатар: Батзул дарга тодруулгад хариулъя.

Ц.Батзул: Батлут гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 56

дугаар зүйл дээр энэ худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чиг үүрэгт нь энэ цахим дэлгүүрт байршуулах барааны үнийн судалгаа хийдэг ийм чиг үүргийг өгсөн. Үүнтэй холбоотой бас нэгж бол манай төрийн худалдан авах ажиллагааны газар байгаа. Одоо хуулийн тогтоол дээр болохоор 7¹-ээр олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам буюу тухайн дүүрэг сумын төсөвт өртгийн 20 сая төгрөгөөс хэтрэхгүй төсөвт өртөгтэй бараан дээр бол иргэд бүлэг байгуулаад оролцдог энэ зохицуулалт байгаа. Жилдээ бол нэг 900-гаад сая төгрөгийн худалдан авалт хийгээд явдаг ийм зохицуулалт байгаа. Орхон аймагт бол бас энийг нэлээдгүй хэрэглэдэг. Баян-Өндөр сум дээр бас олон сайн жишигүүд байдаг юм байна лээ.

Л.Мөнхбаатар: Батлут гишүүн тодруулж асууя 1 минут.

Д.Батлут: Тэгэхээр энэ хуулийг бид нар сайжруулахын тулд л өнөөдөр ингээд мэтгэлцээд сууж байгаа юм. Нэг зүйлийг хэлье. Зүгээр жишиг үнэ урьдын одоо бас хэрэглэж байсан үнэ үнийн судалгаа энэ тэр хийх гэхээсээ илүүтэй тухайн цаг мөчийнхөө судалгааг хийдэг маркетингийн тийм албатай болох хэрэгтэй. Энэ шинэ тутам нэгж байгуулах гээд одоо гол биш илүү тийм хэмнэлттэй үр дүнтэй хөрөнгө оруулалт хийхийн тулд энийг хийх ёстой гэж үзэж байгаа. Тэгэхээр энийг энэ хууль дээрээ бас оруулж өгөх тал дээр анхаараач ээ. Нөгөө талдаа иргэд нөхөрлөнө, одоо хоршоо байгуулна, нөхөрлөнө гэж байна. Үгүй ээ яах вэ тийм жишиг явж байгаа. Зөвхөн иргэн хүн бас орж болохгүй юм уу бичил бизнес эрхэлж байгаа энэ боломжийг нь бас нээж өгөөч ээ гэдэг санааг энэ санааг л хэлээд байгаа юм шүү дээ. Заавал нэгтгэх гээд байдаг. Хүчээр нэгтгэх асуудал байж болохгүй шүү дээ. Иргэн хүн дангаараа бизнес эрхлэх боломжууд байна тэр боломжийг нь. Тэгвэл төр яагаад дэмжиж өгч болохгүй

байгаа вэ гэж. Тэрийг нь бид нар худалдан авалтынхаа бодлогод оруулаад өгье л дөө.

Орон нутагтаа дэмжиж түлхүү одоо боломжуудыг нь олгоод өгье л дөө. Энэ бол хамгийн сайн зөв. Батлут гишүүн санал хэллээ.

Л.Мөнхбаатар: Одоо Чинбүрэн гишүүн асуултаа асууя.

Ж.Чинбүрэн: Миний асуух гэж байгаа зүйл бол энэ эм эмнэлгийн хэрэглэгдэхүүнтэй холбоотой асуудлыг ярих гэж байна аа. Тэгэхлээр ер нь энэ түрүүн бас даргаас чиглэл өгсөн. Одоо найруулга дээр нь засвар хийх асуудал яриад өгчихлөө гэж би ойлгосон гэлээ. Гэхдээ энд бас хэдэн зүйлийг хэлмээр байна. Ер нь энэ эм эмнэлгийн хэрэглэгдэхүүн вакцин энэ тэр дээр бол ер нь хямд үнэ гэж ярьж болохгүй ээ. Бид сүүлийн 30 жил яг энэ тендерийн хуулиар яваад энэ нь өөрөө хямд үнэтэй эмүүдийг эмнэлгүүд нь худалдаж авдаг. Эмнэлгүүд гэдэг маань дандаа л нөгөө төрийн өмчит эмнэлгүүдээ л ярьж байгаа шүү дээ. Гол одоо худалдан авагч нар нь тэгээд тэндээ чанаргүй эмээс болоод чанаргүй эм эмнэлгийн хэрэглэгдэхүүнээс болоод нөгөө өвчнөө үр дүнг нь тооцож чаддаггүй. Буцаад зах зээл дээр нөгөө бүртгэсэн эмээ хэр зэрэг үр дүнтэй байна гэдгээ бүртгэж чаддаггүй тогтолцоо удаан үргэлжилсээр байна.

Эрүүл мэндийн яам тэгээд өөрснөө баталчихсан байсан гээд. Та бүгд Монголд худалдаж болно гэсэн юмыг чинь л бид одоо тендерт оруулж байна шүү дээ гээд байгаа юм. Тэгтэл бид одоо энэ 2020 онд Эм эмнэлгийн хэрэглэгдэхүүний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад агентлаг байгуулаад өгчихсөн. Тэр агентлаг нь өнөөдөр тэр зах зээл дээр бүртгэсэн эмийнхээ буцаагаад чанар болон үр нөлөөллийг хянах тогтолцоо одоо хүртэл байхгүй байж байгаа.

Тийм учраас бид зах зээл дээр байгаа эмүүдийг буцаан татдаг тэрийг оруулж ирсэн компаниуддаа лицензийг нь одоо цуцлах хүртэл тийм асуудал ярьж чадахгүй суусаар өнөөдөр бид энэ хуулиас хойш 3 жил өнгөрч байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ төрийн худалдан авалт хийж байгаа ойролцоогоор нэг 220-иод тэрбум төгрөг 34 хувийн энэ эмийн борлуулалт дээрээ төр өөрөө онцгой байр суурьтай ажиллахгүй бол болохгүй ээ. Ялангуяа би энэ ажлын хэсгийн ахлагч танд бас бүүр зориуд хэлмээр байгаа байхгүй юу. Тэмүүлэн гишүүн энд бид нар ерөөсөө энэ эмийн асуудал дээр хямд үнэ гэхгүйгээр яаж чанартай эмийг өсгөсөн өртгөөр авахгүй байх боломж байна вэ гэдгийг заавал энд ярилцсан байх ёстой. Би бас харамсаад байна. ЭМЯ-нд санал өгсөн ерөөсөө хариулт өгөөгүй гэж байна шүү дээ.

Тэгтэл ДЭМБ-аас эмийн чанарыг буулгуулах гэхээр үнэ буулгах 10 төрлийн аргууд байж байна шүү дээ. Тухайлах юм бол одоо бид нар гэрээ хэлэлцээр хийхдээ дандаа нэг жилээр хийж байна. Тэгтэл сайн эмийг тэр одоо оригинал бүтээгдэхүүн хийдэг үйлдвэрлэлтэй үйлдвэртэй 2, 3 жилийн гэрээ хийх юм бол тэртээ тэргүй одоо дэлхийн зах зээл дээр байгаа аспирын өөрчлөгдөхгүй байхгүй юу. Тэгэхээр тэр аспириныг эхний жилдээ одоо юу гэдэг юм. Дотоодын зах зээл дээр зуун төгрөг байгаа юм мянган төгрөг болж магадгүй оригинал бүтээгдэхүүн үнэтэй. Тэгвэл 2 дахь жилдээ 50 хувийн хөнгөлөлт үзүүлнэ. 3 дахь жилдээ тэр чинь ахиад дээрээс нь нэмээд 25 хувийн хөнгөлөлт буюу 75 хувийн хөнгөлөлт үзүүлээд үнэ буудаг аргууд зөндөө байгаа.

Тийм учраас би бас одоо ажлын хэсгийнхнээс асуух гэж байна. Ер нь энэ хугацааны хувьд ялангуяа эрүүл мэндийн салбарын энэ бүтээгдэхүүн дээр 1 жил гэсэн тийм заалт байна уу? Энийг одоо саяын хэлдгээр 3, 4, 5 жилээр хийх боломж бий юу гэдэг 1 асуулт.

Хоёр дахь чухал зүйл бол бид дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэмжинэ ээ гээд байгаа юм зөв өө. Гэхдээ энэ дээр би ч өөрөө эмнэлгийн даргаар 3 жил ажиллаж байсан. Дотоодын бүтээгдэхүүн ялангуяа тэр үйлдвэрлэгч байгууллага нь GMP буюу Гүүд манифакчер практисийг нэвтрүүлсэн байгууллага мөн үү биш үү гэдгээ одоо хүртэл бид яахгүй. Хуулиараа эмийн хуулиараа бол энийг чинь тийм байж болохгүй гэж хэлчихсэн хэрнээ тийм үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулаа байгаа байхгүй юу. Тэгээд үйлдвэрлэлийнхээ чанарыг сайжруулахгүй болохлоор өртөг зардал нэмэгдэхгүй тэгээд хямдхан үнэ өгдөг. Хямдхан үнэ нь эцсийн бүтээгдэхүүнийхээ үр дүнг хянах тогтолцоо байхгүй болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр бас бид анхаарч энэ дотоодын бүтээгдэхүүн гэдэг дээр бүүр GMP шаардлагыг нь хангасан энэ тэр байх тал дээр нь анхаарч энэ ажиллах хэрэгтэй. Энэ дээр тийм зүйлүүд байна уу энд хариулт өгөхгүй юу?

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүн их чухал асуудлыг хөндөж тавилаа. Энэ эм, эмнэлгийн хэрэгсэл, энэ эмнэлгийн тоног төхөөрөмжийн хувьд бол бас тусгайлан авч үзэх шаардлага бол байгаа. Энэ бол одоо Төсвийн байнгын хороон дээр бас яригдсан юм байна лээ яригдсан. Гэхдээ Раднаасэд гишүүн санал гаргаад дэмжигдээгүй байгаад байгаа юм. Одоо энэ гишүүд үг хэлж асуулт асууж хариулт авсны дараа санал хураалт явагдана. 30 зарчмын зөрүүтэй санал хураалт байгаа.

Тэрэн дээр хамгийн төгсгөлд нь Раднаасэд гишүүний гаргасан санал байгаа юм.

Тэр үед бас Чинбүрэн гишүүн маань өөрийнхөө хөндөж тавьсан асуудлаар бас үг хэлээд тухайн үед нь

чиглэл өгөх ийм боломж бас байгаа гэдгийг бас танд хэлье. Энэ ямархуу зүйл байсан бэ гэхээр төслийн 5 дугаар зүйл дээр эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад энэ хуулийн хэмнэлттэй байх буюу бага үнийг сонгох аргыг хэрэглэхгүй ээ гэсэн ийм санал гаргасан юм байна лээ. Тэгээд энэ санал нь бол Төсвийн байнгын хороон дээр дэмжигдээгүй учраас энэ чуулганы нэгдсэн хуралдаанаар одоо босгох боломж нь бас байгаа гэсэн үг.

Тийм учраас одоо тухайн үед та өөрийнхөө саналыг адилхан санал байгаа учраас тайлбарлаад санал хураалтын үед бас үг хэлээрэй гэдгийг танд хэлье ээ.

Ингээд Чинбүрэн гишүүний асуултад Батзул дарга хариулах уу? Батзул даргын микрофоныг өгье.

Ц.Батзул: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Өмнө нь ч гэсэн гишүүнтэй бас уулзаад энэ талаар ярьж байсан. Тэгээд ер нь бол энэ эмийн чанарын асуудал их хүндрэлтэй. Бид нар бол ингээд 2012 оноос хойш энийг 1 чанартай болгочихъё гээд яваад хэлээд үе үеийн ЭМЯ-тай энийгээ ингээд өөрчилж болдоггүй юм уу? Тэгээд та нар үйлдвэрлүүлэх эрхийг нь өгчхөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь чанаргүй гээд нэг талдаа ярьчихаад нөгөө талдаа үйлдвэрлүүлээд байдаг энэ тогтолцоогоо эргэж харж болдоггүй юм уу гээд ярьдаг.

Тэгэхээр тусгай зөвшөөрөл олгодог этгээдүүд нь өөр чанарыг нь хянадаг этгээдүүд нь өөр байдаг учраас энэ асуудал нэг талдаа гарахгүй байна.

Хоёрдугаарт энэ бид нар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад бүүр 28.7.5-аар чанар болон үнэлгээний харьцуулалтаар нь үнэлж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нь худалдан авалтыг нь шийднэ гээд бүүр

заалт оруулж байсан. Тэгээд үүнтэйгээ холбогдуулаад бид нар бүүр эмийг худалдаж авдаг тендерийн жишиг баримт бичгийг тусгайлан батлаад тэрнийхээ дагуу тендерийг явуулдаг. Тэгээд тэрүүн дээрээ бид нар энэ GMP сертификат болон хатуу орны зохицуулалтын дагуу санал болгож байгаа бараануудын чанарыг нь үзээд тэгээд үзэхээр одоо ингээд Монгол Улсад орж ирж байгаа энэ хатуу орны зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эмүүд байдаггүй. Австрали, Шинэ Зеланд, одоо Америк, Английн тэр эмүүд нь ерөөсөө орж ирдэггүй. Нөгөө талдаа энэ дотоодын үйлдвэрлэгч нь зах зээлээ барьчихсан тэгээд гаднаас ийм юм орж ирдэг дээр нь маш их эсэргүүцэл өгдөг 2017 онд бид нар анх энэ дотоодод үйлдвэрлэж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалуудыг ерөнхий гэрээнд оруулах үед бол эмийн үйлдвэрлэгч нар маш ихээр эсэргүүцэж байсан. Тэгээд одоо бол бид нар ер ерөнхий гэрээнд оруулчихсан тодорхой нэр төрлийн эмүүдийг нь бол бүх эмнэлгүүд авч байгаа. Сүүлдээ бас нэг ковидын үеэр бол Монос Группийн захирал Хүрэлбаатар хүртэл тэгж ярьж байсан. Хамгийн их тендерт ордог мөртөө би тендерт орохоо больчихсон гээд ийм зөрүүтэй мэдээлэл хүртэл өгөөд явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол үнэхээр ярих асуудал бол мөн үү мөн. Тэгэхдээ энийг нь бид нар яг тендерээр энэ салбарт байгаа энэ гэжгийг нь засна гэх юм бол бас буруу байгаа онохгүй байгаа юм болов уу л гэж хараад байгаа юм. Тэгээд ажлын хэсэг дээр бол энийг нь ярьсан тэгээд ЭМЯ-тай бол бас энэ асуудлаа ярьж байгаа.

Төсвийн байнгын хорооны хурлын үеэр бол Булгантуяа сайд бас санал хэлсэн. Сая Засгийн газрын түвшинд бол эмийн чанарын асуудлаар нь тусгайлсан ажлын хэсэг гараад энэ талыг нь бол шийдэхээр ажиллаж байгаа гээд ярьсан. Тэгээд энэнтэйгээ уялдуулан Худалдан

авах ажиллагааны хуулийг нь бас уялдуулах асуудлыг нь бас давхар ярьж байгаа. Одоо бол хуулиараа эмийн худалдан авах гэрээг нь бол 3 хүртэл жилээр байгуулах эрхийг нь бол энэ хуулийн төсөл дээрээ нээгээд өгчихсөн байгаа.

Тэгэхээр цаашидаа бол 3 жилээр эм нийлүүлэх гэрээг нь бол байгуулах боломж бол бүрдэнэ ээ.

Тэгэхээр жил болгон эмнэлэг тендер гээд байх шаардлагагүй. Энэ үедээ бас нөгөө гэрээний явцад үнэ өсөх асуудал дээрээ бас нэлээн уян хатан байхгүй бол бас дараа жилд нь инфляц болон валютын ханшийн нөлөөллөөс хамаараад одоо энэ онд байгуулсан гэрээний үнэ 2024, 2025 онд өсөхөд яах вэ гэдгийг нь бас уян хатан байдлаар зохицуулж тухайн гэрээндээ тусгайлан заах шаардлага бол байдаг юм байна лээ.

Хариулж дууслаа.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүн тодруулж асуух уу? Тодруулъя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Тэгээд Батзул дарга бас чухал зүйлүүдийг хэллээ.

Мэдээж энэ эм дээр бол бид үнэхээр одоо хямд үнэтэй гэж байж болохгүй ээ. Ер нь гишүүд олон гишүүд хэллээ. Үнэ чанар 2 л угаасаа уяатай холбоотой шууд хамааралтай зүйл. Тийм учраас энэ дээр бас олон талаас нь судалж үзсэн байна. Хатуу зохицуулалттай орны одоо асуудлыг хүртэл ярьж байна. Энэ их сайн байна. Одоо Засгийн газар ялангуяа ЭМЯ Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслөө өргөн барих ёстой. Энэ дээр бол энэ асуудлууд нэлээн шийдэгдэнэ. Гэхдээ энэ Тендерийн энэ хууль дээр бид энэ асуудлуудыг нэлээн сайн оруулж өгөхгүй бол болохгүй юм аа. Тийм учраас хурлын

даргын хэлж байгаачлан тэр унасан санал дээр одоо хэдүүлээ дэмжээд оролцох нь их чухал байна гэдгийг бас гишүүддээ бас уриалж хэлмээр байна аа.

Л.Мөнхбаатар: Чинбүрэн гишүүн санал хэллээ. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 30 санал байгаа. Энэ саналын томъёоллоор санал хураана.

Гэхдээ санал хураалтыг үдээс хойших хуралдаан буюу 14 цагаас санал хураалтаар эхэлье гэж бодож байна.

Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөж байна. Ажлын хэсэгт баярлалаа.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 27-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Одоо зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Асуулт, хариултын цаг дуусаад гишүүд асуулт хариулт авч дуусаад, санал хураалт явах гэж байгаа тул чуулганы танхимд гишүүд цугларна уу.

Тэмүүлэн гишүүн хаачив? Байнгын хорооны дарга. Тэмүүлэн гишүүн санал

хураалтад бэлдээрэй, гишүүдээ оруулаарай.

Тэгээд сайд нь ирэхгүй бол би шууд хойшлуулчихдаг болчихсон шүү. Сайд нар хаачсан юм. Энэ Сангийн яамныхан сайдаа дуудахгүй бол хойшлууллаа.

Тэр ч бас таны эрх ашигт ч нийцүүлнэ ч гэж байхгүй. Пүрэвдорж завсарлага авсан, гишүүдээ дуудаарай. Тогтохсүрэн дарга санал хурааж болж байна уу? Тогтохсүрэн дарга аа, 7, 10, 4 хүн байна. Энхбаяр дарга танай асуудал бэлэн үү. Танайхыг орууллаа, бэлэн бол. Сайд нар байхгүй учраас хойшлууллаа.

Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хэлэлцэх асуудлыг холбогдох сайд нар байхгүй байгаа учраас хойшлууллаа. Санал хураалтыг хойшлуулъя.

Дараагийн асуудалд орно.

ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцэнэ.

Илтгэлийг ХЭҮК-ын дарга Жаргалсайханы Хунан дарга эхлээд танилцуулах юм байна. Жаргалсайханы Хунан дарга танилцуулна.

Үүний өмнө, Хунан дарга түр сууж байгаарай. Энэ гишүүд байгаа дээр 1 үүрэг даалгавар чиглэл байна. Энэ сарын инфляцын түвшин 10.9 хувь болж буурсан боловч махны үнэ өндрөөс шалтгаалаад инфляцын түвшин өндөр байна. Иргэдийн нийгмийн судалгаагаар Улсын Их Хурал дээр ирүүлсэн санал, гомдол, өргөдөл, хүсэлтүүдийг харахад үнийн өсөлтийн асуудал одоо иргэдийн гол санаа зовоосон амьдралын амьжиргааны өртөг доройтлын асуудал болсон байна.

Тийм учраас амьдралын чанар, үнийн өсөлт, өртгийн талаар судалгаа хийж хагас, бүтэн сайн өдөр Эдийн засгийн байнгын хороон дарга Цэрэнпунцаг гишүүн, нийслэлээс сонгогдсон гишүүн Бадарчийн Жаргалмаа, Эдийн засгийн байнгын хорооны гишүүн манай Жадамбын Бат-Эрдэнэ, Төсвийн байн байнгын хороон дарга Тэмүүлэн бусад Цэндийн Сандаг-Очир гишүүн нарын бүрэлдэхүүнтэй гишүүд энэ захуудаар явж тэр нөөцийн махны өргөтгөсөн худалдаа энэ тэр хийнэ гэсэн байна лээ. Үнийн өсөлтийн асуудлыг судалж, тэр үнийн өсөлттэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг хянан шалгаж танилцуулна.

Төсвийн байнгын хорооны дарга төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудал, эмч, багш нарын цалингийн холбоотой асуудал, төсвийн тодотгол хийх шаардлагатай асуудлуудыг судалж танилцана. Төрийн албаныхантай уулзаж, эмч нартай, багш нартай, үйлдвэрчний эвлэлтэй уулзана. Ийм үүрэг, чиглэл өглөө шүү.

Одоо ингээд ХЭҮК-ын дарга Жаргалсайханы Хунан илтгэлийг танилцуулна.

Ж.Хунан: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7-гийн 1-ийн 12, 9 дүгээр зүйлийн 9-ийн 1, 17 дугаар зүйлийн 17-гийн 1 дэх хэсэг, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15-ын 1-ийн 4, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10-ын 3-ын 5-д заасан чиг үүргийн дагуу комиссоос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 22 дахь илтгэлийг холбогдох саналын хамт 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн.

Энэ удаагийн илтгэлийг комиссоос 2022 онд гүйцэтгэсэн судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ, комисст ирсэн гомдол, мэдээлэл болон комиссын гишүүний санаачилгаар хийсэн хяналт шалгалтын үр дүн, төр, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын албан ёсны тайлан, мэдээлэл болон бусад эх сурвалжид үндэслэн 7 бүлгийн хүрээнд боловсруулж бүлэг тус бүрээр тоймлон танилцуулж байна.

1.Халдашгүй чөлөөтэй байх эрхийн хэрэгжилтийн хүрээнд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, бүх насаар хорих, ганцаарчлан хорих ял эдлүүлж буй байдал, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндлөө. Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн дэвшилттэй зохицуулалт Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуульд тусгагдсан хэдий ч хуулийг хэрэгжүүлэх явцад эрх зүйн хийдэл үүсэх, хуулийн заалтыг 1 мөр ойлгож хэрэглэхгүй байх, алба хаагчдын мэдлэг, хандлагаас шалтгаалан хүний халдашгүй чөлөөтэй байх эрх зөрчигдөж байна.

Монгол УЕПГ-ын мэдээгээр 2020-2022 онд нийт 2674 сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж, үүнээс 1079 буюу 40.3 хувийг нь шүүх, прокурор, баривчлах байрны даргын шийдвэрээр сулласан байна. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах, хойшлуулигүй тохиолдол, гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан зэрэг үндэслэлүүдийг тодорхой хязгаарлалтгүйгээр хэт өргөн хүрээтэй хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 9 дүгээр зүйлийн үзэл санаанд нийцээгүй байна.

Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа шүүхийн хяналтад бүрэн ороогүй байгаа нь хүнийг хууль бус, дур мэдэн баривчлах нөхцөлийг бүрдүүлж, ЭХХШТХ-д заасан мөрдөгч сэжигтнийг баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор шийдвэрийг шүүхэд даруй хүргүүлнэ. Сэжигтнийг баривчилсан бол 24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ гэсэн хуулийн заалт 1 мөр хэрэгжихгүй байна. Түүнчлэн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх нийтлэг журам тухайн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа нь хүний эрхийг зөрчих нөхцөлийг бүрдүүлж байгаа тул Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод бүрэн нийцүүлэх шаардлага тулгарч байна.

2015 оны Эрүүгийн хуульд бүх насаар хорих ялын агуулга дэглэмийг бүрэн тодорхойлоогүй, бүх насаар хорих ял эдэлж байгаа хоригдлын эрхийг хангах талаар одоогийн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна. Эрүүгийн хуульд заагаагүй ганцаарчлан хорих ял эдлүүлэх шийтгэл өнөөг хүртэл байсаар байгааг комисс хүний эрхийн зөрчил гэж үзэж байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл хоцрогдсон, сэтгэцийн өвчтэй хүнд холбогдох хэргийг шийдвэрлэхэд өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн албадлагын арга хэмжээ үргэлжлүүлэх, сунгах, зогсоох, эмнэлгийн төрөл дэглэм эмчлэгдсэн боловч ар гэрийнхэн хүлээж авахаас татгалзсан хүнийг нийгэмд гаргах талаарх эрх зүйн орчин нь тодорхой бус байгаагаас хүний эрх зөрчигдөх явдал түгээмэл байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлаж саатуулах арга хэмжээг хэрэгжүүлэх процессын зохицуулалтыг нарийвчлан

хуульчлаагүй нь хүнийг дур мэдэн саатуулах, эрх чөлөөг хязгаарлах эрсдэлийг бий болгож байна.

2.Иргэний төрийн үйл хэрэгт шууд оролцох боломжийг бүрдүүлэгч суурь нөхцөл Монгол Улсын иргэний үндсэн эрх чөлөө болох хэвлэн нийтлэх тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэж, олон нийтийн байгууллага байгуулах эрх чөлөөний асуудлыг Иргэний оролцооны эрх зүйн зохицуулагч бүлэгт тусгалаа. Хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчдийн хараат бус олон ургалч дуу хоолой нэмэгдсэн нь 1 талаас тэдний үйл ажиллагааг хянах, эдийн засгийн болон бусад аргаар нөлөөлөх сонирхлыг нэмэгдүүлж байна.

Нөгөө талаас хэвлэл мэдээллийн санхүүжилтийн хязгаарлагдмал нөхцөл нь салбарыг ийм нөлөөлөлд эмзэг болгожээ. Энэ нь хэвлэл мэдээллийн эзэмшлийн хэт төвлөрөл, ил тод бус байдал, бүх төрлийн цензур хэлбэрээр илэрч олон нийт хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд үл итгэхэд хүргэж байна. Цаашид хараат бус мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллагыг төлөвшүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бэхжүүлж, олон ургалч, ил тод байдал, хариуцлагыг нь дээшлүүлсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсад 2020 оноос 2023 онд 736 удаагийн жагсаал цуглаан зохион байгуулагдсаны 649 нь Улаанбаатар хотод, 87 нь орон нутагт зохион байгуулагджээ. Үйл явдал, хэрэг тохиолдлын улмаас зохион байгуулагчгүй, бүртгэх боломжгүй цуглаан аяндаа үүсэх, 1 цуглааныг эсэргүүцсэн зэрэгцээ цуглаан гарах, иргэний үл захирагдахуйн ақи явуулах, хэн болохоо илчлэхгүй эсвэл урлагийн хэв маяг бүхий бүтээлч хэлбэрээр цахим орчинд цахим болон биет байдлыг хослуулж үзэл бодлоо илэрхийлэх боллоо.

1994 онд батлагдсан Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн зарим ойлголт зохицуулалт хэт ерөнхий байгаагаас иргэд, төрийн албан хаагчид хооронд үл ойлголцол үүсэж байна. Өнгөрсөн туршилагад үндэслэн цаг үеийн шаардлагыг харгалзан жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг зайлшгүй шинэчлэх нь зүйтэй байна. Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний үндсэн дээр байгуулагдах төрийн бус байгууллагууд төрийн бодлого хууль тогтоомжид олон нийтийн дуу хоолойг тусган сайжруулах, төрд хяналт тавих, иргэний боловсрол, ардчилсан соёлыг түгээхэд жинтэй хувь нэмэр оруулж ирсэн. ТББ-ын бүртгэл, зохицуулалтыг сайжруулах зорилгоор Засгийн газраас боловсруулж 2021 онд УИХ-д өргөн мэдүүлсэн Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг олон улсын хүний эрхийн зарчим, хэм хэмжээ, сайн туршилагад бүрэн нийцүүлж батлах нь чухал байна.

3.Монгол Улсын нийт ажиллах хүчний 18.4 хувийг эзэлдэг 225205 төрийн албан хаагчдын 67.6 хувийг эзэлж буй төрийн үйлчилгээний албан хаагч, 20.9 хувийг эзэлж буй төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт болон хоригдлын ажил хөдөлмөрийн нөхцөл байдал нь олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан 29 105-дугаар конвенцын үзэл баримтлал стандартад нийцэж буй эсэхэд дүгнэлт хийлээ.

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлал нь улс төрөөс хараат бус, мэргэжсэн, тогтвортой буюу чадахуйн зарчимд тулгуурласан байхаар заасан нь сайшаалтай боловч түүнд орсон олон удаагийн нэмэлт, өөрчлөлт нь тус хуулийн анхны үзэл баримтлал, суурь зарчим алдагдсан гэж комисс үзсэн.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээ

амьжиргаанд нь хүрэлцдэггүй, эдийн засгийн агуулгаараа ядуурлын нөхцөлд байна. Боловсролын байгууллагын удирдлага, ялангуяа сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчдийн томилгооны асуудал нь улс төрөөс хамааралтай, тогтворгүй байгаа нь алба хаагчдаас ажил үүргээ хэвийн явуулахад сөргөөр нөлөөлж байна аа.

Харин эрүүл мэндийн байгууллагын алба хаагчдын хувьд ажлын ачаалал их, аюулгүй байдал хангалтгүй, эмч эрүүл мэндийн алба хаагчдад үйлчлүүлэгчийн зүгээс үзүүлэх дарамт, шахалт, зүй бус харьцах асуудал их байна.

Төрийн цэргийн болон цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг олон салбарын хуулиар ялгамжтай зохицуулснаар алба хаагчдын цалин хөлс, нэмэгдэл тэтгэмж, урамшууллын зөрөөтэй байдал үүсгэсэн. Орон сууцны дэмжлэгийн асуудал хангалтгүй. Эдгээрээс шалтгаалж алба хаагчид өндөр цалин хөлстэй байгууллага, хувийн хэвшлийн байгууллагад эсхүл гадаад оронд ажиллах шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн. Хувцасны хангалт норм харилцан адилгүй байна.

Монгол Улсад ял эдэлж буй 92 хувь нь хэн нэгний дарамт шахалтаар бус өөрийн хүслээр хөдөлмөрийн гэрээгээр цалингийн доод хэмжээг тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцуулан авч, хараа хяналттайгаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа нь олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 105 дугаар конвенцын шаардлагад нийцэж байна аа. Гэвч хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдлуудын хөдөлмөр эрхлэх, цалин урамшуулал авах болон бусад хуулиар олгогдсон боломжийг нь эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага байсаар байна. Түүнчлэн хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь салбарын харилцаа гэж үздэг салбар

дундын бодлого хангалтгүй байгаа нь хоригдлын хөдөлмөр эрхлэлт ажлын байрыг нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

4. Хүүхдийн эрхийн зарим асуудлын хүрээнд 2017 онд байгуулагдсан гэмт хэргийн холбогдогч, хохирогч, гэрч, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа болон ЕБС-ийн дотуур байр дахь хүүхдийн эрхийн анхаарал татсан асуудлыг хөндлөө. БШУЯ-наас өгсөн мэдээллээр улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт 532 дотуур байрыг дотуур байрны зориулалтаар ашиглаж байгаагаас 477 нь стандартын, 55 нь стандартын бус гэж тэмдэглэжээ. Харин комиссоос хийсэн хяналт шалгалтад хамрагдсан 79 дотуур байрны стандартын шаардлага хангаж байгаа эсэх нь эргэлзээтэй байсан. Өнөөдрийг хүртэл дотуур байрны 1 өрөөнд олноороо амьдарч байгаа, ундны усны асуудлыг шийдвэрлээгүй, хоолны зардал хүрэлцээгүй, ариун цэврийн байгууламжийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй, эмч, эмийн хүрэлцээ дутмаг, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх төсөв байхгүй, камерын хяналт бүрэн тогтоогүй байгаа нь хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, зохистой хоол хүнсээр хангагдах эрх, цэвэр усаар хангагдах эрх, эмнэлгийн тусламж авах эрх хувийн орон зайгаа хамгаалуулах эрх, хүүхдийн хөгжих эрх, хүүхдийн хамгаалах эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна гэж комисс дүгнэсэн.

Монгол Улсад 2017 оноос хүүхэд хамгааллын шинэ механизм болох Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо ажиллаж байна. 2022 оны байдлаар улсын хэмжээнд 39 хүүхдийн эрхийн хууль зүйн хороо үйл ажиллагаа явуулж, гэмт хэргийн хохирогч болсон 703 гэмт, хэрэгт холбогдсон 577, гэмт хэргийн гэрч болсон 211, нийт 1491 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн талаар Гэр бүл хүүхэд

залуучуудын газраас мэдээлсэн. Комиссоос хийсэн хяналт шалгалтад хамрагдсан 23 хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа нь харин жигдрээгүй, тогтмол хуралддаггүй, гишүүд нь орондоо өөр хүн хуралд суулгадаг, хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал хангалтгүй, холбогдох төлөвлөгөө хөтөлбөрийг баталдаггүй, гэмт хэргийн холбогдогч гэрч хохирогч хүүхдийн асуудлыг хэлэлцсэн тохиолдол цөөн, үйлчилгээ үзүүлсэн талаар мэдээлэл тайлан бүртгэл бүрэн бус зэрэг зөрчил түгээмэл байна аа. Эдгээр зөрчлүүдийг үндэслэн ХЭҮК хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг хэлбэр төдий явагдаж үр дүн муутай хүүхэд бүрд хүрч ажиллаж чаддаггүй гэж дүгнэсэн.

5. Комисс ахмад настны эрхийн хэрэгжилт бүлгийн хүрээнд ахмад настны нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн цогц үйлчилгээний төрөл, хүртээмж хангалтгүй, тэдний хөгжих, хөдөлмөрлөх, ядууралд өртөхгүйгээр амьдрах боломж нөхцөлийг бодитойгоор бий болгох буйг онцолж байна.

Ахмадуудад төрөөс олгож буй тэтгэвэр нь наад захын хэрэгцээг нь хангадаггүй, үе үеийн Засгийн газраас тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг авдаг ч инфляцтай уялдахгүй улс төрийн шинжтэй шийдвэр гаргагдах тэтгэврийн зөрөө үүсдэг. Улсын хэмжээнд герантлогийн эмч, ахмадын кабинетын хүрэлцээ муу эрүүл мэндийн үйлчилгээ авахад дугаарлах чирэгдэл ихтэй байдал, эмийн хэт өндөр үнэ, эмч, эмнэлгийн ажилчдын зан харилцааны асуудал, Герентологийн үндэсний төвийн барилга байгууламж, материаллаг бааз, хүний нөөц, санхүүжилтийн хүрэлцээгүй байдал зэрэг нь тусламж үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн хүнд өвчтэй байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настанд өдрийн эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засах, гэрээр тусламж үйлчилгээ үзүүлж

буй байдалд онцгой анхаарал хандуулж, Засгийн газраас урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтоо эрчимжүүлэх, асаргааны даатгалын хууль, эрх зүйн орчныг нэн тэргүүнд бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн ахмад настанд ээлтэй аюулгүй орчин нөхцөл бүрдээгүйгээс гэмтэж бэртэх, хөгжлийн бэрхшээлтэй болох, ялангуяа нийгмийн амьдралд оролцоход ихээхэн саад учруулж байна. Ахмад настануудын хувьд ажил хөдөлмөр эрхлэх хүсэл зориг, идэвх санаачилга гаргаж байгаа ч хөдөлмөрийн зах зээлд тэднийг ажиллуулах ажлын байр хомс байгаа учир тэдний чадамж, бүлгийн онцлогт тохирсон ажлын байрыг бий болгох, ахмадуудыг ажилд авч буй ААН-үүдийг татварын урамшууллаар дэмжих бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Ахмад настан нь олон нийтийн газар болон хөдөлмөрийн харилцаанд насаар ялгаварлагдах, гэр бүлийн хүрээнд үл хайхрагдах, хүчирхийлэл, дарамтад өртөх явдал цөөнгүй байгаагаас гадна ганцаардах, сэтгэл санаагаа хэн нэгэнтэй хуваалцахгүй удаан явсаар сэтгэл гутралд орох, нас өндөр болсон хэмээн өөрийгөө голох нийгмээс өөрийгөө тусгаарлах тохиолдол өндөр байна.

6. Монгол Улс хүний эрх хамгаалагчийг хамгаалах бие даасан хуулийг 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр баталснаар Ази Номхон далайн бүс нутагт хүний эрх хамгаалагчийн тогтолцоог бүрдүүлсэн анхны улс болсон. Тус хуульд хүний эрх хамгаалагч, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа зэргийг нарийн тодорхойлсон хэдий ч хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдөх тэдэнд аюул эрсдэл учрах тохиолдол гарсаар байна.

Комиссоос хийсэн судалгаанд хамрагдсан 2064 оролцогчдын 92.1 хувь нь өөрсдийгөө хүний эрх хамгаалагч гэж үзсэн төдийгүй хүний эрх хамгаалагчийг

ялгаварлан гадуурхах, албан тушаалтан эрх мэдлээр дарамтлах явдал ихээхэн тохиолддог гэжээ. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар аюул, эрсдэлд өртсөн, өртөж болзошгүй хүний эрх хамгаалагч түүний хамаарал бүхий гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан хэдий ч хамгаалалтын арга хэмжээнд шаардагдах зардал улсын төс төсөвт тусгаадаагүй байна. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 20-дугаар зүйлд заасан ч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тухайн зөрчлийг ямар байгууллага хариуцан шийдвэрлэх хэргийн харьяаллыг зохицуулаагүй орхигдуулсан байна. Үүнээс үүдэн хэргийн харьяалал тодорхойгүй гэх үндэслэлээр хууль сахиулах байгууллагууд гомдлыг харилцан бие биедээ шилжүүлж байгаагаас хүний эрх хамгаалагчдын зөрчигдсөн эрх үр дүнтэй, сэргээгдэхгүй зөрчигдсөн хэвээр байна.

7. Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдал бүлгийн хүрээнд дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай гэж комисс үзсэн. Эрэгтэй, эмэгтэй хүнийг аливаа хэлбэрээр үл ялгаварлах, бүх шатны сонгуульд нэр дэвшихэд сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байх, томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль 1 хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15%-аас, дүүрэгт 20%-аас, сумд 25%-аас, хороонд 30%-аас доошгүй байхаар туссан заалтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх үр дагавар, хариуцлагын талаар зохицуулалтыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заагаагүй байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8-ын 4 дэх хэсэгт улс төрийн нам нь энэ хуулийн 8-ын 2, 8-ын 3 дахь хэсгийн

хэрэгжилтийн тайланг энэ хуулийн 18-ын 1-д заасан Жендерийн үндэсний хороонд 2 жил тутам хүргүүлж байна гэж заасан. Гэвч Улсын дээд шүүхэд улс төрийн 36 нам бүртгэлтэй байгаагаас Хүн нам, МАН, Иргэдийн оролцооны нэгдэл нам 2022 онд Жендерийн үндэсний хороонд жендерийн эрх тэгш байдлын талаарх тайлан мэдээллээ анх удаа ирүүлжээ. Бусад улс төрийн намууд огт ирүүлээгүй байна.

Эмэгтэй нэр дэвшигч, намын гишүүн, эсвэл намын харьяалалгүй байгаагаас үл хамааран нэр хүндэд нь халдах, хэл амаар доромжлох, дарамт хүчирхийлэлд өртөж байгаа нь жендерийн хэвмэл үзэл олон нийтийн дунд өнөө хэр нь бат бөх оршиж байна. Ялангуяа цахим орчинд улс төрийн албан тушаал хашиж байгаа, сонгуульд нэр дэвшиж байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү их дайралтад өртөж байна.

Монгол Улсад улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийг тусгайлан дэмжсэн санхүүжилт, урамшуулал, хөнгөлөлт байдаггүй. Нөгөө талаас эмэгтэйчүүд нэр дэвших санхүүгийн шалгуурыг тэр бүр давж чаддаггүй, санхүүгийн дэмжлэг авахад намд хүчтэй нөлөөлж чаддаггүй, дэмжлэг ижил хэмжээтэй авсан ч сонгуулийн бусад зардлыг санхүүжүүлэх хэмжээнд хандив, тусламж авч чаддаггүй байгаа нь тэдний улс төрийн оролцоог хязгаарлаж байна.

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ, Монгол Улсын ХЭҮК-оос өргөн мэдүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргаж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Одоо илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн,

Хууль зүйн байнгын хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ, Монгол Улсын ХЭҮК-оос 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг УИХ-д ирүүлсэн.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлд заасан журмыг баримтлан 2023 оны 4 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд 2 өдрийн турш олон нийтэд нээлттэй, ил тод, олон талаас нь сэдэв тус бүрээр хэлэлцлээ. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг Байнгын хорооны хуралдаанд ХЭҮК-ын дарга Хунан танилцуулсан болно.

Монгол Улсын ХЭҮК-оос Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг судалгаа, тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээ, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, дүгнэлтэд үндэслэн дараах 7 сэдвийн хүрээнд боловсруулсан байна. Үүнд:

1. Монгол Улсын ХЭҮК-т сүүлийн 5 жилийн байдлаар ирсэн нийт өргөдөл, гомдлын 17 орчим хувийг халдашгүй чөлөөтэй байх эрхийн асуудал эзэлж байгаагийн зэрэгцээ ОУБ, судлаачид энэ талаар дүгнэлт хийж, шүүмж өрнүүлж байгааг харгалзан халдашгүй чөлөөтэй байх эрхийн талаар,

2. Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, цар тахал, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан иргэдийн тайван жагсаал, цуглаан хийх эрх хангагдаж байгаа эсэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг баталгаажуулах, түүнчлэн хариуцлагатай, ил тод, иргэний нийгэмд төлөвшүүлэх эрх зүйн

зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг харгалзан иргэний оролцооны эрх зүйн зохицуулалтын талаар,

3.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд тулгамддаг нийтлэг асуудал, салбарын онцлогоос шалтгаалсан тодорхой асуудал, шалтгаан нөхцөлийг илрүүлэх, шийдвэрлэх асуудлыг харгалзан хөдөлмөрлөх эрхийн талаар,

4.Хүүхдийн эрхийг баталгаажуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүүхэд хамгааллын үйлчилгээ, бүтэц, тогтолцоог шинэчлэх, түүнчлэн хүүхдийн амь нас, эрүүл мэнд хохирох явдал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг харгалзан хүүхдийн эрхийн талаар,

5.Ахмад настны нийгмийн хамгаалал, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хөгжих эрхийн хэрэгжилт, ахмад настны хамгааллын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлуудыг харгалзан ахмад настны эрхийн хэрэгжилтийн талаар,

6.Хүний эрх хамгаалагчдын эрх зөрчигдөж байгаа хэлбэр, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн байдалд хийсэн дүн шинжилгээг харгалзан хүний эрх хамгаалагчийн эрх, хамгаалалтын талаар,

7.Жендерийн эрх тэгш байдлын талаарх хууль тогтоомжийн зохицуулалт түүний хэрэгжилт болон улс төрийн хүрээн дэх жендерийн ялгаварлан гадуурхалттай холбоотой асуудлыг харгалзан улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдлын талаар илтгэлийг боловсруулсан байна.

Монгол Улс дахь хүний эрх эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцэхтэй холбогдуулан 6

ТББ, 5 хэвлэл мэдээллийн байгууллага, 3 мэргэжлийн холбоо, 23 төрийн байгууллагаас давхардсан тоогоор 97 төлөөлөл Байнгын хорооны хуралдаанд оролцож, Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулт өглөө.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн боловсролын салбарт сүүлийн 2 жилийн хугацаанд улс төрийн албан хаагчдын томилгоогоор ажил, албан тушаалаас чөлөөлөгдөж, хөдөлмөрлөх эрх нь зөрчигдсөн иргэдийн судалгаа байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан хөдөө орон нут нутагт ажиллах боловсон хүчин хомсдолд орсонтой холбогдуулан тухайн орон нутгийн онцлогийг харгалзаж, төрийн албаны шалгалтыг ялгамжтай авах боломж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Адьшаа хүний хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн асуудлаар төрийн байгууллагуудад өгсөн зөвлөмж, шаардлагын биелэлтийн талаар, Хүүхдийн эрхийн зарим асуудлын сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан нар хүүхдийн бэлгийн хүчирхийллийн талаар болон насанд хүрээгүй хүүхэд жирэмсэн болж үр хөндүүлж байгаа асуудлыг шийдвэрлэх бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн амьдрах орчин, нөхцөл хамгааллын талаар, Ахмад настны эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир ахмадын тэтгэврийн зөрөөг арилгах бодлогын талаар болон ахмадуудад олгодог орон сууцны хөнгөлөлтөд хамрагдах нөхцөл, хамрагдсан ахмадын тооны талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр ахмад настны ганцаардлын асуудал, хүчирхийлэлд өртсөн ахмадын тоо өсөх болсон шалтгаан нөхцөлийн талаар, Улс төрийн хүрээн дэх жендерийн эрх тэгш байдлын хүрээнд Улсын Их Хурлын

гишүүн Пүрэвдорж улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог хангах зайлиггүй шаардлагатай гэж үзэж байгаа бодлогын талаар, Халдашгүй чөлөөтэй байх сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хойшлуулиггүй тохиолдолд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж болно гэсэн зохицуулалт нь хүний эрхийн ноцтой зөрчил үүсэх шалтгаан болж байгаа. Түүнчлэн аливаа этгээдийг гэмт хэрэгт сэжиглэн шалгаж байгаа үедээ гэм буруутай, гэмт хэрэг үйлдсэн мэтээр урьдчилан цахим орчинд нийтэд зарладаг. Энэ нь шүүхийн шийдвэр, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир мөрдөгчийн хойшлуулиггүй ажиллагаа нэрийн доор шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулж байгаа нь зөв эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүрээ хязгаарыг хумих хэрэгцээ шаардлага байгаа эсэх, түүнчлэн шалгаж байгаа хэргийн мөрдөн байцаалтын нууцыг задруулдаг, хэргийн үйл баримтын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргаж байгаа асуудлыг хуулийн байгууллага шалгаж байгаа эсэх талаар, Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалтын сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтэд мэдээллийг хүргэхдээ аливаа этгээдээс хараат бус байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр ХЭҮК-ын 22 дахь илтгэлийг боловсруулахдаа судалгаанд үндэслэн олон эх сурвалж ашиглан ажил хэрэгч хандсаныг онцолж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулах шатанд талуудын оролцоог хэрхэн хангасан, ямар бодлого барьж байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Адъяа гадаадын хөрөнгө оруулалттай ААН, уул уурхайн компанид ажиллаж байгаа

иргэдийн хөдөлмөрлөх эрх, эрүүл мэнд, байгаль орчны асуудлаар ХЭҮК-той хамтарч шалгалт хийх саналтай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар холбогдох хуульд хариуцлагын тогтолцоог чангаруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир улс төрд манлайлагч эмэгтэйчүүдийг сонгохын тулд сонгуулийн эрх зүйн зохицуулалтад тодорхой өөрчлөлтийг оруулах нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.4 дэх хэсэгт энэ хуулийн 112.2.2, 112.2.8, 112.2.12-т заасан танилцуулга мэдээллийг холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж танилцуулж болно гэж заасны дагуу Байнгын хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг танилцуулъя.

Жаргалсайханы Хунан ХЭҮК-ын дарга, Сангишаравын Дондов ХЭҮК-ын гишүүн, Хүрэлбаатарын Мөнхзул ХЭҮК-ын гишүүн, Ганбатын Нарантуяа ХЭҮК-ын гишүүн, Дугарын Сүнжид ХЭҮК-ын гишүүн, Батзэвэгийн Энхболд ХЭҮК-ын

гишүүн, Цээхээгийн Адьяахишиг ХЭҮК-ын Тамгын газрын дарга.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд. Нанзадын Наранбаатар, Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасалъя.

Эрхэм гишүүн Нямаагийн Энхболд асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хамт явж байгаа.

Н.Энхболд: 2 асуулт тавья. Комиссоос, Байнгын хорооноос. Энэ сүүлийн үед нийгэмд асуудал учруулаад байгаа 1 зүйл бол энэ аливаа эрүүгийн хэргийг энэ хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр урьдчилсан хуулиар хориглосон мэдээллүүдийг тараагаад, уур амьсгал бүрдүүлээд, нийгмээр яллуулдаг. Энэ нь хамгийн одоо ноцтой нь эргээд шүүх, прокурорын байгууллагууд биеэ даасан, хараат бус байдлаар ажиллахад хүндрэл дарамт учруулж байна гэж ярьж байгаа. Үүнийг зүгээр хэвлэл мэдээлэлд гарсан сургаар одоо материалаар биш, хүмүүсийн яриагаар биш, бид нар бас Байнгын хороод, тусгай хороодын шугамаар хууль хяналтын байгууллагуудтай асуудал ярьж байхдаа тодруулж асуусан. Яагаад ингээд урьдчилаад мэдээ гараад байдаг юм бэ? Хуулиар хориотой байдаг аа. Гэтэл энэ зүгээр өөрөө тэр цаас нь өөрөө хүн дээр хийсээд оччихгүй шүү дээ. Ингээд хэвлэл мэдээллийн эс үгүй бол 1 сүлжээний хүмүүст оччихоод тэр нь ийм байдал үүсгээд байна. Яагаад үүнийгээ та нар илрүүлж чаддаггүй юм бэ. Хуулиар хориотой мэдээлэл дотроосоо гараад байхад хариуцлага тооцож чадахгүй байна уу гэдэг асуудлыг удаа дараа тавьж байсан. Үнэхээр хүндрэлтэй олж чадахгүй байна аа, илрүүлж чадахгүй байна аа, ийм явж байгаа нь буруу гэдгийг өөрснөө хүлээн зөвшөөрч байгаа.

Тэгээд энэ 2 асуудалд анхаарал хандуулахад хүргээд байгаа юм л даа.

Прокурорын зүгээс энэ хууль хяналтын байгууллагууд ялангуяа мөрдөн байцаах шатанд явж байгаа үйл ажиллагаанд тавьдаг хяналтыг сайжруулах шаардлага байна аа гэж харагдаад байгаа юм. Хуучин тэр 1 тогтолцоог нь сэргээх хэрэгтэй гэж үзээд байгаа юм, олон хүн.

Тэр илрүүлж чадахгүй байгаа гэдэг нь тэр байгууллагууд өөрөө өөрсдийнхөө юмыг илрүүлж чадахгүй байна гэдэг нь бас л дотроо учиртай. Хөндлөнгөөс хяналт тавьж үүнийг илрүүлэхгүй бол болохгүй байна аа гэсэн ийм уур амьсгал их явдаг аа. Энэ дээр одоо комисс, Байнгын хороо 2 ямар бодолтой байгаа юм, юу гэж ярьсан бэ?

Хоёрдугаарт, хэрэв илрүүлж чадахгүй байгаа бол тэгвэл хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нь тэд нар хаана нэгэн газраас олсон л байж таар аа. Хэн нэгэн хүн дамжуулсан байж таар аа. Тэр хүмүүстэй нь, тэр байгууллагатай нь хариуцлага тооцож болохгүй байна уу гэхээр үгүй ээ одоо тэгээд мэдээллийн эх сурвалжаас эхлээд сэтгүүлчдийн эрх, шүгэл үлээгчдийн эрхэд халдсан ийм асуудал болчих гээд байгаа юм аа. Бас хуулийн зохицуулалт тааруухан гэж хэлж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн арга хэмжээ авах хэрэгтэй байна. Энэ талаар комисс, Байнгын хороо 2 дээр ямар яриа болсон бэ? Дүгнэлт гаргахдаа, илтгэл тавихдаа юу гэж бичсэн бэ?

Тэгээд ядаж 1 арга хэмжээ авахгүй бол ерөөсөө үнэхээр болохгүй байгаа юм. Үгүй ээ, тэр дамжуулаад байгаа хүмүүс ядаж тэр хэвлэл мэдээллийн байгууллага, тэр сэтгүүлчдээ сүүлдээ хайрлах хэрэгтэй болно шүү дээ. Бид нар олж чадсангүй ээ гэдэг нөгөө гаргасан, олон нийтэд нууц материал түгээсэн хүмүүс нь хэрэгт орчих гээд байвал тэр дамжуулаад байгаа улсууд нь тэгж дамжуулахаа болих юм биш байгаа даа гэж хүртэл бид нар асууж байсан. Энэ дээр тэгээд л тийм хөндлөнгийн хяналт хэрэгтэй байгаа юм аа.

Прокурорын байгууллагаас гэсэн. Энэ дээр яг ямар байр суурь байдал баримталж байгаа вэ? Хоёулангаас нь асууж байгаа.

Байнгын хорооны дүгнэлт нь гарсан байна. Бас нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа энэ хүрээ хязгаарыг нь хумих хэрэгцээ шаардлагын тухай бас яригдсан байна. Үүнийг зохицуулах ямар арга зам байна гэж Байнгын хороон дээр гишүүдийн зүгээс ярьсан бэ, асуусан бэ, холбогдож оролцсон хүмүүс ямар байр суурьтай байсан бэ? Энэ өөрөө нийгмийн их том асуудал болчихоод байгаа юм л даа. Ямар сайндаа хууль хяналтын байгууллагын хүмүүс, шүүх, прокурорынхон яах аргагүй энэ нь бид нарыг хүртэл одоо биеэ даасан нийгмийн дарамт уур амьсгалд авт ... /минут дуусав/

Г.Занданшатар: *Хариулт хангалтгүй бол тодруулж асууна. Хэлэлцээний журмаар. Эхлээд хариулна. Хэн хариулах вэ? Комисс, илтгэлээс асуулаа. Энхболд гишүүн хариулах уу? Батсүхийн Энхболд 84.*

Б.Энхболд: *Та бүхний өдрийн мэнд хүргэе. Энхболд гишүүний асуултад хариулъя аа. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хэргийн материалыг гаргаж тавьж байгаа асуудал яах аргагүй сүүлийн 1 жилийн хугацаанд маш их болсон. Энэ дээр бол комисс дээр өргөдөл, гомдлууд нэлээн ирдэг. Үүнийг яг шалгаж тогтооход ХЭҮК бол бас эрх зүйн орчны хувьд их хүндрэлтэй. Яг хэргийн материал руу орох ийм асуудал гардаг.*

Нөгөө талаасаа сэтгүүлчдийг нөгөө эх сурвалжаа нэрлэ гэх иймэрхүү асуудлууд бол хүндрэл бэрхшээл тулгардаг байгаа. Тэгэхээр энэ дээр эрх зүйн орчинд нь бас 1 өөрчлөлт юм уу, эргээж харах 1 асуудал байдаг юм байна лээ. Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байгаа буюу эрүүгийн хэрэг үүсгэгчсэн хэрэг дээр прокурорын

зөвшөөрөлтэйгөөр мэдэгдэх энэ эрх зүйн зохицуулалт нь байдаг. Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагаа эхлээгүй байхад энэ харилцаа бол зохицуулагдаагүй юм байна лээ. Тэгэхээр нөгөө хэрэг яг анх шалгаж эхэлж байгаа буюу сэжиглэж байгаа үндсэн тэр ажиллагаа эхлэхдээ дамжуулаад холбогдох мөрдөх байгууллагуудаас гэмт хэргийг илрүүлсэн, ийм баримтаар тогтоогдож байж болзошгүй, цаашид шалгалтын ажиллагаа явуулж байна гээд ингээд олон нийтэд зарлачих тохиолдол бол түгээмэл байгаа. Тэгэхээр үүнийг бас эргээж 1 харах шаардлагатай юм байна аа гэж ингэж үзсэн.

Өнгөрсөн онд 3 гомдлыг бид бүхэн цагдаагийн байгууллага, хэвлэл мэдээллийн зөвлөлд хүний хувийн мэдээллийг хууль зөрчиж нийтэд цацсан, дээр нь хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын ажиллагааны нууцыг задруулсан байж болзошгүй гэдгийг болбол шилжүүлж шалгуулахаар явуулсан. Үүний үр дүн бол яг ямар байдлаар гарсан бэ гэдэг дээр буцаж тодорхой хариу бол байдаггүй. Тэгээд энэ ихэнхдээ бол мөрдөн шалгах ажиллагааны яг зүгээр дотоод алба хаагч, бүр цаашлах юм бол магадгүй эрх мэдэлтэй нөлөө бүхий ер нь бол бас зарим улс төрчидтэй холбоотойгоор энэ мэдээллүүд задардаг гэдэг иймэрхүү байдлууд байгаа.

Тэгэхээр ХЭҮК энэ дээр тодорхой саналуудыг ирэх жилийн туршид гэм буруугүйд тооцогдох зарчим, хэргийн материалыг олон нийтэд задруулах, хувийн мэдээлэл хамгаалах асуудлын хүрээнд цогцоор нь бас танилцуулна гэсэн ийм байр суурьтай байгаа.

Хоёрдугаар асуудал дээр нууц мөрдөн шалгах ажиллагааны асуудлыг бол бүрэн хуулиар зохицуулах шаардлагатай гэсэн байр суурийг ХЭҮК илэрхийлж байгаа. Одоогийн байдлаар хуульд бол тодорхой заалтуудыг оруулсан

боловч эрх бүхий байгууллагуудын хамтарсан тушаалаар энэ нууц мөрдөн шалгах ажиллагааны журмыг баталж цагдан хорих байр болон бусад газруудад энэ нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаатай холбоотойгоор хүний эрх зөрчих, хэмжээ хязгаараасаа хэтрэх, гэр бүлийн гишүүд бусад хүмүүст халдаан хэрэглэх иймэрхүү нөхцөл байдал үүсэж болзошгүй байгаа гэж ингэж дүгнэсэн. Яг тэр нарийн одоо гүйцэтгэх ажлын журам дүрэм нь бол үнэхээр хаалттай, олж авч үзэж танилцахад хүний эрхийнхээ зарчмын хэмжээнд нийцэж байгаа эсэх дээр дүгнэлт хийхэд хүндрэлтэй ийм асуудал байгаа. Энэ бүхнийг Байнгын хороотой одоо нийлж холбогдох хууль тогтоомжийн энэ санал юу боловсруулахад бол ХЭҮК оролцоход бэлэн байгаа.

Г.Занданшатар: Батсүхийн Энхболд гишүүний хариултад Нямаагийн Энхболд гишүүн тодруулах уу? Байнгын хороон дарга Баттөмөрийн Энхбаяр гишүүн гүйцээж хариулъя, 2 минут.

Б.Энхбаяр: ХЭҮК-ын тайланд гарсан нийт өргөдлийн 17 нь халдашгүй чөлөөтэй байх эрхийн талаарх гомдол байгаа. Энэ халдашгүй чөлөөтэй байх эрхэд гол халдаж байгаа 1 зүйл нь бол нууц мөрдөн шалгах ажиллагаа байгаа. Нууц мөрдөн шалгах үйл ажиллагааны арга журам нь хууль, эрх зүйн хангалттай үндэслэлээр хязгаарлалт биш, байгууллагын дарга, Ерөнхий прокурор болон тагнуулын байгууллагын дарга нарын баталсан журмаар хүний эрхэд халдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл хүний эрхийг зөвхөн хуулиар хязгаарлана гэдэг Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй байгаа гэж үзэж байгаа юм. Тийм учраас энэ асуудлыг тухайлсан нарийвчилсан хууль хийх хэрэгтэй.

Мөн тэр дотроо гүйцэтгэх ажил дотор цагдаа, тагнуул, АТГ-ын нууц мөрдөн шалгах ажиллагааг хамтдаа ойлгоод байгаа. Үүнийг салгах

шаардлагатай гэж үзэж байгаа юм. Зорилгоор нь. Тагнуулын байгууллагын үйл ажиллагаа бол зорилго нь үндэсний аюулгүй байдлын эрх ашигтай учраас зорилго нь өөр. Харин АТГ болон цагдаагийн байгууллагаас хийдэг нууц мөрдөн шалгах ажиллагаа нь гэмт хэргийг шалгах, илрүүлэх, тухайн цугларсан нотлох баримт нь шүүх дээр нотлох баримтын шинж чанартай үнэлэгддэг учраас прокурорын хяналтын хүрээ хязгаар дотор энэ ажиллагаанууд явагддаг байх учиртай. Харин тагнуулын байгууллагын үйл ажиллагаа бол үндэсний аюулгүй байдлын эрх ашигийн үүднээс хийгддэг учраас бүгдийг нь прокурорын байгууллага нь хяналтад байлгаад байх шаардлагагүй гэж үздэг. Тийм учраас энэ зааг, ялгааг нарийн зааглаж ямар тохиолдолд энэ хүний эрхэд халдах вэ, хязгаарлах вэ гэдгийг нууц мөрдөн шалгах ажиллагааны нарийвчилсан хуулиар зохицуулах шаардлагатай гэж ингэж үзэж байгаа.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууна, 1 минут.

Н.Энхболд: Энэ гараад байгаа үзэгдлийн хор холбогдол ийм үнэхээр гараад байгаа гэдэг энэ нь буруу шүү гэдгийг бол Хүний эрхийн комисс ойлгочихсон байгаа юм байна гэж бодлоо. Тэгээд заавал 1 жил хүлээж хойтон оруулж ирэх гэдэг шийдвэр гаргасан нь ямар учиртай юм бэ? Дахиад 1 жил явж л байг гэсэн маягтай. Нэгэнт та нар тийм дүгнэлт хийсэн бол энэ удаа тодорхой саналууд оруулаад ирэхгүй яасан юм бэ?

Прокурорын байгууллагын тэр хууль хяналтын бусад байгууллагуудад хяналт тавьдаг үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг зохих арга хэмжээнүүдийг өөрийнхөө шугамаар авдаг тийм биеэ даасан тогтолцоо бий болгох тал дээр ямар байр суурьтай байгаа вэ? Комисс, Байнгын хороон дээр

энэ талаар юм яригдсан уу. Энхбаяр дарга аа

Г.Занданшатар: Ингээд Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга хариулна.

Б.Энхбаяр: Прокурорын байгууллагын дэргэд байсан тусгай субьектүүдийг хянадаг прокурорын мөрдөнг бол татан буулгасан. Үүнтэй холбоотойгоор тусгай субьектүүд буюу АТГ, тагнуул, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудын мөрдөн шалгах ажиллагааны эсрэг гэмт хэргийг шалгах, илрүүлэх, нотлох энэ чиглэлээр хөндлөнгийн бас бие даасан механизмыг прокурорын дэргэд нь байна уу эсвэл одоо ямар нэгэн байдлаар өөр бүтцээр байна уу, сэргээх шаардлага бас үүсэж байгаа талаар бол Байнгын хороон дээр бас хөндөгдөж байсан. Тэгэхгүй бол энэ одоо мөрдөн шалгах ажиллагааны баримтуудыг хэвлэл мэдээллээр гаргадаг, урьдчилж ялладаг нийгмээр, тэгж байгаад шүүхэд нөлөөлдөг ийм хандлага сүүлийн үед ихээхэн идэвхжиж байгааг олон гишүүд бас Байнгын хорооны хурал дээр тэмдэглэж байсан.

Г.Занданшатар: 86. Нарантуяа. 84 Батзэвэгийн Энхболд.

Б.Энхболд: Энхболд гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье. Ер нь ХЭҮК үүнийг яг үндсэн одоо асуудалдаа анхааралдаа авсан байгаа, 1 жил хүлээхгүй ээ. Би бас буруу ойлгуулсан бололтой. Ер нь бол энэ нөгөө энэ жилийн илтгэлд оруулчихъя гэхээр зарим зүйлүүд нь бол бас яг судалгаа дүгнэлтүүд нь бүрэн гарч ирэхгүй байсан учраас бид бүхэн түр хойшлуулсан. Тухайн асуудлыг одоо ингээд тухай тухай асуудалд нь бол тодорхой дүгнэлтийг гаргаад холбогдох байгууллагын албан тушаалтанд нь шаардлага, зөвлөмжийг нь өгөөд жилийн туршид энэ дээр анхааралтай бас сайн ажиллаж тухай бүрд нь хууль тогтоомжид саналуудаа өгөөд явна аа

гэсэн ийм байр суурьтай байгаа. Тэгээд энэ цугларсан мэдээллүүдийг нэгтгэсэн том дүгнэлтийг ирэх жилийн илтгэлд бас оруулна гэдэг ийм байр суурийг илэрхийлсэн байгаа.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн. Улсын Их Хурлын дэд дарга. Салдангийн Одонтуяа гишүүн таны карт ...

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр ХЭҮК-ынхонд би бас баярлалаа гэж хэлмээр байна. Үнэхээр энэ удаагийн дүгнэлт маш сайн бичигдсэн байна. Нийт 400 гаруй хуудастай 7 бүлэг ийм зүйл байна. Тэгэхээр өнөөдөр одоо би цаг бага бүгдийг нь ярих амжихгүй учраас 7 бүлэг зүйл тус бүр дээр би 44 саналыг бэлдсэн байгаа. Үүнийг би бичгээр ХЭҮК-т хүргүүлнэ ээ. Энэ бол жишээлэхэд халдашгүй чөлөөт байх эрхийн талаар, иргэний оролцооны эрх зүйн талаар, хөдөлмөрлөх эрхийн асуудлаар, хүүхдийн эрх, ахмад настны эрх, хүний эрх хамгаалал гээд ингээд 7 зүйлээр бичсэн.

Би 1 зүйл дээр маш эмзэглэж байна. Өнөөдөр энэ илтгэлээс харахад ер нь энэ цөөхөн Монголчуудыг арай дэндүү яллаж байна. Юм л бол, Адьшаа гишүүн ээ, би 1 чухал юм ярих гэсэн юм. Энэ цөөхөн Монголчуудыг арай дэндүү яллаж байна. Яллана гэнэ, шийтгэнэ гэнэ, шоронд орж байна. Хамгийн их хүний эрх зөрчиж байгаа нь ЗГ гэж би хэлмээр байна. Өнөөдөр 3.3-хан сая хүмүүсээ та нар хуваагаад үз. 200000 нь гадаадад, хөгжлийн бэрхшээлтэйгээ хасаад, хүүхдээ хасаад ингэхээр цаана нь хэдхэн Монголчууд үлдэж байгаа байхгүй юу. Энэ хэдхэн Монголчуудад цагдаа 700, шүүхийн шийдвэрт 3300, шүүгч 500, прокурор 500, өмгөөлөгч гэхээр ингээд энэ цөөхөн Монголчуудад ёстой 100 ямаанд 60 ухна гэгчээр ийм том бүрэлдэхүүнээр ажиллачхаад, хүний эрхийг л зөрчиж байна шүү дээ та нар. Хуучин талбай дээр хүмүүс үгээ хэлээд, үзэл бодлоо илэрхийлэхэд ингэж их шийтгэл авч

байсан удаа байхгүй юм. Та нар ковидизмаар далимдуулаад 3 жил ард түмний амьг хамхичаад одоо сонгуулиудаа ялчихаад одоо эргээд тэрийгээ дахиад улам бүр лавируулж байна. Бүр арай даварч байна.

Яагаад энэ залуучуудыг үгээ хэлснийх нь төлөө бүх хүнд яагаад цахим гав зүүгээд байгаа юм. Одоо фэйсбүүк дээр лайк дарсных нь төлөө дарга нь дуудаж арга хэмжээ авч байна. Бид нар ийм нийгмийг байгуулахыг хүсээгүй. Өнөөдөр Ерөнхий сайд нь, Засгийн газрын гишүүд нь, АТГ нь гараад шууд ард түмнийг яллаж байна. Үүний чинь дагуу фэйсбүүкээр сошиалаар сэвэгдээд, өнөөдөр шүүх шууд нөлөөнд автаж байна. 37 онд хүртэл яг ийм технологи явж байсан байхгүй юу. Тийм учраас энэ хүний эрх зөрчдөг асуудал чинь хэрээс хэтэрч байна шүү гэдгийг би хатуу хэлмээр байна.

Өнөөдөр НҮБ-ын шинжээчид ирээд 99 хувь нь шүүхийн шийдвэргүй баривчлаад байна аа гэхэд чухамхүү тийм юм байхгүй гэсэн, өнөөдрийн илтгэлд гарч байна шүү дээ. Илтгэлд гарахдаа ХЭҮК-ынхон маш олон кэйс дээр нарийн судалгаа хийгээд гаргаад ирсэн байна. 60 хувь нь ямар ч шаардлагагүй баривчилгаа байсан байна аа гэж. Та нар энэ цөөхөн Монголчуудын 60 хувийг яагаад ингээд шаардлагагүй баривчлаад байгаа юм. 5 хүний 4-ийг нь ямар ч гэм буруугүй байсан байна аа гээд шүүх шийдвэр гаргаж байна. Энэ хооронд чинь энэ 5 хүн чинь тэр 461-д хэчнээн сараар тарчилж байна шүү дээ. Ямар ч байцаалт авдаггүй, шүүх хурал нь хэзээ болох нь мэдэгдэхгүй, ингэж Монгол хүний эрхийг зөрчихөө боль оо. Бид нар маш цөөхүүлээ. Тийм учраас энэ дээр одоо тэр яаралтай хүний эрхийн хуулиудаа оруулж ир.

Тэр Пүрэвдорж гишүүний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийг яагаад одоо болтол батлахгүй байгаа юм. Тэр хууль ороод ирсэн бол үүний чинь

нэлээд хэсгийг нь шийдэх байсан. Яагаад жижүүрийн шүүхийн асуудлыг та нар одоо болтол батлахгүй байгаа юм. Тийм учраас өнөөдөр ХЭҮК-ын илтгэлд дурдагдаж байна шүү дээ. 73 хувь нь шүүх мэдээгүй байхад энэ баривчилгаанууд яваад байна аа гэж. Энэ чинь одоо бас арай дэндэж байгаа юм биш үү? Яах вэ 7 хувь байж болно, 10 хувь байж болно. Гэтэл энэ чинь 73 хувь нь шүүх мэдээгүй байхад ингэж ийм баривчилгаа хийж болохгүй ээ. Тийм учраас энэ дээр одоо сайн ажиллацгаа гэж хэлмээр байна.

Төрийн албан хаагчийн хүний эрхийг бол бас дэндүү зөрчиж байна.

Г.Занданшатар: Комисс хэн хариулах вэ? Энхболд гишүүн хариул, 84. Батзэвэгийн Энхболд.

Б.Энхболд: ХЭҮК, НҮБ-ын ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлттэй холбогдуулаад 99. 98 гэдэг хувийг ер нь хуульд заасан энэ баривчилгааны арга хэмжээ хуулийнхаа дагуу явсан эсэх тал дээр бол хяналт шинжилгээ хийсэн. Тэгээд ингээд 461 дүгээр анги дээр 864 кейс дээр аваад үзэхэд өнөөдөр хууль тогтоомжид заасан баривчлах ажиллагаа шүүхийн хяналт доор явагдана аа гэдэг энэ заалт бол нийтдээ бидний судалгааны дүнгээр 73 хувь нь шүүхийн хяналтад одоо орохгүй байгаад байгааг одоо хүний эрхийн зөрчил өө гэж ингэж үзсэн. Яагаад вэ гэхээр хуульд бол яг нарийвчилсан процессыг нь нарийн заачхаад байхад энэ процессоороо явагдахгүй байгааг бол залруулах шаардлагатай гэж ингэж дүгнэж байгаа. Үүний шалтгаан нь бол хэд хэдэн зүйлтэй холбоотой юм байна лээ.

Нэгдүгээрт, тэр жижүүрийн шүүх байдаггүй. Шүүх өөрөө бие дааж шүүгч нарыг жижүүрт оруулах хууль, эрх зүйн орчин нь тодорхойгүй юм байна лээ.

Хоёрдугаарт, тэр мөрдөгчийн тогтоолыг прокурор шүүх рүү хүргүүлэх

гээд. Тэгэхээр тэрийг хүлээж авдаг, хянадаг тогтолцоо бүрэн байхгүй байгаа учраас прокурор бол тэрийг дотооддоо шийдвэрлэдэг ийм асуудлууд гарч ирээд байгаа учраас үүнийг бол олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн шүүхийн энэ зөвшөөрөлгүй баривчлах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийг нь бол засах шаардлагатай гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн.

Цаашлаад бол олон улсын энэ хууль тогтоомжуудыг судлаад байхад ер нь энэ шүүхийн зөвшөөрөлгүй гэдэг нэр томъёог дэлхийн улс орнууд бол хэрэглэдэггүй юм байна лээ. Тэгэхээр энэ нэр томъёотой холбоотойгоор бас гаднын улсын шинжээч нар болбол шууд одоо хүний эрхийг зөрчсөн хуулийг хуульчилчихсан байна аа гэдэг агуулгаар бас дүгнэсэн байж болзошгүй байгаа. Тэгэхээр энэ бол хойшлуулиггүй тохиолдолд баривчлах, яаралтай тохиолдолд баривчлах, нөхөж шийдвэр авах болзолтойгоор баривчлах гэдэг энэ нэр томъёонууд дээрээ бас бид нар эргэж харахгүй бол энэ нэр томъёо бол шууд Үндсэн хуулийнхаа бас зарим үзэл санаатай зөрчилдсөн байх болзошгүй ийм байдлыг үүсгэж байгаа.

Г.Занданшатар: Тодруулъя, Одонтуяа гишүүн 1 минут.

С.Одонтуяа: Энэ жагсаал цуглаан хийсэн, үзэл бодлоо илэрхийлсний төлөө маш олон залуучууд ял авч байгаа. Тэгэхээр энэ дээр ХЭҮК дээр энэ гомдлыг ер нь ХЭҮК яг юу гэж үзэж байгаа вэ?

Дээрээс нь Энхбаяр дарга аа, би танд шаардлага хүргүүлсэн байгаа. Ганибал гишүүн бид 2. Дараа 7 хоногт хүний эрхийн дэд хороогоо хуралдуул аа, ингэж юмыг хавтгайруулж болохгүй ээ. Үг, үзэл бодлоо илэрхийлсэн хүмүүсийг ингэж толгой дараалан шийтгэж болохгүй ээ. Үүн дээр ХЭҮК-ынхон маш сайн бэлтгэж ирж, хүмүүсийн асуултад хариулах хэрэгтэй. Саяын сүүлийн асуултынхаа хариултыг авъя.

Г.Занданшатар: 86, Нарантуяа.

Г.Нарантуяа: Тэгэхээр тайван хуран чуулах эрх чөлөөний хэрэгжилтийн талаар хэсэгт бол энэ эрх зүйн зохицуулалтыг яаж сайжруулах юм бэ гэдэг бид нар энэ удаагийн илтгэл бол илүү шийдэл рүү чиглэсэн жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн найруулахад шаардлагатай 11 чиглэлийн асуудлыг бид тодорхойлж тус бүрд нь тайлбарласан юм аа. Тэгэхээр ер нь өнгөрсөн хугацаанд ялангуяа Ковид-19 цар тахлаас хойш иргэд үзэл бодлоо илэрхийлэх, тайван хуран чуулах энэ эрмэлзэл бол их нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор одоо жагсаал цуглааныг албадан тараадаг, албадан тараагаагүй байсан ч ямар нэгэн байдлаар шууд бус аргаар хясан боогдуулдаг, тэгээд жагсааж цуглах тэр эрмэлзлийг мохоох зорилготой гэх үү, үр дагавар үүсгэсэн ийм арга хэмжээ авч байгаа тохиолдолд ХЭҮК-т цөөнгүй бүртгэгдсэн бөгөөд энэ эрх зүйн зохицуулалтыг санал болгохдоо өнгөрсөн 2 жил ... /минут дуусав/

Г.Занданшатар: 86, гүйцээгээд хариулчихъя.

Г.Нарантуяа: Өнгөрсөн 2 жилд болж өнгөрсөн жагсаал цуглаанд хийсэн комиссын дүгнэлтийг танилцуулсан байгаа. Тэгэхээр жагсааж цугласан хүмүүст эрүү зөрчлийн хэрэг үүсгэмэгц ХЭҮК бол тэр хэрэгтэй холбоотой асуудлыг хянах ийм боломж бололцоо байхгүй. Гэхдээ системийн хувьд ер нь одоо үзэл бодлоо илэрхийлсэн хүмүүстэй холбоотой эрүү зөрчлийн хэрэг яаж шийдэгдэж байна вэ гэдэг том зургаар нь дүн шинжилгээ хийж бид энэ болоод байгаа үйл явцын мөн чанар нь юу юм бэ гэдэг дээр болбол дүгнэлт хийж энэ илтгэлд оруулсан байгаа.

Г.Занданшатар: 83, Сангишаравын Дондов.

С.Дондов: Одонтуяа гишүүний хариултад нэмэлт хийе.

Хүний эрхийн хамгаалагчтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээлэлд хийсэн ийм мониторингийг бид хийсэн. Тэгээд үүний тайланг гарахдаа болбол үгээ хэлж үзэл бодлоо илэрхийлсэн суурь эрхээ хэрэгжүүлсний төлөө цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хамгийн дээд хэлбэрийг хэрэглэх, мөн ялын дээд хэмжээ болох хорих ялыг өндрөөр оногдуулж байгаа явдал бол Монголчуудын хүний эрхийн байдлыг дордуулж байна аа гэсэн энэ дүгнэлтийг ХЭҮК хийж байгаа. Үүнд бол Тусгаар тогтнолын хөдөлгөөний залуучууд, мөн цэнхэр үст Цэрэндолгор, мөн үгээ хэлж үзэл бодлоо илэрхийлсний төлөө надыг барьж авч хорилоо гэсэн энэ удаа дараагийн гомдлуудын мөрөөр бид цагдан хорих ангид биечлэн очиж нөхцөл байдлуудтай танилцаж үзсэн. Энд бол үнэ тэгэхээр суурь эрхээ хэрэгжүүлсэн тэд бол хүний эрхийн хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулиар ямар нэгэн хүч хэрэглээгүй, ямар нэгэн одоо хэн нэгнийг заналхийлээгүй, хэн нэгнийг гүтгээгүй доромжлоогүй энэ ... /минут дуусав/

Г.Занданиатар: 83, Дондов гүйцээгээд хариулчихъя.

Байж байгаарай. Микрофон одоохон 83.

С.Дондов: Хариуцлага оногдуулж байгаа нь бас хууль бус байна аа гэсэн ийм дүгнэлт хийсэн. Мөн Зөрчлийн тухай хуулийн 5-ын 20-д хүний эрхийн хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд зөрчлийн хэрэг үүсгээд шалгах тухай зохицуулсан боловч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд үүнийг хэргийн харьяаллыг тодорхой заагаагүй байгаа нь энэ зөрчилд хамрагдаж байгаа хүмүүст хариуцлага тооцох боломжийг алдагдуулж байна аа. Тийм учраас Зөрчил

шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах, нэмэлт хийх шаардлагатай байна аа гэсэн ийм саналыг оруулж байна.

Г.Занданиатар: 84. Батзэвэгийн Энхболд

Б.Энхболд: Энэ саяын үзэл бодлоо илэрхийлсний төлөө хорих ял оногдуулаад байна гэдэг ийм ойлголт бол яг нийгэмд яваад байгаа. Тэгээд энэ юутай холбоотой юм бэ гэхээр ер нь бол үзэл бодлоо илэрхийлээд жагсаал цуглаан хийгээд, худал мэдээлэл тараах гэдэг 1 зүйл ангиар хэрэг үүсчхэж байгаа юм. Тэгээд энэ зүйл анги нь болбол ямар нэгэн хорих ял байхгүй байгаа юм, 1 талаасаа.

Нөгөө талаасаа энэ хэрэг үүсгэчхэнгүүтээ ямар нэгэн тийм 1 таслан сэргийлэх арга хэмжээ авчхаж байгаа юм. Тэгээд тэр таслан сэргийлэх арга хэмжээг зөрчихөөр цагдан хорьчихдог ийм одоо асуудал яг хууль дээр болбол үүсээд байгаа юм. Тэгэхээр энэ бол олон нийтийн дунд нөгөө үзэл бодлоо илэрхийлсний төлөө хориод байна аа гэдэг шууд энэ агуулга руу орж дүгнэгдээд байгаа учраас нөгөө манай цагдан хорих үндэслэл маань бүх төрлийн гэмт хэрэг дээр цагдан хорьж болохоор хуульчилсантай холбоотойгоор ийм байдлууд үүсчхэж байгаа юм. Тэгэхээр сүүлд гарсан хэд хэдэн кейсүүд бол яг л ийм байгаа юм. Эхлээд дууддаг, хувийн баталгаа авдаг ... /минут дуусав/

Г.Занданиатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. ХЭҮК-ын 22 дахь илтгэлийг сонслоо, танилцлаа. Би илтгэлтэй холбогдуулаад нэг 2 чиглэлийн асуулт байна. Ер нь хүний эрх зөрчигдөж байгаа их түгээмэл зөрчигдөж байгаа 2 гол чиглэл байгаа юм л даа.

1 дэх нь бол энэ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл

ажиллагааны үед гарч байгаа асуудлууд байгаа юм. Энэ дээр сүүлийн үед маш их гарч байгаа юм аа. Сая ч илтгэлд дурдагдаад байна. Хамгийн гол юм бол энэ цагдан хорихтой холбоотой асуудлыг яриад байгаа юм аа. Тэгээд ХЭҮК-оос ер нь шалгаж үзээд нийт цагдан хориглолтын хэдэн хувь нь ер нь үндэслэлгүйгээр цагдан хоригдоод байна вэ гэдэг асуудал байгаа юм аа. Түрүүн Одонтуяа гишүүний асуулт дотор 70 хувь нь үндэслэлгүй гэж гарч байна аа гээд байгаа юм. Үнэхээр энэ ийм үндэслэлгүй юм байна уу? Байвал манай ХЭҮК үүнийг яаж таслан зогсоож байгаа юм бэ? Хамгийн гол нь энэ ХЭҮК өөрөө таслан зогсоож байх ёстой байхгүй юу.

Нөгөө талаар нь энэ олон сараар хорьдог, тэгээд одоо янз бүрийн дарамт шахалт үзүүлдэг, бизнесүүдийг болохтой нь зэрэг дансыг нь хаадаг, бизнесийг нь зогсоодог, утас шөрмөсийг нь хянадаг эд нар гээд ингээд олон үйлдлүүд байгаа юм аа. Үүнийг бол иргэд маш их одоо шүүмжилж ярьж байгаа юм. Үүнтэй холбоотой асуудал дээр ХЭҮК тодорхой хүрээнд шалгалт хийгээд энэ илэрсэн зөрчлүүдийг цаашид гаргахгүй байх чиглэлээр ямар арга хэмжээ авав аа гэдэг асуудал байгаа. Ер нь ХЭҮК байгуулагдсанаасаа хойш бид эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгөх, орон тоо, зохион байгуулалтын хувьд нь санхүүгийн хувьд нь бэхжүүлэх чиглэлээр Улсын Их Хурал тодорхой арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байгаа. Сүүлийн 2 жилийн хугацаанд энэ хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр яг ХЭҮК-оос одоо юу гэдэг юм эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг ингэж боловсронгуй болгомоор байна аа. Хүүхдийн эрхийн хуулийг ингэж боловсронгуй болгомоор байна аа гэж тодорхой одоо яг Их Хуралд оруулж ирсэн асуудал байна уу? 2 дугаарт нь би ингэж асуух гээд байгаа юм.

3 дугаарт нь, сүүлийн үед хамгийн их хүний эрх зөрчигдөж байгаа салбар энэ

сошиал орчин байгаа юм аа. Энэ нийгмийн сүлжээгээр маш их хүний эрх зөрчигдөж байгаа юм аа. Нэр төрд нь халдах, залилан хийх тэгээд одоо энэ нийгмээр яллах маш олон асуудал байна. Тэгэхээр энэ сошиал орчны энэ хүний эрх хангах чиглэлээр ХЭҮК-оос тодорхой хэмжээнд энэ дээр ажиллаж, дүгнэлт гаргаж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэж байгаа ажил байна уу гэж би ийм 3 зүйлийг тодорхой асууя аа гэж бодож байна.

Г.Занданшатар: Энхболд гишүүн хариулъя.

Б.Энхболд: Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, баривчлах арга хэмжээ гээд 2 өөр одоо ойлголт хууль дээр хуульчилсан байгаа юм. Тэгэхээр энэ баривчлах ажиллагаа дээр бол 73 хувь нь шүүхийн хяналтад орохгүй байна. Үүнийг болбол одоо хууль бус гээд бид нар бол тодорхой холбогдох статистикуудаас аваад дүгнэлт хийж үзэж болж байгаа юм.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний яг хэдэн хувь нь үндэслэлтэй, үндэслэлгүй байна вэ гэдгийг дүгнэх гээд ингэхээр энэ болбол өөрөө эцсийн шийдвэрийг шүүх гаргадаг, шүүх бол тодорхой одоо яг нөгөө хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байх учраас бид нар яг нөгөө хэргийнх нь материалтай яг бүрэн танилцах ийм боломж олгогдохгүй байгаа учраас яг хэдэн хувь нь цагдан хоригдсон нь хууль бус байна аа гэж дүгнэхэд хүндрэлтэй байгаа юм.

Нийтдээ Монгол Улсад 2500 орчим хүн жилд цагдан хоригддог. Үүнээс 63 орчим хувь нь 120 хоног хүртэл болбол цагдан хоригддог ийм статистик байгаа. Дээр нь шүүхээр одоо шийдвэрлэгдсэн нийт хорих ял авсан хүний 24.3 хувь нь шүүхийн өмнөх шатанд цагдан хоригджээ гэж байгаа юм.

Мөн хууль бусаар цагдан хоригдсоны улмаас цагаатгагдсан тохиолдолд бол жилд 1 дунджаар 6 орчим хүний эрхийг шүүх сэргээж нөхөн төлбөр олгож байгаа энэ асуудлууд байгаа. Тэгэхээр энэ бол бас маш урт хугацааны дараа гэм буруу нь хууль зүйн үндэслэлтэй цагдан хорьсон, хориогүй асуудал шийдвэрлэж байгаа. 2021 онд бол ХЭҮК хууль бусаар цагдан хоригдсонтой холбоотойгоор 1 төлөөлөн нэхэмжлэлийг гаргаж холбогдох албан тушаалтан юу төлбөрийг гаргуулж өгсөн байгаа. Энэ гэмт хэрэг нь болбол 2013 он, 2017 онд үйлдэгдсэн гэмт хэргүүдийг хэрэгт холбогдон шалгагдсан хүнийг 2021 онд эрхийг нь сэргээх ийм нөхцөл байдал жишээлбэл байгаа. Тэгэхээр ХЭҮК Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай бусад хуулиудад нийтдээ 11 удаа санал өгсөн байгаа. Ихэвчлэн Засгийн газраас боловсруулсан хуулийн төслүүд дээр бол тухай бүрд нь саналыг өгөөд явж байгаа. Энэ дээр цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн нарийвчлан унших шаардлагатай гэдэг саналыг хүргүүлээд байгаа хэлж байгаа.

Г.Занданшатар: 31.5-ыг өөрчилж байж л болно. Хунан дарга хариулъя.

Ж.Хунан: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд ХЭҮК 22 удаа Улсын Их Хуралд илтгэлийг өргөн барьсан байдаг. Үүнээс халдашгүй чөлөөтэй байх эрхтэй холбоотой 8 удаагийн илтгэлд бол тодорхой сэдэв одоо бүлгийн хүрээнд танилцуулсан байдаг. Үүнээс цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой хүний эрхийн асуудлаар 3 удаа танилцуулсан байдаг. 9, 14, 15 дахь илтгэл ...

Г.Занданшатар: Үгүй ээ, үгүй танилцуулсан асуудал биш Хунан дарга аа, наадах чинь яг тийм тодорхой

тогтоолын төсөл, хуулийн заалтын тэр тэрийг өөрчилье гэсэн санал танилцуулсан уу гэж байна шүү дээ. Наадах чинь бол тэдэн хүн баривчлагдсан байна аа. Хойшлуулигүй тохиолдол хэд байна аа. Тэгээд сая тоо хэлэгдээд 90, 93 хувь нь цагдаагийн байгууллага гэж байгаа шүү дээ тийм ээ. Тэрийгээ ч тодорхой.

Дараагийн асуулт. Тийм санал оруулж ирсэн юм уу гэж асуугаад байна шүү дээ. 86 Нарантуяа.

Г.Нарантуяа: Тогтохсүрэн гишүүний сошиал орчинтой холбоотой эрх зүйн зохицуулалт, тэгээд тодорхой саналыг ХЭҮК тавьж байна уу гэдэг асуултад би нэмэлт өгье өө. Тэгэхээр онлайн оффлайн орчин бол ерөнхийдөө мөн чанарын хувьд ижил төсөөтэй үйл ажиллагаа явагддаг ийм орчин байгаа. Оффлайн орчинд бид нарын бодит амьдрал дээр болдог бүх л төрлийн гэмт хэрэг зөрчлүүд онлайн орчинд болж байдаг аа. Гэхдээ ямар ялгаа байна вэ гэхээрээ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаггүй, гадаад улсын гуравдагч компанийн платформыг ашиглаж энэ тийм ээ, маш хурдан шуурхай олон нийтэд түгээх ийм боломжтой нөхцөл байдалд бол энэ одоо оффлайн орчны амьдрал үргэлжилдэг. Үүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох гарцаагүй шаардлагатай. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль өөрөөр хэлэх юм бол хоруу контентыг маш хурдан хугацаанд тархаж, хүний эрх зөрчихөөс яаж хамгаалах вэ гэдэг эрх зүйн зохицуулалт байх шаардлагатай 1 талаас.

Нөгөө талаасаа гадаад улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг гуравдагч компанийн алгоритм өөр бусад одоо технологийн арга хэмжээнээс Монгол Улсын язгуур ашиг сонирхлыг яаж хамгаалах вэ гэдэг энэ 2 тулгуур асуудлыг цогцоор нь бодож

шийдэж байж тэгээд Монгол Улсын дотоодод болж байгаа нөхцөл байдлыг болбол гэмт хэрэг зөрчлөөс хамгаалах гээд бусад тогтолцоотой яаж давхцалгүй, харилцан уялдаатай нийцэлтэй ажиллах юм бэ гэдэг энэ гарц гаргалгааг тодорхойлж байж социал орчинд хүний эрхийг хамгаалах асуудал бол нэлээд цогц тодорхой болох юм.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдэд тараасан ХЭҮК-ын илтгэлийн 580 дугаар хуудсанд жишээлэхэд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг ийм байдлаар боловсруулж батлах юм бол бас Монгол Улсад хариуцлагатай, ил тод, ёс зүйтэй, нөгөө талаасаа хараат бус олон ургалч хэвлэл мэдээллийн салбар бий болох юм байна аа гэдэг бид нар загвар хуулийн төслийг боловсруулж орж ирсэн байгаа. Комисс маш тодорхой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах сайжруулах саналуудыг илтгэл бүрээрээ тавьж ирсэн гэдгийг бас би хэлмээр байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 58 дугаар хуудсанд чинь алга байна даа, 580 уу.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн тодруулж асууя.

Д.Тогтохсүрэн: Энхбаяр гишүүнээс асуух уу? Тэгвэл би ийм л юм асуух гээд байгаа юм. ХЭҮК ингээд илтгэлээ тавьж байна аа. Тодорхой саналуудыг ингээд тавьж байна аа. Сая гэхэд л одоо 580 дугаар хуудас дээр яг ийм загвар байгаа л гэж байна. Түрүүн Хунан даргын илтгэл дээр энэ цагдан хорих үйл ажиллагаагаа цаашидаа эрх зүйн орчныг нь улам боловсронгуй болгож, процессоо нарийвчлах хэрэгтэй байна аа гээд тодорхой санал хэлж байна лээ. Энэ чиглэлээр Хууль зүйн хороо тодорхой санал бэлтгэгдэж байгаа юм байна уу? Жил бүр л ингээд л ХЭҮК-ын илтгэл орж ирдэг. Бид ингээд л 2 өдөр юм уу 1 өдөр ярьдаг. Хамгийн гол асуудал нь энэ гараад байгаа юмнуудыг таслан зогсоох, эрх зүйн

орчныг нь боловсронгуй болгох чиглэлээр бид нар юм хийх ёстой юм байна аа. Энэ чиглэлээр ХЗБХ ямар ажил хийхээр төлөвлөж байна аа? Энэ яг энэ илтгэлтэй холбогдуулж би асууя аа гэж бодож байна.

Г.Занданшатар: Энхбаяр дарга хариулъя. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Байнгын хорооны хуралдааны үеэр ХЭҮК-ын гишүүн Энхболдоос халдашгүй чөлөөтэй байх эрхийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, сая ярьсан нууц мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нэн тодорхой асуудлуудыг танилцуулсан байгаа. Санал, дүгнэлтээ. Энэ нэн тодорхой санал, дүгнэлтүүдтэй танилцахад энэ бол зүй ёсны, шуурхай шийдвэрлэх ёстой ийм асуудлууд байна лээ. Тийм учраас Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцээд энэ санал, дүгнэлттэй холбоотойгоор ХЭҮК-оос гаргасан санал, дүгнэлтийн чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ЗГ-т чиглэл өгч болно гэж үзэж байгаа юм. Хэрвээ Их Хурлын гишүүд зөвшөөрвөл би тогтоол гаргах саналтай байгаа.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Та бүхэнд өдрийн амгаланг айлтгая. ХЭҮК-ын тайлан илтгэл ер нь ямар үр дүнтэй болдог вэ гэдэг дээр олон нийт бас анхаарал хандуулж байгаа байх гэж бодож байна. Зөвхөн дүгнэлт гаргаад тайлан илтгэл гаргаад одоо авах арга хэмжээ бодит үр дүн ер нь байдаг юм уу, үгүй юу гэдэг асуудал бас олон нийтийн дунд байдаг. Тэгвэл үнэхээр одоо хуулийн зүйл заалт дээр санал өгөх, сая Энхбаяр даргын хэлсэнчлэн бас Их Хурлын тогтоол гаргах ийм зайлигүй шаардлага байгаа гэдэг нь бас энэ тайлан илтгэлээс хардаж байгаа байх аа гэж бодож байна.

Би өөрийнхөө анхаарч байсан асуудлаасаа л бас онцгойлон бас асууя гэж бодож байна. Тайланд дурдсан 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын сангаас өндөр настны тэтгэвэр авч байгаа 333046 ахмад настан байна. Үүнээс тэтгэврийн доод хэмжээ буюу 500000 төгрөгийн тэтгэврийг нийт ахмадын 73.49 хувь нь авч байна аа гэсэн үг. Өөрөөр хэлбэл ихэнх ахмадууд 500000 төгрөгийн тэтгэвэрээр амьдарч байна аа гэсэн үг. Үнийн өсөлт нь тэнгэрт тулчихсан, махны үнэ 20000-д хүрчихсэн энэ цаг мөчид 500000 төгрөгийн тэтгэвэр хаанаа ч хүрэхгүй хэмжээнд байгаа. Тэгвэл энэ тоо үнэхээр анхаарал татаж байгаа. Тэгвэл яаж бид одоо энэ тайланд дурдсанаар тухайн өрхийн сарын дундаж орлого болон ам бүлийн одоо тоон харьцаагаар амьжиргааны түвшин тодорхойлогдоод нийслэлийн гэр хорооллын ахмад настнуудын 54.5 хувь нь амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур ийм нөхцөл байдалд амьдарч байна. Би ганцхан жишээ хэлье. Манай 6 дугаар хороонд 6 цагаан байр гэж байдаг. Нийтдээ 150 өрхийн 600 гаруй иргэн байгаа. Энэ байшин, дээвэр нь цоорхой, тийм ээ, тааз нь цөмөрхий ийм л байшинд иргэд амьдарч байгаа. Энэ дахин ашиглах боломжгүй орон сууцыг ашиглах энэ хууль, эрх зүйн зохицуулалтыг бид нар хийхгүй бол Монгол Улсад саятан хотын эгнээнд, дарга аа би уг нь үгээ хэлчихмээр байх юм, Пүрэвдорж гишүүн ээ. Баярлалаа.

Тэгвэл энэ нийт ахмадуудынхаа энэ 73%-ийн тэтгэврийн энэ одоо нөхцөл байдлыг яаж бид өөрчлөх юм бэ гэдэг дээр бас анхаарах зайлиггүй шаардлага байгаа. Нийгмийн даатгалын багц хууль орж ирж байгаа, бид нар бас энэ дээр анхаарах зайлиггүй шаардлага байгаа. Энэ дээр бас ХЭҮК шаардлага тавьж бас саналаа өгөх байх гэж бодож байна.

Миний бие 2022 онд Ахмад настны тухай хууль болон Халамжийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг Нийгмийн бодлогын байнгын хорооноос одоо үүрэг авч ажилласан байгаа. Зүгээр яг энэ ажилласан үр дүнд гэдэг юм уу одоо олон ахмадуудтай уулзсан. Үнэхээр хүчирхийлэл дор байна аа гэдэг үгээ хүртэл хэлж байсан. Би бас энэ ХЭҮК-ынхонд хэлж байсан. Орхон аймгийн иргэн Банди гуай бас хэлж байсан. Хүүхэд харж байна. Тэтгэврээ буухаар одоо тэтгэврээ өөртөө авахын тулд тийм ээ, зориулахын тулд би бас энэ одоо их хүчин чармайлт гаргаж байна. Өдөр, хоногийг бид нар юуны төлөө өнгөрөөж байгаа вэ гэдэг дээр заримдаа бид нар бодохоор гутарч байна гэдэг ийм зүйлийг ахмадууд ярьж байсан. Тэгвэл яаж одоо насжилтыг сайжруулах юм, тийм ээ. Бид энэ дээр чанартай насжилтыг яаж бий болгох юм бэ гэдэг дээр бид гол анхаарах зүйл бол ЭМЯ-ны одоо хийх ажил бас байгаад байгаа юм. Геронтологийн үндэсний төв.

Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд Геронтологийн үндэсний төв 500 метр хүрэхгүй байранд үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Би Их Хурлын гишүүн болсноос хойш Геронтологийн үндэсний төвийг бариад өгөөч ээ гээд сайд болгоноос гуйж байгаа. 24 онд Чинзориг сайд маань анхаарна биз. Төсөвтөө тусгана биз. Одоо нэг 36 ортой эмнэлгийн байраар ингээд үйл ажиллагааг нь явуулах гэж байгаа. Гератор эмч байхгүй. Ахмад настанд чиглэсэн үйл ажиллагаа бидэнд байхгүй. Тэгвэл энэ дээр бид нар яг Монгол Улсын ЗГ-аас, Их Хурлаас бид нар хууль эрх зүүдээ өөрчлөлт оруулах зайлиггүй шаардлага байгаа юм байна. Ахмадуудад чиглэсэн бодитой ажлууд бид нар хэрэгтэй юм байна аа гэдэг дээр бас ХЭҮК-ын тайлан гарчихсан байна.

Бас 1 анхаарах зүйл. Халамж үйлчилгээний ерөнхий газраас ХЭҮК ирүүлсэн ахмад настны статистик тоон

мэдээллийг хангалтгүй, бүртгэл судалгааг бүрэн гүйцэд хийдэггүй нь ахмад настанд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг үнэлэхэд хүндрэл учруулсныг бас энд нь дурдмаар байна. Яагаад Монгол Улсын хүн амын тоон судалгаа зөрчөөд байдаг юм, Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам. Яагаад бид хүн амынхаа тоог зөв гаргаж чаддаггүй юм бэ? Энэ дээр ямар тайлбар хэлэх вэ? ХЭҮК энэ дээр ямар нэгэн байдлаар Статистикийн үндэсний хороо болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд шаардлага тавьсан уу?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ тоог ч гэсэн бид нар гаргаж чаддаггүй шүү дээ. Тэгвэл яаж зорилтод бүлэгтээ бид нар хүрч ажиллах юм бэ?

Г.Занданшатар: Энэ тайлбар байх. 85.

Ж.Мөнхзул: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Таны бас энэ ахмадын хуулийн асуудлаар одоо хийсэн бас энэ тайлантай танилцсан байгаа. Мөн тэр асуудлыг бол бас илтгэлд оруулсан байгаа.

Ер нь бол энэ Монгол Улсад ахмад настны эрхийн хэрэгжилт бол бас анхаарал татах түвшинд хүрсэн байна аа гэж ХЭҮК дүгнэсэн байгаа. Энэ ахмад настны чиглэлээр одоо төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ маань бас төдийлөн үр дүнгүй байна аа. Ялангуяа одоо энэ тэтгэврийн асуудал үнэхээр энэ нийт ахмад настнуудын 73.49 хувь нь бол хамгийн одоо доод түвшний тэтгэвэр ингэж авч байгаа нь бол энэ анхдагч хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа нь бол бусад эрх хэрэгжих ийм суурь нөхцөлийг нь бүрдүүлж чадахгүй байна гэж бол үзсэн байгаа. Тэгээд тэтгэвэр маань ингээд өвлөгддөг ийм тогтолцоо бас байхгүй. Авч байгаа зээл нь бас ингээд юу өвлөгдөөд байгаа энэ асуудал дээр бид нар бас анхаарлаа хандуулж, энэ яаралтай энэ олон

давхаргад энэ тэтгэврийн тогтолцоонд шилжих асуудал бол бас зайлиггүй шаардлагатай юм байна аа гэж харсан.

Тэгээд мөн энэ Герентологийн үндэсний төвийн барилгын асуудлыг бол бид нар бас төрөөс анхаарал хандуулж бас яаралтай шийдвэрлэх асуудал бол зайлиггүй шаардлагатай байна. 2011 онд шавыг нь тавьсан хэрнээ одоо хүртэл энэ асуудал гацсан байдалтай байгаа. Мөн энэ халамж үйлчилгээний энэ газраас ингээд явуулж байгаа энэ бүртгэл судалгаа бол маш хангалтгүй байна. Зөвхөн нийгмийн халамжийн үйлчилгээ авч байгаа хүмүүсийн л судалгаа байна. Тэр орон гэргүй хүмүүс, яг энэ зорилтот бүлгийн харж хандах энэ үр хүүхэдгүй эд нар гэсэн энэ хүмүүсийн яг халамж авч байгаа хүмүүсийнх нь л юу байгаа гэхээс бусад одоо энэ ахмадуудын талаарх энэ бүртгэл судалгаа маш хангалтгүй байна аа. Тэгэхээр бол энэ дээр ХЭҮК-оос холбогдох яам, Тамгын газарт бол энэ асуудлыг тавьж бас анхааралдаа авахыг зөвлөсөн байгаа.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Асуулт гэхээсээ илүү бас анхааруулан үг хэлмээр санагдлаа. Дэлхий нийт, хүн ам бүхэлдээ насжилт нэмэгдэж байгаа, насжих динамикийн хувьсал хөтөлсөн энэ цаг мөчид бид нар бол ахмадуудаа анхаарах зайлиггүй шаардлагатай. Өнөөдөр Батсүмбэр дэх ахмадын асрамжийн төвд байгаа нийт иргэдийн 60 хувь нь сэтгэцийн өөрчлөлттэй байгаа. Тэр сэтгэцийн өөрчлөлт гэдэг бол шууд ганцаардал. Хэн ч аав, ээжийнхээ тийм ээ, ач буяныг хариулахгүйгээр тийшээ аваачихыг хүсэхгүй. Тэгвэл гэртээ суусаар байгаад л ахмадууд маань ийм ганцаардах эмгэгтэй болчихоод байгаа. Тэгэхээр энэ бүхэн дээр Монгол Улсын ЗГ бас анхаарч ажиллахгүй болбол ахмадуудад чиглэсэн Ахмадын чөлөөт цаг өнгөрөөх төв одоо юу байдаг юм, тийм ээ. Энэ чиглэл рүү

анхаарсан үйл ажиллагаа зохион байгуулахгүй бол, хийхгүй бол, хөрөнгө оруулалт хийхгүй болбол бид үнэхээр одоо ахмадуудаа хүндлэхгүй, насжилтаа одоо тийм ээ анхаарч чадахгүй ийм улс болно шүү гэдгийг бас анхааруулж хэлэх нь зүйтэй байгаа гэж бодож байна.

Одоо нийгмийн даатгалын багц хууль орж ирж байгаа. Х-хөдөлмөр нийгмийн хамгааллын одоо халамжийн хууль орж ирж байгаа. Тэгээд энэ бүхэн дээр бас одоо гишүүд маань анхаарч хөрөнгө оруулалт татгалзахгүй ахмадуудаасаа харамлахгүйгээр энэ асуудал ... /минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Асуулт, үг 2 хамт явж байгаа. Үг хэлж болно.

Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Баярлалаа. Тэгээд ХЭҮК-ын тайлан сонсож байгаа. Монгол хүн бүрийн эрхийн асуудал яригдах ёстой байх. Бид нар чинь одоо хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, жендерийн тэгш байдал, төрийн албан хаагчийн эрх тэгээд л одоо ахмадын эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө гээд л одоо баахан л асуудал ярьж байгаа. Энд хамгийн яригдахгүй байгаа мөртөө хамгийн их ярих ёстой анхаарах ёстой асуудал хаягдчихаад байгаа юм. Энэ их хувийн хэвилийнхний эрх, эрх чөлөө гэдэг юм, татвар төлөгчдийн, баялаг бүтээгчдийн, ажил олгогчдын. Тэгээд л одоо тэрийг хүмүүс гэж одоо тийм үү? Мөрөөрөө ажил олгодог, татвар төлдөг, баялаг бүтээдэг, түүнээс нь төрийн албан хаагчид, ахмадууд, эмэгтэйчүүд, хүүхдүүд бүгдээрээ одоо бид нар хүртээд явж байдаг. Цалингаа аваад, хүүхдийн мөнгөө аваад, тэтгэвэр тэтгэмжээ аваад, төрийн одоо эмнэлэг, сургууль гээд бүхий л одоо зардлууд тэндээс гарч байдаг. Тэд нарыг хүн болгон шоовдорлож байдаг, хүн болгон дээрэлхэж байдаг. Улс төрчид нь дээрэлхдэг, хууль хяналтынхан нь дээрэлхдэг, хэвлэл мэдээллийнхэн нь

дээрэлхдэг. Энэ хүмүүсийн эрхийг яах вэ. Одоо тэд нар чинь ерөөсөө Монголд бизнес хийж чадахгүй байна. Ерөөсөө төртэй холбоотой юм хийж болохгүй юм байна. Энэ улс төрчдөөс, хэвлэл мэдээллийнхнээс энэ төрөөс л аль болох хол байх юм сан яаж амьдрах вэ гээд л одоо ингээд л үнэхээр хэцүү болчихсон байна л даа. Тэгээд эдгээр хүмүүсийн эрх ашгийг хэн хамгаалах юм бэ? Эдгээр хүмүүсийн эрх ашиг яагаад хөндөгдөөд байгааг ХЭҮК-ынхон олж харахгүй байна аа? Энэ асуудал дээр та бүхэн одоо ямар бодлого барьж байгаа юм цаашид яах юм, ер нь. Үүнийг 1 ярьж өгөөч бас.

2 дугаарт нь, энэ хэвлэл мэдээлэл юу захиалгатай, төлбөртэй, хүн гүтгэдэг, худал мэдээлэл тараадаг, шантаажилдаг сэтгүүлч нэртэй нөхөд байна. Яг жирийн одоо юу гэдэг юм шударга хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг сэтгүүлчид нь тэд нарыг сэтгүүлч гэж битгий хэлээч, наана чинь зүгээр 1 шантаажчин шүү дээ. Бидний салбарын нэр хүнд гутааж байгаа шүү дээ гэж ярьдаг. Энэ хэдэн нөхдийг одоо бас яах ёстой юм. Эд нар чинь одоо бүр хаданд гарлаа, тийм. Тэгээд л хаа сайгүй л хүн гүтгээд явж байдаг, хүн гутаагаад явж байдаг, худал мэдээлэл тарааж байдаг. Тэндээ одоо юу гэдэг юм хулгайч хэдэн улс төрчдийг ашигладаг байсан тийм, тэрний захиалгыг хэн өгч байна. Хулгайч хэдэн улс төрчид өгч байгаа байхгүй юу. Захиалгыг нь. Тэгээд л хулгайч хулгайчийг бариарай гээд л баахан хаширдаг. Тэгэнгүүтээ бүгдээрээ хулгайч болчихсон. Улсын Их Хурлын 76 хулгайч, Засгийн газрын гишүүд, сайд нар бүгд хулгайч, төрийн албан хаагч нар бүгд хулгайч. Яагаад гэвэл өөрөө баригдахгүйн тулд бүгдийг хулгайч болгож зарлуулдаг, зарладаг, захиалга өгдөг, мөнгө төлдөг. Яагаад гэвэл өөрөө ганцаараа хулгайчид нь баригдчих гээд байгаа учраас бүгд хулгайч болгох гэж байна. Ингээд эцэст нь төрийн нэр хүнд унадаг, төрд итгэх ард түмний итгэл алдардаг. Энэ асуудал дээр та бүхэн бас одоо яах ёстой юм бэ?

Энэ дээр бодож байгаа, санаж байгаа зүйл байна уу, байхгүй юу бас.

Одоо ард түмэн чинь ерөөсөө тийм сайн юм сайхан юм, тийм үү, Монголын төр засгийн бодлого, үйл ажиллагаа зөв юмыг ер нь сонсохоо больчихож. Тэгээд л хэдэн хулгайч нар захиалгатай, төлбөртэй шантаажчин хэдэн сэтгүүлч нэртэй нөхдүүд мөнгө төлдөг тэд нар нь бүгдийг харлуулдаг, тэрийг тойрсон бөөн хэрүүл л явдаг. Ийм л болчихоод байна л даа. Тэгээд энэ дээр манай энэ дээр манай ХЭҮК-ынхон юу хийх, энэ талаар мэдэж байна уу, мэдэрч байна уу бас тийм. Өөр одоо юу гэдэг юм, хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, одоо тийм ээ гээд л ингээд л нэлээн одоо шударга ёс гээд л нэлээн л яриад л байдаг одоо энд зөрчигдөж байна тэгэж байна гээд. Гэтэл энэ асуудлууд чинь хаягдчихаад байна шүү дээ. Энэ дээр одоо бас ямар байр суурь, ямар бодлого анзаарч мэдэж байгаа зүйлүүд ... /минут дуусав/

Г.Занданшатар: 82 Сүнжид.

Д.Сүнжид: Бямбацогт гишүүний 1 дүгээр асуултад мэдээлэл хийе. Аж ахуй эрхлэх эрхтэй холбоотой 2021 оны хүний эрхийн форум гэж зохион байгуулсан. Энэ дээр бизнес ба хүний эрх гээд тусдаа сэдвийн хүрээнд татварын эрх зүй, төсвийн эрх гээд тийм ээ, энэ төсвийн хуваарилалттай холбоотой асуудлыг авч үзсэн.

Яг ХЭҮК-ын илтгэл тухайлан энэ аж ахуй эрхлэх эрхийг бол өмнө нь оруулж байсан. Энэ сүүлийн 5 жил бол оруулаагүй байна. Тэгэхээр энэ жилийн тухайд энэ аж ахуй эрхлэх эрх, ялангуяа хувийн хэвшилд ажиллаж байгаа хүмүүсийн хөдөлмөрлөх эрх, энэ бизнес эрхлэх орон зайтай холбоотой асуудлыг бас авч үзэх нь зүйтэй юм байна аа гэдэг саналыг хүлээж авч байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хунан дарга 2 дахь асуудалд нь, бусад асуултад нь хариулах уу?

86 Нарантуяа.

Г.Нарантуяа: Хэвлэл мэдээллийн салбарын хараат бус байдал, төлөвшилтэй холбоотой асуудал хөндөгдөж байна. Тэгэхээр ерөөсөө өнөөдөр одоо энэ хэвлэлийн эрх чөлөөний талаарх дотоод гадаадын бүх судалгаагаар Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбар улс төр, эдийн засгаас хамааралтай, дээрээс нь өөрөө нөгөө зах зээлийн жамаар хэрэглэгчээс одоо ашиг орлого олоод хараат бус үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаад байгаа учраас энэ нь энэ хамааралд их эмзэг болгож байна аа гэсэн ийм дүр зураг гарч байгаа. Үндэсний статистикий хоро, Хэвлэлийн Хүрээлэн, Глоб Интернэшнл гээд дотоодын байгууллага, хил хязгааргүй сэтгүүлчид гээд олон улсын байгууллагуудын дүгнэлт ер нь бол яг одоо 1 ийм чигтэй байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт гэдэг 2 дугаар бүлэгт санал болгож байгаа асуудал болбол ерөөсөө л УИХ-д хандсан эрх зүйн зохицуулалтаа ингэж сайжруулъя аа гэсэн тодорхой саналуудыг оруулсан юм.

Энэ дээр хэвлэл мэдээллийн байгууллагуудын тухайд болбол 1 дүгээрт нь мэдээж хараат бус байдал олон ургалч байдлыг нь дэмжихийн зэрэгцээгээр ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг нь дэмжих шаардлагатай. Энэ хүрээнд тэр хэвлэл мэдээллийн байгууллагыг хэн эзэмшээд байгаа юм бэ, ямар байдлаар санхүүжээд байгаа юм бэ гэдэг ил тод байдлыг бий болгоё. Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх редакц хэвлэж нийтлүүлсэн мэдээлэлтэй холбоотой хариуцлагыг хүлээхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт, иргэний редакцын эсрэг гомдол гаргах энэ одоо журмыг бий болгох, хэвлэл мэдээллийн салбар өөрөө хараат бус үйл ажиллагаа явуулах мөн

чанартай учраас өөрийгөө зохицуулах, өөрөө ёс зүйгээ сахиулах, сэтгүүлч сэтгүүлчдээ чиний буруу байна шүү дээ гэдэг энэ үг хэлэх, тэр сэтгүүлч нэр хүндээрээ салбартаа одоо юу гэдэг юм хэр удаан оришин тогтнох вэ мэргэжлийнхээ хувьд гэдэг энэ өөрийнх нь бие даасан зохицуулалтыг бий болгоё оо гэсэн үзэл санаагаар бичигдсэн энэ одоо эрх зүйн зохицуулалтыг УИХ-д бид санал болгож байгаа юм.

Г.Занданшатар: Бямбацогт гишүүн тодруулж асууна.

С.Бямбацогт: ХЭҮК хазах шүдгүй байгууллага байсан. УИХ хуулийг нь баталж өгөөд хазах шүдтэй болгоод, өргөжүүлээд улам бэхжүүлээд, дэмжээд ажиллаж байгаа. Гэтэл одоо нийтлэг илүү анхаарах зүйлдээ та нар анхаарахгүй байна. Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, нэр төр, алдар хүнд, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гээд заачихсан. Гэтэл Үндсэн хуульд заагдсан хүний эрхийг зөрчөөд байна шүү дээ, цаана чинь. Захиалгатай, төлбөртэй, шантаажсан сэтгүүлч нэртэй нөхөд худал мэдээлэл тарааж энэ хүнийг гүтгэж, гүжирдэж байна. Гэтэл энэ дээр одоо юу гэдэг юм I ерөнхий одоо тийм ээ, ерөнхийдөө ингэчихвэл зөв байх аа. Энэ тунхгийн шинж чанартай юм яриад суумааргүй байна. Тодорхой бодитой үр дүн гаргаж ажил хиймээр байна, хавтгайрлаа шүү дээ. Үүнээс чинь болоод Монгол төрийн нэр хүнд гэдэг юм чинь байхгүй болж байна. Үүнээс чинь болоод Монголын ард түмний төрд итгэх ит итгэл алдарч байна. Энэ чинь өөрөө үндэсний аюулгүй байдалд тусгаар тогтнол тийм үү, Монгол үндэсний дархлаа ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хунан дарга хариулъя, 81.

Ж.Хунан: Бямбацогт даргын асуултад хариулъя. Юуны өмнө хүний эрхийн асуудал I дүгээр асуудлаас нь бас

нэмж тайлбарлаад явъя. Хүний эрхийн асуудал болбол төр иргэн хоорондын харилцаанд илүү яригддаг асуудал байгаа. Өөрөөр хэлбэл төрийн зүгээс хүний эрхийг зөрчихгүй байх тал дээр бол хяналт тавьдаг ийм механизм байдаг. Иргэд хоорондын харилцаа бол илүүтэйгээр нөгөө хувь хүний хүсэл зориг дээр үндэслэж иргэд хооронд бий болдог харилцаа учраас төдийлөн бас яригддаггүй. Тэгэхдээ мэдээж хэрэг хувийн хэвшил буюу энэ аж ахуй бизнес эрхлэх эрхтэй холбоотой асуудал бол байдаг. Энэ дээр ХЭҮК одоогоор бол хийсэн ажил байхгүй байна. Тэгэхдээ үүнийг ирээдүйд төлөвлөж хийнэ гэж харж байгаа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхэд халдаж байгаа, хүний эрхийг зөрчиж байгаа нэр төрийг ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хунан дарга товч тодорхой хариулъя, гүйцээж хариулъя. 81

Ж.Хунан: Тэгэхээр ХЭҮК-т ирж байгаа энэ зарим гомдлуудыг шалгаж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа гэдгийг бас танд мэдэгдье.

Дээрээс нь энэ хэвлэл мэдээллийн зөвлөлд хандаж яг одоо хүнийг гүтгэсэн, аль эс үгүй бол одоо ёс зүй зөрчил гаргасан ийм хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг шилжүүлж шалгуулах ийм ажлыг зохион байгуулж байгаа.

Г.Занданшатар: Тийм манай Хүний эрхийн комисс бас их санаачилгатай ажиллаж байгаа. Энэ тайланд олон санал санаачилга гаргаж байгаа, их сайшаалтай байна, ахиц дэвшил гарч байна. Тэгэхдээ та хэдийн энэ школ чинь ерөөсөө ийм социалист эрх зүйн школтой улсууд юм байна гэж дүгнэхээс аргагүй. Тэгээд бид нар шалгаж байгаад төр шалгана гэсэн. Тэгээд Үндсэн хуулийн 16 дугаар бүлгийн утга агуулга,

тэгээд 17 дугаар зүйлд заасан үүргийг та нар сайн ойлгооч ээ л гэж хэлээд байгаа шүү дээ. Тэгээд энэ хууль хэрэгжихэд яг ингээд нөгөө социалист эрх зүй заавал төр хянах ёстой, төрд гомдол гаргана, Хүний эрхийн комисс тийшээ Хэвлэлийн зөвлөл рүү шаардлага санал тавьсан. Тэгээд ийм юмаар ч хууль хэрэгжих л байх, тэгэхдээ тэр үндсэн механизм ийм байгаа шүү дээ. Одоо энэ Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг чинь үзлээ, тэгнэ ингэнэ гэсэн бас л тийм санкцууд байгаа болохоос биш хүний эрх бусдын эрх, эрх чөлөөгөөр хязгаарлагдана гэсэн үндсэн зарчим дээр тулгуурлаад бусад хүний талаар бичих бол сэтгүүлч ч бай, хэн нэгэн иргэн ч бай шүүмжлэх болбол болно оо. Бүрэн эрх чөлөөтэй. Гагцхүү тэр хүний эрхийг хүндэтгэх гэсэн Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн тэр Үндсэн хуулийг дээдэлж сахих, хүний эрх, нэр алдар, хүндийг хүндэтгэх гэсэн үүрэгтэйгээ уялдаад тэр хүний эрхийг хүндэтгэж байгаа учраас яг адилхан хэмжээнд өөрт нь няцаалт хаах няцаалт тавих хэрэгтэй. Бусад улсуудын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль яаж хэрэгжиж, тэд нарт хаалт цензур тавьж болохгүй бүх юмыг хийнэ.

Гагцхүү тэр хүнээс өөрөөс нь өөрийгөө хамгаалах хүний эрх няцаах эрхийг нь хангаж өгөх ёстой. Телевиз бол яг адилхан цагаар. Энэ иргэн Хунангийн талаар бичиж байгаа бол Хунангаас өөрийнх нь няцаах эрхийг яг адилхан цагт нь эфирийн цаг зарцуулах ёстой. Хунан өөрөө би няцаалт өгөхгүй гэвэл тэр нь баримт болоод үлдлээ. Сонинд хэвлэлээ яг адилхан хэмжээтэй дандаа энэ CNN ч юм уу олон улсын хэвлэл мэдээлэл бүх энэ энд тэндхийн сонин хэвлэлээр яг адилхан хэмжээтэй тэнцвэртэй мэдээлэл гэж түүнийг хэлж байгаа юм. Ерөөсөө тэнцвэртэй мэдээллийн зарчим биш хэвлэлийн эрх чөлөөний суурь зарчим. Тэгэхээр Хунангийн талаар бичиж байгаа бол Хунан өөрийгөө хамгаалах эрхийг сонинд яг адилхан хэмжээтэй зай гаргаж өгнө. Би ингээгүй, тэгээгүй. Энэ 2-оос харин үнэн бодитойг нь уншигч мэдэх

эрхийг тэгж хангана. Иргэний мэдэх эрхийг. Түүнээс хэвлэл мэдээллийн эрх ч гэсэн шүүх биш байхгүй, үүнийг шууд яллаад буруутгадаг юм биш. Одоо ингээд хавтгайраад байгаа юм нь болохоор ингээд тэнцвэртэй мэдээлэл тавилаа. Аль нь үнэн бодитой байна гэдгийг хүнд л ялгах эрхийг нь өгчих.

Хэрвээ үүнийг тэгээгүй байвал тэр хууль хяналтын байгууллагадаа юм уу, Хүний эрхийн комисстой юм уу хандана. Миний эрхийг хангаагүй байна аа. Ингэвэл хэрэг маргаан хянан шийдвэрлэх маш амархан. Тэгэхгүй бол одоо ингээд хэн нэгнийг бичихлээ, цагдаад хандлаа, нөгөөдөх нь цагдаагийн үүд сахиж хууль хяналтын байгууллагууд дээр баахан байлаа. Тэгээд тэр хооронд нэр хүнд нь хохирдог нь хохироод, хохирохгүй бол хохирохгүй болсоор байгаад ингээд замхраад алга болдог. Сүүдэр нь үлдчихдэг, толбо нь үлдчихдэг. Ийм тохиолдолд бол маш тэр Хэвлэлийн зөвлөл чинь шууд ханддаг байхгүй юу. Хэвлэлийн ёс зүйн зөвлөл чинь энэ сэтгүүлч энэ няцаах эрхийг хангаагүй байна аа, иргэний эрхийг үндсэн эрхийг хангаагүй байна. Ингэвэл ингээд хэрэг маргаан шийдвэрлэх юм чинь та нар. Түүнээс одоо сэтгүүлчийг юу гэж бичих юм. Ингээд сэтгүүлчийн эрх чөлөө ч, хэвлэлийн эрх чөлөө ч дээдлэгдэнэ. Хэн нэгэн хууль хяналтын байгууллага юм уу хэн нэгнээр хязгаарлуулахгүй. Тэгээд ийм агуулгаар хууль бичсэн болов уу гээд ингээд харсан тэр чинь зүгээр л дандаа тэгж болохгүй, ингэж болохгүй, ёс зүйгээр хэм хэмжээгээр зохицуулагдах тийм агуулга л биччихсэн юм байна.

Тэгэхээр энэ яг социалист агуулгаар хууль бичиж байгаа юм. Хэн нэгэн хүн төр зохицуулах ёстой гэсэн.

Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж асууя.

С.Бямбацогт: Их Хурлын дарга үндсэндээ сая бол гол санаа хэлчихлээ.

Гомдол тийм үү, өргөдөл гарах юм бол бид шалгана тэгэхгүй бол одоо шалгах боломжгүй ээ гэдэг байдлаар битгий хандаач ээ. Энэ хүний нэр төр, алдар хүндээ гутаадаг, доромжилдог, гүтгэдэг, худал мэдээлэл тараадаг асуудал бол газар авлаа. Энэ Их Хурлын 76 чинь 76-уулаа хулгайч биш ээ, хууль зөрчдөг хүмүүс биш ээ. Цөөхөн бас тийм үү, хүмүүс байж магадгүй ээ. Гэтэл бүгдийг нь харлуулсаар байгаад ингээд энэ 76 гишүүд 76-уулаа хулгайч болчихож байна. Энэ төрийн чинь нэр хүнд алга болж байна тэгээд унаж байна. Төрд итгэх ард түмний итгэл алдарч байна. Энэ нь эцэстээ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд ноцтой аюул занал учруулна аа. Тэр агуулгаар нь та нар хараач ээ. Тийм болохоор Үндсэн хуульд заасан тийм үү. Тэр хүний нэр төр, алдар хүндэд тийм үү хамаагүй халддаг асуудлыг Эрүүгийн хуульд заасан хүнийг гүтгэж, гутааж болохгүй ээ. Худал мэдээл тарааж болохгүй ээ гэдэг заалтуудыг хэрэгжүүлэх тал дээр та нар жоохон санаачилга гаргаач, санаачилга гаргаач.

Г.Занданшатар: Шүүмжилж, яллаж бичиж болно. Хэвлэлийн эрх чөлөөг бүрэн нээлттэй тэгэхдээ ганцхан няцаах эрхийг нь хангаад л болоо байхгүй юу. Тэгэхгүй бол шууд. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Хүний эрхийн асуудал бол өөрөө суурь асуудал. Хүний эрх, эрх чөлөө. Монгол Улсынхаа Үндсэн хууль дээр ч тэр ерөөсөө Монгол Улсын бүрэн эрхт байдлын дараа 2 дугаар бүлэг дээр Хүний эрх чөлөөний асуудал суурь болж орж байсан. Тэгэхээр дээр бол өөрөө өргөн хүрээтэй том сэдэв. Бид нар бусад бүх л асуудлыг ярьж болно. Хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд залуучууд, төрийн албан хаагч нар гээд. Би зүгээр эндээс 1 онцлох гээд байгаа зүйл байгаа. Байнгын хороон дээр хэлэлцэхэд ч хэлсэн. Хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудал. Хөдөлмөрлөх эрхтэй.

Өнөөдөр нийт Монгол Улсад магадгүй төрөөс цалин авч байгаа 220, 230 мянган төрийн албан хаагч нар байгаа бол үүний 60, 70 мянга нь буюу 20, 30 хувийг нь бүрдүүлж байгаа нь боловсролын салбарынхан байгаа. 2017 онд төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулаад, боловсролын салбарынхны томилгоог нь хэвтээ буюу бүх улс төрийн албан тушаалтнууд, сум, дүүрэг, нийслэлийн Засаг дарга нар томилдог болсон. Энэ хууль 2017 онд батлагдсанаас хойш 2-хон жилийн дотор бүх Монгол Улсын нийтдээ 700 гаруй сургууль, 100 гаруй цэцэрлэг, 1700 гаруй байгууллагын эрхлэгч, захирлуудын 50-60 хувийг бүгдийг нь халж, сольсон байгаад байгаа юм. Бүгдийг нь халж, сольсон. Буцаагаад хэнийг томилсон 30, 40 хувьд нь дандаа мэргэжлийн бус хүмүүс, энэ салбарт байгаагүй, хэн нэгэн улс төрчдийн гар, хөл болсон, Засаг дарга болоод улс төрийн албан хаагч нарын улс төрийнх нь ажлыг нь хийдэг л ийм хүмүүсийг томилж байгаа юм. Тэгээд мэргэжлийн бус хүмүүс тэр салбарт очоод 1700 гаруй сургууль, цэцэрлэг дээр чинь очиж удирдах албан тушаал эрхлэхээр тэд нарын ард байгаа тэр 60, 70 мянган боловсрол сургууль, цэцэрлэгийн салбарт ажиллаж байгаа албан хаагч нарыг чинь бүгдийг нь ажлын байрны дарамт, эргээд салбартаа тогтворгүй байдлыг үүсгэдэг, халдаг, чөлөөлдөг, дарамталдаг, улс төрийн нөлөөлдөө үйл ажиллагаандаа авч ажиллуулах гэдэг, ажлын байртай маргаан хөдөлмөрийн маргаанууд асар ихээр гарсан. Мянга мянгаараа гарсан. Олон зуун хүн шүүхэд гомдлоо гаргаж, асуудлаа шийдүүлж ингэж цаг хугацаа, хүч хөдөлмөр, бие сэтгэлээ алдаж байгаа асуудлууд гарч ирж байгаа юм.

Тэгэхээр та бүхний дүгнэлт дээр эхлээд танилцуулга дээр бол гарч байсан. Санал дээр болоод дүгнэлт дээр тодорхой боловсролын салбартай

холбоотой нийт хөдөлмөрлөх эрх нь хөндөгдөөд байгаа энэ салбарынхны 30, 40 хувь нь хөндөгдөөд байгаа энэ салбарынхантай холбоотой ямар 1 санал, дүгнэлтүүд байхгүй байна. Хунан дарга танилцуулга дээр уншсан. Хамгийн их хөдөлмөрлөх эрх зөрчигдөж байгаа газар бол боловсролын салбар байна гэдэг асуудлыг ярьсан. Тэгэхээр ишийдэл, гарц нь юу байгаад байгаа юм бэ. Одоо бид нар цаашдаа ерөөсөө л улс орны чинь хамгийн суурь салбар болсон боловсролын салбар, эрүүл мэндийн салбараа бид нар чадвартай, чадалтай, мэдлэгтэй, мэргэжилтэй, мэргэшсэн ийм хүмүүсээ байлгаж байж энэ салбараа тогтвортой байлгаж байж л үр хүүхдүүддээ чанартай боловсрол олгоно уу гэхээс биш тэр одоо юу гэдэг юм Улс төрийн өнцгөөр халдаг, сольдог тогтолцоогоор 6 жил яваад бүх горьг нь энэний ард байгаа салбарынхан бүгдээрээ л амсчихлаа. 60, 70 мянган хүмүүс бүгдээрээ амсаж байна. Түүний цаана чинь өөрөө бараг 1 сая гаран хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол болоод ерөнхий боловсрол бүх сургуулиудад сурч, хүмүүжиж байна. Ямар боловсролыг эзэмшиж байгаа нь одоо бол хүндрэлтэй болчихож байгаа байхгүй юу. 6 жилийн хугацаанд манай боловсролын чанарын асуудлууд хэр түвшинд очиж байгаа юм.

Энэ босоо түвшинд болгохгүй бол, энэ муу жишигийг арилгахгүй бол, эрүүл зөв тогтолцоог бий болгохгүй бол цаашдаа Монгол Улсын хөгжилд ч гэсэн өөрөө том чөдөр тушаа болж байгаа ийм асуудал байгаад байгаа юм. Уг нь энийг өөрчлөх хуулийн төслийг 2017 онд батлагдсаных нь дараа 2020 онд би нэр бүхий гишүүдтэй хамт өргөн барьсан. Одоог болтол хэлэлцэгдээгүй. Боловсролын том багц хуультай хэлэлцэгдэнэ гээд хүлээгдээд байгаа юм.

Г.Занданшатар: 82. Сүнжид.

Д.Сүнжид: Тэмүүлэн гишүүний асуулт болон саналд тодруулга хийе.

Байнгын хороон дээрээ бас ярьж байсан. Энэ асуудлыг 3 дугаар бүлгийн хөдөлмөрлөх эрхийн хүрээнд ялангуяа боловсролын салбар дээр хөдөлмөрлөх эрхийн зөрчил гэдэг хэсэг дээр яг тодруулж бол бичсэн. Өөрөөр хэлэх юм бол сургууль, цэцэрлэгийн удирдлагуудыг улс төрөөс хамааралтайгаар сольж, халж байгаа нь ажлаа хэвийн явуулах боломжгүйд хүргэж байна. Тэгээд ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалт ихээр үүсгэж байна. Тийм учраас бид нар хэвийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй байна гэдгээ бол илэрхийлсэн. Энийг нь дүгнээд 246 дахь тал дээр 2 дахь санал дээр нь юу гэж оруулж байгаа вэ гэхээр өмнө нь бас бид нар Боловсролын Ерөнхий Газрын Хууль зүйн байнгын хороо дээр мэдээллийг сонсож байхад 1 жилдээ 769 сургууль, цэцэрлэгийн эрхлэгчдийг шууд халж, сольж байна гээд энэ нь тэгэхээр энэ салбарын үйл ажиллагаа үнэхээр хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болох, нөлөөлөх, шууд эрсдэлтэй болж байгаа гэдэгтэй бол санал нийлж байгаа. Тийм учраас одоо явж байгаа хууль дээр өмнөх тэр Боловсролын тухай хуулийн 29.2 дахь томилох, санал авах болон томилох зохицуулалтыг өөрчлөөд улс төрөөс хамааралтай бишээр, процессыг зохицуулах байдлаар өөрчлөгдье гэдэг саналыг 246 дээр оруулсан байгаа юм.

Г.Занданшатар: Тэмүүлэн гишүүн тодруулж асууя. 1 минут.

Г.Тэмүүлэн: За ойлголоо. Уучлаарай. 2 дахь санал дээр байсныг би анзаараагүй өнгөрсөн юм байна. Тэгэхээр ерөөсөө Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 1 талдаа Улсын Их Хурлын нүд, чих болж байгаа байгууллага. Тэгэхээр бид бүхэн байгууллагын оруулж ирсэн санал, дүгнэлт дээр үндэслээд Улсын Их Хурлаас тодорхой алдаатай асуудлууд дээр тодорхой Улсын Их Хурлын тогтоол гаргаж, шийдвэр гаргаж шийдвэрлэх нь зөв байх гэсэн саналтай байгаад байгаа. Тэгэхээр улс 1 талдаа

Засгийн газар энэ зөрчлүүдийг арилгах үүрэг нь Засгийн газар дээр байгаа. Хууль, эрх зүйн орчин талаасаа бид нар Үндсэн хуулиараа бол ерөөсөө тэр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн бусад баталгааг хангах үүрэг нь угаасаа Үндсэн хуулиар бид нарт байгаад байгаа. Улсын Их Хурал дээр. Тэгэхээр одоо хувь гишүүний үүднээс ч тэр, Улсын Их хурал дээр өргөн баригдчихсан байгаа боловсролын тогтолцоог босоо болгож мэргэжлийн байгууллага нь хийдэг болох хуулиа том багц хуулиа хүлээхгүйгээр тусад нь хэлэлцээд хавартаа энэ батлах нь зүйтэй байх гэсэн ийм саналтай байна. Бусад зөрчлийн асуудлууд дээр Улсын Их Хурлаас бол тусгайлан Засгийн газарт чиглэл өгөх үүрэг даалгавар өгсөн.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэллээ. Байнгын хороо анхаарч байгаа байх. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ удаагийн тайлан бол Засгийн газрын үнэн төрхийг илчилсэн сайн тайлан болсон. Тэгэхдээ энийг мэдчихээд мэдээгүй юм шиг ингээд арга хэмжээ авахгүй яваад байгаад харамсаад байгаа юм.

Хоёрдугаарт нь та нарын оруулж ирж байгаа юман дээр чинь ерөнхий зүйл ярьсан болохоос биш ингэж шийдье, тийм заалтад ийм өөрчлөлт оруулъя гэдэг юм ерөөсөө байхгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ тайлангаас бол 98 хувь нь шүүхийн шийдвэргүйгээр баривчлаад байна гэж байгаа юм. Тэгээд 2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5-аар хойшлуулигүй ажиллагаа гэдэг нэрийн доор нийтдээ 870 хүнийг баривчлан, хорьсон байгаа юм. Тэрний талыг нь шүүхийн шийдвэр үргэлжлүүлэн гараад хориод явсан. Үлдсэн талыг нь суллаад явуулсан байгаа юм. Энэ юуг илэрхийлж байна вэ гэвэл тэнд хэлмэгдлийг бий болгож байна л гэсэн үг байхгүй юу. Өөрөөр хэлбэл

мөрдөн байцаагч өөртөө давуу эрх авчхаад тэр хойшлуулигүй ажиллагааны нэрийн доор хүмүүсийг баривчилдаг ийм зүйл одоо хэрээс хэтэрсэн нь эндээс харагдаж байгаа шүү дээ. Тэгээд танай тайлан дотор чинь тэр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5-ыг болиулъя гэсэн санал ерөөсөө байхгүй байгаад байна шүү дээ. Ийм хууль Их Хурал батал санаачлах ёстой гэдэг тэр зөвлөмж нь зөвлөмж дээр ерөөсөө байхгүй байна. Тэгээд одоо юу ярьж байна вэ гэхээр аль болох хүнийг хорих тухай л яриад байна шүү дээ. Хагас сайнд шүүгч байлгаж байгаад тэнд шийдвэрийг нь гаргаад хориод байя л гэсэн ийм хүний эрхийн комисс гэж юу байдаг юм бэ.

Тэр шалтгааныг нь арилгуулах талаар ажиллах ёстой байхгүй юу даа. Тэгээд өнөөдөр миний өргөн бариад 2 жилийн өмнө өргөн бариад, 1 жилийн өмнө хэлэлцэх эсэхийг нь шийдсэн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1-ийг хасах тэр хуулийг та нар мэдэхгүй байна шүү дээ. Яг энэ хуулиар чинь 360 хүнийг торгоод, баривчлаад явчихсан байна шүү дээ. 2020 онд бөөн хэл ам болсон. Зөрчлийн тухай 2017 онд бөөн хэл ам болсон Зөрчлийн тухай хуульд гүтгэдэг заалтыг оруулж ирээд хэвлэлийнхэн эсэргүүцээд энийг болиулсан. Тэгсэн чинь нөгөө Нямдорж яасан бэ гэхээр зальдаад, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр хүндэд халдах гэдэг заалт оруулж байгаад тэгээд тэрийгээ Зөрчлийн хуулиар эхлээд 50000-аар торгодог, дараагийн удаа 500 мянгаар торгодог. Тэгээд 1 сараар баривчилдаг. Тэгээд үүний дагуу чинь 360 хүнийг торгоод, шийтгээд ингээд явчихсан байна шүү дээ. Тэгээд энэнийхээ дагуу ерөөсөө хүмүүсийн амыг барьдаг, үг хэлэх эрх чөлөөг хаадаг ийм зүйл гарч байна.

Тэгээд тэр Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу мөрдөн байцаагч нар, цагдаагийн мөрдөн

байцаагч нар яаж байна гэхээр ямар ч прокурорын хяналтгүй, шүүхийн шийдвэргүйгээр тэр хүмүүсийг торгоод, тэгчхээд дараа нь торгосон тэр юунуудаа прокурор руу ерөнхий мэдээ маягаар өгч байна шүү дээ. Тэгээд аргагүй эрхэнд нөгөө 1 сараар баривчлах болохоор л шүүхийн шийдвэр гаргуулдаг. Тэгээд энэнээс чинь болоод хүн болгон тэнд очоод 50 мянгаар, би 1 сар баривчлагдах учраас үг хэлж болохгүй, юм ярьж болохгүй, дарга нар руу шүүмжилж болохгүй. Төр засгаа янз янзаар хэлж болохгүй гэдэг ийм л зүйл рүү орлоо шүү дээ. Болохгүй, бүтэхгүй байгаа тэр даргын буруутай үйлдлийг ЖДҮ, Нүүрс, Хөгжлийн банк, Төмөр замын хулгай гээд энэ бүх зүйлүүдийг хэлж байсан тэр хүмүүсийг 1, 1-ээр нь үгийг нь хаагаад байхаар төрд хэлдэг хэн байх юм, хэн үлдэх юм,. Ямар ардчилсан орон болж Монгол цаашаа явах юм. Ямар ч ардчилалгүй болж хувирна шүү дээ. Дарангуйлал чинь дасгаж хийдэг зүйл байхгүй юу. 1, 1-ээр нь нь хаширааж, 1, 1-ээр нь хүмүүст үзүүлэн болгож, тэгж байж дарангуйлал бий болдог. Дарангуйллын элементүүд чинь яг.../минут дуусав/

Г.Занданшатар: Бараг үг хэлчихлээ дээ. Энхбаяр дарга. Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга.

Б.Энхбаяр: Манай Пүрэвдорж гишүүн бол ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг илэрхийлснийх нь төлөө хүмүүсийг торгоож байгаа асуудал дээр ер нь сүүлийн 2, 3 жил идэвхтэй дуугарч, хуулийн төсөл санаачилсан байгаа юм. Тэгээд судлаад үзэхээр Пүрэвдорж гишүүний яг хэлээд байгаа олон зуун иргэдийг торгосон гэдэг нь үнэн юм байна лээ. Тэгээд энэ ковидын нөхцөл байдал энэ юутай яаж олон хэвлэл мэдээллийн сэтгүүлчид бас торгуулсан ийм дүн байдал танилцагдсан. Хүний эрхийн Үндэсний комисс бас зүгээр суугаагүй юм байна. Энэ тайлан,

илтгэлийг үзэхээр их ажил хэрэгч хандсан байгаад байгаа юм. Та бүхэн ер нь Хүний эрхийн Үндэсний комиссын тайлан, илтгэлийг ингээж 2 өдөр дэлгэрэнгүй эрх болгоноор нь урьд нь бол бас танилцаж, сонсож байгаагүй юм байна лээ. Хууль зүйн байнгын хороо бол энэ асуудалд их ач холбогдол өгч, хагас сонсгол хэлбэрээр зохион байгуулсан юм.

Түрүүн хэлсэнчлэн 97 холбогдох албан тушаалтнуудыг байлгаж байгаад асууж, хариулж эрх болгоноор нь ярьсан. Хүний эрхийн Үндэсний комиссоос гишүүдэд тараасан 590 хэдэн хуудас юм бэ. Энэ чинь бараг 600 хуудас том тайлан байгаа юм. Энэ тайлангийн та бүхэн тэр төгсгөлийг нь хараарай. Их ажил хэрэгч хандаад, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай загвар хуулийн төсөл гээд хавсаргаад тараачихсан байгаа энэ тайланд. Өөрөөр хэлбэл Хүний эрхийн Үндэсний комисс энэ асуудлыг хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай ийм хуулиар зохицуулах ёстой юм байна гээд бүр төслийг нь хийгээд, энэ хуулийг дагах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн өөрчлөлтийг нь хавсаргаад гишүүдэд тараачихсан байгаа. Тийм учраас би бол хуулийн төслийг бас үзсэн. Тараагаад. Ер нь дүн нуруу нь гарчихсан бас сайн хуулийн төсөл хийсэн байна лээ. Тийм учраас бас Пүрэвдорж гишүүнтэйгээ хамтдаа ер нь энэ хуулийн төслийг нь өргөн барьчихвал яасан юм бэ 2-уулаа. Тэгээд хэвлэлийн эрх чөлөөний төлөө ажил хэрэгчээр, бүтээлч Хүний эрхийн Үндэсний комисс бас гаргаж ирсэн зүйлийг гүүр болж, хүний эрхийн манаанд бас хамтдаа нам үл харгалзаад манаач хийе гэсэн ийм бас хариултыг хэлье.

Г.Занданшатар: 86. Нарантуяа хариулъя.

Г.Нарантуяа: Хэвлэлийн эрх чөлөөний загвар хуулийг боловсруулахад бас яг худал мэдээлэл тараах, гүтгэлэг, тэгээд нэр төрийг доромжилсонтой

холбоотой гэмт хэрэг зөрчлийг яаж шийдвэрлэх ёстой вэ гэх мэтчилэн олон 10 дагалдах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг бид нар боловсруулсан юм. Бидэнд бэлэн байгаа. Ганцхан харин Хүний эрхийн Үндэсний комисс хууль боловсруулагч биш, хууль санаачлагч биш учраас бид нарын өнөөдөр хавсаргасан загвар хууль хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах ёс зүйтэй, хариуцлагатай хэвлэл мэдээллийн салбарыг төлөвшүүлэх яриа хэлэлцээг эхлүүлэх ийм үзэл санаа зорилготойгоор бичигдсэн учраас бол бид дэлгэрэнгүй тэр бусад нэмэлт, өөрчлөлтийг эндээ хавсаргаагүй юм. Бас 1 талаасаа цаас, цагийг ч бодсон. Хэрвээ Улсын Их Хурлын гишүүд сонирхож байвал Хүний эрхийн Үндэсний комиссын тэр боловсруулсан 10 дагалдах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг бас бид нар хүргүүлэх боломжтой.

Г.Занданишатар: Пүрэвдорж гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Пүрэвдорж: Хүний эрхийн Үндэсний комисс бол Үндсэн хуулийн байгууллага болсон. Маш их олон шалгуурыг дагаж сонголтоор гарч ирсэн ийм гишүүд байгаа. Мэдээж 22 дугаар илтгэл бол урьд урьдынхаас илүү өндөр хэмжээнд, олон салбарыг хамаарсан сайн илтгэл болсон гэдгийг бас ямар ч байсан та бүхэн цаашаагаа хэлье. Дээрээс нь Улсын Их Хурал хүний эрхийг хангах талаар энэ жил бол илүү сайн ажиллана гэсэн ийм зорилтыг тавиад ажиллаж байгаа. Дээрээс нь Байнгын хороо бас Хүний эрхийн 22 дугаар илтгэлийг 2 өдрийн турш тал талаас нь бүх сэдвээр нь бүгдээр нь хэлэлцэж, бүх албан тушаалтнуудыг оролцуулж тэдний чих сонорт хүний эрхийн талаар бас нэлээн сайн ойлголт мэдлэг өгүүлж тэрний цаашдын үйл ажиллагаанд илүү сайн болгох тэр процессыг хийсэнд ийм Байнгын хорооны даргадаа бас баярлая. Тэгээд ингээд дараа дараагийн хамгийн гол нь.../минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Өнөөдөр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл, тайлангаа хэлэлцүүлж байна. Тэгээд Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнд нэр дэвшиж орж ирж байсан хүмүүсийг орж ирэхэд нь сайшаан дэмжиж бүгдэд нь амжилт хүсэж байсан. Тэгээд цаг хугацаа бол бас маш хурдан өнгөрч байна. Та бүхний хийж байгаа тайлан, энэ зүйлийг харахад бас сайшаалтай зүйлүүд, 600 хуудас боть ном, тэгээд өчнөөн цаас үйлдвэрлэсэн, хийж байгаа ажлыг ярихад бол олон зүйл байна. Энэ бол сайшаалтай зүйлүүд байгаа байх. Гэхдээ бодит нөхцөл байдал дээр бол хүний эрхийн нөхцөл байдал дээрдэхгүй байна. Энэ дээр анхаарлаа хандуулаач ээ. Арга барилаа өөрчлөөч ээ.

Өнөөдөр Монгол Улсыг эргээд харахад ардчилсан орон. Ардчиллын индексээрээ хэдэн ч байраар ухарчхав. Ардчиллын индексээр ухрах гол нөхцөл зүйл бол хүний эрхийн асуудал байдаг. Хувийн өмчид халдаж байгаа асуудал байдаг. Хэвлэн нийтлэх эрхийг хаан боогдуулсан асуудлууд байж байдаг. Тэгээд мэдээж 2 нүүртэй байна. Жишээлэх юм бол Мөнх-Эрдэнэ гээд хүн нийтийн эрх ашигийн төлөө нэлээд сайн дуугарч байсан. Буруу зөрүү зүйл хийж байсныг нь бол үгүйсгэхгүй. Гэхдээ тэр хүнийг заавал шоронд хорьж байгаад, нар үзүүлэхгүй байж байгаад, тэндээс нь яллаж байна шүү дээ. Тэгэх хэмжээний гэмт хэрэг хийсэн хүн мөн үү. Хэдийгээр буруутай зүйл байхыг үгүйсгэхгүй ч гэсэн Монголын ард түмний төлөө олон салбарт бугшсан идээ бугшааг бүгдийг шахсан. Ард түмний хэлж чадахгүй байгаа, төрд үйлчилж чадахгүй байгаа зүйлийг олон мянган иргэдэд хэлсэн, энэ үйлдлийг яагаад та бүхэн өмгөөлөхгүй байгаа юм. Саяхан 2 хоногийн өмнө байна уу. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Чинбат гээд хүн тэгээд засаг төрийн эсрэг болохгүй байгаа зүйлийг хэлж байна. Тэнд

болоогүй зүйл байхгүй шүү дээ. Тэрийг цагдаа ирээд бариад явж байхад Хүний эрхийн Үндэсний комисс дуугүй байдаг юм. Тэгээд 1 бичиг тоотоор хандсан, хандаагүй гээд. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэдэг шиг бүгдийг араас нь хөөж өөрсдийнхөө юуг хамгаалах төдий л явж байгаа байхгүй юу. Яагаад талбай дээр нь гарч ирээд гар дээрээс нь хөтөлчхөөд байх юм бол та нарын олон хүмүүсийн 1 нь тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тэр цагдаа нар ирээд хумиад, боогоод, чирээд гулдраад ингээд баривчлах уу. Монголхүү гээд сайхан зүйл дайныг эсэргүүцэж байсан, дабль стандартыг эсэргүүцэж байсан. Тэгээд энэ хүмүүсийг талбайд гарчхаад байхад нь хамгаалахгүй, тэгээд хүмүүс чинь тэр ЖДУ-чин биш шүү дээ.

Монгол Улсын та бидний татварын мөнгийг бүгдийг идээгүй, уугаагүй. Хөгжлийн банкны хэдэн их наядыг идээгүй, концесс цуцлаагүй, нүүрсний хэрэгт холбогдоогүй, зүгээр л Монгол ардчилсан нийгэмд амьдрах гэж байгаа хүмүүст ийм ийм үйл явдлууд болоод байна. Ийм давхар стандарт, төрийн 2 нүүр бий болоод байна гэж. Ийм зүйлүүд болж байхад яагаад гарч ирдэггүй юм бэ. Гарч ирдэггүй. Тэгээд дараа нь асуунгуут тийм бичиг явуулсан. Ийм хариу ирсэн. Тэдэн удаагийн хариу явуулаад, тэдэн гэж. Үгүй ээ, өөрсдөө гарч ирээд ийм ийм нөхцөл байдал ийм байна гэдгийг эхнээс нь хэлэх хэрэгтэй шүү дээ. Өнөөдөр та бид энэ ардчиллыг бэхжүүлэх гэж 2 том гүрний дунд, Дэлхий нийттэй хөл зэрэгцүүлэх гэж олон сорилтуудыг тоолж байгаа. Энэ сорилтуудыг цааш нь явж байхад манай Хүний эрхийн Үндэсний комисс та бүхний үйл ажиллагаа бол цаасан дээр биш, амьд бодитоороо гарч ирээч ээ. Энэ жагсаалуудын өмнө, үгээ хэлж байгаа хүмүүсийн өмнө, эрхээ хасуулж байгаа хүмүүсийн өмнө, очоод хөтлөлцөөгөө зогсож байгааг нь ерөөсөө харахгүй байна. Тайлан номыг нь уншихад бол мэдээж сайн сайхан зүйлүүд бол зөндөө

байж байна. Тэгэхээр яг бодит байдал дээр бид.../минут дуусав/

Г.Занданшатар:

83.

Сангишаравын Дондов, Хүрэлбаатарын Мөнхзул биш.

С.Дондов: Гишүүний асуултад хариулъя. Үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлсэн, мөн талбай дээр жагссан, мөн Засгийн газар болоод эрх баригчдын хийж байгаа үйлдэл, үгийг шүүмжилж байгаа хүмүүсийн эрх зөрчигдсөн тохиолдолд Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүд санаачилгаараа болон гомдол гаргасан тохиолдолдоо байнга ажиллаж байна. Мөн үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлсний төлөө хариуцлага оногдуулахаар шийдэгдэх гэж байгаа Мөнх-Эрдэнэ, мөн өчигдрийн, саяхан тэр Чинбат гээд хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлаар бол бид ажиллаж байгаа. Мөн Мөнхбаяр, Чинбат нартай бол биечлэн уулзаж, тухайн нөхцөлийн байдлыг нь манай референт, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнүүд уулзаж ярилцсан.

Мөн холбогдох байгууллагуудад хүний эрхийн байдлыг дээдлэх, хүний эрхийн Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгох гэх мэтийн ийм хүний эрхийн наад захын зарчим стандартуудыг хэрэгжүүлэх талаар санаачилга гарган ажиллаж байгаа. Гэхдээ хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын хэрэг үүсгээд явчихсан энэ үйл ажиллагаанд бол Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22.2-т зааснаар бол Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд хэргийн материалтай танилцах, бусад процесст оролцох боломжоор бол хязгаарлагдсан байдаг. Мөн илтгэлийн 578-д бид үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлсэн гэмт хэрэгт холбогдуулан шалгагдаж байгаа хүмүүсийн талаар Улсын ерөнхий прокурорт нэгдсэн ийм хяналтыг сайжруулаад, энэ төрлийн гэмт хэргийг Улсын ерөнхий прокуророос нэгтгэсэн

байдлаар татаж, хянаж, олон нийтэд мэдээлэх асуудлыг хийгээч гэсэн ийм саналыг бол албан ёсоор оруулсан байгаа. Баярлалаа.

Г.Занданиатар: Батсуурь гишүүн тодруулъя 1 минут.

Ж.Батсуурь: Үгүй ээ бид нар нэг иймэрхүү маягаар нэг нь асуугаад, нэг нь ингээд хариулаад, биеэ хураад л яваад байгаа юм л даа. Тэгээд үр дүн нь болонгуут Ардчиллын индексээрээ олон байраар ухраад, Дэлхий нийтийн жишиг болоод л явж байгаа. Бодит нөхцөл байдал бол өнөөдөр цахим ертөнц бол шууд мэдээлэлтэй байна. Та бүхний яг голомтод нь очоод ажилласан зүйлийг ерөөсөө олж харахгүй байгаа байхгүй юу. Тэр Чинбатын дэргэд оччихсон хөөе та нар ингэж болохгүй гэж байгаа үг сонссонгүй. Тэр Мөнх-Эрдэнийн дэргэд, тэр Монголхүүгийн дэргэд та нар ингэж болохгүй гээд дэргэд нь зогсож байсан зүйлийг олж харахгүй байгаа юм. Зөвхөн араас нь бид нар ийм бичиг явуулсан, ийм мөрдөн шалгах үйл ажиллагаанд оролцож болоогүй гээд нэг арьсаа хамгаалсан байдалтай асуудалд ингэж хандаж байгаад сэтгэл дундуур байгаа. Тэгээд энэ нөхцөл байдал руу ард түмэн та нараас юу хүсэж байна вэ гэхээр биднийг бодитоор хамгаалаад өгөөч ээ, бодитоор өмгөөлөөд өгөөч ээ, бодит зүйл асуугаад байгаа. Тэгээд энэ дээр цаашид бас анхаараасай л гэж хүсэж байна даа.

Г.Занданиатар: Нарантуяа 86.

Г.Нарантуяа: Тэгэхээр Улсын Их Хурлын эрхэм гишүүдийг хүний эрхийн эрх зүйн харилцаа гэж юу юм. Хүний эрхийн асуудал гэж юу юм. Энэ эрх зүйн харилцаанд эрх эдлэгч нь хэн юм, үүрэг хүлээгч нь юу юм. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс бас Хүний эрхийн үндэсний байгууллагын мандат чиг үүрэг юу вэ гэдэг дээр бас нэлээн тодорхой ойлголттой болох шаардлагатай байх гэж бодож байна. Тэгэхээр Хүний эрхийн

Үндэсний Комисс бол цагдаагийн байгууллага биш, энэ бол төрийн захиргааны шууд үйлчилгээ үзүүлдэг байгууллага биш. Бид хүний тогтолцоо хянадаг байгууллага. Тэгэхээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн сайн сайхан амьдрахад зориулсан хөдөлмөрийн, боловсролын, эрүүл мэндийн, эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх гээд маш олон төрлийн тогтолцоонуудыг бүрдүүлсэн бөгөөд энэ тогтолцоо чинь өөрөө хүний эрхийг хамгаалахад зүй зохистой ажиллаж чадаж байна уу гэдэг дээр мэргэшсэн хяналт тавьдаг ийм байгууллага. Тэгэхээр нэгдүгээрт нь ер нь яг талбай дээр болж байгаа жагсаал цуглаан байдаг юм уу, өөр бусад хүний эрхийн асуудал дээр Хүний эрхийн Үндэсний Комисс нэгдүгээрт нь энэ асуудал дээр нэн даруй арга хэмжээ.../минут дуусав/

Г.Занданиатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр хүний эрх, эрх чөлөөний асуудал яригдахаар 3, 4 зүйл яригдаад байх шиг байдаг юм.

Нэгдүгээрт тэр эрх, эрх чөлөөг эдлэх эрх зүйн орчны тухай яриад байна уу гэж.

Хоёрдугаарт чадамжийн тухай яригддаг болов уу гэж.

Гуравдугаарт орчны тухай яриад байдаг болов уу.

Дөрөвдүгээрт тэр зөрчигдөж байгаа эрхийг сэргээн эдлүүлэх тухай л асуудал яригдаад байх шиг л байдаг юм.

Тэгээд бид хэд эрх зүйн орчны талын асуудлыг бол цухас дурдаад яваад байна. Хамгийн ноцтой зүйл бол орчин бүрдүүлэлттэй холбоотой асуудал байгаад байгаа юм бидэнд. Тэгээд бид тайлбар хийхээрээ юу ярьдаг вэ гэхээр

эдийн засгийн чадамж, улс орны хөгжлийн түвшний тухай асуудал ярьцаагаад ингээд хаалт хийчхээд л яваад байгаа хүмүүс. Тэгэхээр энэ чиглэл дээр ер нь нарийсгаж их тодорхой хийсэн судалгаанууд байдаг юм уу. Хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал дээр төв суурин дээр чинь ер нь ямар стандарт юунууд нэн тэргүүн ээлжид гарах ёстой юм бэ. Юуг бид анхаарах ёстой юм гэж. Энэ талаарх тов тодорхой судалгаа, дүгнэлт, мэдээллүүд байна уу.

Тэр хүний зөрчигдсөн эрхийг таслан зогсоох тухай асуудал байгаа юм. Тэгээд эдлүүлэх тухай асуудал байгаа юм. Баахан хүнийг шийдвэртэй, шийдвэргүй бариад, хорьсон, барьсан гээд л ингээд л яриадад байх юм тэгээд. Үүнийг яг таслан зогсоогоод, сэргээгээд эдлүүлчихсэн юмнууд юу байгаад байгаа юм. Энэ талаар ямар бодлогын дүгнэлт, саналууд хаана тавиад, яаж шийдэгдээд яваад байна вэ. Үүн дээр 1 тодорхой хариулт авъя. Тэгээд би тэр цаана ерөөсөө хүний хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн үнэлэмжийн тухай асуудал, тэр нь буцаад амьжиргааны өртөгтэйгөө уялдах тэр 2 хоорондоо хэрхэн балансалж байгаа тэр гээд асуудлууд байсан юм. Тэгээд манай өмнөх гишүүд асуугаад тодруулчихсан учраас хариултыг авлаа гэж ингэж ойлголоо.

Г.Занданшатар: 81. Хунан дарга.

Ж.Хунан: Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийж байгаа хяналт, шалгалт, шалгах ажиллагааны үр дүн бол хамгийн түрүүнд бол эрх зүйн орчныг боловсронгуй болгох байдаг. Эрх зүйн орчныг бол баталгаажуулах байдаг. Үүнийг дагаад бид нар хамт дэд бүтэц буюу тэр тухайн зохицуулалт, тухайн эрх зүйн баталгааг хэрэгжүүлэх чадавч, чадамжийн асуудлыг үргэлж хөнддөг.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхийн асуудалтай гэж байгаа, үзэж байгаа асуудал бүрийн цаана чадавч, чадамжийн асуудал байгаа. Энэ дээр бол эдийн засгийн чадавхын асуудал байна. Тэгээд алба хаагч, хүний нөөцийн чадамжийн асуудлууд яригддаг. Энэ бүх юм дээр бид нар үнэлгээ хийдэг. Жишээ нь хог хаягдалтай холбоотой стандартууд бол мөрдөгдөхгүй байна. Яагаад мөрдөгдөхгүй байна вэ гэвэл тэдгээрийг тээвэрлэх, устгах дэд бүтэц байхгүй, тэрийг хийх мэргэшсэн боловсон хүчин, санхүүжилт байхгүй учраас хийгддэггүй гэдэг ийм.

Жишээ нь хүүхдийн эрхийг хангах эрх зүйн орчныг баталгаажуулсан стандарт, нормыг баталсан хэдий ч өнөөдөр ашиглагдаж байгаа хүүхдийн Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр 320 нь бол 1990 оны өмнө ашиглалтад орсон. Эдгээрийг шинэчлэх төсөв хөрөнгө байхгүй. Дээрээс нь тэнд наад зах нь камерын бүрэн хяналт тавих санхүүжилт байхгүйн улмаас энэ бол хийгдээгүй гэдэг ийм нөхцөл байдал байгаа. Тийм учраас бид нар илтгэлээрээ нэгд гэвэл эрх зүйн орчныг боловсронгуй болгох, 2-т гэвэл тэр дэд бүтэц буюу энийг бодитой хэрэгжүүлэх төсөв, хөрөнгө санхүүжилтийг нь шийдвэрлэх ийм саналыг бас гаргадаг.

Г.Занданшатар: Амгалангийн Адьяасүрэн гишүүн.

А.Адьяасүрэн: Хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлийг сонсож байна. Үндсэн 2 асуудлыг тодруулъя.

Нэгдүгээрт тайлан дээр жагсаал цуглаан хийх тухай журмын хуулийг боловсронгуй болгох тухай санал боловсруулсан талаар илтгэлийн тайланд бол тусгасан байна. Ямар тодорхой саналууд байна. Тодруулга тайлбар авмаар байна. Мөн түүнчлэн жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах талаар Ардчилсан

намын бүлгийн гишүүд өнгөрсөн намар хуулийг бол өргөн мэдүүлсэн байгаа. Одоо хүртэл хэлэлцэгдэхгүй явж байгаа. Энэхүү өөрчлөлтийн талаар Хүний эрхийн Үндэсний Комисс маань ямар дүгнэлт, ямар саналтай байгаа вэ. Энэ талаар бас сонсох гэсэн юм.

Хоёр дахь асуудал гэх юм бол хүүхдийн хүчирхийллийн асуудал байна. Манай улсад өдөр бүр сэтгэл сэрэхийлгэм мэдээ мэдээлэл олноор сонсогдох болсон. Гэр бүлийн орчинд хүүхдүүд хүчирхийлүүлж байна, сургалт сургуулийн орчинд хүчирхийлүүлж байна. Мөн хүүхдүүд өөрөө өөрсдийгөө хүчирхийлүүлж байгаа асуудлууд маш их гарч байгаа. Энэ бас тайланд Монгол Улс хүүхдийн эрхийг хамгаалах индексээр Дэлхийн 185 орноос хүүхдийг амьд явах эрхийг хангаж байгаа байдлаар 110 дугаар байр, хүүхдэд ээлтэй орчин бий болгож байгаа байдлаараа 123-130 дугаар байрт эрэмбэлэгдэж байгаа гэж тусгасан байна. Тэгвэл удахгүй 4 сарын 30-нд хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдөр тохиож байгаа. Энэ өдрийг угтаж Хүүхдийн эрхийн үндэсний комисс ямар бодлого, ямар үйл ажиллагаа зохион байгуулах гэж байна вэ. Мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн дагуу Монгол Улсын Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах ёстой. Гэтэл энэ талаар төрийн бодлого байхгүй байгаад Хүний эрхийн Үндэсний Комисс ямар дүгнэлт хийж байгаа вэ. Түүнээс гадна мөн ажил олгогчид өөрийн ажил үйлчилгээ болоод албан хаагчдаараа дамжуулаад гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх мөн ажилтан албан хаагчдынхаа ажил амьдралын тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудад зайлиггүй шаардлагатай байгаа өөрчлөлтүүдийг оруулах талаар Хүний эрхийн Үндэсний Комисс ямар байр суурийг илэрхийлж

байгаа талаар бас тайлбарыг авах гэсэн юм.

Г.Занданшатар: 81. Хунан дарга. Тодорхой хариулаарай.

Ж.Хунан: Хүүхдийн эрхийн асуудал үнэхээр хүнд байгаа. Ялангуяа бага насны хүүхдийн хүчирхийллийн асуудал бол үргэлж комиссын анхаарлын төвд байдаг. Комисс өнгөрсөн оны илтгэлдээ бол хүүхдийн хүчирхийллийн тогтолцооны асуудлыг бол хөндсөн байгаа. Энэ хүрээндээ Хүүхэд хамгааллын хамтарсан баг, хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, тэнд дүн шинжилгээ хийсэн. Тэгээд хийсэн дүгнэлт нь бол хамтарсан багийн үйл ажиллагаа хангалтгүй байна, хүртээмжгүй байна, дээрээс нь мэргэжлийн биш байна гэдэг ийм дүгнэлтийг бол хийсэн байгаа. Энэ жилийн хувьд хүүхэд хамгааллын шинэ тогтолцоо болох гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн гэрч, гэмт хэргийн холбогдогч хүүхдийн эрхийн асуудлыг хүүхдэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаанд нь хяналт шалгалтыг хийсэн. Тэгээд энэ хүрээндээ ямар дүгнэлт хийсэн бэ гэхээр энэ гэмт хэргийн хохирогч болж байгаа, гэмт хэргийн холбогдогч болж байгаа, гэмт хэргийн гэрч болж байгаа хүүхдэд үзүүлдэг үйлчилгээ бол хангалтгүй байна. Тэнд бол хүүхдийн эрх зөрчигдөж байгаа дахин зөрчигдөх нөхцөлийг бол бүрдүүлж байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа хангалтгүй байгаагийн гол шалтгаан бол төсөв, хөрөнгө байдаггүй. Холбогдох байгууллагуудын уялдаа холбоо бас хангалттай хэмжээнд байдаггүй юм байна гэдэг ийм дүгнэлтийг хийсэн. Тийм учраас Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, энд төсөв зайлиггүй хуваарилах шаардлагатай гэдэг ийм саналыг гаргаж байгаа. Үүнээс гадна хүүхэд Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүүхдийн эрхийн чиглэлээр Хүүхэд хамгааллын тухай хууль,

Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрсдийн саналыг боловсруулж байна. Тэгээд шинэчилсэн найруулга буюу нэмэлт, өөрчлөлттэй холбоотой саналыг хүргүүлнэ гэж харж байгаа.

Г.Занданшатар: Нарантуяа. 8б.

Г.Нарантуяа: Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг сайжруулах 11 төрлийн үндсэн чиглэлүүдийг бид нар танилцуулсан байгаа. Тэгэхээр ерөөсөө жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд тайван хуран чуулах эрх чөлөөний мөн чанар агуулгыг бас бүрэн тусгах шаардлагатай байгаад байгаа. Нийтийн орон зайд хэрэгжүүлдэг улс төрийн эрх чөлөө үндэсний аюулгүй байдал, нийтийн нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн ёс суртахуун, эрүүл мэнд, бусад хүний эрх, эрх чөлөө гэсэн энэ хууль ёсны хязгаарлалтуудаар хязгаарлагддаг. Тэр тайван хуран чуулах эрх чөлөөг хэрэгжүүлэх орон зайг бид нар бас тодорхой хуульчлах шаардлагатай байгаад байгаа юм. Тэгээд энэ хүрээнд ямар асуудлуудыг тусгасан бэ гэхээрээ мэдээж эрх чөлөөний мөн чанар концепцыг бүрэн тусгах шаардлагатай. Тайван хуран чуулах эрх чөлөөний хууль гэдэг үзэл баримтлалын үүднээс боловсруулахдаа тайван жагсаал цуглааны бүх үе шатыг хамгаалах, өөрөөр хэлэх юм бол зөвхөн талбай дээр жагсаал цуглаан гэдэг бол зөвхөн өрнөж байгаа процесс биш. Энд бэлтгэх олон хүн үзэл бодлоо илэрхийлэх ийм арга хэмжээ учраас бэлтгэх үе шат, тэрний дараах аюулгүй тарах, дараа нь үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбоотой хүнийг мөрдөж мөшгөхгүй гэсэн айдас түгшүүрээс ангид байхтай холбоотой энэ бүх үе шатны асуудал байгаад байгаа.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд хуулиар хориглосон жагсаал цуглааныг жагсаасан байгаа. Энэ агуулга нь өргөн хүрээтэй олон улсын гэрээнд нийцэхгүй байгаа. Жагсаал цуглаан хийх хууль ёсны олон төрлийн арга хэлбэрүүд

шинээр бий болж байгаа. Нөгөө аяндаа үүссэн цуглаан гээд бүртгэл тодорхой зохион байгуулагчгүй гэнэт үүсдэг энэ асуудлууд гээд энэ бүх хэлбэрүүд ямар ямар мөн чанартай юм бэ гэдгийг тодорхойлоод бүгдийг нь хуульд тусгаж хамгаалах ёстой гэсэн асуудал байгаа. Жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хэрэгжүүлэгч субъектийн талаарх зохицуулалт бас хүний эрхийн зарчимд нийцэхгүй байгаа. Тайван жагсаал цуглаан хийх хориглосон газруудыг хянаж үзэхтэй холбоотой асуудал, хязгаарлах үндэслэл журмыг түрүүнд хэлсэн. Тэгэхээр жагсаал цуглааныг бүртгүүлэхтэй холбоотой асуудлыг мөн эрх чөлөөг хүндэтгэн хангах үзэл баримтлалын үүднээс тодорхойлох нь зүйтэй. Жагсаал цуглааныг мэдэгддэг бүртгэдэг зохицуулалт байх нь хүний эрхийг зөрчсөн асуудал биш. Энэ бол жагсаал цуглааныг явуулах тэр төрийн захиргаа, хууль сахиулах байгууллагын дэмжлэгийг бий болгох, зохион байгуулалтыг хийх зорилгоор байх боломжтой.

Ганцхан энийг оновчтой эрх чөлөөг хүндэтгэх, хангах үзэл баримтлалын үүднээс хуульчлах шаардлагатай гэж үзсэн байгаа. Тайван жагсаал цуглааны үеэр олон нийтийг мэдээллээр хангах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн хяналт тавих гээд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тэр эрх зүйн зохицуулалтууд байх ёстой, дараа нь тайван жагсаал цуглааны үеийн хууль сахиулах ажиллагааг журамлах шаардлагатай байгаад байгаа. Энэтэй холбоотой Зөрчлийн хуулийн 5.8 дугаар зүйлд заасан хариуцлага тооцох үндэслэлүүдийг бас тайван хуран чуулах эрх чөлөөний үүднээс хянаж үзэх шаардлагатай гэсэн үндсэн асуудлуудыг илтгэлд тусгасан байгаа.

Г.Занданшатар: Адьясүрэн гишүүн тодруулъя. 1 минут.

А.Адьяасүрэн: Тодорхой асуулт бас асуусан л даа. 4 сарын 30-нд Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг олон улсын өдөр гэсэн. Энэтэй холбоотойгоор ямар арга хэмжээ авах гэж байна вэ.

Хоёрдугаарт нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйл дээр Монгол Улсын Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах төрийн бодлого боловсруулах ёстой, төрийн бодлого байхгүй яваад байгаа дээр Хүний эрхийн Үндэсний Комисс ямар дүгнэлт өгч бас Засгийн газарт ямар чиглэл өгч байгаа вэ. Энэ талаар би тодорхой хариултыг авмаар байна.

Г.Занданшатар: 85.
Хүрэлбаатарын Мөнхзул.

Х.Мөнхзул: Адьяасүрэн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, ахмад настны эсрэг хүчирхийлэл гээд энэ асуудлууд бол нэг талаар хүний эрхийн зөрчил, нөгөө талаар гэмт хэрэг байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид нар энийг гарсан хойно нь үр дагавартай нь тэмцээд байна. Урьдчилан сэргийлэх хамгийн гол нь эрт шатанд нь илрүүлэх ийм Засгийн газрын бодлого дутмаг байгаа. Тийм учраас бол Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхийн талаарх үндэсний хөтөлбөрийг батлуулах ажлыг бол Засгийн газартай хамтраад үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажил дээр хамтарч ажиллаад явж байна. Тэгэхээр энэ бодлого хөтөлбөрийг бол Улсын Их Хурал батлах нь бол зайлиггүй шаардлагатай байгаа. Энэ дээр бол олон хүний эрхийн зөрчлөөс урьдчил сэргийлэх, таслан зогсоох асуудал бол нэгдсэн зохицуулалттайгаар уялдаа холбоотойгоор.../минт дуусав/

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Баярлалаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан, мэдээлэл, дүгнэлт ер нь зүгээр цаг хугацаандаа яг өнөөдөр тулгамдаад байгаа асуудлуудаа оруулаад ирсэн байна л даа. Ер нь манай парламентын, Их Хурлын дэргэдэх 3 байгууллага ингээд жилдээ бас Засгийн газарт чиглэл өгүүлэх, Их Хурлын хуулийг боловсронгуй болгох талаар бас зөвлөмж дүгнэлтүүд өгдөг л дөө. Үүний нэг нь бол Хүний эрхийн Үндэсний Комисс. Тэгэхдээ бид нарт нэг ийм юм байна. Бид Монголчууд маань өдрөөс өдөрт хүний эрхийн ийм ноцтой зөрчлүүд дээр ингээд бодит байдал дээр нүүр тулаад эхэлсэн. Ер нь бас ард иргэд маань хэзээ бид нар хүний эрхийн зөрчилгүй болох тал дээр хэнд гомдол гаргах бол. Хүний эрхийн Үндэсний Комисс маань биднийг хэзээ бүрэн хамгаалж чаддаг болох бол. Хэзээ эрх мэдэлтэн, дарга нар нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргаж байгаа шийдвэр нь бас хамааралтай, түүнээсээ айдаг болох юм бол гэсэн ийм л хүлээлтэд байгаа л даа. Цаг хугацааны хувьд ч гэсэн өнгөрсөн хугацаанд би Хүний эрхийн Үндэсний Комисст бас тодорхой хүсэлтийг хувь хүнийхээ зүгээс гаргаж байсан. Мэдээж энэ дээр өнөөдрийн илтгэл, тайлангийн хамгийн 1 дүгээр асуудал болоод ороод ирсэн байна л даа. Сайн байна. Мэдээж халдашигүй чөлөөтэй байх эрх. Одоо шүүхийн ямар нэгэн тогтоол, шийдвэргүй баривчлах, түүнийг сунгах цаг хугацаанд нь бас баривчилгааны газар, тэр шорондоо хорьдог энэ асуудлууд бол үнэхээр хэрээс хэтэрсэн.

Сая НҮБ-ын гаргасан шийдвэрүүд гаргасан тэр тайлан дүгнэлтэд бүр тодорхой тусгагдаад, тэрийг та нар маань бас сайхан оруулсан байна. Тэгээд дүгнэлт нь болохоор тайлан нь болохоор прокурорын байгууллага эндээ хяналт тавих хэрэгтэй, энийгээ тогтмолжуулах хэрэгтэй, баривчилгааны бус, ямар нэгэн алдаатай шүүхийн шийдвэргүй баривчилгааг хийсэн бол түүнийг нь тавиулах ёстой тэр гээд л тодорхой

хэмжээнд чиглэл өгсөн байгууллагуудын үйл ажиллагаанд чиглэл өгсөн байна л даа. Энд ер нь зүгээр шууд Засгийн газар нэн ялангуяа эрхтэн дархад нь дарга нарын тушаал шийдвэрээр хийгдэж байгаа ажлууд их байгаа. Энийг та бүхэн маань бас маш сайн гаргаж тавимаар байна. Энийг зөвлөмжид тэр шийдвэр гаргаж байгаа шүүхийн байгууллага түүнийг Засгийн газрын харьяа байгууллагууд болох тэр Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, энэ байгууллагуудаас гарч байгаа тэр алдаа дутагдлуудыг нь бас яг зөв чиглэлийг нь олж бас чиглэлийг нь өгмөөр байна. Ингэж байж бид нар энэ засах залруулах асуудал нь тодорхой болох байх л даа. Түрүүн яриад л байна.

Батзандан Улсын Их Хурлын гишүүнээр 2 удаа сонгогдсон хүнийг баривчилчхаад, тэгээд шүүхийн шийдвэр гараагүй байхад хориод л байсан. Үгүй ээ, жирийн иргэд дээр чинь бүр илүү аймаар байгаа байлгүй дээ бодвол. Сая Мөнх-Эрдэнийн асуудлыг ярьж байна. Тэр хүн яагаад нийгэмд тэр мэдээллийг хүргэхийн тулд маш олон үйлдлүүдийг гаргаж байна вэ гэхээрээ өнөөдрийн бид нарын яриад байгаа шиг асуудалд хандахаар хэн ч энийг хүлээж авахгүй байгаа байхгүй юу. Тийм учраас л олон нийтэд хүргэж нийгмийн бас дэмжлэгийг авах гэж тэр хүн тэр хүмүүст нь зориулсан хэзээ ч бусдын үгийг сонсдоггүй. Одоо бид нарын та бүхний гаргаж байгаа тайланг тэр дарга нар хүлээж авна гэж бодож байна уу. Авдаггүй л байхгүй юу. Энийг ер нь хэн хянах ёстой юм. Энэний хэрэгжилтийг хэн хянах юм. Энэний эсрэг л тэр хүн үйлдэл гаргасан. Харамсалтай нь түүнийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах юм. 85. Энхболд. Бүх байгууллагад зөвлөмж өгч байна.

Б.Энхболд: Ганибал гишүүний асуултад хариулъя. Бас өмнө нь бас хэд хэдэн гишүүд тодорхой хүний нэр дурдаж

асуудлуудыг тавиад байгаа. Тэгэхээр үнэхээр олон нийтийн зүгээс үзэл бодлоо илэрхийсний төлөө цагдан хориод байна гэдэг асуудал бол хүчтэй явагдаж байгаа. Тэгээд энийг бид бүхэн хараагүй юм шиг өнгөрөөгүй. Мэдээж холбогдох байгууллагуудаас нь мэдээллийг авдаг, шалгадаг, үздэг. Тэгээд ийм зүйл хэлэхэд I талаар 2-3 төрлийн гэмт хэрэгт холбогдчихоод байгаа хүмүүс, тэгээд тодорхой хууль тогтоомжоо зөрччихсөн. Тэгээд ийм хүмүүс дээр ер нь хүний эрхийн байгууллага ямар зарчмаар ажиллах вэ. Хүний эрх гэж ярьсан болгоныг бид нар яг шууд утгаар нь суллах ёстой гээд яваад байхаар чинь бас тийм яг мэргэжлийн үйл ажиллагаа биш болоод явчхаад байгаа юм л даа. Бид нар хүний эрхээ хамгаална. Олон улсын гэрээ, конвенцод заасны дагуу. Гэтэл чинь өөр Монгол Улсад үйлчилж байгаа бас яах аргагүй бас нарийн сайн боловсруулчихсан хууль тогтоомжийн хүрээнд асуудлууд шийдэгдээд байгаа бол бид бүхэн бол хууль тогтоомжийг л барьж ажиллаж байгаа. Үнэхээр тэр хориод байгаа хууль нь цагдан хорих хууль бас хэт ерөнхий зохицуулалттай байна гэдгийг бид нар хангалттай сайн хэлж байгаа. Холбогдох ажлын хэсэг гарч хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулъя. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын судалгаа дүгнэлтийг авъя гэж хэлж байгаа дээр бид бүхэн бас орж ажиллахад бэлэн байгаа. Ийм асуудал бас байгаа. Тэр олон хүний асуудал дээр Монголхүү, Батзандан, Мөнх-Эрдэнэ, Чинбат гээд энэ хүмүүс дээр яг ганцхан ийм зүйл байхгүй байгаа шүү гэдгийг та бүхэн бас I талаас нь хараарай.

Хоёрдугаарт. Засгийн газарт бол чиглэл өгч байгаа. Зөвлөмж өгч байгаа. Энийг Улсын Их Хурал бол тогтоол гаргаж, хүний эрх, эрх чөлөөг хангах тал дээр тодорхой үүрэг өгөгдөх байх гэж ингэж харж байгаа. Мэдээж тэр гүйцэтгэх эрх мэдлийн мөрдөн шалгах байгууллагуудын хүний эрхийн тэр хууль тогтоомжийн хэрэглээ, мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, хүний эрхийг

зөрчиж байгаа асуудлуудыг илтгэлд маш тодорхой тусгасан. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа энэ судалгааны үр дүнг нарийн харах байх гэж ингэж бодож байгаа.

Г.Занданшатар: Ганибал гишүүн тодруулъя 1 минут.

Н.Ганибал: Тэгээд асуудал яг мөн чанар нь болохоор шүүмжлэлийг хүлээж аваад асуудлыг шийдэх биш, буцаагаад нөгөө хүмүүсээ буруутан болгож байгаа асуудал нь хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил байгаад байгаа байхгүй юу. Хүн нь байвал хэрэг нь олдоно гэдэг 1939 оны л бараг арга байх даа. Тэгээд энийг та хэд жоохон ухаж сайн ойлгоорой. Өнөөдөр заавал хэн нэгнийг шүүмжилснийхээ төлөө ямар нэгэн хэрэгт заавал холбогдох ёстой гэсэн байр суурин дээр асуудалд хандаад байна шүү дээ. Энэ дээрээ анхаараарай л гэдгийг бас хэлье. Тэгээд ер нь хүний эрхийн тайлан, илтгэлийн хэрэгжилтийн үр дүнг Их Хурлын тогтоолын төслөөр ер нь тэгээд ийм зузаан юм өгчихнө. Нөгөө хэд чинь ер нь Засгийн газрынхан уншдаг ч юм уу, үгүй ч юм уу. Хэрэгжүүлдэг юм уу, үгүй юм уу. Энэ асуудал дээр ер нь яг яаж тодорхой болгох тал дээр та бүхэн бас өөрсдийнхөө байр суурийг байнга илэрхийлж, зөвхөн юу гэдэг юм Их Хурлын гишүүдэд найдах биш, Их Хурлын тогтоолд найдах биш.../минут дуусав/

Г.Занданшатар: 84. Энхболд хариулъя. Батзэвэгийн Энхболд 84, 81 Хунан дарга.

Ж.Хунан: Ганибал гишүүний асуултад бас тодруулга хийе.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль шинэчилсэн найруулга бол 2020 онд батлагдсан. Тэгээд найруулгаар орсон нэг гол чухал өөрчлөлт бол Хүний эрхийн Үндэсний Комиссоос Улсын Их Хуралд өргөн барьж байгаа хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлийг чуулганы

хуралдаанаар заавал хэлэлцээд шийдвэр гаргадаг болсон байгаа. Өөрөөр хэлбэл Засгийн газар тодорхой үүрэг даалгавар бол өгөгдөж, тэдгээрийн хэрэгжилтийг бол Хууль зүйн байнгын хороонд бол эргэж тайлагнадаг ийм механизм явж байгаа. Тийм учраас бидний хөндөж байгаа асуудлууд, бидний гаргаж байгаа саналууд бас үр дүнгээ өгнө гэж харж байгаа.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн хаслаа. Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Энд бас яригдахгүй орхигдоод байгаа зүйл бол уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн асуудал ер нь их бүдэгхэн сонсогдоод байгаа юм. Уул уурхайн олборлолтын явцад, ашиглалтын явцад, тээвэрлэлтийн явцад бас нэлээд их хүний эрх зөрчигдөөд байгаа юм. Ялангуяа уул уурхайн бүс нутаг, уул уурхайн лиценз тусгай зөвшөөрөл ихээр олгогдсон бүс нутаг, олборлолт, экспорт хийгдэж байгаа бүс нутгийн хувьд бас....

Г.Занданшатар: Өнөөдрийн хэлж байгаа яг асуудлууд дотор дараагийн юун дээр хэлэлцэгдэх байх. Эрүүдэн шүүх хамаарахгүй л байх. Эрүүдэн шүүх тусдаа. Тэгэхдээ өнөөдөр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, төрийн албан хаагчийн цалин хөлс, хүүхдийн эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх гээд ахмадын эрх, жендерийн эрх гэсэн л асуудлууд гол яригдаж байгаа л даа.

Н.Наранбаатар: Үргэлжлүүлъя. Тэгэхээр уул уурхайн үйл ажиллагаатай холбогдуулаад уул уурхайн олборлолт ашиглалт хийж байгаа бүс нутагт их ойрхон байгаа сум, багийн хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь нэлээд зөрчигдөж байгаа талаар өмнө нь бас нэлээд орон нутагт бас яригдаж байсан. Тухайлах юм бол манай Өмнөговь аймгийн Цогтцэций суманд уул уурхайн томоохон үйл ажиллагаа явуулж

олборлолт хийгдэж байгаа. Үүнтэй холбогдуулаад Цагаан-Овоо баг гэхэд л сумын 1 баг нь уул уурхайн лицензийн талбайд орчихсон, хүн тэнд амьдрах, ажил хөдөлмөрлөл хийх, оршин суух ямар ч боломжгүй. Цогтцэций сум өөрөө бас уул уурхайн нөлөөнд орчихсон ийм асуудлууд байдаг. Энэ дээр ямар тооцоо судалгаа та бүхэн хийж байгаа вэ. Тайланд тодорхой тусгагдсан зүйл байгаа юу.

Хоёрт гэвэл уул уурхайн компанид ажиллаж байгаа ажилчдын бас хүний эрх зөрчигдөж байгаа асуудлууд бас байгаад байгаа юм. Тухайлбал Хөдөлмөрийн хуулийн өөрчлөлт ажлын цагийг амралтын горимыг 14/14 болгосонтой холбогдуулаад бас уул уурхайд шөнийн ээлжид ажиллаж байгаа хүмүүсийн эрх зөрчигдөж байна. Мөн илүү цагийн цалингаа авч чадахгүй байгаа асуудлууд байж байна гээд олон асуудлуудыг бас уул уурхайн ажилчид, үйлдвэрчний эвлэлүүдээс бас ярьж байгаа юм.

Дараагийн асуудал гэвэл уул уурхайн тээвэрлэлтээс болоод малчдын маань эрх нэлээд зөрчигдөж байна. Олон салаа зам гаргаж байна. Тоос шороо буужигнуулж байна. Үүнтэй холбоотойгоор бэлчээр нутаг хомсдох, цөлжилт бий болох, малын өвчлөл, хүний эрүүл мэнд уушгины өвчлөл гээд олон асуудлууд тулгардаг. Ийм зүйлүүд байгаа. Тэгээд энэ дээр өнгөрсөн хугацаанд та бүхэн ямар судалгаа шинжилгээ хийв. Цаашидаа энэ дээр бас ямар зохицуулалт хийх шаардлагатай байна вэ гэдэг дээр бас тодруулга мэдээлэл авъя.

Г.Занданишатар: 82 Сүнжид. Дугарын Сүнжид.

Д.Сүнжид: 2018 онд ялангуяа Өмнөговь аймагт амьдарч байгаа хүмүүсийн амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, усны чанарын асуудал, хөрсний чанарын асуудлаар нэгдсэн ийм байгаль орчны үнэлгээ бол

хийгээд Хүний эрхийн Үндэсний Комиссоос танилцуулсан юм билээ. Энэ жилийн тухайд яг 2018 онд гаргасан тэр тайлан мониторингийн мөрөөр сайжруулах ажил хийгдсэн үү гэдэг талаар энэ жилээр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотойгоор мониторинг үнэлгээ үргэлжлээд хийгдээд явна. Тэгэхээр тэрийгээ бас харьцуулаад 2018 онтой танилцуулах юм.

Энэ 14/14 гээд Хөдөлмөрийн тухай хуульд орсон ээлжийн ажилтай холбоотой саналыг бол ирүүлж байгаа. Энэ талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хууль зүйн байнгын хорооны хуралдааны явцад бас тодорхой саналаа илэрхийлж байна лээ. Өөрөөр хэлэх юм бол ажил амьдралын тэнцвэр болоод цалин 25 хувиар хасагдсантай холбоотой асуудлаар судалгаа хийгээд тэгээд Засгийн газраар уламжлаад Улсын Их Хуралд танилцуулна гэдэг ийм мэдээллийг өгсөн.

Г.Занданишатар: 81. Хунан дарга.

Ж.Хунан: Уул уурхайн том төслүүдтэй холбоотой хүний эрхийн асуудлууд бол яригддаг. Хүний эрх хамгаалагчийн асуудлын хүрээнд бол хэд хэдэн томоохон уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотой очиж иргэдтэй уулзсан. Иргэдийн зүгээс асуудал тавьдаг хүндрэлтэй байдаг асуудал нь юу вэ гэхээр иргэдийн оролцоогүйгээр тэдний асуудлыг шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговрын асуудлыг шийдэхдээ тэдний оролцоогүй шийддэг гэдэг ийм асуудлыг гаргаж тавьдаг. Уул уурхай ба хүний эрхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн ажлын хувьд бол хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачлал гэж гарын авлага боловсруулсан байдаг. Тэгээд энэ аргачлалын дагуу 2021 онд туршилтын журмаар Төв аймаг болон Дорноговь аймгийн Даланжаргалан, Төв аймгийн Баянжаргаланд үнэлгээ хийж туршиж

үзсэн байдаг юм. Харамсалтай нь тухайн үед бол яг нөгөө уул уурхайн компаниуд өөрсдөө үйл ажиллагаа нь жигдрээгүй, ороогүй байсан учраас тэрийг хийж чадаагүй байгаа. Тэгээд тэрийг үргэлжлүүлж хийнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Мөн томоохон уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын ажилчдын хөдөлмөрлөх эрхийн асуудлыг бол комиссоос шалгалт хийхээр төлөвлөсөн байгаа. Үүн дотор бол Оюутолгой, Цагаанхад дэх тээвэрчдийн хөдөлмөрлөх эрхийн асуудал орсон байгаа. Тэгээд энийг бол ойрын хугацаанд буюу 5 сард хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байгаа гэдгийг бас танд дуулгая.

Г.Занданшатар: Болсон уу. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тэгээд Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дугаар илтгэл бол бас харьцангуй дэвшилттэй боловсруулсан. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргах, аливаа асуудлаар гэж байгаа шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр цагдаагийн байгууллага ч гээгүй, прокурор ч гээгүй. Тэгэхдээ хүний эрхийн асуудлыг анхаарч зөвлөмж гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд бүх албан тушаалтад зөвлөмж хүргүүлэх эрх бүхий байгууллага хараат бусаар ажиллах, хүний эрхийн талаар ярих гол байгууллага учраас л гишүүд санаа зовж, анхаарал тавьж, асуулт асууж, саналаа хэллээ гэж ойлговол зохино. Түүнээс ойлгохгүй, мэдэхгүй дээ хүний эрхийн комисс гэж ямар байгууллага байдаг юм Их Хурал тэр нь ямар байгууллага гэдэг талаасаа биш. Их Хурал ч гэсэн ард түмний төлөөллийн байгууллага учраас ард түмнээс төлөөлж хуулийг нь тогтоодог байгууллага учраас хууль тогтоолтой холбоотой асуудлыг ч авч хэлэлцэж болно. Санал шүүмжлэл

өрнүүлж болно. Үүнийг анхаарч ажиллавал зохино. Тэгээд энэ дотроо 1 дүгээр асуудал дээр хүний эрхийн зөрчлийн 17 хувийг хүний халдашгүй чөлөөтэй байх эрхтэй холбоотой гэж Олон улсын байгууллагын шинжээч судлаачид дүгнэж байгаа гэж үзээд тэр хойшлуулигүй тохиолдол гэдгийг хэт өргөн хэрэглэж байна гээд байгаа боловч яг үнэн хэрэг дээрээ тэр хууль хэрэглээндээ байна уу аль эсвэл яг манайх бүх юмыг болохоор л хууль руугаа чихчихдэг. Хууль болохгүй байна гээд. Дээд шүүх ч гэсэн хуулийн тайлбар гаргаж Хүний эрхийн Үндэсний Комисст санал хүргүүлж, зөвлөмж хүргүүлж энийг тайлбарлаж болно.

Тэгээд бүр болохгүй бол хойшлуулигүй тохиолдлыг нарийвчилж, тодорхой болгож зохицуулалт хийж болно. Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй тохиолдол гарна шүү дээ. Хойшлуулигүй тохиолдол гэж гарч таарна. Тэгэхдээ тэр процесс нь тэр нь ямар ялын санкц дээр байх юм. Ялын дээд хэмжээ авах бүх насаар нь хорих ч байдаг юм уу ийм ялын хэмжээтэй зүйл ангиуд дээр хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй тохиолдлоор нотлох баримтыг устгах эрсдэл бүхий нөхцөл байдал гэж юуг хэлэх юм гэж. Процессоо үүнийгээ тодорхой болгож байж энэ асуудлыг хуульчлахгүй бол тэгээд ерөөсөө л ийм болохоор хуулийн буруу. Ингээд хууль руу эзэн биегүй чихчихдэг. Тэгтэл яг хууль хэрэглээний талаасаа, хуулийн эргэх хандлагын талаасаа яг аль байгууллага дээр гэхээр цагдаагийн байгууллага дээр 93 хувь гээд биччихсэн байгаа шүү дээ. Ямар тохиолдлоор нь ингэж илүү сурталчлаад энэ асуудлаа бол 1 мөр болгох ийм санаачилга гаргах хэрэгтэй гэж үзэж байна.

Тийм учраас ер нь холбогдох бүх асуудлаар Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын тогтоолын төслөө санаачилж хэлэлцүүлнэ. Халдашгүй

чөлөөтэй байх эрхийн талаар бол ер нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд ч гэсэн ер нь процессын хуульдаа тодорхой болгох шаардлагаа илүү нарийвчилж тусгах хэрэгтэй байх. Тэгээд энийгээ бас Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд илүү тодорхой болгох.

Тэр хэвлэлийн эрх чөлөөний асуудал бол зүгээр ингээд хууль санаачилчихгүй л дээ. Энийг хэвлэлийн мэдээллийн байгууллагууд, Хууль тогтоомжийн хуулийн дагуу санаачилж, холбогдох байгууллагуудын саналыг авч, иргэд олон нийтээр хэлэлцүүлж, хэвлэлийн байгууллагуудын саналыг авч 60 хоног, 30 хоног заасан хугацаатай хууль тогтоомжийн хуульд заасан шаардлагуудыг хангаж байж тэгээд нууц эх сурвалжийг шүүхийн даалгавраар илчилж болно ч гэдэг юм уу. Гэх мэтчилэн санкцууд зохицуулалт энэ тэрүүдийг бол олон улсын туршилага харгалзаж байна. Хамгийн гол нь энэ нэг босоо хяналтын тогтолцоо гэж байгаа юм. Дандаа манай бүх хуулийн босоо буюу төрийн тогтолцооны уламжлалт арга хэлбэрээр социализмаас урагшилж ирсэн тэр тогтолцоогоор асуудлыг шийдэх гэж байдаг. Хэвтээ хяналтын тогтолцоо буюу /horizontal accountability/ гэж хүний эрхийн иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор ингэж саяын хэлдэг бол иргэнээр өөрөөр нь хяналт тавиулж байгаа байхгүй юу. Миний няцаах эрхийг хангагдаагүй байна. Ийм юмыг тогтооход хууль хяналтын байгууллагууд маш амархан. Үнэхээр бичлэг хүсэлт бичиг нь хангагдаагүй бол ингээд ийм санкцуудаар хуулийг хууль зүйн техникийн хувьд ч гэсэн хийхгүй болохоор дандаа ингээд нэг албан тушаалтан эцсийн эцэст бас л хүн шүү дээ ингэж шийднэ гэж ийм босоо удирдлагын тогтолцоонд хууль хийдэг юмнууд чинь хүний эрхийн зөрчлийн нэг гол шалтгаан болдог гэж олон улсад үздэг болчихсон шүү дээ. Тийм учраас хэвтээ хариуцлагын тогтолцоо буюу /horizontal accountability/ гэж байгаа юм.

Энийг бол та хэд сайн анхаарч судалмаар санагдаж байна.

3 дахь маш чухал асуудал дээр тэр та хэд харин их сайн дүгнэлтүүд гаргасан байна лээ. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд тэр ахмад настнуудыг ч оруулаад, багш нарын асуудал, эмч нарын асуудал, нэн ялангуяа хөдөө орон нутгийн багш нарын эрхийн асуудал, ажил хөдөлмөрөө чөлөөтэй сонгох эрхийн хүрээндээ энэ асуудлуудыг бол шалтгаан нөхцөлийг илрүүлэх шийдвэрлэх асуудлыг харгалзсан тэр хөдөлмөрлөх эрхийн талаар хөдөлмөрийн харилцааны талаарх санаачилгуудыг бол цалин хөлстэй холбоотойгоор холбогдох байнгын хороодод Төсвийн байнгын хороонд чиглэл өгсөн байгаа. Энэ чиглэлээрээ бас тогтоолд тусгах шаардлагатай байх. Тэгээд хүүхдийн эрхийн асуудал, ахмадын эрхийн асуудал, жендерийн эрхийн асуудал гээд тодорхой асуудлууд дээрээ Хууль зүйн байнгын хороо ахиж хэлэлцээд гишүүдийн гаргаж байгаа санал, дүгнэлтийг нийтлэг ард иргэдийн чиг хандлага гэж үзээд нэлээн олонх дийлэнх нь нэн ялангуяа тэр халдашгүй чөлөөтэй байх эрхийн талаар хөндөж ярилаа. Сүүлдээ эрүүл аюулгүй байдалд орчинд амьдрах эрхийн талаар ч гэсэн хөндөгдлөө. Тэгээд ер нь бас цаашидаа Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндсэн Хуулийн Цэцэд ч гэсэн хүний үндсэн эрхийн гомдлын талаар үндсэн хуулийн асуудлыг яриад байгаа үед бол бас хүний эрхийн комисс энэ дээр бас саналаа ирүүлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд хүний эрхийн үндсэн комисс бол бас ахиц дэвшил гарч байна. Аятай сайн ажиллаж байна гэдгийг онцлон тэмдэглээд нэгдсэн хуралдаанаар Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцлээ.

Ингээд Байнгын хороо холбогдох тогтоолын төсөл, арга хэмжээний

төлөвлөгөө болгомоор юм байна лээ. Ноднингийн тогтоол чинь хэрэгжээгүй л явж байгаа шүү. Тэгээд тогтоол болоод хэрэгждэг эрх хандлага тогтолцоог нь тодорхой болгох асуудлуудыг бас бүр үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бараг баталж өгмөөр юм байна лээ.

Ингээд дараагийн асуудалд орно оо. Баярлалаа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдэд баярлалаа.

Санал хураалттай учраас Улсын Их Хурлын гишүүд асуулт хариултын цаг дууссан. Чуулганы танхимд цугларна ээ. Хунан дарга аа, эрүү шүүлтийг маргааш хэлэлцье.

Санал хураалт дууссан тэрийгээ дуусгах уу. Мөнхбаатар дарга аа, Тогтохсүхэн дарга та хэд аль асуудлыг хэлэлцэх вэ гэдгээ надад яаралтай хэлээдхээч. Үндсэн эрхийн маргааныг иргэнээс гадна шууд Цэц ханддаг байвал илүү процессын хуулиараа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр процессын хуулиараа хийж болохгүй юм байна.

16.52 цаг

Тэгвэл эрүү шүүлтээ сонсьё. Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ.

Тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Ядамжавын Цэлмэн танилцуулна.

Я.Цэлмэн: Монгол Улсын Их Хурлын эрхэм дарга, Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд өдрийн мэндийг хүргэн мэндчилье ээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31

дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулан хэвлэн нийтэлнэ гэж хуульчилсан билээ.

2022 оны 6 сарын 2-ны өдөр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг томилсноос өнөөдрийг хүртэл буюу 10 сарын хугацаа дахь хийсэн ажлыг дараах бүтэцтэйгээр бичиж та бүхэнд танилцуулж байгааг хүлээн авна уу.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хууль эрх зүйн орчны шинэтгэл, эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтын онцлог, статистикт хийсэн дүн шинжилгээ, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээ, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын бүлэг болгон тус бүр тайланд оруулсан болно.

Эрүү шүүлтийн эсрэг конвенц түүний нэмэлт протокол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан зарчимд нийцүүлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны алсын харааг эрүү шүүлтгүй Монголын төлөө гэж тодорхойлон, эрүү шүүлтээс ангид байх эрхийг зөрчиж болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийг судалж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг үр нөлөөтэй, бодитой, хүртээмжтэй зохион байгуулахад үндэсний болон бүс нутгийн хэмжээнд манлайлагч нь байх эрхэм зорилгыг тавьж дараах стратегийг баримтлан ажиллаж байна. Үүнд урьдчилан сэргийлэх, хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагаа бүхий тогтолцоог бэхжүүлэх, эрүү шүүлтээс

урьдчилан сэргийлэх ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хяналт шинжилгээг тогтмол үр дүнтэй хэрэгжүүлэх, хүн бүрд эрүү шүүлтээс ангид байх эрхийг нь мэдүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зарчмын хэрэгжилтийг хангуулах зэрэг болно.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан бүх газар буюу хүн өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй нөхцөлтэй нийт 843 газарт давтагдсан тоогоор жилд 144 мянга гаруй иргэн урт, богино ямар 1 хугацаагаар байрлаж байгаагаас нэн тэргүүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн ойролцоогоор 37 мянга гаруй хүнд тогтмол хүрэлцээж хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх ажлыг хууль олон улсын гэрээнд зааснаар хийх шаардлагатай байгаа бөгөөд энэхүү урьдчилсан сэргийлэх ажлыг шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын удирдлага, тэдгээрийн албан хаагчдын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх боломжтой юм. Ялангуяа эдгээр 843 газрын удирдлага, албан хаагчдын манлайлал, хүний эрхийн мэдрэмж, хандлага, хэлбэрийн төдий бус үйл ажиллагаа туйлын чухал байгааг онцлох нь зүйтэй.

Бид тайлангийн хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хийсэн ажлуудаас товч хураангуйлан танилцуулбал, 2022 оны 8 сарын 4-ний өдрөөс хойш нэгэжийн 5 албан хаагчтайгаар Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Шүүх, сэтгэц эмгэг судлалын клиник, асрамжийн тасгууд, Ахмад настны үндэсний төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төв, орон нутагт байрлах хорих анги, цагдан хорих хаалттай 461-дүгээр анги, баривчлах байр, цагдан хорих байр, Цагдаагийн ерөнхий газрын харьяа

цагдаагийн газар, хэлтсүүдийн эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр, сургуулийн дотуур байр зэрэг нийт 23 газар орон, байриилд батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хяналт, шинжилгээ хийж, тэдгээр газар төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрийн хүсэлтээр гарч явах эрхээ хязгаарлуулсан хүмүүсийн эрхийн хэрэгжилт, мөн албан хаагчдын хөдөлмөрлөх нөхцөл, эрүү шүүлт, гарч болзошгүй тогтолцооны шалтгаан нөхцөлийн асуудлыг судаллаа.

Хяналт шинжилгээний хүрээнд нийт 10614 километр зам туулан өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй нөхцөлд байгаа 1954 хүнээс олон улсын жишиг стандарт, өөрийн улсын хууль эрх зүйн орчны онцлогт уялдуулан боловсруулсан асуумж авч, хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдсон баривчлагдсан 411 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийж, 48 ажилтан алба хаагчидтай өөрсдийнх нь хүсэлтээр уулзаж, 209 хүнд зөвлөгөө өгч, харьяаллын дагуу 6 гомдол мэдээллийг шилжүүлэн шалгууллаа.

Үндэсний урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд хяналт шинжилгээгээр тогтоогдсон эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар шийдэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй нөхцөл байдлыг арилгуулах урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд 11 зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг тооцон ажигласан байна.

Мөн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах хууль сахиулах байгууллагын албан хаагч зорилтот бүлгийн иргэд буюу нийт 3357 хүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх болон хүний эрхийн асуудлаар сургалтууд хийж, сэтгэцийн тулгамдсан асуудалтай болон хүүхдийн аливаа хэлбэрээр гарч явж болохгүй газарт байгаа хүүхдийн эрхийн

асуудлаар мониторинг хийх гарын авлагуудыг эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор боловсруулж, төрийн албан тушаалтан, иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа 8 удаа, цахим мэдээллийн хэрэгслээр 32 удаа, олон удаагийн давтамжтайгаар сурталчлан ажилласан бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаар тухай бүр цахим хуудсаараа олон нийтэд мэдээлж ирлээ.

Эрүү шүүлтийн эсрэг конвенцын нэмэлт протокол батлагдсаны 20, НҮБ-ын Эрүү шүүлтийн урьдчилсан сэргийлэх дэд хороо байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээнд Монгол Улсаас төлөөлөл оролцуулна уу хэмээн албан ёсоор урьсан нь Монгол Улс Үндэсний урьдчилсан сэргийлэх механизм байгуулсантай холбогдуулан гэрээний үүргээ нэр төртэйгөөр биелүүлж байгааг онцолсон үйл явдал юм.

Харамсалтай нь эрүү шүүлт тулгаж хүнтэй хүнлэг бусаар доромжлон харьцаж хууль бусаар мөрдөх нотлох ажиллагаа явуулж олон жилийн ял шийтгэсэн үйл баримт олон нийтэд дэлгэгдэж, нийгмийг айдаст автуулж, ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг үгүйсгэсэн үйлдэл, эс үйлдэл өнгөрсөн хугацаанд гарч түүний сүүдэр одоог хүртэл арилахгүй байна.

Монгол Улсынхаа Үндсэн хууль олон улсын гэрээгээр хамгаалсан хүний эрхийн төлөө иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэгтэй, үнэнч байж, эрсдэлээс үл айн зориг гарган зүтгэж байгаа олон олон шударга төрийн албан хаагч хүнлэг хүмүүсийн идэвх санаачилга, бодитой үйл ажиллагаа, олон нийтийн дэмжлэгийн үр дүнд бид хүний халдашгүй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн аймшигт зөрчлийг мэдэж, хожуу ч гэсэн хор хохирлыг засаж залруулах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх боломж гарлаа.

Дахин ийм харамсалтай хүний үнэт зүйл, мөн чанарыг үгүйсгэсэн харгис хэрэг гаргуулахгүйн тулд бид эрүү шүүлтийн эсрэг хамтдаа чин сэтгэлээсээ үр дүнтэй тэмцэж үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг тогтолцооны хувьд цаг алдалгүй улам бэхжүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хууль Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрицгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн чухлыг эргэн санаж, НҮБ-ын хүний эрхийн механизм тэдгээрийн хараат бус шинжээч, ажлын хэсгийн зөвлөмжийг гарцаагүй хэрэгжүүлэх шаардлагатайг анхаарч, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа Монгол Улсад шинээр бүрэлдэн бий болж байгаа эмзэг үе гэдгийг мэдэрч маш олон хаалттай хаалганы цаана байгаа хүмүүсийн эрхийг хамгаалахыг чухалчлан хууль тогтоогч, улс төрч, Олон улсын байгууллага, Төрийн бус байгууллага, хүний эрхийн болон нийгмийн зүтгэлтэн, судлаачид, иргэдийн оролцоо, дэмжлэг нэн хэрэгтэй байгааг тодотгон Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлан түүнд тусгасан асуудлын хүрээнд холбогч холбогдох шийдвэрийг гаргаж өгнө үү. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Тайланг хэлэлцсэн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын

хорооны дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Хууль зүйн байнгын хороонд ирүүлсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлд заасан журмыг баримтлан Хууль зүйн байнгын хороо 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Цэлмэн танилцуулсан болно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2022 оны буюу анхны тайланг эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтын онцлог, дүн шинжилгээ, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээ, сургалт сурталчилгаа, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн ажил, дүгнэлт, санал гэсэн бүлэг сэдвийн хүрээнд тайланг хэлэлцлээ.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр хорих ангид ял эдэлж байгаа хүмүүсийн орчин нөхцөл, эрүү шүүлт байж болзошгүй улаан шугамын эрх зүйн үндэслэлийн талаар,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид хоригдож байгаа хүнийг хорих ял шийтгэгдсэн этгээдтэй нэг өрөөнд оруулдаг, хяналтын камергүй газарт оруулж эрүүл мэндэд нь халддаг асуудал байгаа эсэх, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эмчлүүлж байгаа хүмүүст олгодог нийгмийн халамжийн тэтгэврийн талаар, мөн эрүүл хүнд хуурамч өвчний онош тавьж ял завишуулдаг асуудал байгаа эсэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ямар нэг шийдвэргүй үргэлжлүүлдэг асуудал байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.4 дэх хэсэгт энэ хуулийн 112.2.2, 112.2.8, 112.2.12-т заасан танилцуулга мэдээллийг холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаан танилцуулж болно гэж заасны дагуу Байнгын хорооны хуралдаан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан мөн илтгэлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн

байна уу. Ширнэнбандийн Адьшаа гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Ядамжавын Цэлмэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Бурмаагийн Эрдэнэбилиг Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Далхсүрэнгийн Түвшинтөр Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах референт

Байнгын хорооны Энхбаяр дарга, референт, ахлах зөвлөх Үнэнбат нар юу шүү дээ. Дэгийн тухай хуульд чинь ийм зөрчил байгаа учраас чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үү, үгүй юу гээд байсан. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9.2-т зааснаар чинь хаврын чуулганаар заавал хэлэлцэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд тогтоол гаргана гээд Хүний эрхийн Үндэсний Комиссын хурлаараа заачихсан шүү дээ. Зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тогтоол гаргана гээд заачихсан. Тийм учраас заавал хэлэлцэнэ. Илтгэл нь. Харин эрүү шүүлтийн тайлан бол тийм юугүй юм байна лээ.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Улсын Их Хурал Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүний орон тоо гэдгийг бий болгож, энэ асуудал дээр анхаарал тавьж, эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгсөн. Ингээд 1 жил гаруй хугацаанд болж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ гишүүн нь томилогдоод 1 жил арай болоогүй юм байна. 7, 8 сар ажилласан юм байна. Тэр тайлангаа танилцууллаа гэж ойлгож байна. 2

зүйлийг би тодруулъя гэж бодож байна. Тайланг уншиж байгаад.

Нэгдүгээрт ер нь эрүү шүүлтийн асуудал хариуцсан гишүүн маань ажиллаад нийт 12 албан тушаалтанд зөвлөмж өгчээ. Хяналт, шалгалт хийгээд, ажиллаад. Энэ зөвлөмжийн хэрэгжилт ямар байна вэ гэж би нэгдүгээрт асуух гэж байгаа юм. Бодвол Засгийн газрын гишүүнд гэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайд ч юм уу, ийм хүмүүст тодорхой хэмжээний зөвлөмж хүргүүлсэн болов уу гэж бодож байна. Зөвлөмжийн хэрэгжилт ямар байна вэ. Таны тавьсан зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэв. Хэрэгжүүлээгүйд нь ямар арга хэмжээ авав. Танд хэрэгжүүлээгүй тохиолдолд арга хэмжээ авдаг эрх зүйн боломж байна уу. Нэгдүгээрт нь асууя гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь Хүний эрхийн Үндэсний Комисс тэр дотроо Эрүү шүүлт хариуцсан гишүүнд эрүү шүүлтэд өртлөө гэдэг гомдол мэдээлэл хэр олон ирсэн бэ. Тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн бэ. Тэр талаарх мэдээлэл дээр байхгүй байгаад байх юм. Тайлан уншихаар. Энэ аягүй чухал асуудал байхгүй. Иргэн хүн өөрөө ийм гомдол гаргасан тохиолдол байна уу. Энийг шийдсэн, хэлэлцсэн, шалгасан, тогтоосон, шийдсэн ийм асуудал ямар байна вэ. Ийм 2 асуулт асууя.

Г.Занданшатар: Ядамжавын Цэлмэн. 80.

Я.Цэлмэн: Баярлалаа. Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хэрэгжүүлэх чиг үүрэг дотор бол хяналт шинжилгээ хийгээд үүгээр илэрсэн асуудал дээр бол түүнийг засаж залруулах, ялангуяа тогтолцооны асуудлыг гол нь судалж ингэж түүнийг засуулах шаардлагатай гэсэн ийм эрх зүйн орчинтой. Үүний хүрээнд бол зөвлөмж

өгдөг байгаа байгууллага албан тушаалтанд. Ингээд 11 зөвлөмжийг бол хүргүүлсэн. Энэ дотор бол яг хяналт шинжилгээ хийсэн байгууллагуудтай холбоотой Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам тээвэр, хөгжлийн яам гээд бусад Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдлага гээд хүргүүлсэн байгаа. Зөвлөмжийн биелэлтийг бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хэрэглэсэн гишүүний зөвлөмжийг хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор заавал биелүүлж, түүнд бичгээр хариу мэдэгдэнэ гэсэн ийм эрх зүйн зохицуулалттай. Үүний дагуу яг 30 хоногийнхоо дотор бол зөвлөмж хүргүүлсэн байгууллага, албан тушаалтнууд бүгд ирүүлсэн зөвлөмжийг биелүүлсэн тайлантайгаа ирүүлсэн байгаа. Ингээд бид нар бол зөвлөмжийг тайланг нь уншиж судлаад, тэгээд холбогдох албан тушаалтнуудыг байлцуулж байгаад, биелэлтэд дүгнэлт хийдэг. Мөн газар дээр нь очиж шалгасан. Зөвлөмжүүд бол үндсэндээ бол маш өндөр хувьтай бол биелсэн. Зарим биелээгүй байгаа асуудал бол мэдээж төсвийн хөрөнгө мөнгөтэй холбоотой болон хууль, эрх зүйн орчны шинэчлэлтэй холбоотой асуудлууд бол түүнтэйгээ холбогдсон хугацаагаараа бол сунгагдаж, биелэгдэхээр ингэж тавигдсан байгаа.

2 дугаар асуудал бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа бол яг гол зорилго нь бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх байгаа. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бол энэ гишүүнд бол гомдол, мэдээлэл яг хяналт шинжилгээнийхээ хүрээнд ийм эрүүдэн шүүгдсэн нөхцөл байдалтай тулгарах юм бол түүнийг бол шалгуулахаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр ийм зохицуулалттай байгаа. Үүний хүрээнд бол бид нар 6 гомдол, мэдээллийг бол шалгуулахаар хүргүүлсэн. 6 гомдол мэдээллийн шалгаж шийдвэрлэлт бол

одоогийн байдлаар тодорхой зарим хариу нь бол ирээгүй, зарим нь бол шалгагдаж байгаа гэсэн ийм дүн мэдээтэй байгаа. Гишүүн, түүнд туслах нэгж бол гомдол мэдээллийг шалгах ийм эрх зүйн орчингүй байгаа өнөөдөр. Баярлалаа.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хамт явж байгаа.

Ш.Адьяа: Өнөөдөр Улсын Их Хурал дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг бид хэлэлцэж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комисс бас энэ хугацаанд хууль, тогтоомжийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөний асуудал, Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд хэрхэн явагдаж байгаа, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудал дээр бас анхаарал хандуулж тодорхой бас ийм урьд жилүүд байхаас тодорхой дэвшил гарсан байгаа нь энэ илтгэлүүд дээрээс харахад бас ийм зүйл ажиглагдаж байна гэж ойлгож байгаа. Эрүү шүүлтийн асуудал эрхэлсэн комиссар Цэлмэний илтгэлийг бас анхааралтай сонсож байна.

Монгол Улсад эрүү шүүлтийн асуудал, эрүү шүүлт тулгах асуудал энэ бол хэрэг бүртгэх, мөрдөн байцаахын шатад явагддаг хамгийн ноцтой хүний эрхийн зөрчлийн асуудал байгаа. Энэ асуудал ер нь ямар түвшинд байна гэж ер нь ойлгож байгаа юм бэ. Сүүлийн жилүүдэд энэ дээр бас өөрөө бас Эрүүгийн мөрдөн байцаах газар ажиллаж байсан. Энэ асуудалтай бас нэлээн ойрхон байсан. Таныг томилогдож байхад би энэ дээр яригдаж байсан. Тэгэхээр энэ асуудал өөрчлөлт гарсан уу, гараагүй юу. Эдийн засгийн талаасаа, хөрөнгө мөнгөний талаас бас их хүндрэлтэй байдаг тухай өөрөө сая ярьчих шиг боллоо. Хууль, эрх зүйн талаасаа бас зайлшгүй шийдэх ёстой асуудал байх талаар бас мэдээлэл өгөх шиг боллоо гэсэн ийм ойлголттой байна.

3 дахь асуулт. Өнөөдрийн нийгэмд сүүлийн үед их анхаарал татаад байгаа Зоригийн хэргийн асуудал буюу Содномдаржаа, Чимгээ нарт холбогдох асуудал өнөөдөр олон нийтийн Монголын төр, хууль хүчний байгууллага, хүний эрхийн байгууллагуудын өмнө асуудал тулгарсан ийм асуудлуудыг өнөөдөр бид анхааралтай ажиглаж байна.

Зоригийн хэргийн асуудлыг улсын нууцаас гаргасан. Улсын нууцаас гаргасан. Энэ хэргийн бүх материал нээлттэй байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтийн асуудал эрхэлсэн комиссарын хувьд энд ямар бодолтой байна. Прокуророос хэргийг нь хэрэгсэхгүй болгосон. Тэгээд эрүүдэн шүүж, ингэж хүнийг өчнөөн олон жилээр ял оноосон байдал өнөөдрийн байдлаар прокурор, шүүхийн 3 шатын шүүхийн асуудлаар ийм асуудал өнөөдөр байгаа зүйл бодит байдал дээр бий болсон байна. Энэ дээр ямар дүгнэлттэй байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний хувьд. Энэ бол өөрийн чинь гол үнэлэлт, дүгнэлт гэх ёстой асуудал гэж би ойлгож байгаа. Бүх юм нээлттэй байгаа. Аль эс үгүй бол нөгөө талаасаа ял завхсан асуудал байгаа юм уу. Хуурамч нотлох баримт бүрдүүлж ингэсэн юм уу. Энэ бол өөрөө бол энд бол маш хариуцлагатай хариултыг бид нарт өгөх байх гэж бодож байгаа. Та өнөөдөр эрүү шүүлт хариуцсан комиссарын хувьд энд хүний эрхийн зөрчлийн хувьд та энд ямар хариулт өгөх вэ гэдгийг би сонсмоор байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Цэлмэн. 80.

Я.Цэлмэн: Баярлалаа. Адъяаа гишүүний асуултад хариулъя. 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль шинэчлэгдэн мөрдөгдөж Монгол улс хэрэгжиж эхэлснээс хойших дүн мэдээ, 2015 онд Эрүүгийн хууль шинэчлэгдэж мөн тухайн оноос 2017 оноос хэрэгжиж эхэлсэн өнөөдрийг хүртэлх дүн мэдээгээр

бол Эрүүгийн хуульд заасан тусгай ангид заасан 13.9 хууль бусаар баривчлах. 14.1 ялгаварлан гадуурхах, 21.12 эрүү шүүлт тулгах гэсэн гэмт хэргүүдэд нийтдээ 385 гомдол, мэдээлэл бүртгэгдэн 471 хүн шалгагдсан байгаа. Ингээд энэ дотор бол субъектээр нь ангилбал цагдаагийн албан хаагч, Тагнуулын ерөнхий газрын албан хаагч, 3.8 хувь нь бусад төрийн албан хаагч гэж байгаа юм. Ингээд шалгагдсан байдал бол энэ. Шалгагдаад хэрэг бүртгэлтийн шатад бол гомдол мэдээллүүд бол цөөрч байгаа юм. Дараа нь мөрдөн байцаалтын шатад бас цөөрөөд. Ингээд анх шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэрэг бол үндсэндээ 2017, 2018 онд байхгүй байж байгаад 2019 онд 3, 2020 онд 3, 2021 онд 3, 2022 онд 3 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн гэсэн дүн мэдээтэй. Тэгэхээр энэ бол бас эргээд анхаарах зайлшгүй судлах шаардлагатай ийм нөхцөл байдал тогтоогдож байгаа гэж бид үзэж байгаа. Энэ рүү бол анхаарч шалгана.

Биднийг томилсноос хойших хугацаанд бол эрүү шүүлтээс яг холбогдолтой хэрэг бол одоогийн байдлаар шийдэгдээгүй байна. Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш.

Хоёр дугаар асуултад бол мэдээж бид нар үйл ажиллагаагаа явуулахад хэрэгцээ шаардлага бол байгаа. Хүний нөөц, боломжит техникийн болон бусад дэмжлэг бол мэдээж шаардлагатай байгаа. Мэдээж хүн өөрөө сайн дураараа гарч явах боломжгүй нөхцөл байдал байлгах ийм газар бол Монгол Улсын хэмжээнд 843 буюу Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан бүх газар гэдэгт харьяалуулсан газруудын тоо ийм байгаа юм. Тэгээд үүнд бол жилд бол 100 гаруй мянган хүн ямар нэгэн хугацаагаар байрлаж байгаа. Тэдгээр хүмүүсийн эрхийг зайлшгүй хангах шаардлагатай. Дээрээс нь Комиссын тухай хуулиар тогтмол очих хяналт шинжилгээ хийх ийм үүрэгтэй байгаа. Тэгэхээр энэ дээр бол хүний нөөцийн болон

бусад асуудлаар бид нарт мэдээж бас тодорхой зохицуулалтаар эрх зүйн зохицуулалтаар дэмжлэг бол шаардлагатай байгаагаа бол тайландаа тусгасан.

Хүн эрүүдэн шүүсэн асуудалтай холбоотой олон нийтэд нээлттэй мэдээлсэн иргэн Содномдаржаа, Чимгээ нарын 3 шатын шүүхээр ял аваад, эргээд хэрэг нь хэрэгсэхгүй болж байгаа асуудлаар бол бас яг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон мөн хууль, эрх зүйн хүрээнд заасан эрхийнхээ хүрээнд иргэдтэй уулзсан. Иргэдтэй уулзсаны хүрээнд бол тодорхой мэдээлэлтэй бас болсон байгаа байх гэж. Яг үүнийхээ хүрээнд бол дүгнэлттэй байгаа. Эрүүдэн шүүх асуудлыг бол ерөөсөө хориглоод, манай улс бол эрх зүйт төр үүсэн бий болсноос хойш бол хориглосон дэлхий нийтийн жишигийг дагаад мөн адилхан тэр хугацаануудад хориглоод явж байсан байна. Яг энэ хүмүүсийн асуудал дээр эрүү шүүлт тулгаж болохгүй гээд Эрүүгийн хуульд тусгайлан заачихсан, өмнө нь бол 4 субъект байсан, 2002 оны Эрүүгийн хуульд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүг. Одоо бол Эрүүгийн хуулиар 21.12-т бол төрийн бүх албан хаагч нар гэж байгаа. Тэгээд дээрээс нь ганцхан эрүүдэн шүүлт гэдэг дээр бас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотой заалтыг бол эргэж харах шаардлагатай байгаа. Энэ бол зөвхөн тайлбар мэдүүлэг авахтай холбоотойгоор хүнийг эрүүдсэн бол, сэтгэл санааны хохирол учруулсан бол, дарамталсан бол гэж ингэж тулгаж мэдүүлэг авсан бол гэж байгаа.

Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай бусад ажиллагааг эрүүдэн шүүж авсан бол энэ зүйл ангид хамааруулах боломж өнөөдөр яг энэ хуулиар, энэ зохицуулалтаар бол харагдахгүй байгаа юм. Тэгэхээр зөвхөн тайлбар мэдүүлэг авахтай холбогдож байна. Тэгэхээр энийг бас тодорхой анхаарах шаардлагатай. Дээрээс нь бол

бид нарт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу эрүүдэн шүүсэн гэдэг гэмт хэргийн тодорхойлолтыг бол тодорхой болгох шаардлагатай байгаа. Энэ дээр бол мэдээж гуравдагч этгээд буюу эрүүдэн шүүх асуудлын гол хэрэгжүүлж байгаа субъект бол төрийн албан.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр. Хууль зүйн байнгын хорооны дарга хариулна.

Б.Энхбаяр: Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх гэж байгаа шүү. Урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн гэж бид шинээр байгуулсан. Анхны тайлангаа тавьж байгаа. Тийм учраас энэ хуульд заасан байгууллага, хуулиар тогтоосон эрх хэмжээгээ их сайн ойлгож хариулмаар байна шүү. Би анх томилогдоход нь хэлж байсан шүү дээ. Цэлмэн гишүүнд. Та бол цагдаагийн байгууллагад ажиллаж байсан хүн шүү. Мөрдөс зүүж байсан шүү. Мэдлээ, гүйцэтгээ гэдэг командаар ажиллаад сурчихсан шүү. Одоо энэ ажил чинь өөр шүү. Энэ жил чинь өөр шүү гэдэг зүйлийг хэлж байсан шүү дээ. Тэгээд одоо Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан энэ чинь хариуцлагатай танхим, нийт ард түмэн үзэж байгаа. Өөрөө гэмт хэрэг шалгадаг хүн биш байхгүй юу даа. Нөгөө сэтгэхүй чинь ажиллаад эхлээд байна шүү дээ. Нөгөө цагдаа сэтгэхүй чинь. Надад би шалгадаг баймаар байна. Наад тусгай субъектүүд эрүүдэн шүүсэн үү, үгүй юү гэдэг хэрвээ гэмт хэргийн асуудал бол энийг тэр зохих мөрдөх алба чинь гэмт хэргийг шалгана. Прокурор чинь хянана. Өөрөө юу хариуцах вэ гэхээр тодорхой төрлийн гэмт хэрэг шалгадаг хүн биш ээ. Урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлэх, тогтолцоог бэхжүүлэх, нийтлэг ямар асуудлууд байна вэ. Эрх зүйн орчин дээр юу байна вэ гэдэг дээр үнэлэлт, дүгнэлт өгдөг ийм хүн байхгүй юу. Тэгээд надад эрх эрх дутаад байна. Хүн дутаад байна. Яах гээд байгаа

юм. Тусгай гэмт хэрэг шалгадаг ийм бүтэц биш байхгүй юу. Наад цагдаа сэтгэхүйгээ толгойноосоо авч хая.

Г.Занданшатар: Ширнэнбандийн Адьшаа гишүүн тодруулж асууна. 1 минут.

Я.Цэлмэн: Цэлмэн тэр бас тогтолцооны өөрчлөлтийн талаар саналаа хэлсэн байх гэж бодож байна. Нэг их буруу юм яриагүй л болов уу гэж ойлгож байгаа юм. Тэр эрүүдэн шүүсэн гээд тэр Содномдаржаа, Чимгээ нарын асуудал гээд өнөөдөр нийгэмд маш том асуудал үүсчхэж. Хүний эрхийн Үндэсний Комисс, Засгийн газраас нууцаас гаргасан асуултыг судалж үзэж ямар дүгнэлттэй байна гэдэг ийм л юмыг би асуугаад байгаа шүү дээ. Энэ дээр 1 тодорхой хариулт авъя. Энэ бол нууц биш. Улсын нууц биш. Мөрдөн байцаалтын нууц биш. Энэ хэрэгсэхгүй болсон. 3 шатын шүүхээр асуудал шийдэгдсэн. Энэ асуудал дээр Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, түүний дотор эрүүдэн шүүсэн асуудал хариуцсан комиссар гэдэг хүн та энд хариулах ёстой.

Г.Занданшатар: 80. Цэлмэн.

Я.Цэлмэн: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа гэдэг бол эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг хэлнэ гэж ингэж заасан. Яг энэ хүрээнд бол бид энэ хэрэг дээр тодорхой судалгааг бол бас хийсэн. Яагаад хийсэн бэ гэхээр дахиж ийм төрлийн хэрэг гаргуулахгүй байх, энэ хэрэг яагаад гарсан бэ гэдэг учир шалтгаан нь юу юм, үнэхээр тогтолцоондоо байсан уу гэдгийг бол судалсан байгаа. Тэгэхээр хэргийг бол ийм төрлийн хэргийг цаашид гаргуулахгүй байх чиглэлээр бол бид бүх холбогдох арга

хэмжээг тогтолцооных нь хүрээнд судалж байгаа.

Эрүүдэн шүүсэн гэдгийг бол олон нийттэй адилхан мэдээлэлтэй байгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Гол асуудлыг нь юуг нь л хариулчих. Эрүүдэн шүүлтийг тэгээд хэн шалгах юм бэ гэдэг асуулт асуучхаад байгаа байхгүй юу. Тойрч шалгадаг болчихоод байна шүү дээ. Үндсэн хуулиар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд прокурор хяналт тавина гэж байгаа тийм үү. Тэрний статистик өмнө нь бол танай тайлангуудад өмнөх тайлангуудаа үзсэн бол чи бахиар хавчдаг, ганцаарчлан хорьдог, өндөр сандал суулгадаг гэх мэтчилэн ийм эрүү шүүлтийн асуудлууд танай тайлангууд ингээд өндөр давтамжтай гардаг байсан. Тэгээд буурсан юм уу. Энийг л асуугаад байна. Тодорхой хэрэг кэйсийг ярихгүй байж болох байх л даа. 80.

Я.Цэлмэн: Өнөөдөр эрүүдэн шүүсэн хэргийг бол хууль сахиулах байгууллагууд бол тойрч шалгаж байгаа. Субъектийн хувьд. Эрүүдэн шүүсэн асуудал бол өмнө нь хүний бие эрхтнийг цохиж гэмтээх, чимхэх ийм аргууд дийлэнхээр гарч байсан бол одоо сэтгэл зүйн болон бусад байдлаар түүнд дарамт учруулах ийм төрөл рүү бас ажиглагдаж байна. Мөн нөхцөлийн эрүү шүүлт бол бид нарын хяналт шинжилгээгээр явсан газруудад бас ажиглагдаж байгаа. Тухайн байр нөхцөл ямар байх ёстой юм тэрнээс нь бол өөр байдлаар байлгаж, тухайн хүнийг эрүүдэн шүүх ийм нөхцөл бол илэрсэн. Тэгэхээр энийг бол арилгуулахаар бид бол ажиллана, ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Түүрэн Энхбаяр дарга, Хууль зүйн байнгын хорооны дарга хэлсэн. Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл бас зорилгоор

хийгдсэн гүйцэтгэх ажиллагааны мэдээлэл хаашаа ч шилждэггүй, зөвхөн үндэсний аюулгүй байдлын зөвлөл ашигладаг. Тэрийг задруулахыг хориглоно гэсэн санкцыг хиймээр юм шиг байна лээ. Зөвхөн зүгээр тусгаарлахаасаа гадна тэр хаашаа задарч болдоггүй. Одоо энэ чинь бүгд холилдоод, саяын ярьдаг хэргүүд ч гэсэн тэр ингээд 1 уутан дотор ингээд хүн амины хэрэг юм уу, үндэсний аюулгүй байдлын хэрэг юм уу гэдгийг холиод ингээд сүүлд нь олон асуудлууд байгаа. Энийг ер нь бас яг гүйцэтгэх ажлын тухай хуулиараа сайн салгаж ялгахгүй бол хууль бусаар цуглуулсан нотлох баримт бол хорт модны жимс юм гэсэн үг байдаг юм шүү дээ. Тэрийг нотлох баримтад тооцохгүй, шүүхэд ашиглахгүй. Тэгээд энийг бол эрүүдэн шүүлтийн тайландаа бас хууль бус нотлох баримт гэдэг юмыг бас давхар хянаж явах ёстой юм шиг байна лээ.

Ингээд нэгдсэн хуралдаанаар Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс

урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

За байз хуралдаан өндөрлөх гэж байна санал хураалт явуулах ирц байна уу. Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсгоё.

Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тогтохоо дарга аа. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

/17:27/

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА